


АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАР ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ:

Зарчим, механизм, үйл ажиллагаа



Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа

“Vis consilii expers mole ruit sua”

(Хараа хяналтгүй эрх мэдэл өөрийн хүндэд сөхрөн унадаг)

Хорациу Квинтус Флаккус, Одэс, 3, 4, 65

Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвөөс хамтран гаргасан “Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт” гарын авлагыг бэлдэхэд дор нэр дурдсан хүмүүс оролцсон болно

Ерөнхий редактор

Филип Флюри (Швейцарь), Андерс Б. Жонсон (Швед)

Редактор, ахлах зохиогч

Ханс Борн (Нидерланд)

Зохиогчид

Алексей Арбатов (Орос), Жан-Кристоф Буркел (Франц), Ева Буза (АНУ), Марина Капарини (Канад), Умит Цизре (Турк), Давид Дархиашилли (Гүрж), Жона Исава Элайгву (Нигер), Ханс-Питер Фюррер (Швейцарь), Денис Гарсиа (Бразил), Сюзанна Гаврилеску (Румын), Вильхелм Германн (Герман), Оуэн Грийн (Их Британи), Мирослав Хадцик (Серб-Монтенегро), Карл Халтинер (Швейцарь), Хайнер Хангий (Швейцарь), Дэйвид Хоббс (Их Британи), Ян Хикима (Нидерланд), Рожие Хуйзенга (Нидерланд), Андрей Каркозжка (Польш), Питер Г. Келли (АНУ), Саймон Ланн (Их Британи), Том МакДональд (Их Британи), Дориян Марсыч (Словени), Жан Жакомо Мигоне (Итали), Майкл Ф. Нүүн (АНУ), Александр Пикаев (Орос), Кристин Пинтат (Франц), Андреас Прюферт (Герман), Кристофер Сабатини (АНУ), Лилиан Сербан (Румын), Равиндер Пал Сингх (Энэтхэг), Андерс С. Саастад (Норвеги), Бауке Сноп (Нидерланд), Свитлана Светова (Украйн), Ян Трапанс (Латви), Матайас Тулер (Аргентин), Марлине Урсшеллер (Швейцарь), Пэнтти Фаананнен (Финлянд), Биляна Ванковска (Македон), Мари Влахова (Чех), Каспер В. Врум (Нидерланд), Тамас Вахслер (Унгар), Донна Уйнслоу (Канад), Херберт Вулф (Герман).

Редакцийн зөвлөл

ОУПХ-ны Улс төр, олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах асуудал хариуцсан хорооны гишүүн Виллем ван Ээкэлен (Нидерланд), Андреас Гросс (Швейцарь), Мирослав Филипович (Серб-Монтенегро), Степан Сулакшин (Орос), Димитро Табачник (Украйн), Ахмад Хусни Ханадзла (Малайз), Адесее Огунлэвэ (Нигер), Элиссавет Пападимитроу (Грек) болон Парламент, иргэн, хүний эрхийн асуудал хариуцсан хорооны гишүүн Бет Муго (Кени), Рикардо Васкес (Аргентин).

Хэл найруулгын редактор

Оливер Уэйтс (Их Британи)

Эх хувь: Англи хэл дээр, Женев, 2003

Монгол хэлнээ хөрвүүлэх ажлыг зохион байгуулсан:



Орчуулсан: Э.Энхгэрэл

Хянан тохиолдуулсан: Т.Баярмагнай

Орчуулгын зөвлөх: М.Батчимэг, УИХ-ын гишүүн

Өмнөх үг



МАНААЧИЙГ ХЭН МАНАХ ВЭ? Улс орны аюулгүй байдал, Та бидний өдөр тутмын амгалан тайван амьдралын баталгааг хангаж, шударга ёсыг манах үүрэгтэй цэрэг, цагдаа, тагнуул, шүүх болон бусад хуулийн байгууллагууд өөрсдөө шударгаар ажиллах баталгаа нь хаана байна? Тэд хуулиар олгогдсон давуу эрхээ хэтрүүлэн хэрэглэж, хүний эрхийг зөрчиж, тайван амьдралд нь өнгөлзсөн “аюулын үүр уурхай”, дарангуйллын арга хэрэгсэл болон хувирахгүй байх баталгаа бий юу?

Аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах үүрэгтэй төрийн тусгай албад иргэдийн төлсөн татвараар цалинжиж, төрийн бусад алба хаагчдаас илүү нийгмийн баталгаагаар хангагдаж, онцгой эрх ямба эдэлдэг. Тиймээс ардчилсан оронд иргэд, олон нийт тэдгээр байгууллагын алба хаагчид хуулийн дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих бүрэн эрхтэй. Ардчилал хөгжсөн орнуудад иргэд энэ эрхээ ПАРЛАМЕНТ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР дамжуулан хэрэгжүүлдэг бөгөөд эдгээрийн дотроос МАНААЧИЙГ МАНАХ хамгийн гол үүргийг ПАРЛАМЕНТ хүлээдэг.

Парламент энэ үүргээ дараах гурван үндсэн арга хэлбэрээр хэрэгжүүлдэг:

Нэгд, аюулгүй байдал, хууль хяналтын байгууллагууд үүсгэн байгуулагдахаасаа эхлээд өдөр тутмын бүхий л үйл ажиллагаандаа хүний эрхийг зөрчихгүй байх баталгааг хуулиар бүрдүүлж өгөх.

Хоёрт, тэдгээр байгууллагын төсвийг батлахдаа дээрх хуулийн шаардлагууд хангагдаж байгаа эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргах.

Гуравт, тэдгээр байгууллагууд парламентаас баталсан хууль, тогтоосон төсвийн зарцуулалтын хүрээнд ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавих.

Та бүхний гар дээр тавьж байгаа энэхүү гарын авлагыг аюулгүй байдлын салбарт сайн засаглалыг төлөвшүүлэх судалгаагаар дэлхийд тэргүүлэгч байгууллага болох Зэвсэгт хүчин ардчилсан хяналт тавих Женевийн төв, Олон улсын парламентын холбооноос хамтран гаргажээ. Хэдэн жилийн өмнө монгол хэлээр цөөн хувиар хэвлэгдсэн энэхүү гарын авлагын орчуулга, үг найруулгыг шинээр нягтлан зүгшрүүлж дахин хэвлүүлж байгаад баяртай байна.

Энэ номноос Та бүхэн Монгол Улсын хувьд өнөөгийн тулгамдсан асуудал болоод байгаа улс төрийн нөлөөнөөс ангид, хүний эрхийг дээдэлдэг, үндсэн үүргээ мэргэжлийн түвшинд сайн биелүүлдэг аюулгүй байдал, хууль хяналтын байгууллагыг төлөвшүүлэхийн тулд УИХ юу хийх шаардлагатай вэ гэдэг талаар оновчтой санаа, тодорхой шийдлүүдийг олж унших болно. “МАНААЧИЙГ МАНАЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА БОЛ ГОЛ ХАРИУЦЛАГЫГ УИХ ҮҮРЭХ ЁСТОЙ” гэдэг дүгнэлтийг энэ номыг уншсан олон хүн хийнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэхүү гарын авлага нь УИХ-ын гишүүд төдийгүй аюулгүй байдал, хуулийн салбарын шинэчлэлийн төлөө оюун, сэтгэлээ чилээж яваа мэргэжлийн хүмүүс, судлаачдын ажилд ч тусаа өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

Эцэст нь, энэ бүтээлийг монгол хэлнээ шинээр хөрвүүлж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан “Улаанбаатар” бодлогын судалгааны төв, энэ ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвийн удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлье.

УИХ-ын гишүүн М.Батчимэг

Улаанбаатар хот

2014 оны 11 дүгээр сарын 26

Өмнөх үг

Парламентын гишүүдэд зориулсан эл гарын авлага монгол хэлнээ дахин хэвлэгдэж буйд ихээхэн баяртай байна. Монгол Улс саяхан манай байгууллагын бүрэн эрхт гишүүн болж, ижил төстэй үзэл санаа бүхий орнуудын эгнээнд нэгдсэн билээ. Монгол Улс аюулгүй байдлын салбарын суурь, ардчилсан шинэчлэлийг хэрэгжүүлж байгаа энэ үед тус гарын авлага хэвлэгдэж байгаа нь төлөөллийн ардчилал болон парламентын хяналт, түүнийг хэрэгжүүлэх стратеги, арга замын талаарх ойлголтыг сайжруулахад өөрийн гэсэн хувь нэмрийг оруулна гэдэгт итгэлтэй байна.

Доктор Филип Флюри

Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвийн Дэд захирал

Женев хот

2014 оны 11 дүгээр сар

Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа

“Vis consilii expers mole ruit sua”

(Хараа хяналтгүй эрх мэдэл өөрийн хүндэд сөхрөн унадаг)

Хорациу Квинтус Флаккус, Одэс, 3, 4, 65

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Номын аливаа хэсгийг Олон улсын парламентын хороо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэх, дахин үзэх боломжтой системд хадгалах, цахим ба механик хэлбэрээр болон өөр бусад арга хэрэгсэлээр хуулбарлах, бичлэг хийх, дамжуулахыг хориглоно.

Энэхүү бүтээлийг арилжааны болон өөр бусад хэлбэрээр зээлдүүлэх, худалдах, ашиглуулах замаар, хэвлэгч байгууллагын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр, одоогийн хэвлэгдснээс өөр бусад ямар нэг хэлбэрээр үдсэн, хавтасласан байдлаар ашиглаж болохгүй бөгөөд эх хувиас өөр хэлбэртэйгээр, энэ нөхцлийг оруулахгүйгээр дахин хэвлэж үл болно.

ISBN 92-9142-142-1 (IPU)

ISBN 86-83543-10-2 (DCAF)

ISBN 978-99973-2-802-1 (УББСТ)

**Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм,
үйл ажиллагаа**

Хэвлэн нийтэлсэн:

Олон улсын парламентын холбоо
Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв

Ерөнхий хянан тохируулагчид:

Филип Флюри, **Швейцарь**
Андерс Б.Жонсон, **Швед**

Хянан тохируулагч-Тэргүүлэгч зохиогч

Ханс Борн, Голланд

Ерөнхий хэвлэгч:

Иргэн-цэргийн харилцааны төв, Белград

Хэвлэсэн


Женев, 2003

Оршил

Аюулгүй байдал нь хүмүүсийн ахуй амьдралын нэг гол тулгуур мөн. Тиймээс иргэдийн санал бодлыг тухайн үндэстний аюулгүй байдлын бодлогод тусгах нь нэн чухал. Төр улсын зүгээс сахин хамгаалахыг эрмэлзэж буй аюулгүй байдалд хамаарах гол үнэт зүйлс болон зарчмыг уг бодлого өөртөө агуулсан байх ёстой.

Тиймээс ч ард түмнээс сонгогдсон, тэдний шууд төлөөлөл болох парламентын гишүүд нь гүйцэтгэх засаг болон аюулгүй байдлын салбартай нягт ойртож ажиллах зайлшгүй шаардлагатай гэдэг нь дээрхээс харагдаж байна. Тэд бүгдийн эцсийн зорилго нэг. Гэхдээ тэр зорилгодоо хүрэхэд гүйцэтгэх тус тусын үүрэг нь зарчмын хувьд харилцан адилгүй байдаг ба тийм ч байх ёстой. Парламент нь хууль эрх зүйн хэм хэмжээг тогтоож, төсөв батлан, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Харин эдгээр үүргээ бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд парламент шаардлагатай мэдээ мэдээлэл, мэргэжлийн чадавхаар хангагдсан байхаас гадна гүйцэтгэх засагтай хариуцлага тооцох эрх, эрмэлзлийн аль аль нь байх ёстой. Нөгөө талаас, үүнд харилцан итгэлцэл, ойлголцол дээр тулгуурласан нийгмийн харилцаа чухал.

Сүүлийн жилүүдэд Чилийн иргэд болон зэвсэгт хүчний харилцаа мэдэгдэхүйц сайжирсныг тэмдэглэх хэрэгтэй. Өнөөдөр тэдний хооронд харилцан хүндэтгэсэн, хамтын ажиллагаа давамгайлсан уур амьсгал бүрдсэн болохыг олон улсын хамтын нийгэмлэг харж болох бөгөөд цаашид ч энэ харилцаа улам нягтран хэмээн бид найдаж байна. Улмаар аюулгүй байдлын салбар дахь бүх гол оролцогчид иргэн бүрийн нийтлэг сайн сайхны төлөөх хамтын зорилгодоо хүрэхэд нь эл гарын авлага тус дөхөм болно гэдэгт бид итгэлтэй байна.



Сенатор Сержио Пааз Вэрдуго
Олон улсын парламентын холбооны Зөвлөлийн ерөнхийлөгч

Өмнөх үг

Өнө эртнээс үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал нь бие даасан аливаа улсын хувьд амин чухал асуудал байсаар ирсэн билээ. Өдгөө аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын тогтолцоо, үүрэг хариуцлагад томоохон өөрчлөлт гарч байна. Зэвсэгт мөргөлдөөний шинэ төрлүүд бий болж, улс хоорондын харилцаа, хамаарал улам бүр нэмэгдэж байгаагаас үүдэн аюулгүй байдлын суурь ухагдахууныг эргэн харах, шинэлэг хариу үйлдэл, арга хэмжээг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний халдлага, түүний үр дагавар энэ хэрэгцээ шаардлагыг улам ч тод харуулсан билээ.

Тиймээс эдгээр шинэлэг хариу үйлдлийг ил тод, хариуцлагатайгаар хэрэгжүүлж буйг баталгаажуулахад үр нөлөө бүхий парламентын хяналтын гүйцэтгэх үүрэг улам бүр чухал болж байна. Ийм хараа хяналт үгүй бол аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албад чиг үүргээсээ хальж, улс доторх улс болон хувирах, улс орны хязгаарлагдмал нөөцөд хэт хүнд дарамт болох, эсвэл улс төр, эдийн засагт нөлөө тогтоох эрсдэлтэй. Түүгээр ч зогсохгүй, ардчиллыг нухчин дарж, зөрчил, мөргөлдөөнд хүргэх аюул бий. Шилжилтийн үедээ яваа, дайнд нэрвэгдсэн, эсвэл хямралт нөхцөл дэх улс орнуудын хувьд ийм магадлал харьцангуй өндөр. Гэхдээ ардчилал нэгэнт төлөвшсөн улс орнууд ч мөн адил хувьсан өөрчлөгдөж буй аюулгүй байдлын орчинтой хөл нийлүүлэн алхахын тулд иргэн-цэргийн харилцаандаа тогтмол анхаарч, шинэчлэн зохицуулж байх ёстой.

Аюулгүй байдлын салбарын мөн чанар, зүй тогтлоос үүдэн парламентын хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд бэрхшээл зайлшгүй учирдаг. Хамаарч буй олон нарийн ширийн асуудал, аюулгүй байдлыг хангах албадын ээдрээтэй бүтэц зохион байгуулалт, цаашилбал нууцын тухай хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг нь парламентын гишүүдийн зүгээс тус салбарт үр нөлөөтэй хяналт тавих үйл ажиллагааг маш амаргүй болгодог бөгөөд үүнд хөндлөнгийн судалгаа, мэргэжлийн дүгнэлтийг ашиглахад хүргэдэг.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан, аюулгүй байдлын салбарт парламентчдын зүгээс хувь нэмрээ оруулах арга механизмуудыг цогцоор агуулсан энгийн бөгөөд тодорхой чиглэлийг гаргах зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж Олон улсын парламентын холбоо (ОУПХ), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв (ЗХАХТЖТ) үзсэн болно. Энэхүү гарын авлага нь бидний тэрхүү санаачилгын бодит биелэл билээ. Гарын авлагыг боловсруулах бүхий л шатанд парламентын гишүүдээс бүрдсэн редакцийн зөвлөл санаа бодлоо илэрхийлсний дээр төрөл бүрийн нарийн мэргэжлийн хүмүүс хянан тохиолдуулсан болно.

Эл гарын авлагыг боловсруулахдаа бид бүх улс оронд ижил тэгш үйлчлэх парламентын хяналтын хэвшмэл нэг загвар байхгүй гэсэн үндсэн зарчмыг баримталсан. Нэг улсад хүлээн зөвшөөрч, үр дүнтэй ашиглаж болох дүрэм журам,

үйл ажиллагаа нь өөр улс орны хувьд үл зөвшөөрөгдөх эсвэл огт хамааралгүй байж болно. Түүнээс гадна, газар газрын парламентын эрх мэдэл харилцан адилгүй байдаг. Энэ бүх нөхцөл байдлаас шалтгаалан, уг номд дурдсан зарим санаа хэт өөдрөг мэт санагдаж болох юм. Үүний зэрэгцээ, аюулгүй байдлын асуудлууд ихэвчлэн маш цогц агуулгатай байдаг учир бүх талыг ганц номд иж бүрнээр нь багтаах боломжгүй. Иймээс энэ гарын авлагыг аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтыг сайжруулах зорилго бүхий ерөнхий танилцуулга хэмээн үзэх нь зүйтэй бөгөөд энэ чиглэлээр цаашид гүнзгийрүүлэн судлах ажлын эх болоосой гэж найдаж байна. Эцэст нь, ард түмэндээ үйлчлэх зориулалттай үндэсний аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаа нь тэднийхээ санаа бодол, хүсэл эрмэлзлийг тусгасан байхыг баталгаажуулахад манай гарын авлага хувь нэмэр болно гэж найдаж байна.



Андерс Б.Жонсон

Олон улсын парламентын холбооны
Ерөнхий нарийн бичгийн дарга



Элчин сайд, Доктор Теодор Х. Уинклер

Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих
Женевийн төвийн захирал

Энэ гарын авлагаас Та юу олж мэдэх вэ?

Энэ гарын авлага 8 хэсэгтэй, хэсэг тус бүр хэд хэдэн бүлгээс бүрдэх агаад хоёр янзаар уншиж болно. Гарын авлагыг бүхэлд нь уншсанаараа та аюулгүй байдлын асуудлууд, тэр дундаа аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтын талаар цогц мэдлэгтэй болох боломжтой. Нөгөө талаар, уншигч та, өөрийн тухайлан сонирхож буй сэдэв, бүлгийг салган уншиж ч болно. Ингэж уншихад тань манай гарын авлагын нэр томъёоны ангилсан тайлбар, харилцан ишлэл танд тус болно.

Гарын авлага дахь зарим нарийн асуудлыг тайлбарлах, аюулгүй байдлын салбарт тавих зарим орны парламентын хяналтын үйл ажиллагаа, хууль эрх зүйн зохицуулалтыг харьцуулах зорилгоор хайрцагласан тодруулгуудыг тухай бүрт нь оруулсан. Мөн ихэнх бүлгийн төгсгөлд Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс гэсэн тодорхой зөвлөмжүүд бүхий хэсэг бий. Гэхдээ өмнө тэмдэглэсэнчлэн, эдгээр зөвлөмжийг ашиглахдаа өөрийн үндэсний онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй болов уу.

Эхний хоёр хэсэгт аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтыг онолын болон дүн шинжилгээний үүднээс авч үзсэн. Нэгдүгээр хэсэгт аюулгүй байдлын үзэл баримтлалын асуудлыг авч үзсэн бөгөөд аюулгүй байдлын асуудлуудыг шийдэхэд парламент болон төрийн бусад институциуд ямар чиг үүрэгтэй болохыг ерөнхийд нь тайлбарлав. Энэ бүлэгт багтсан гол асуудлууд гэвэл:

- Аюулгүй байдлын орчин дахь сүүлийн үеийн өөрчлөлтүүд
- Шинэ хэмээгдэх аюул заналууд ба хариу арга хэмжээ
- Аюулгүй байдлын салбарт парламентын хяналт яагаад шаардлагатай вэ
- Аюулгүй байдлын салбарын ардчилсан засаглалын үндсэн зарчмууд
- Засгийн газар, Шүүх засагтай харьцуулахад Парламентын гүйцэтгэх үүрэг

Хоёрдугаар хэсэгт үндэсний аюулгүй байдлын бодлогын бүх мөчлөг болон үндэсний аюулгүй байдлын бодлогод хамаарах олон улсын эрх зүйн зохицуулалтуудыг тодорхойлсон. Энэ хэсгийн сүүлийн хоёр бүлэгт иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, түүнчлэн аюулгүй байдлын салбар дахь хүйсийн асуудлын талаар тайлбарласан болно. Гол асуудлуудыг дурдвал:

- Үндэсний аюулгүй байдлын бодлоготой холбоотой шийдвэр гаргахад парламентын үүрэг оролцоо
- Үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулахад олон улсын эрх зүйн зохицуулалтуудын бий болгож буй хязгаарлалт болон боломжууд
- Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд аюулгүй байдлын

салбарт хэрхэн хамаардаг, парламентын зүгээс тэдний оролцоог хэрхэн бүтээлчээр ашиглах

- Олон нийтэд аюулгүй байдлын асуудлыг хэрхэн мэдээлэх
- Аюулгүй байдлын салбарт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг

Гуравдугаар хэсэгт аюулгүй байдлын салбарын гол оролцогчид болох зэвсэгт хүчин, цагдаа, тагнуулын алба болон төрийн бусад цэрэгжсэн байгууллага, аюулгүй байдал хангах хувийн хэвшлийн байгууллагын талаарх ойлголтыг өгсөн болно. Үүнд:

- Аюулгүй байдлыг хангах байгууллага тус бүрийн үндсэн үйл ажиллагаа, онцлог
- Байгууллагын дотоод болон улс төрийн хариуцлагын механизмууд
- Парламентын зүгээс аюулгүй байдлын албадад үр дүнтэй хяналт тавих

Гарын авлагын Дөрөвдүгээр хэсэгт аюулгүй байдлын салбарт парламентаас хяналт тавихад хэрэглэх арга хэрэгслүүд, тухайлбал дараах асуудлуудад хариулт өгсөн болно. Үүнд:

- Аюулгүй байдлын салбар дахь хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд парламентын ашиглаж болох арга хэрэгслүүд
- Аюулгүй байдлын асуудлаарх парламентын ур чадварыг хэрхэн сайжруулах
- Аюулгүй байдлын асуудлаар парламентын асуулга, сонсгол явуулахын үүрэг, ач холбогдол
- Батлан хамгаалах асуудал хариуцсан парламентын хороод хэрхэн үр дүнтэй ажиллах
- Омбудсмэний үүрэг
- Батлан хамгаалах салбар дахь омбудсмэний үүрэг
- Парламентын гишүүд аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудад биечлэн очиж танилцах шаардлага

Тавдугаар хэсэгт онц байдал зарлах, дотоод аюулгүй байдалд аюул занал учрах, терроризм, кибер гэмт хэрэг зэрэг үндэсний аюулгүй байдалд сорилт учруулагч зарим тодорхой нөхцөл байдлын талаар оруулсан. Түүнээс гадна, ихэвчлэн аюулгүй байдал бүрэн алдагдсан буюу нэн хэврэг улс орон, бүс нутагт явагддаг олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцохоос үүдэлтэй болзошгүй хүндрэл бэрхшээлийг тодорхойлсон болно. Гол асуудлуудыг дурдвал:

- Онц байдал зарлах, дотоод аюулгүй байдлыг хангах болон хүний эрхийг хүндэтгэх хоорондын эмзэг тэнцвэрийг хэрхэн хангах
- Онц байдал зарлах зорилго болон хязгаарлалтууд
- Есдүгээр сарын 11-ний явдлаас хойш ямар сорилтууд бий болсон бэ? Хууль ёсны дагуух ардчилсан жагсаал, эсэргүүцлийг терроризмаас

хэрхэн ялгах вэ? Улс орнуудын олон улсын аюулгүй байдлын орчинд ямар өөрчлөлт гарсан бэ? Энэ салбарт парламент ямар үүрэг гүйцэтгэх вэ?

- Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд цэрэг илгээх шийдвэр гаргахад парламентын оролцоо ямар хамааралтай вэ?

Зургаа, Долоо, Наймдугаар хэсгүүдэд аюулгүй байдлын салбартай холбоотой гурван төрлийн нөөцийг тус тус тайлбарласан. Зургаадугаар хэсэгт батлан хамгаалахын төсөв, парламент болон төрийн аудитын байгууллагуудаас хэрхэн хяналт тавих талаар дурдсан болно. Үүнд:

- Төсөв бол аюулгүй байдлын гол элемент
- Аюулгүй байдлын төсөвт ил тод, хариуцлагатай байдлыг хэрхэн хангах
- Аюулгүй байдлын төсөвт үр дүнтэй хяналт тавих үнсэн нөхцөлүүд
- Аюулгүй байдлын салбарт хэрхэн аудит хийх вэ? Хараат бус аудитын үйл ажиллагаа, түүний ач холбогдол

Долоодугаар хэсэгт аюулгүй байдлын салбарын хүний нөөцийн асуудлыг авч үзсэн. Ингэхдээ бие бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, сургах, албанаас чөлөөлөх, тэтгэвэр тэтгэмж, цэргийн хугацаат болон гэрээт албаны талаар оновчтой зохицуулалт хийхэд парламентын гишүүдэд туслах зорилгыг агуулсан болно. Үүнд:

- Аюулгүй байдлын салбарт ажиллагсдад ардчилсан үнэт зүйлсийг хэрхэн төлөвшүүлэх
- Албан хаагчид цэргийн нийгэмлэг холбоо байгуулж болох уу?
- Аюулгүй байдлын салбарын мэргэжлийн ёс зүй
- Дэлхийн улс орнуудад цэргийн хугацаат болон гэрээт албыг хэрхэн зохицуулдаг вэ?
- Энэ салбарт алба хаагчдын ёс зүйн дүрэм гэж бий юу? Олон улсын нийтлэг хэм хэмжээ байгаа юу?
- Аюулгүй байдлын салбарын хүний нөөцийн удирдлагын чухам аль хэсэг нь парламентын гишүүдэд хамааралтай вэ?

Төгсгөлийн буюу Наймдугаар хэсэгт аюулгүй байдлын салбарын материаллаг нөөц, тухайлбал худалдан авалтын үйл ажиллагаа (юуг хэнээс худалдаж авах) болон зэвсгийн худалдаа, шилжүүлгийн талаар голлон тайлбарласан болно. Үүнд:

- Хуулийн ямар хязгаарлалтууд үйлчилдэг вэ?
- Худалдан авалтын талаарх цогц шийдвэр гэж юу вэ?
- Нууцлалтын үндэслэл гэж юу вэ?
- Тэдгээрт парламент хэрхэн үнэлгээ өгөх вэ?

Агуулга

Өмнөх үг	4
----------------	---

Энэ гарын авлагаас Та юу олж мэдэх вэ?	6
--	---

Тодруулгын жагсаалт	11
---------------------------	----

Нэгдүгээр хэсэг

Аюулгүй байдлын хувьсан өөрчлөгдөж буй ухагдахуун ба оролцогчид: Парламентын гишүүдэд тулгарч буй сорилт

Бүлэг 1 – Хувьсан өөрчлөгдөж буй дэлхий, түүний аюулгүй байдал	17
Бүлэг 2 – Парламентын хяналтын ач холбогдол	21
Бүлэг 3 – Парламент болон төрийн бусад институцийн үүрэг хариуцлага	24

Хоёрдугаар хэсэг

Үндэсний аюулгүй байдлын бодлогод тавих хяналт

Бүлэг 4 – Үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулах нь	31
Бүлэг 5 – Үндэсний аюулгүй байдлын бодлого ба олон улсын эрх зүйн зохицуулалтууд	37
Бүлэг 6 – Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо	42
Бүлэг 7 – Аюулгүй байдлын бодлого дахь хүйсийн асуудал	52

Гуравдугаар хэсэг

Аюулгүй байдлын салбарын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд

Бүлэг 8 – Цэрэг	63
Бүлэг 9 – Төрийн бусад цэрэгжсэн байгууллага	69
Бүлэг 10 – Цагдаагийн бүтцүүд	72
Бүлэг 11 – Нууц болон тагнуулын албад	76
Бүлэг 12 – Хамгаалалтын болон цэргийн чиглэлээрх хувийн компаниуд	82

Дөрөвдүгээр хэсэг

Үндэсний аюулгүй байдал ба парламентын хяналт: нөхцөл болон механизмууд

Бүлэг 13 – Парламентын хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нөхцөл	89
Бүлэг 14 – Аюулгүй байдлын салбарт парламентын ашиглах арга хэрэгсэл	96

Бүлэг 15 – Батлан хамгаалах болон аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын хороод	104
Бүлэг 16 – Омбудсмэн	109
Бүлэг 17 – Аюулгүй байдлын албадтай очиж танилцах	114

Таөдугаар хэсэг

Аюулгүй байдлын албадын үйл ажиллагаанд хяналт тавих: Онцгой нөхцөл байдал ба тусгай ажиллагаа

Бүлэг 18 – Онцгой нөхцөл байдал	119
Бүлэг 19 –Дотоод аюулгүй байдлыг сахин хамгаалах	123
Бүлэг 20 – Терроризм	128
Бүлэг 21 – Аюулгүй байдал ба мэдээллийн технологи: Шинэ арга хэрэгсэл болоод сорилтууд	138
Бүлэг 22 – Олон улсын энхийн ажиллагаа	142

Зургаадугаар хэсэг

Санхүүгийн эх үүсвэр: Аюулгүй байдалтай холбоотой төсөвт үр дүнтэй хяналт тогтоох

Бүлэг 23 – Аюулгүй байдал ба санхүүгийн нөөц	154
Бүлэг 24 – Аюулгүй байдалтай холбоотой үндэсний төсөвт хийх аудит	169

Долоодугаар хэсэг

Аюулгүй байдлын салбарын хүний нөөц: Мэргэжлийн ур чадвар ба ардчилсан хяналт

Бүлэг 25 – Аюулгүй байдлын салбарт ардчилсан үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх	177
Бүлэг 26 – Аюулгүй байдлын салбарын хүний нөөцийн бодлого	190
Бүлэг 27 – Цэргийн үүрэг ба алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах	193

Наймдугаар хэсэг

Материаллаг нөөц: Зэвсэг техникийн нийлүүлэлт, худалдан авалтад үр дүнтэй хяналт тавих

Бүлэг 28 – Зэвсэг техник худалдан авах ажиллагаа	203
Бүлэг 29 – Зэвсгийн наймаа болон нийлүүлэлт	209

Олон улсын парламентын холбоо	222
--	------------

Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв	223
---	------------

Сэдэвчилсэн индекс	226
---------------------------------	------------

Тодруулгын жагсаалт

Тодруулга N° 1	Аюулгүй байдалд учирч буй бусад аюул занал: дангаараа болон бүхэлдээ ...	18
Тодруулга N° 2	Аюулгүй байдлын асуудлаарх төрөл бүрийн хэлцлүүд	19
Тодруулга N° 3	Төрийн үндсэн байгууллагуудын аюулгүй байдлын салбартай холбогдуулан гүйцэтгэж болох үүрэг	25
Тодруулга N° 4	Сайн засаглал аюулгүй байдлын салбарт тавих ардчилсан хяналтын чухал хэсэг болох нь	27
Тодруулга N° 5	Аюулгүй байдлын бодлогын талаарх асуултууд	31
Тодруулга N° 6	Шууд ардчилал ба олон улсын болон бусад томоохон гэрээ хэлцлийг соёрхон батлах нь: Швейцарийн жишээнээс	40
Тодруулга N° 7	Латин Америк дахь иргэний нийгэм: Иргэний нийгмийн үүрэг оролцоо, түүний ач холбогдлын бодит жишээ	44
Тодруулга N° 8	Шинэ төрлийн дайн: Хэвлэлийн эрх чөлөөний амаргүй сорилтууд	45
Тодруулга N° 9	2001 оны 9 дүгээр сарын 11-нээс хойшхи хэвлэл мэдээллийн эрх чөлөө	47
Тодруулга N° 10	Парламентын цахим хуудас	48
Тодруулга N° 11	Парламент ба хэвлэл мэдээлэл	50
Тодруулга N° 12	Энхийг тогтоох үйл явц дахь хүйсийн асуудал	53
Тодруулга N° 13	Энхийг тогтоох ажиллагаа, үйл явц дахь хүйсийн асуудал	53
Тодруулга N° 14	Цэргийн эмэгтэй албан хаагчид: НАТО-ын гишүүн орнуудын жишээнээс	55
Тодруулга N° 15	Аюулгүй байдлын бодлого боловсруулахад эмэгтэйчүүд оролцох нь хүйсийн тэгш эрхийн томоохон чиг хандлага мөн	56
Тодруулга N° 16	Аюулгүй байдлын салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо: шинэ нөхцөл байдал хийгээд сорилтууд	57
Тодруулга N° 17	Цэрэггүй улс орнууд	63
Тодруулга N° 18	Батлан хамгаалахын шинэчлэл: Зорилго нь юу вэ?	64
Тодруулга N° 19	Иргэний хууль сахиулах ажиллагаанд цэргийн хүчийг ашиглах нь: Өмнөд Африкийн жишээнээс	66
Тодруулга N° 20	Зарим орны төрийн цэрэгжсэн нэгжийн жишээнээс	70
Тодруулга N° 21	Ардчилсан цагдаагийн үндсэн хэв шинж	72
Тодруулга N° 22	Аюултай нөхцөл байдал ба завхруулга	73
Тодруулга N° 23	Эритрея Улсын цагдаагийн үйл ажиллагаа: хөгжил дэвшилт	74

Тодруулга N° 24	Парламент ба тагнуулын албадын тусгай төсөв: Аргентины жишээ	77
Тодруулга N° 25	Парламентын хороод нууц баримт бичигтэй ажиллах зарим туршлага	78
Тодруулга N° 26	Хамгаалалтын болон цэргийн чиглэлээрх хувийн компаниуд ба тэдгээрийн зүгээс ардчилалд учруулж болзошгүй аюул занал	83
Тодруулга N° 27	Аюулгүй байдлын салбарт тавих ардчилсан хяналтыг баталгаажуулахад парламентын ашиглаж болох арга хэрэгслүүд	90
Тодруулга N°28	Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтын давшингуй стратеги	93
Тодруулга N° 29	Аюулгүй байдлын асуудлаарх парламентын чадавхыг бэхжүүлэх арга хэрэгсэл: зарим санал	94
Тодруулга N° 30	Парламентаас гүйцэтгэх засаглалыг хянахад өргөнөөр хэрэглэгддэг бүтэц, горим	97
Тодруулга N° 31	Парламентын асуултыг үр дүнтэй болгох	99
Тодруулга N° 32	Парламентын хяналт шалгалтын хороодын үндсэн шинж.....	100
Тодруулга N° 33	Канадын цэргийн хүчийг Сомали руу илгээх асуудлаарх Хяналт шалгалтын хороо: Аюулгүй байдлын асуудлаар парламентаас гаргасан дүгнэлт ба олон нийтэд үзүүлэх нөлөө	102
Тодруулга N°34	Батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын хорооны зарим жишиг үүрэг	104
Тодруулга N° 35	Стортинг (Норвегийн парламент)-ийн Гадаад хэргийн хороо болон Батлан хамгаалахын хорооны хамтарсан хуралдаан	106
Тодруулга N° 36	Омбудсмэн	109
Тодруулга N°37	Зарим орны батлан хамгаалахын омбудсмэний үйл ажиллагааны талаар	110
Тодруулга N° 38	Германы парламентын Зэвсэгт хүчний асуудал хариуцсан комиссар	111
Тодруулга N° 39	Аргентины жишээ	114
Тодруулга N° 40	Эрүүдэн тамлахын эсрэг конвенцийн нэмэлт протокол батлагдсан нь аюулгүй байдлыг хангах байгууллагуудтай газар дээр нь танилцах боломжийг өргөсгөж байна	115
Тодруулга N° 41	Онц байдал: Зорилго ба зарчим	120
Тодруулга N° 42	Аюулгүй байдал, ардчиллыг тэгш хангах	125
Тодруулга N° 43	Ноцтой үр дагавар бүхий гажуудлууд	126

Тодруулга N° 44	Есдүгээр сарын 11-ний үйл явдалтай холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс авсан хариу арга хэмжээ	129
Тодруулга N° 45	Терроризмын эсрэг тэмцэл	131
Тодруулга N° 46	Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбогдуулан Хувь хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц (ETS N°108)	140
Тодруулга N° 47	Энхийг бүрдүүлэх, энхийг сахиулах, энхийг тогтоох, энхийг байгуулах: НҮБ-ын түгээмэл хэрэглэгддэг зарим тодорхойлолтууд	142
Тодруулга N° 48	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны үе шат	146
Тодруулга N° 49	Энхийг сахиулах ажиллагааны дүрэм журам	147
Тодруулга N° 50	Энхийг сахиулагчдад зориулсан НҮБ-ын сургалт	149
Тодруулга N° 51	Төсөв: Ардчилсан засаглалын үндсэн арга хэрэгсэл	154
Тодруулга N° 52	Төсвийн асуудлаар парламент яагаад идэвхтэй байр суурь баримтлах шаардлагатай вэ?	156
Тодруулга N° 53	Дэлхийн бүс нутгууд болон зарим орны ДНБ-д батлан хамгаалах төсвийн эзлэх хувь	156
Тодруулга N° 54	Төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв боловсруулах систем	159
Тодруулга N° 55	Батлан хамгаалах төсвийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд: 2002 оны Испанийн батлан хамгаалах төсөв	161
Тодруулга N° 56	Аюулгүй байдлын төсвийн ил тод байдлыг хангахад тулгардаг гол бэрхшээл	162
Тодруулга N° 57	Аюулгүй байдалтай холбоотой төсвийн нууцлалын гурван зэрэглэл	164
Тодруулга N° 58	Аюулгүй байдлын салбарын төсөвт үр дүнтэй хяналт тавихад учирдаг гол асуудлууд	165
Тодруулга N° 59	Зүүн өмнөд Европын зарим орны батлан хамгаалах төсвийн жишээ	167
Тодруулга N° 60	Ерөнхий аудитор	170
Тодруулга N° 61	Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд Их Британийн Үндэсний аудитын газраас гүйцэтгэх үүрэг	171
Тодруулга N° 62	Гүржийн парламент ба төсвийн хяналт	173
Тодруулга N° 63	Европын зөвлөл: Зэвсэгт хүчний мэргэжлийн бие бүрэлдэхүүний эвсэлдэн нэгдэх эрхийн талаарх зөвлөмж	179
Тодруулга N° 64	Германы зэвсэгт хүчний манлайлал болон иргэний боловсрол: "Innere Führung"-ийн зарчмууд	183

Тодруулга N° 65	Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын Ёс зүйн дүрэм	184
Тодруулга N° 66	ЕАБХАБ: Аюулгүй байдлын салбарын улс төр-цэргийн талын Ёс зүйн дүрэм (1994): Гол агуулга.....	186
Тодруулга N° 67	Хүний нөөцийн удирдлага: Парламентын гишүүдийн анхаарах гол асуудлууд	190
Тодруулга N° 68	Дэлхийн улс орнуудын цэргийн алба	194
Тодруулга N° 69	Хугацаат цэргийн албан хаагчдад дарамт учруулах	195
Тодруулга N° 70	НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1998/77 тоот тогтоол: Цэргийн алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах	197
Тодруулга N° 71	Дүйцүүлэх алба: Швейцарийн жишээнээс	199
Тодруулга N° 72	Парламентын гишүүд яагаад зэвсэг, техник худалдан авах ажиллагааг анхаарах ёстой вэ?	204
Тодруулга N° 73	Зэвсэг, техник худалдан авах бодлого хэт сул, тодорхойгүй эсвэл эсрэгээр хэт хаалттай байхын үр дагавар	205
Тодруулга N° 74	Нидерланд: Батлан хамгаалах салбарын худалдан авалтын бодлого ба парламентын хяналт	206
Тодруулга N° 75	Зэвсэг нийлүүлэх: Тодорхойлолт	209
Тодруулга N° 76	Зэвсэг техник нийлүүлэх талаарх бүс нутгийн гэрээ хэлцлүүд	210
Тодруулга N° 77	Зэвсэглэлийн хоригийг боловсронгуй болгох нь: Парламент юу хийж чадах вэ?	213
Тодруулга N° 78	Илүүдэл зэвсгийн худалдаа: Зэвсэглэл хураах санаачилгын нэгэн сөрөг үр дагавар	215
Тодруулга N° 79	Жижиг зэвсгийн наймааны тоон үзүүлэлтүүд	216
Тодруулга N° 80	Жижиг зэвсэг болон хөнгөн зэвсэглэлийн хууль бус худалдааны эсрэг НҮБ-ын Үйл ажиллагааны хөтөлбөр: Парламентын гишүүдийн анхаарах гол асуудлууд	216
Тодруулга N° 81	Зэвсгийн экспортын хяналтад парламентын гүйцэтгэх үүрэг: Европын холбооны орнууд дахь ил тод, хариуцлагатай байдал	217

Нэгдүгээр хэсэг

Аюулгүй байдлын хувьсан өөрчлөгдөж буй ухагдахуун ба оролцогчид:

Парламентын гишүүдэд тулгарч буй сорилт

Бүлэг 1

Хувьсан өөрчлөгдөж буй дэлхий, түүний аюулгүй байдал

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд олон улсын аюулгүй байдлын орчинд томоохон өөрчлөлтүүд гарсан. Хуучин аюул заналууд замхран алга болсон ч оронд нь шинэ, ээдрээтэй сорилтууд урган гарлаа. Үүнээс үүдэн аюулгүй байдал, зөрчилдөөн, энх тайвны талаарх суурь ухагдахуунуудыг эргэн харах, шинээр томъёолох хэрэгцээ шаардлага зүй ёсоор бий болов.

Ардчилсан орнууд дахь энх тайван, аюулгүй байдал

Зөрчилдөөн бүр энх тайван, аюулгүй байдалд заналхийлээд байдаггүй. Аль ч улс оронд янз бүрийн асуудлаар өөр хоорондоо өрсөлдсөн, түүгээр ч үл барам зөрчилдсөн үзэл бодлууд байдаг нь жам билээ. Ардчилсан орны иргэдийн хувьд, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдэлж, өөрсдийн сонгосон төлөөлөлд саналаа уламжлах боломж нээлттэй байдаг. Харин тэдгээр төлөөлөл нь нээлттэй хэлэлцүүлгийн аргаар тухайн асуудлуудыг хэлэлцэн, үнэлж дүгнэх үүрэг хүлээдэг. Ардчиллын энэ үйл явц хямрал зөрчил үүсэх эрсдлийг бууруулж, улмаар нийгэмд олонхийн дэмжлэгийг хүлээсэн тохиромжит гарц, шийдлийг олоход тус дөхөм болдог юм. Тиймээс ч харилцан уялдаа, үр дүнтэй ажилладаг ардчилсан институциуд байхгүй бол хямрал зөрчил даамжирч, ноцтой мөргөлдөөнд хүрдэгт гайхах зүйлгүй билээ. Зөрчлийг чиглүүлэн зохицуулах тогтолцоог өөртөө агуулсан байдгаараа ардчилал нь энх тайван, аюулгүй байдалтай салшгүй холбоотой.

Аюулгүй байдал бол өөрөө туйлын зорилго биш, харин ард түмний сайн сайхныг хангах цор ганц чиг үүрэгтэй гэдгийг өдгөө олноо хүлээн зөвшөөрөх болсонд энэхүү уялдаа холбооны учир утга оршиж байна. Эл зарчмыг амьдрал дээр хэрэгжүүлэх хамгийн дөхөм хувилбар нь парламентын үр дүнтэй засаглалд тулгуурласан ардчилал мөн.

“Тагцхүү хувь хүний бүрэн эрхт, халдашгүй дархан байдлаас эхтэй бол аливаа хамтын нийгэмлэг, бүс нутаг, үндэстэн, улс гүрний бүрэн эрхт байдал учир утгатай байна.” – Вацлав Хавел

Төр улсын аюулгүй байдалд голлон төвлөрдөг “үндэсний аюулгүй байдал” нь хувь хүн, хамтын нийгэмлэгийг тэргүүнд тавьдаг “хүний аюулгүй байдал” болон

өөрчлөгдөж байна. Үүний улмаас улс орнууд өөрийн аюулгүй байдалд учрах аюул заналын эсрэг хариу арга хэмжээний цар хүрээг тэлж, дараах асуудлыг багтаах болжээ. Үүнд:

- ✓ **Урьдчилан сэргийлэх:** хямралыг зохицуулах хүн-төвтэй бодлого, энхийг тогтоох арга хэмжээ гэх мэт зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх санаачлага;
- ✓ **Хөндлөнгөөс оролцох:** бусад хүчин чармайлт үр дүнд хүрээгүй тохиолдолд өндөр эрсдэлд буй хүн амыг хамгаалахын тулд дотоодын хямралд хөндлөнгөөс оролцох;
- ✓ **Хариу арга хэмжээ авах:** дайнд нэрвэгдсэн энгийн иргэдэд туслалцаа үзүүлэхийн тулд иргэний дайны үед эсвэл дайны дараа аврах ажиллагаа явуулах зайлшгүй шаардлагатай. Үүнд, дайжигсдын хуаран байгуулах, дүрвэгсдэд орогнох эрх олгох, авран туслах зэрэг ажиллагаа багтана.

Цэргийн аюулгүй байдлаас цогц аюулгүй байдал руу

“Хүний аюулгүй байдал” руу хандсан энэхүү шилжилт нь цэргийн явцуу хүрээнээс хальж, аюулгүй байдлын үзэл баримтлалын агуулгыг өргөжүүлэхтэй холбоотойгоор хэрэгжих ёстой. Аюулгүй байдлын асуудалд цэргийн бус бусад хүчин зүйлийг хамруулан цогц байдлаар хандах ёстой гэсэн ойлголт улам түгэж байна. (Тодруулга N°1).

Тодруулга N° 1

Аюулгүй байдалд учирч буй бусад аюул занал: дангаараа болон бүхэлдээ ...

- ▷ **Улс төрийн аюул занал:** дотоодын улс төрийн тогтворгүй байдал, засаглалын хямрал, терроризм, хүний эрхийн зөрчлүүд гэх мэт;
- ▷ **Эдийн засгийн аюул занал:** ядуурал, баян болон ядуу орнуудын ялгаа нэмэгдэх, олон улсын санхүүгийн хямрал, эдийн засгийн хувьд хүчирхэг эсвэл тогтворгүй хөрш орны нөлөө, далайн дээрэм гэх мэт;
- ▷ **Хүрээлэн буй орчны болон хүнээс үүдэлтэй аюул занал:** цөмийн гамшиг, дэлхийн экологийн өөрчлөлт, хөрс, усны доройтол, хүнсний болон бусад нөөцийн хомсдол гэх мэт;
- ▷ **Нийгмийн аюул занал:** үндэстний олонх\цөөнхийн зөрчилдөөн, хүн амын хэт өсөлт, зохион байгуулалттай гэмт хэрэг, хил дамнасан мансууруулах бодисын наймаа, хууль бус худалдаа, олныг хамарсан хяналтгүй цагаачлал, өвчний тархалт гэх мэт.

Аюулгүй байдлыг илүү өргөн хүрээтэй авч үзэхийн давуу тал нь аюулгүй байдалд учрах аюул занал, тэдгээрийн эсрэг хариу арга хэмжээний талаар илүү цогц ойлголттой болоход оршино. Харин үүний сул тал бол аюулгүй байдлыг сахин хангах байгууллагууд буюу төр, иргэнийг хамгаалахын тулд хуулийн дагуу хүч хэрэглэх, хүч хэрэглэхийг тушаах, хүч хэрэглэхээр завдах эрхтэй байгууллагууд цэргийн бус нийгмийн салбаруудад идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхлэхтэй зэрэгцэн хэт их эрх мэдэлтэй болох эрсдэл юм. Үүний зэрэгцээ, эдгээр шинэ сорилтод таарч тохирох хариу үйлдэл хийх мэдлэг туршлага аюулгүй байдлын салбарт дутагдаж болох юм.

Нэг улсын аюулгүй байдлаас улс хоорондын аюулгүй байдлын хамтын ажиллагаа руу

Аливаа улс орон аюулгүй байдлаа өөрийн хүчинд дулдуйдан дангаараа хангах боломжгүй бөгөөд үүнд улс хоорондын аюулгүй байдлын хамтын ажиллагаа шаардлагатай тухай үзэл санаа эрт дээр үеэс улбаатай. Арван есдүгээр зуунд “хүчний тэнцвэр”-ийн тухай үзэл баримтлал давамгайлж байлаа. Харин 20 дугаар зуунд Үндэстнүүдийн лиг, түүнээс улбаатай Нэгдсэн Үндэстний Байгууллага зэрэг аюулгүй байдлын хамтарсан бүтцээс гадна НАТО гэх мэт батлан хамгаалахын чиглэлээрх хамтарсан байгууллагууд бий болов.

Хүйтэн дайны төгсгөлөөс хойш дотоод зөрчил, хямрал газар авсан. Мөн саяхнаас терроризмын асуудал олон нийтийн анхаарлын төвд байх боллоо. Даяарчлал нь аюулгүй байдлын салбарыг оролцуулан, улс хоорондын харилцан хамаарлыг нэмэгдүүлж байна. Өнөөдөр нэг улс орны аюулгүй байдалд учирсан аюул занал тухайн улсын хил хязгаараас хялбархан хальж, бүс нутаг, тэр ч байтугай олон улсын амар тайван байдлыг алдагдуулж болзошгүй болжээ. Энэхүү шинэ бодит байдал нь аюулгүй байдлын агуулгын цар хүрээ өргөсч буйтай зэрэгцэн олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагааны хэрэгцээ шаардлагыг улам бүр өсгөж байна.

Тодруулга № 2

Аюулгүй байдлын асуудлаарх төрөл бүрийн хэлшлүүд

▷ Хамтын батлан хамгаалал

Хамтын батлан хамгаалал гэж хоёр буюу түүнээс дээш тооны орнууд гадны халдлагад өртсөн тохиолдолд харилцан туслалцахаар тохирсон гэрээг хэлдэг. НАТО болон Америкийн орнуудын байгууллага нь аюулгүй байдлын энэ төрлийн хэлцлийн хамгийн тод жишээ болно.

▷ Хамтын аюулгүй байдал

Энэ тогтолцоо нь хамтын нийгэмлэгийн улс орнууд хүч хэрэглэхээс татгалзан, гишүүн орнуудын нэгнийх нь эсрэг хүч хэрэглэсэн тохиолдолд

туслалцаа үзүүлэх тохиролцоо юм. Өөрөөр хэлбэл, энэ систем нь олон улсын энх тайванд заналхийлсэн аливаа үйлдэлд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүч хэрэглэсэн хариу үйлдэл үзүүлнэ гэсэн үг юм. Хамтын аюулгүй байдлын хэлцэл нь оролцогч талуудын дотроос гарсан дайралтын эсрэг чиглэгдээрээ хамтын батлан хамгааллаас ялгаатай. Ийм хэлцлийн хамгийн том жишээ гэвэл Нэгдсэн Үндэстний Байгууллага мөн. НҮБ-ын дүрмийн 41, 42 дугаар зүйлд зааснаар энх тайвныг бусниулагч этгээдэд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс цэргийн болон цэргийн бус аргаар нөлөөлөх, дарамт үзүүлэх эрхтэй байдаг.

Эх үүсвэр: Бруно Симма: Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, 1995

▷ Хамтарсан аюулгүй байдал

Хамтарсан аюулгүй байдал нь хамтын аюулгүй байдлыг аюулгүй байдлын цогц хандлагатай холбож өгдөг. Өөрөөр хэлбэл, энэ нь “аюулгүй байдлын олон чиглэлийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд айлган сүрдүүлэлтээс илүү аюулгүй байдлыг баталгаажуулах, хязгаарлагдмал бус хүртээмжтэй, гишүүнчлэл нээлттэй, хоёр талын бус олон талт оролцоонд тулгуурласан, цэргийн арга хэрэгслийг бусад арга хэрэгслээс дээгүүрт тавьдаггүй, аюулгүй байдлын тогтолцооны гол тоглогч нь төр улс байх гэхдээ бусад оролцогчдын хувь нэмэр мөн адил чухал гэдгийг хүлээн зөвшөөрсөн, аюулгүй байдлын албан ёсны тогтолцоог чухалчилдаггүй ч хүлээн зөвшөөрдөг, түүнчлэн хамгийн гол нь олон талт харилцаан дээр суурилсан “яриа хэлцлийн заншил”-ыг чухалчилдаг болно.

Эх үүсвэр: ЭВАНС Гарет: Энх тайвны төлөө хамтран ажиллах нь, 1993

“Хамтарсан аюулгүй байдлын” хэлцэл нь хамтын ажиллагааны хамгийн хэтийн төлөв бүхий хэлбэрийн нэг мөн. Түүнчлэн албан ёсны эсвэл цэргийн байгууллагагүй, хоёр талын болон олон талт гэрээ хэлцлийн сүлжээн дээр суурилсан аюулгүй байдлын хамтын ажиллагааны арай сул зохион байгуулалттай механизмууд мөн бий.

Аюулгүй байдлын хамтын ажиллагааны аливаа хэлцэл, нэн ялангуяа батлан хамгаалах хамтын ажиллагааны байгууллагад нэгдэн орох шийдвэр тухайн улсын аюулгүй байдлын орчин нөхцөлд хүчтэй нөлөө үзүүлэх нь ойлгомжтой. Зарчмын хувьд ийм хамтын ажиллагаа нь аюул заналын эсрэг хамтын “нударгыг” бий болгодог учир үндэсний аюулгүй байдлыг бататгахад чухал юм. Гэхдээ хамтын ажиллагааны байгууллагын гишүүнчлэлийн төлөө тодорхой үнэ цэнэ төлөх ёстой. Тухайлбал, тухайн улс орон эвслийн зорилго, шаардлагыг дагаж мөрдөх үүрэг хүлээх бөгөөд ингэснээрээ өөрийн аюулгүй байдлын бодлогыг толгой мэдэн тодорхойлох боломж нь хязгаарлагдана. Түүгээр ч үл барам, шийдвэр гаргах үйл явц зарим талаар үндэсний цар хүрээнээс хальж, олон улсын талбарт шилжих тул үндэсний парламентын зүгээс тавих хяналтад нөлөөлдөг байна.

Бүлэг 2

Парламентын хяналтын ач холбогдол

Гүйцэтгэх засагт аюулгүй байдлын бодлого боловсруулахад шаардлагатай мэдлэг, түргэн шуурхай ажиллах боломж байдаг тул энэ нь тэдний зүй ёсны ажил үүрэг мөн. Харин парламентын үйл ажиллагаа их хугацаа зарцуулдаг, шаардлагатай мэдээлэл, ойлголт хомс учир аюулгүй байдлын асуудлуудыг хариуцахад тохиромж багатай гэж үзэх нь олонтаа. Гэсэн хэдий ч бүхий л салбарын нэгэн адил аюулгүй байдлын салбарт ч засгийн газрыг хянах эрхийг парламент эдэлдэг. Парламентын хяналт яагаад ийм чухал болохыг нотлох дор хаяж дараах дөрвөн үндэслэл бий:

Дарангуйллаас сэргийлэх нь ардчиллын тулгын чулуу

Францын Ерөнхий сайд асан Жорж Клемансо нэгэнтээ “Дайныг зөвхөн цэргийнхний мэдэлд үлдээхэд дэндүү чухалдана” гэж хэлсэн нь бий. Эл ёжтой үгний цаана, ардчилсан нийгэмд ард түмний төлөөлөл төрийн дээд эрхийг эдлэх агаад аль ч салбар тэдний хараа хяналтаас гадуур орших ёсгүй гэсэн санаа оршино. Аюулгүй байдлын салбар, тэр дундаа цэргийн асуудлаар парламентын хяналт тогтоогоогүй улсыг сайндаа л бүрэн бус ардчилал, эсвэл бүрэлдэн тогтож буй ардчилал гэвээс зохилтой.

“Улс төрд хамгийн язгуур, амин чухал асуудал бол дарангуйллаас зайлсхийх явдал юм” гэж америкийн нэрт судлаач Роберт А.Даль хэлжээ. Аюулгүй байдлыг хангах нь төрийн язгуур үүрэг зорилтуудын нэг. Үүнээс үүдэн гүйцэтгэх засгийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх хараа хяналт, шалгалтын механизм зайлшгүй хэрэгтэй. Тийм ч учир аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт нь төрийн түвшин дэх эрх мэдлийн хуваарилалтын нэг чухал элемент бөгөөд үүнийг үр дүнтэй хэрэгжүүлсэн тохиолдолд засгийн газар эсвэл ерөнхийлөгчийн эрх мэдэлд зохистой хязгаарлалтыг тогтоож өгнө.

Төлөөллийн оролцоогүй татвар ноогдуулалт гэж үгүй

Парламентаас гүйцэтгэх засгийг хянах хамгийн чухал арга хэрэгсэл бол төсөв. Баруун Европт анх үүссэн цагаасаа эхлээд парламентууд бодлогын түвшинд оролцох эрхээ шаардсаар ирсэн бөгөөд ингэхдээ “Ард түмний төлөөллийн оролцоогүй татвар ноогдуулалт гэж үгүй” гэсэн зарчим дээр хатуу зогсож байв. Улсын төсвийн үлэмж хэсгийг аюулгүй байдлын салбарт зарцуулдаг тул улс

орны хомсхон нөөц хөрөнгийг оновчтой, үр дүнтэй зарцуулж байгаа эсэхэд парламентын зүгээс хяналт тавих нь нэн чухал.

Аюулгүй байдлын асуудлын хууль эрх зүйн цар хүрээг тодорхойлох

Бодит амьдрал дээр аюулгүй байдлын асуудлаарх хуулийн төслийг засгийн газар боловсруулдаг. Гэхдээ парламентын гишүүд тэрхүү төслийг хянан засварлахад чухал үүрэгтэй оролцдог бөгөөд шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын шинэ сэтгэлгээ, үзэл баримтлалыг зохистойгоор тусгасан заалтуудыг баталгаажуулсан нэмэлт өөрчлөлтүүдийг санал болгодог. Түүнээс гадна батлагдсан хууль тогтоомж зөвхөн цаас төдий үлдэх бус харин амьдрал дээр бүрэн хэрэгжихэд парламентын үүрэг оролцоо маш чухал.

Ард түмэнтэй холбох гүүр

Ард иргэдийн хувьд тэргүүлэх ач холбогдолтой аюулгүй байдлын бүх асуудлыг гүйцэтгэх засаг бүрэн дүүрэн мэдэхгүй байж болно. Харин парламентын гишүүд иргэдтэй байнгын харилцаа холбоотой байдгийн хувьд тэдний санаа бодлыг илүү ойлгож мэдрэх боломжтой. Өөрөөр хэлбэл, парламентын гишүүд иргэдийн санал, зовнилыг парламентын танхимд хэлэлцэж, аюулгүй байдлын бодлого, хууль тогтоомжуудад тусгах арга замыг эрэлхийлдэг.

Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтад тулгарах сорилтууд

Аюулгүй байдлын салбартай холбоотой дараах гурван асуудал парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд бодитоор хүндрэл учруулдаг байна. Үүнд:

- ✓ Нууцын тухай хууль тогтоомж нь аюулгүй байдлын салбарын ил тод байдлыг хангахад бэрхшээл учруулж болзошгүй. Нэн ялангуяа, шинэ залуу ардчилсан орнууд болон зэвсэгт мөргөлдөөн, дайны байдалд байгаа орнуудын хувьд нууцын тухай болон мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан хууль тогтоомж байхгүй байх нь парламентын хяналтын хэрэгжилтийг хязгаарлаж, тэр ч атугай алдагдуулах магадлалтай.
- ✓ Аюулгүй байдлын салбар олон талтай бөгөөд үүний дотор зэвсэг техникийн худалдан авалт, зэвсэглэлийн хяналт, цэргийн анги нэгжийн бэлэн байдал зэрэг асуудлыг парламент хянах учиртай. Энэ талаар үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад хангалттай ойлголт, мэдлэг парламентын гишүүдэд тэр болгон байдаггүй. Цаашилбал, парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь хязгаарлагдмал бөгөөд дотоод, гадаадын мэргэжлийн хүмүүст

хандах бололцоо дутагдсанаас шаардлагатай мэдлэг чадавхыг бүрдүүлэх хугацаа, боломж тэдэнд байгаагүй байж ч болно.

- ✓ Тухайн улс орон олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагааг голчилж, харин парламент нь уг үйл явцаас гадуур үлдсэн бол энэ нь тухайн орны аюулгүй байдлын бодлогын ил тод, ардчилсан эрх зүйт байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Тиймээс тухайн орны парламент олон улсын түвшин дэх яриа хэлцэл, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэгтэй байж, түүнд оролцож, санал бодлоо илэрхийлэх боломжтой байх нь маш чухал.

Парламент болон төрийн бусад институцийн үүрэг хариуцлага

Хамтын үүрэг хариуцлага

Парламент болон засгийн газрын аюулгүй байдлын асуудлаарх чиг үүрэг харилцан адилгүй хэдий ч, аюулгүй байдлын салбарын үр дүнтэй ажиллагааг хангах үүргийг хамтран хүлээдэг. Хамтын үүрэг хариуцлагын зарчим улс төрийн болон цэргийн удирдлагад мөн адил хамаатай. Өөрөөр хэлбэл, энэ хоёр тал нь өөр өөр зорилготой сэргөлдөгч талууд бус харин эсрэгээр үр нөлөө бүхий цогц, хүн-төвтэй аюулгүй байдлын салбарын бодлогыг цогцлооход харилцан бие биендээ хэрэгтэй хамтрагчид юм. Тиймээс ардчилсан хяналтыг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн шийдвэр гаргагчид болон цэргийн өндөр түвшний албан тушаалтнуудын харилцаа нь итгэлцэл, нээлттэй холбоо, бие биенээ хүлээн зөвшөөрч хүндэтгэх зарчим дээр тулгуурласан байх ёстой. Байнгын ийм яриа хэлцлийн давуу тал нь улс төрийн болон цэргийн удирдлагын хооронд үл ойлголцол үүсэхээс зайлсхийх, тогтвортой байдлыг бүрдүүлэхэд оршино.

Чиг үүргийн хуваарилалт

Засаглалын гурван салбар болох гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх институциуд нь үндэсний аюулгүй байдлын бодлогод чухал үүрэг гүйцэтгэдэг. Тодруулга №3-т эдгээр чиг үүргийг тодорхойлохыг оролдсон бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийн 3 оролцогч болох төрийн тэргүүн, засгийн газар, жанжин штаб тус бүрийн гүйцэтгэх үүргийг мөн нарийвчлан оруулсан болно. Орон орны улс төрийн тогтолцоо өөр учир энэ хүснэгтэд гүйцэтгэж болох чиг үүргүүдийг зөвхөн нийтлэг, ерөнхий байдлаар харуулахыг зорьсон бөгөөд бүх улс орны нөхцөл байдлыг бүрэн хэмжээнд илэрхийлэх боломжгүй юм.

Парламентаас гадна шүүх болон гүйцэтгэх засаг, иргэний нийгмийн байгууллагууд аюулгүй байдлын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал албан бус үүрэг гүйцэтгэдэг. Харин хэвлэл мэдээллийн байгууллагууд төрийн бүхий л тоглогчдын зорилго, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх хэлбэрээр оролцдог байна. (Бүлэг 6-г үз).

Эцэст нь, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий хоёр чухал оролцогч байдаг нь Омбудсмэн (Бүлэг 16-г үз) болон Ерөнхий аудитор (Бүлэг 24-ийг үз) юм.

Улс төрийн хариуцлага

Аюулгүй байдлын албад нь төрийн эрх мэдлийн салаа бүрийн өмнө хариуцлага хүлээнэ. Үүнд:

- ✓ **Гүйцэтгэх засаг** нь төв, бүс нутгийн болон орон нутгийн түвшний удирдлагаар дамжуулан аюулгүй байдлыг хангах байгууллагуудын үйл ажиллагаанд шууд хяналт тавих ба төсөв, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, баримтлах зарчмуудыг тодорхойлдог.
- ✓ **Хууль тогтоох байгууллага** нь аюулгүй байдлын албадын эрх үүргийг зааж, тэдний үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж батлах, мөн төсөв хуваарилах, батлах замаар парламентын хяналтыг хэрэгжүүлдэг. Түүнчлэн, парламентын хяналтын үйл ажиллагааны хүрээнд олон нийтээс гаргасан санал, гомдлын мөрөөр хяналт шалгалт хийх зорилго бүхий парламентын омбудсмэн болон хороо байгуулан ажиллаж болно.
- ✓ **Шүүх байгууллага** нь аюулгүй байдлын салбарт хяналт тавихын зэрэгцээ аюулгүй байдлын салбарт ажиллагсдын гэм буруутай үйлдлийг иргэний болон эрүүгийн журмаар шүүн таслах үүргийг хүлээдэг.

Тодруулга № 3

Төрийн үндсэн байгууллагуудын аюулгүй байдлын салбартай холбогдуулан гүйцэтгэж болох үүргүүд

	Парламент	Шүүх байгууллага	Гүйцэтгэх засаг		
			Төрийн тэргүүн	Засгийн газар	Жанжин штабын дарга
Ерөнхий командлагч	Зарим оронд парламент нь Ерөнхий командлагчийн томилгоог хэлэлцэх/эсвэл томилох эрхтэй байна.	Үндсэн хуулийн цэц нь Ерөнхийлөгч эсвэл Засгийн газар Ерөнхий командлагчийн үүрэг гүйцэтгэх нь үндсэн хуульд нийцж буй эсэхийг хянадаг.	Зарим оронд төрийн тэргүүн нь бэлэг тэмдгийн шинжтэй байдаг бол бусад орны хувьд дайны байдалд Ерөнхий командлагчийн үүрэг гүйцэтгэх зэрэг бодит эрх мэдэл эдэлдэг.	Дайны байдалд Засгийн газар нь Ерөнхий командлагчийн үүрэг гүйцэтгэдэг.	Зарим оронд цэргийн ерөнхий командлагч гэсэн албан тушаал зөвхөн дайны байдалд л хэрэглэгддэг бол заримд нь байнгынх байдаг.
Аюулгүй байдлын бодлого	Аюулгүй байдлын үзэл баримтлал, хуулийг хэлэлцэж, баталдаг.	-	Аюулгүй байдлын хууль тогтоомжид гарын үсэг зурдаг.	Аюулгүй байдлын бодлогыг санал болгож, хэрэгжүүлдэг.	Засгийн газарт зөвлөж, аюулгүй байдлын бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд тусалдаг.

Төсөв	Төсөв баталдаг.		-	Төсөв өргөн мэдүүлдэг.	Засгийн газарт зөвлөдөг.
Батлан хамгаалахын хууль тогтоомж	Хууль баталдаг.	Үндсэн хуулийн цэц хууль тогтоомжийн Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар тайлбар гаргадаг.	Хуулийг олон нийтэд зарлан тунхагладаг.	Хуулийн төсөл өргөн барьж, дагалдах дүрэм журмыг боловсруулан баталдаг.	Засгийн газарт зөвлөгөө өгдөг; хуулийг хэрэгжүүлдэг.
Бие бүрэлдэхүүн	Зарим оронд парламент нь өндөр түвшний томилгоог хийдэг.	Тэдний зан төлөв, үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шүүдэг.	Гол командлагчдыг томилдог; бие бүрэлдэхүүний төлөвлөгөөг баталдаг.	Гол командлагчдыг томилдог.	Бие бүрэлдэхүүний төлөвлөгөөний талаар зөвлөгөө өгдөг; хэрэгжүүлдэг. Доогуур түвшний командлагчдыг томилдог.
Ханган нийлүүлэлт	Зэвсэг техникийн худалдан авалтын гол гэрээг хянах ба/буюу батлах.	Авилга, залилан мэхлэлтийн талаарх хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг шүүдэг.	-	Зэвсэг техникийн худалдан авалт санал болгодог	Зэвсэг техникийн худалдан авалтын ажиллагааг санаачилж, хэрэгжүүлнэ.
Гадаадад цэргийн хүч илгээх / Гадны цэргийн хүч нэвтрүүлэх	Ажиллагааны өмнөх болон дараах зөвшөөрөл олгох, эсвэл огт зөвшөөрөл олгодоггүй байх.	Тэдний зан төлөв, үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шүүдэг.	-	Олон улсын ажиллагаанд оролцох эсэх талаар хэлэлцээ хийж, үйл ажиллагааны дүрэм журмыг боловсруулах.	Операцийн түвшний удирдлагаар хангадаг.
Олон улсын гэрээ хэлцэл, эвсэлд нэгдэх	Зөвшөөрөл олгох.		Олон улсын гэрээг эцэслэх, соёрхон батлах.	Олон улсын хэлэлцээр хийх үүрэгтэй.	Засгийн газарт зөвлөгөө өгдөг.

Өмнө дурдсанчлан, төрийн эрх мэдлийн энэхүү 3 салбарын хүлээх үүрэг хариуцлага орон бүрт харилцан адилгүй байж болно. Гэхдээ аюулгүй байдлын салбарыг улс төрийн хүчирхийллийн зорилгоор ашиглахаас сэргийлсэн байнгын хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлсэн эрх мэдлийн тэнцвэртэй хуваарилалт үргэлж байх шаардлагатай. Олон оронд аюулгүй байдлын салбарын удирдлагыг засгийн газар голлон хэрэгжүүлдэг гэдгийг харгалзан үзэх аваас, үр дүнтэй хяналт тавих эрх мэдэл, бололцоо парламентад байх нь нэн чухал юм. Нэн ялангуяа, аюулгүй байдлын шинэ сорилтууд (Бүлэг 1-ийг үз)-ын улмаас төрийн байгууллагууд чиг үүргээ шинээр томъёолох шаардлага урган гарч буй өнөө үед энэ нь онцгой ач холбогдолтой болж байна.

Ардчилсан парламентын хяналтын зарчмууд

Аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудал улс үндэсний бүрэн эрхт байдалд хамаардаг тул ардчилсан парламентын хяналтын олон улсын стандарт гэж байхгүй. Харин бүс нутгийн хэмжээнд ЕАБХАБ-аас гаргасан Ёс зүйн дүрэм зэрэг зарим стандарт (дэлгэрэнгүйг Тодруулга N°66-аас үз) байдгийн зэрэгцээ иргэн-цэргийн ардчилсан харилцааны тодорхой зарчмууд бий. Үүнд:

- ✓ Хүч хэрэглэх хууль ёсны монополь эрхийг зөвхөн төр эдлэх бөгөөд аюулгүй байдлын албад нь эрх барих хууль ёсны, ардчилсан байгууллагуудын өмнө хариуцлага хүлээнэ;
- ✓ Парламент нь бүрэн эрхт байгууллага бөгөөд аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх чиглэлээр засгийн газраас явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавина;
- ✓ Парламент нь аюулгүй байдал, батлан хамгаалахын зардлыг батлах, хянах өвөрмөц эрхийг Үндсэн хуулийн дагуу эдэлдэг;
- ✓ Парламент нь онц болон дайны байдал зарлах, цуцлахад онц чухал үүрэг гүйцэтгэдэг (Бүлэг 18-ыг үз).
- ✓ Сайн засаглал, хуульд захирагдах ёсны зарчмууд (Тодруулга N°4-ийг үз) нь засгийн газрын бүх салбарт хамаатай бөгөөд үүнд аюулгүй байдлын салбар ч мөн багтана;
- ✓ Дотоодын болон олон улсын хууль тогтоомжийг зөрчсөн аюулгүй байдлын салбарын ажилтан шүүхийн өмнө хариуцлага хүлээнэ (иргэний болон эрүүгийн зөрчил);
- ✓ Аюулгүй байдлын албад нь улс төрийн хувьд төвийг сахисан байна

Тодруулга N° 4

Сайн засаглал аюулгүй байдлын салбарт тавих ардчилсан хяналтын чухал хэсэг болох нь

“Сайн засаглалын үндсэн шинж нь урьдчилан таамаглах боломжтой, нээлттэй, мэдлэг мэдээлэл дээр тулгуурласан улс төрийн бодлого, төрийн албан хаагчдын нийтийн сайн сайхны төлөөх мэргэжлийн ёс зүй, хуулийн засаглал, ил тод байдал, бүх нийтийн үйл хэрэг дэх иргэний нийгмийн идэвхтэй оролцоо зэргээр илэрдэг. Харин муу засаглалын шинжүүд нь эсрэгээр эргэлзээтэй бодлого, хариуцлагагүй албан тушаалтан, шударга бус эсвэл хэрэгждэггүй хуулийн тогтолцоо, гүйцэтгэх эрх мэдлийг урвуулан ашиглах, иргэний нийгмийн идэвхгүй байдал, авлига хээл хахууль өргөн тархсан байх зэрэг болно. “

Эх үүсвэр: Дэлхийн банк. 1994. Засаглал: Дэлхийн банкны туршлагаас Вашингтон

Хоёрдугаар хэсэг

Үндэсний аюулгүй байдлын бодлогод тавих хяналт

Үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулах нь

Бүрэлдэхүүн хэсгүүд

Үндэсний аюулгүй байдлын бодлого нь аюулгүй байдалд хандах засгийн газрын хандлага, зорьж буй аюулгүй байдалд хэрхэн хүрэх арга замыг тодорхойлдог. Түүнчлэн, үндэсний аюулгүй байдлын бодлогын дагуу тус улсын гадаад, дотоод аюулгүй байдлын орчинд нөлөөлөх гол шийдвэрүүдийг гаргадаг байна. Тус бодлого нь аюулгүй байдалд хандах тодорхой хандлагад тулгуурлахын зэрэгцээ цэргийн номлолын үндсэн чиглэлийг зааж, тухайн улсын элссэн бүс нутгийн болон олон улсын түвшний зохицуулалтын хүрээнд боловсруулагдсан байдаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн тухайн улсын үндэсний аюулгүй байдлын хэрэгцээ шаардлага, тэргүүлэх чиглэлүүдэд тулгуурлах төдийгүй, олон төрлийн гадаад хүчин зүйлс, дарамт шахалт, үүрэг амлалтаас хамаардаг гэсэн үг. Ямар ч тохиолдолд, үндэсний аюулгүй байдлын бодлого нь тухайн улсын өөрийн Үндсэн хууль, суурь тунхаглалд заасан зарчмуудыг хангах ёстой.

Тодруулга №5

Үндэсний аюулгүй байдлын бодлогын талаарх асуултууд

Үндэсний аюулгүй байдлын бодлогын баримт бичгийг батлах буюу түүний талаар мэтгэлцэх, эсвэл зарим тодорхой нөхцөл дэх тэдний хэрэгжилтийн талаар хэлэлцэх үед ард түмний төлөөлөл дараах асуултад бүгдэд нь буюу нийтэд нь хариулт олохыг эрмэлзэх нь зүйтэй. Үүнд:

- ✓ Нийгмийг ямар төрлийн аюул занал, эрдслээс хамгаалах шаардлагатай вэ? Хэний, ямар үнэт зүйлсийг хамгаалах хэрэгтэй вэ? Эдгээрийг харгалзан үзвэл, ямар төрлийн аюулгүй байдал шаардлагатай вэ?
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлогод зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм зэрэг шинэ тутам тулгарч буй аюул заналыг үнэлэх үнэлгээ багтаж байна уу?
- ✓ Аюулгүй байдал ямар хэмжээнд хангагдахыг хангалттай гэж үзэх вэ?
- ✓ Үндэсний аюулгүй байдлыг ямар арга замаар хангах нь хамгийн тохиромжтой вэ: Эвсэлд нэгдэх үү? Төвийг сахисан байр сууриа хадгалах уу?
- ✓ Үндэсний аюулгүй байдлын албад чухам ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх магадлал илүү вэ? Зөвхөн батлан хамгаалах үйл ажиллагаа юу, эсвэл энхийг сахиулах ажиллагаанд мөн оролцох уу?

- ✓ Аюулгүй байдлын хүсэмжит түвшинд хүрэхийн тулд аль салбарууд ямар арга, замаар оролцох шаардлагатай вэ? Ямар хугацааны туршид, ямар нөхцлөөр үргэлжлэх вэ?
- ✓ Аюулгүй байдлын бодлогын үнэлгээг ямар давтамжтайгаар хийх ёстой вэ?
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлогыг хэрхэн олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомжтой нийцүүлэх вэ?
- ✓ Санхүү, эдийн засгийн ямар үр дагавар гарах хийгээд үүний ямар хэсгийг татвар төлөгчдөөс гаргахад бэлэн байна вэ?
- ✓ Аюулгүй байдлын бодлого, түүний хэрэгжилт нь гадаад харилцаа, бүс нутгийн тогтвортой байдалд ямар нөлөө үзүүлэх вэ?
- ✓ Бөөнөөр устгах зэвсгийн талаар баримталж буй өнөөгийн бодлого, хэтийн стратеги юу вэ?

Үндэсний аюулгүй байдлын хэрэгжилт төрийн олон байгууллага, бодлогын баримт бичгүүдийг хамрах нь зүй ёсны хэрэг. Тийм ч учир, аливаа улс аюулгүй байдлын бүхий л хэсэг, тоглогчдыг хамарсан үндэсний аюулгүй байдлын цогц бодлогыг боловсруулах нь чухал. Ингэснээр засгийн газар аюулгүй байдлын бүхий л асуудлуудыг бүрэн хэмжээнд, цогц байдлаар шийдэх боломжтой болдог юм. Нэн ялангуяа, терроризм, хил дамнасан гэмт хэрэг зэрэг шинэ тутам аюул заналтай тэмцэхэд цэрэг, сангийн яам, цагдаа, хил хамгаалах алба, тагнуулын алба зэрэг олон байгууллагын оролцоо хэрэгтэй тул нэгдмэл, цогц арга барил зайлшгүй шаардагддаг.

Парламентын оролцооны ач холбогдол

Энэ бүхнийг харгалзан үзэхийн зэрэгцээ, ард түмний ашиг сонирхолыг төлөөлөх парламентын үндсэн үүргийг санаваас чухам ямар учраас үндэсний аюулгүй байдлын бодлогыг боловсруулах, ил тод байдлаар батлахад парламент оролцох ёстой вэ гэдгийг харуулсан хэд хэдэн шалтгаан харагдана. Үүнд:

- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлого нь иргэдийн аж амьдрал, үнэт зүйлс, сайн сайханд нөлөөлдөг бөгөөд зөвхөн засгийн газар, эсвэл цэргийн байгууллагын мэдэлд үлдээх ёсгүй;
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлого нь цэргийн алба, түүний бие бүрэлдэхүүний хувьд чухал ач холбогдолтой;
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлого нь санхүүгийн том үр дагавартай, өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн мөнгөтэй холбоотой;

- ✓ Санхүүгийн зардлаас гадна, аюулгүй байдлын арга хэмжээ нь иргэдийн эрх, эрх чөлөөнд зарим хязгаарлалт тогтоох магадлалтай учир ардчиллын төлөвшил, хөгжилд ихээхэн нөлөөтэй.
- ✓ Ийм ч учир, эдгээр арга хэмжээ олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж, нэн ялангуяа Женевийн дөрвөн конвенц, дагалдах хоёр протокол болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт зэрэг хүний эрхийн хууль тогтоомжид нийцсэн эсэхэд парламент хяналт тавьж байх нь нэн чухал. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад зарим тодорхой эрхийг ямар ч нөхцөлд хязгаарлах, зөрчих ёсгүй гэсэн байдаг. Дэлгэрэнгүйг Бүлэг 18-20-иос харна уу.

Үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулах үе шат тутам дахь парламентын үүрэг

Парламентын хувьд үндэсний аюулгүй байдлын бодлогын мэтгэлцээн нь нэг удаа болоод өнгөрөх үйл явдал төдий бус, харин боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн бүх 4 үе шатын туршид үргэлжлэх үйл явц юм. Энэ бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх засгийн газрын үүрэг хариуцлагад хөндлөнгөөс оролцох хориотой ч энэ үйл явц аль болох ил тод, оролцоог хангасан байдлаар явагдаж, аюулгүй байдлын салбар өөрөө, мөн цэрэг-аж үйлдвэрлэлийн цогцолбор гэх зэрэг энэ үйл ажиллагаанд оролцож буй бүх талуудын хооронд тэнцвэр хангагдсан байх нь нэн чухал.

Тиймээс парламентын гишүүд дээрх бүх үе шатанд аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодол, зовнилыг засгийн газарт хүргэх аман болон бичгээрх асуулт, санал, асуулга, парламентын зарим хороодын сонсгол, “цагаан номууд”, яамд, агентлагуудад төлөөлөл томилон ажилуулах зэрэг арга хэрэгслүүдийг ашиглах чадвартай байх ёстой. (Аюулгүй байдлын салбартай холбоотойгоор ашиглагддаг парламентын арга хэрэгслийн талаар Бүлэг 14-өөс дэлгэрүүлж үз)

Боловсруулах

Парламентын засаглалын бүхий л төрлийн хувьд үндэсний аюулгүй байдлын шинэ бодлого боловсруулах үйл явц дахь парламентын оролцоо хязгаарлагдмал байдаг. Энэ ажил нь чухам энэ асуудлыг хариуцсан яам, агентлагт хамаарна. Гэхдээ, тэдний боловсруулж буй бодлого ард түмний хэрэгцээ шаардлага, хүсэл зоригийг тусгасан эсэхэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулахад парламент, түүний гишүүд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Онолын үүднээс үзвэл парламентын үүрэг оролцоо зөвхөн баримт бичгийн

төслийг батлах, эсвэл буцаах төдийгөөр хязгаарлагдах ёсгүй билээ. Тухайн баримт бичиг, эсвэл хуулийн төслийг боловсруулах үеэс эхлэн чиглэл хариуцсан парламентын хороо(д) оролцож, парламент дахь улс төрийн олон ургальч үзлийг тусгасан санал, зөвлөмжөөр хангаж байх ёстой. Ингэснээр, иргэдийн санал бодлыг төсөлд эртнээс тусгах төдийгүй, бодлогын баримт бичгийг өргөн барьсаны дараа парламентаар хэлэлцүүлэх үед илүү таатай уур амьсгал бүрдүүлэх, мэтгэлцээн өрнүүлэхэд тустай юм. Парламент дахь олонх, цөөнхийн хүчний харилцаанаас улс үндэсний нийтлэг эрх ашиг дээгүүр тавигдах ёстой бөгөөд ийм ч учир үндэсний аюулгүй байдлын баримт бичигт ардчилсан байр сууринаас хандахад саад учруулах ёсгүй. Тиймээс парламент өргөн барьсан төсөлд өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй байх нь зүйтэй.

Шийдвэр гаргах

Үндэсний аюулгүй байдлын бодлогын баримт бичгийг өргөн барьсанаар цаашид парламентын мэдэлд шилжиж, өөрөөр хэлбэл парламентын шууд хариуцсан ажил болдог. Тиймээс, парламентад төслийг нарийвчлан судлах цаг олгон, хөнгөн хуумгай шийдвэр гаргахаас татгалзах ёстой.

Засгийн газраас өргөн барьсан шинэ бодлого, баримт бичгийн төслийг парламент нэг бол хүлээн зөвшөөрч батлах, эсвэл татгалзаж, оронд нь өөрчлөлт оруулах, шинэ хувилбар санал болгох эрхтэй. Өмнө хэлсэнчлэн, парламент энэ шатанд идэвхтэй ажиллаж, нөлөөлөл үзүүлэх чадавхтай байхын зэрэгцээ баримт бичгийн төсөлд сэтгэл дундуур байгаа бол өөрчлөлт санал болгодог байх ёстой. Парламентын мэтгэлцээний болон шийдвэр гаргах үед хэлэлцэж болох гол асуултуудыг өмнө дурдсан билээ.

Энэ үе шат дахь парламентын хамгийн чухал нөлөөлөл нь төсвийн хуваарилалтаар дамжин хэрэгждэг. (Санхүүгийн эх үүсвэрийн талаарх Зургаадугаар хэсгээс дэлгэрүүлж үз). Нэн ялангуяа, энэ асуудлыг хариуцсан парламентын хороогоор аюулгүй байдлыг хангахтай холбоотой төсвийг тусгайлан хэлэлцүүлж, хэсэг зүйл бүрээр нь болон аюулгүй байдлын салбарын хэмжээнд бүхэлд нь авч үзэж чадсан тохиолдолд парламентын үзүүлэх нөлөө огцом нэмэгдэх юм. Батлан хамгаалах салбарын төлөвлөгөөг парламентад хугацаанд нь өргөн барьж хянуулахын зэрэгцээ төсвийн хэрэгцээ шаардлагатай нягт уялдуулсан байх ёстой.

Түүнчлэн, батлагдсан бодлогыг олон нийтээр дэмжүүлэх, эрх зүйн байдлыг баталгаажуулахад парламент чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Тиймээс аюулгүй байдлын асуудлаарх парламентын мэтгэлцээнийг ил тод байдлаар өрнүүлж, олон нийт, хэвлэл мэдээллийн оролцоог хангах нь чухал ач холбогдолтой.

Хэрэгжилт

Үндэсний аюулгүй байдалтай холбоотой парламентын үүрэг хариуцлага зөвхөн бодлогын баримт бичиг баталж, төсөв тогтоох төдийгөөр хязгаарлагдалгүй, хяналт, аудитын чиг үүргээ тогтмол, идэвхтэйгээр хэрэгжүүлэх ёстой. Хэрэгжилтийн шатанд парламент засгийн газрын үйл ажиллагааг өөрийн мэдэлд буй бүхий л арга хэрэгслээр дамжуулж (Бүлэг 14-өөс дэлгэрүүлж үз) болон хөндлөнгийн хяналтын бусад байгууллагуудын (үндэсний аудитын алба г.м; Бүлэг 24-өөс дэлгэрүүлж үз) тусламжтайгаар хянах ёстой. Нэн ялангуяа, холбогдох төсвийн хуваарилалтаар дамжуулан парламент өөрийн нөлөөллийг хэрэгжүүлэх боломжтой юм. Үүний зэрэгцээ, хуулийн хэрэгжилт болон хуулийг сахин мөрдөж буй байдалд аудит хийх аудитын байгууллагын мэргэжлийн болон техникийн ур чадварыг парламент хянаж байх ёстой.

Томоохон өөрчлөлт, хямралын үед засгийн газраас явуулах үйл ажиллагааг парламент баталгаажуулах ёстой. Жишээ нь: хилийн чанадад цэрэг илгээх (Бүлэг 22-ыг үз) эсвэл онц байдал зарлах (Бүлэг 18-ыг үз). Үүний зэрэгцээ, засгийн газар ноцтой алдаа гаргасан тохиолдолд парламентын оролцоо нэн чухал. Ийм тохиолдолд парламент асуулга тавих, онц ноцтой нөхцөл байдал үүссэн үед тусгай асуулга явуулахыг шаардах эрхтэй байдаг.

Үнэлгээ, хуримтлуулсан туршлага

Ардчилсан оронд засгийн газар өөрийн бодлогын ач холбогдол, зохист байдлыг үнэлж, тэр үнэлгээнийхээ үр дүнг тоон болон чанарын үзүүлэлтээр парламентад танилцуулах үүрэгтэй байдаг. Парламентын хувьд, ийм үнэлгээ нь холбогдох төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтэд хийсэн аудит зайлшгүй багтаасан байх ёстой. Уг үнэлгээ цаг хугацааны хувьд хоцорсон байлаа ч түүний үр дүнг хэрэгжиж буй бодлогыг дахин нягтлах эсвэл шинэ бодлого боловсруулахад харгалзан үзэх боломжтой. Уян хатан иргэний нийгмийн тогтолцоотой улс орнуудад ТББ-ууд өөрсдийн үнэлгээг хийх боломжтой байдаг. Жишээлбэл, энхийг сахиулах ажиллагаа, өндөр өртөгтэй үндсэн зэвсэг худалдан авах, батлан хамгаалах яамны бие бүрэлдэхүүний (нэн ялангуяа хугацаат цэргийн) бүтэц, зохион байгуулалт зэргийг дурдаж болно. Түүнчлэн, парламент нь гүйцэтгэлийн тусгай аудит хийлгэх зорилгоор зөвлөхүүд авч ажиллуулах боломжтой.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Аюулгүй байдлын бодлого

- ▷ Үндэсний аюулгүй байдлын бодлого, оперативын номлол, батлан хамгаалах төлөвлөгөө, төсвийн хэрэгцээ зэрэг нь хоорондоо логик уялдаа холбоотой байхад анхаарах.
- ▷ Боломжтой бол – нэн ялангуяа, ижил төстэй нөхцөл байдал бүхий бусад улсын бодлоготой харьцуулж үзсэний дараа – өөрийн орны аюулгүй байдлын бодлого тухайн салбарт гарсан шинэ өөрчлөлтүүдтэй хэрхэн нийцэж байгаа болон шинэчлэх шаардлага бий эсэх талаар парламентын түвшинд асуудал дэвшүүлэх: “Аюулгүй байдлын хувьсан өөрчлөгдөж буй бодлого ба тоглогчид” гэсэн Нэгдүгээр хэсгээс үз.
- ▷ Парламент үндэсний аюулгүй байдлын бодлогыг боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг хуульчилж, энэ 4 үе шатад парламентын гүйцэтгэх үүргийг тодорхойлох ёстой.

Холбогдох асуудлууд

- ▷ Үндэсний аюулгүй байдлын бодлогыг тодорхойлох эсвэл дахин тодотгох явцад “Үндэсний аюулгүй байдлын талаарх асуултууд” гэсэн Тодруулга N°5-д заасан ихэнх асуултыг хэлэлцэн шийдвэрлэсэн байхад анхаарах.

Бүлэг 5

Үндэсний аюулгүй байдлын бодлого болон олон улсын эрх зүйн зохицуулалтууд

Олон улсын зарчмууд

Олон улсын гэрээ хэлцлүүд үндэсний аюулгүй байдлын бодлого тодорхойлох боломжийг зарим талаар хязгаарлаж эсвэл түлхэц өгдөг. Дийлэнх улс НҮБ-ын гишүүн бөгөөд НҮБ-ын дүрмийн 2.3, 2.4 дүгээр зүйлийг сахин мөрдөх үүрэг хүлээнэ. Үүнд:

“Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн нь улс хоорондын маргаанаа олон улсын энх тайван, аюулгүй байдал, шударга ёсонд хор хүргэхгүйгээр эв зүйгээр шийдвэрлэж байна.”

“Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн нь олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний зорилгод харшлах ямарваа бусад үйлдлийг цээрлэнэ.”

Үүний дээр, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, хэвшсэн уламжлалт зарчмууд зохицуулалтын үүрэг гүйцэтгэдэг. Улс хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай холбоотойгоор 1970 онд Ерөнхий ассамблейгаас гаргасан 2625 дугаар Тунхаг (XXV)-ийг НҮБ-ын дүрмийн жинхэнэ тайлбарт тооцдог бөгөөд НҮБ-ын бүх гишүүн орон сахин мөрдөх үүрэг хүлээнэ. Уг Тунхагт адил тэгш үнэт зүйлсийн тухай үл хуваагдах найман зарчмыг тодорхойлсон байдаг. Үүнд:

Зарчим I: Заналхийлэх, хүч хэрэглэхээс зайлсхийх.

Зарчим II: Олон улсын маргааныг эв зүйгээр шийдэх.

Зарчим III: Улс орны хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх.

Зарчим IV: Ард түмэн өөрөө сонголт хийн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, баталгаажсан хил хязгаарын доторх өөрийн нутаг дэвсгэр дээр энх тайвнаар амьдрах эрх.

Зарчим V: Улс орнуудын бүрэн эрхт байдал адил тэгш бөгөөд бусдын дотоод хэрэгт үл оролцох.

Зарчим VI: Хүний эрхийг дээдлэх.

Зарчим VII: Улс хоорондын хамтын ажиллагаа.

Зарчим VIII: Олон улсын хуулийн дагуу хүлээсэн үүргээ чанд сахин мөрдөх.

Аюулгүй байдал, батлан хамгаалахын олон талт гэрээ

Аюулгүй байдлын асуудлаар төрөл бүрийн олон талт гэрээ бий. Тэдгээрийн гол төрлүүдийг дурдвал (энэ нь бүрэн бус жагсаалт бөгөөд зөвхөн гэрээний төрөл тус бүрээс зарим жишээг авч үзсэн болно):

Дэлхий нийтийн аюулгүй байдлыг зохицуулж буй гэрээ: Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм

Олон улсын болон олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулдаг олон улсын хүмүүнлэгийн хуулийн олон улсын гэрээ: Женевийн дөрвөн конвенц (1949) хийгээд тэдгээрийн нэмэлт хоёр протокол (1977).

Төрөл бүрийн зэвсэглэл, тэдгээрийн дэглэмтэй холбоотой олон улсын гэрээ: Баллистик пуужингийн довтолгооноос хамгаалах гэрээ, Стратегийн зэвсэглэлийг хорогдуулах гэрээ, Газрын минын тухай конвенц, Тлателолокийн гэрээ г.м.

Аюулгүй байдлын асуудалтай зарим талаар холбоо бүхий бүс нутгийн байгууллага үүсгэн байгуулах тухай олон улсын гэрээнүүд: Америкийн орнуудын байгууллагын дүрэм, Европын холбооны гэрээ, ЕАБХАК-ын Сүүлчийн акт – ЕАБХАК/ ЕАБХАБ, Африкийн холбооны Үүсгэн байгуулах гэрээ.

Бүс нутгийн цэргийн хамтын ажиллагаа болон батлан хамгаалах салбарт харилцан туслалцаа үзүүлэх хэлцэл: НАТО-ын гэрээ, Энхийн төлөөх түншлэлийн гэрээ, Баруун Европын холбооны гэрээ, Харилцан туслалцаа үзүүлэх тухай Америкийн орнуудын гэрээ.

Аливаа улс аюулгүй байдлын олон улсын гэрээ, хэлцэлд нэгдэх үндсэн учир шалтгаан нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагаагаа сайжруулах зорилгоор олон улсын дэг журмыг тодорхой болгоход оршино. Холбогдох яриа хэлцлийг тухайн улс орнуудын Засгийн газар өөрийн гадаад хэргийн асуудал эрхэлсэн ямаар дамжуулан явуулдаг.

Найрамдал, хамтын ажиллагаа, цэргийн харилцан туслалцаа үзүүлэх тухай хоёр талын гэрээнүүд

Аливаа улсын аюулгүй байдлын бодлогын хүрээг тодорхойлоход хоёр талын гэрээ хэлцэл мөн адил гол үүрэг гүйцэтгэдэг. Зөвхөн хоёр улсын хооронд хийгддэг учир ийм гэрээний зүйл заалтуудыг оролцогч хоёр талын үнэт зүйл, нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад аль болох нарийвчлан тохируулах боломжтой. Ийм гэрээний жишээ болгон хуучин ЗХУ болон АНУ-ын хооронд байгуулсан Стратегийн зэвсэглэл бууруулах гэрээ (START)-г дурдаж болно.

Ийм төрлийн гэрээ нь зөвхөн найрамдал, үл түрэмгийлэх байдлыг илэрхийлээд зогсохгүй (жишээ нь: Орос, Армени Улсуудын хооронд 1997 оны 8 дугаар сард байгуулсан Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцааны хоёр талт гэрээ) мөн гадаад орны нутаг дэвсгэр дээр цэргийн хүч, зэвсэглэл байрлуулах зэрэг цэргийн хамтын ажиллагааны зарим тодорхой асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлдэг. Тухайлбал, 1990-ээд оны үед Орос Улс хуучны ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан хэд хэдэн оронтой цэргийн хамтын ажиллагааны хоёр талт гэрээ байгуулж байв.

Мөн шаардлагатай тохиолдолд цэргийн тодорхой тусламж үзүүлэх асуудлыг гэрээнд тусгаж болдог. АНУ-Казахстаны хооронд хоёр талын цэргийн харилцааг хөгжүүлэх замыг нээсэн 1992 оны АНУ-Казахстаны гэрээний үргэлжлэл болох 1994 оны Ардчилсан түншлэлийн дүрмийг энд жишээ болгон дурдаж болно.

Ерөнхийдөө, хоёр талын гэрээг гадаад аюулгүй байдлын бодлогын чигийг тодорхойлох, бусад улстай найрамдалт харилцаа бэхжүүлэх, бодит асуудлуудыг шийдвэрлэх нэгэн арга хэрэгсэл хэмээн үзэж болно. Аюулгүй байдлын олон талт гэрээтэй харьцуулахад, парламент нь хоёр талын гэрээг батлахдаа, түүний агуулгад өөрчлөлт оруулахыг санал болгож, тэдгээрийн дагуу яриа хэлцэл хийхийг Засгийн газарт даалгах зэргээр илүү шийдэмгий байр суурь эзлэх боломжтой байдаг.

Парламентын болон олон нийтийн оролцооны ач холбогдол

Олон улсын гэрээ хэлцлийг соёрхон батлах ажиллагаанд олон нийт, парламентын оролцоог хангах нь иргэдээс хүлээх дэмжлэгийг нэмэгдүүлэхэд тустай учир ийм туршлага дэлгэрээгүй орны хувьд энэ оролцоог аль болох өргөжүүлэхийг хичээх нь чухал. Зарчмын хувьд, ардчилсан улс оронд засгийн газар нь парламентад мэдэгдэж, зөвшөөрөл авалгүйгээр аливаа нууц гэрээ эсвэл хоёр талын хэлцэл байгуулах эрхгүй байдаг. Тухайн улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, олон улсын статусыг хөндөж байгаа аливаа олон улсын гэрээг парламентаар хэлэлцэж, батлах зайлшгүй шаардлагатай.

Швейцарь зэрэг зарим улс оронд томоохон гэрээ хэлцэлд нэгдэх асуудлыг олон нийтийн санал асуулгаар шийддэг. Ингэснээр, гадаад бодлогод гарах томоохон өөрчлөлт дэх иргэний нийгмийн оролцоо баталгааждаг байна. Швейцарьт аливаа гэрээг батлахын өмнө олон нийтийн санал асуулга явуулдаг (Дэлгэрэнгүйг Тодруулга N°6-аас үз).

Тодруулга N°6

Шууд ардчилал ба олон улсын болон бусад томоохон гэрээ хэлцлийг соёрхон батлах нь: Швейцарийн жишээнээс

Швейцарь Улсад Холбооны парламент, Холбооны зөвлөл (засгийн газар) болон нийт иргэд олон улсын гэрээ хэлцлийг соёрхон батлах үйл явцад оролцдог. Тус улсын хувьд чухал ач холбогдол бүхий гэрээ хэлцэл нь зөвхөн парламентын бус, олон нийтийн хэлэлцүүлгээр мөн дамждаг байна. Ард иргэд тухайн гэрээний талаарх үзэл бодлоо олон нийтийн санал асуулгаар дамжуулан илэрхийлдэг аж. Үүний зэрэгцээ, иргэд нийтийн санал асуулгаар дамжуулан Холбооны зөвлөлд тухайн гэрээний асуудлаар цаашид яриа хэлцэл эхлүүлэх эсвэл зогсоох эрхийг олгодог байна. Тухайлбал, засгийн газар “хамтын аюулгүй байдлын байгууллага, эсвэл аюулгүй байдлын олон улсын нийгэмлэг”-т элсэхийг хүссэн тохиолдолд олон нийтийн санал асуулга явуулах үүрэг хүлээдэг (Холбооны Үндсэн хуулийн 140.b дэх зүйл).

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Гэрээний хэлэлцээр

- ▷ Парламент/түүний холбогдох хороо(д):
 - хэлэлцээр хийх багийн бүрэлдэхүүнд улс төрийн харилцан адилгүй үзэл баримтлал бүхий гишүүдийн төлөөллийг оруулах зэргээр оролцоог хангах;
 - иргэний нийгмийн байгууллага, нэн ялангуяа тухайн асуудлаар мэргэшсэн судалгааны байгууллагаас зөвлөгөө, туслалцаа авах;
 - засгийн газарт өөрийн байр суурийг албан ёсоор цаг тухайд нь илэрхийлж, ард түмний санал зовнил, хүсэл эрмэлзлийг дамжуулах.

Нөлөөллийн үнэлгээ

- ▷ Тухайн гэрээг байгуулснаар үүсэх улс төр, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны болон бусад боломжит үр дагаврын үнэлгээг гаргуулж авах, түүнийг хэлэлцэх боломжоор хангагдсан байх.

Соёрхон батлах

- ▷ Тухайн гэрээг соёрхон батлах хүсэлтийг зохих цаг хугацаанд нь парламентад өргөн барьсан байх;
- ▷ Дотоодын хуулинд шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх, эсвэл шаардлагатай хийгээд боломжтой тохиолдолд олон улсын гэрээтэй холбоотой тайлбар заалтуудыг оруулах замаар батлах гэж буй олон улсын гэрээ хэлцэл болон дотоодын хууль тогтоомжийн уялдааг хангах.

Тайлбар зүйл заалт

- ▷ Үндэсний аюулгүй байдлын бодлогыг хянан шинэчлэх бүрт танай улсаас хууль тогтоомждоо оруулсан тайлбар заалтууд хүчин төгөлдөр хэвээр үлдэх явдлыг баталгаажуулах.

Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо

Аюулгүй байдлын салбарын цар хүрээ, цогц байдал улам өсөн нэмэгдэж байна. Аюулгүй байдлын салбарт үр дүнтэй хяналт тавихад нь тус дэм болох эх сурвалж, мэргэшсэн ажилтан дутагдах бэрхшээл парламентад тулгарах нь олонтаа. Засгийн газрыг хянах эрх үүргийг парламент голлон хүлээдэг хэдий ч, дээрхээс үүдэн, уг үүргийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой өөр бусад байгууллагууд бий болсон байна. Иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн байгууллагын аль аль нь парламентаас тогтоосон хууль эрх зүйн хэм хэмжээний хүрээнд аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой.

Иргэний нийгэм

Иргэний нийгэм гэсэн нэр томъёо нь нэг талаас төрийн байгууллагууд, нөгөө талаас хувь хүмүүс, тэдний нэгдлийн хооронд оршин буй бие даасан байгууллагуудад хамаардаг. Иргэний нийгэмд олон төрлийн сайн дурын холбоод, бүлгүүд буюу нэг үгээр хэлбэл, харилцан адилгүй нийгмийн ашиг сонирхол, үйл ажиллагааг төлөөлсөн байгууллага, нийгмийн хөдөлгөөнүүд багтана. Дараах дэд хэсгүүдэд аюулгүй байдлын салбарын хариуцлагатай байдлыг хангахад иргэний нийгэм яагаад оролцох ёстой, энэхүү үүрэг оролцоонд чухам юу багтдаг, парламентын хяналтад иргэний нийгэм хэрхэн хувь нэмэр оруулдаг талаар тайлбарласан болно.

Иргэний нийгэм ба ардчилал

Иргэний нийгэм нь ардчиллын үйл явцын нэгэн чухал хэсэг, илрэл бөгөөд ардчилал төлөвшсөн орнуудын хувьд нэн чухал, нөлөө бүхий үүрэг гүйцэтгэдэг. Тэдний үйл ажиллагаа нь төсвийн зарлага, төрийн бодлогын талаар шийдвэр гаргахдаа харгалзан үзэх ёстой ялгаатай, харилцан өрсөлдсөн хэрэгцээ шаардлага, сонирхлууд оршин байгааг улс төрийн удирдлагад байнга сануулж байдаг. Тийм ч учир иргэний нийгэм бэхэжсэн, идэвхтэй байх нь ардчиллын үндсэн шаардлага байдаг билээ. Иргэний нийгэм нь төрийн эрх мэдлийг сөрөн тэнцвэржүүлж, авторитар дэглэмээс сэргийлэхийн зэрэгцээ олон урьгалч мөн чанарыг агуулдгийн хувьд төр засаг цөөн хэдэн хувь хүн, бүлгийн ашиг сонирхолд үйлчлэхээс хамгаалах чухал үүргийг гүйцэтгэдэг.

Иргэний нийгэм ба аюулгүй байдлын салбар

Иргэний нийгэмд багтах эрдэм шинжилгээний байгууллагууд, тинк танк байгууллагууд, хүний эрхийн ТББ-ууд болон бодлогын асуудлаар дагнасан ТББ-ууд нь аюулгүй байдлын салбартай холбоотой шийдвэр, бодлогод нөлөөлөхийг идэвхийлэн эрмэлзэх ёстой.

Үндэсний аюулгүй байдал, зэвсэгт хүчин, цагдаа, тагнуулын асуудлаарх олон нийтийн мэтгэлцээнд ТББ-уудын оролцох оролцоог засгийн газраас дэмжиж, урамшуулах нь зүйтэй. Эл мэтгэлцээн нь засгийн газрын ил тод байдлыг улам нэмэгдүүлэхэд тус дэм болдог.

Төрийн бус байгууллага, судалгааны хүрээлэнгүүдийн аюулгүй байдлын салбартай холбогдуулан гүйцэтгэх үүрэг

Төрийн бус байгууллагууд нь ерөнхийдөө тодорхой асуудлаар нийгмийн хүсэл эрмэлзэл, ашиг сонирхлыг төлөөлөх зорилго бүхий хувийн, ашгийн төлөө бус байгууллага байдаг. Харин судалгааны байгууллага нь засгийн газраас үл хамаарах ТББ-ын хэлбэртэй эсвэл эсрэгээр төрөөс санхүүждэг гэхчилэн төртэй ямар нэг байдлаар холбоотой байж болно.

ТББ, судалгааны хүрээлэнгүүд нь дараах арга замаар аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтыг бэхжүүлэх боломжтой. Үүнд:

- ✓ Парламент, хэвлэл мэдээлэл, олон нийтэд зориулан аюулгүй байдлын салбар, цэрэг, батлан хамгаалахын асуудлаар бие даасан судалгаа шинжилгээ, мэдээлэл гаргах;
- ✓ Аюулгүй байдлын салбар дахь хүний эрх, хуулийн засаглалыг хянах, дэмжих;
- ✓ Нийгэмд бүхэлд нь чухал ач холбогдол бүхий аюулгүй байдлын асуудлуудад улс төрийн анхаарлыг хандуулах;
- ✓ Сургалт, хурал семинар зохион байгуулах замаар парламентын мэдлэг чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах;
- ✓ Засгийн газраас хэрэгжүүлж буй аюулгүй байдлын бодлого, батлан хамгаалахын төсөв, ханган нийлүүлэлт, нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтын хувилбаруудын талаар шинжээчийн ялгаатай байр суурийг илэрхийлэх, олон нийтийн мэтгэлцээн өрнүүлэх, бодлогын боломжит хувилбаруудыг боловсруулах;
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлогын шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаар үнэлэлт дүгнэлт хийх;
- ✓ Олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, олон нийтийн сүлжээний домэйнээр хэлэлцүүлэг өрнүүлэх.

Латин Америк дахь иргэний нийгмийн үйл ажиллагаа нь аюулгүй байдлын салбарт хяналт тавихад ТББ, судалгааны хүрээлэнгүүдийн гүйцэтгэх боломжтой өргөн цар хүрээтэй үүрэг оролцоог харуулж байна (Дэлгэрэнгүйг Тодруулга №7-оос үз).

Тодруулга №7

Латин Америк дахь иргэний нийгэм:

Иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоо, ач холбогдлын бодит жишээ

Латин Америкийн иргэний нийгмийн олон бүлэг 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр буюу шинэ тутам байгуулагдсан иргэний засгийн газар зэвсэгт хүчинд бүтцийн өөрчлөлт хийхээр оролдож байсан тэр үед иргэн, цэргийн хоорондын зөвшилцлийг сайжруулах зорилготойгоор бий болжээ. Энэхүү зөвшилцлийн үр дүнд зэвсэгт хүчний тусгаарлагдмал байдал арилсан бөгөөд иргэний нийгэм, сонгуульт албан тушаалтан, цэргийн дээд удирдлагын хооронд мэргэжлийн харилцаа, хамтын ажиллагаа бий болоход чухал хувь нэмэр оруулсан юм. Чухам энэ үеэс эхлэн, тэдгээр бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг өргөжин тэлж, аюулгүй байдал, цэргийн асуудлаарх мэргэжлийн судалгаа, дүн шинжилгээ, техникийн тусалцааны чухал эх үүсвэр болохын зэрэгцээ цэргийн бодлого, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр томоохон хариуцлага хүлээх болжээ.

Жишээ

Дээрхийн нэг жишээ нь Аргентины *SER en 2000* бүлэг юм. Цэргийн эргэлт хийх 1990 оны оролдлогын дараахан байгуулагдсан тус хөдөлгөөн нь иргэний нийгэм, улс төрийн нам, цэргийнхний зөвшилцлийн талбар хэлбэрээр анх үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Эдгээр яриа хэлцэл дээр үндэслэн *SER en 2000* нь дараа дараагийн батлан хамгаалах бодлогын тогтолцоог бүрэлдүүлэхэд үндсэн үүрэг гүйцэтгэсэн хууль тогтоомжуудад иргэний байр суурийг тусгуулж чадсан юм.

Үүний нэгэн адил, Бүгд Найрамдах Доминикан Улсын аюулгүй байдал, батлан хамгаалахын иргэний мэргэжилтнүүдээс бүрдсэн FLACSO бүлэг нь цэргийнхэнтэй хамтран ажилласны үндсэн дээр цагдаагийн шинэчлэлийг хэрэгжүүлэх хуулийн төсөл боловсруулсан бөгөөд хуулийн төслийг гүйцэтгэх засаг болон Конгрессоор хэлэлцүүлэх үед зөвлөгөө өгч байв.

Латин Америкийн олон бүлгүүд хууль тогтоох дээд байгууллагаас цэргийн үйл ажиллагааг хянах боловсон хүчний болон техникийн чадавхыг сайжруулах зорилгоор үндэсний конгресс дахь батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал хариуцсан хороодтой нягт хамтран ажилладаг.

Перугийн *Instituto de Estudios Políticos y Estratégicos* (IDEPE) бүлгээс конгрессын гишүүд болон батлан хамгаалахын асуудал хариуцсан парламентын хорооны ажилтнуудад зориулж цэргийн төсөв, удирдлагын асуудлаар сургалт явуулдаг.

Гватемала дахь FLACSO бүлэг нь цэргийн асуудлаарх хэд хэдэн хууль, түүний дотор тагнуулын шинэчлэл болон цэргийн албаны талаарх хуулиудад дүн шинжилгээ хийх, конгрессоор хэлэлцүүлэх үед туслалцаа үзүүлж байжээ.

Иргэний мэргэжилтэн хүрэлцээгүй байх

Латин Америкт батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар мэргэшсэн энгийн мэргэжилтнүүд дутагдсан хэвээр байна. Чухам энэ хомсдлоос шалтгаалан гүйцэтгэх засаг, хууль тогтоох байгууллагаас цэргийн салбарт тавих хяналтын үр дүн хангалтгүй байгаа юм. Одоохондоо иргэний нийгмийн байгууллагууд төрийн байгууллагуудад туслалцаа үзүүлэх, иргэний албан хаагчдыг сургалтад хамруулах замаар энэхүү орон зайг нөхөж байна.

Сүлжээ

SER en 2000 аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар дагнасан судалгааны болон төрийн бус байгууллагын сүлжээг саяхан үүсгэжээ. RES-DAL (www.ser2000.org.ar) нэртэй энэ сүлжээ нь аюулгүй байдал, батлан хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, мэдээллийн санг бий болгохын зэрэгцээ иргэдэд тухайн байгууллагуудад зочлох, судалгаа хийх боломж олгодог байна.

Эх сурвалж: Крис Сабатини, National Endowment for Democracy, Вашингтон, 2002

Хэвлэл мэдээлэл

Хараат бус хэвлэл мэдээллийн салбар нь олон нийт, тэдний улс төрийн төлөөлөлд баримт, мэдээлэл дээр тулгуурласан шийдвэр гаргахад тусалдаг. Тэд засаглалын гурван салбарын үйл ажиллагааг хянахад хувь нэмэр оруулахын зэрэгцээ олон нийтийн анхаарлын төвд буй асуудлын агуулга, мөн чанар, үүгээр дамжуулан засгийн газар, хувийн хэвшил, судлаачид, иргэний нийгэмд нөлөөлөх боломжтой. Тиймээс чөлөөт хэвлэл мэдээлэл нь ардчиллын үндсэн хэсгүүдийн нэг мөн. Засгийн газрыг шүүмжлэхийг оролдох үед сэтгүүлчдэд тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийн талаар Тодруулга N°8-д дурдав. Сэтгүүлчийн аюулгүй байдлыг баталгаажуулах нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний суурь нөхцөл юм.

Тодруулга N°8

Шинэ төрлийн дайн: Хэвлэлийн эрх чөлөөний амаргүй сорилтууд

“Дэлхийн нийт хүн амын бараг гуравны нэг нь хэвлэлийн эрх чөлөөг зөвшөөрдөггүй улс оронд амьдарч байна. (...) Бид дайны бүсэд ажил үүргээ гүйцэтгэж яваад бусдын хамт алагдсан сэтгүүлчид болон эгзэгтэй асуудал болон ялгаварлан гадуурхалт, шамшигдуулалт, шударга бус байдал, гэмт хэрэг, дарамт сүрдүүлгийн талаар эрэн сурвалжилж, нийтлэл бичсэнийх нь төлөө санаатайгаар амь насыг нь бүрэлгэсэн сэтгүүлчдийг ялгаж салгах хэрэгтэй. Байнгын цэрэг арми хоорондын уламжлалт дайн бус, харин яс

үндэс, итгэл үнэмжил, шашин шүтлэг, эсвэл зүгээр л гэмт хэргийн шинжтэй ашиг сонирхлуудын хооронд өрнөж буй шинэ төрлийн дайн нь сурвалжлах ажлыг улам аюултай болгож байна. Гэхдээ эдгээр мөргөлдөөний үеэр сурвалжлагч амь насаа алдах, бэртэх гэмтэх нь тэр болгон санамсаргүй осол байдаггүй. Заримдаа байлдаж буй талууд, зарим тохиолдолд байнгын армийнхан хүртэл өөрийн үйлдлийн гэрчийг санаатайгаар устгадаг.”

Эх үүсвэр: 2002 оны жилийн тайлан, Хил хязгааргүй сэтгүүлчид

Хэвлэл мэдээллийн салбар нь төрөөс хараат байдаг орнуудын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг эрх баригчдын суртал ухуулгын хэрэгсэл болгон ашиглах нь их. Ийм нөхцөлд, аюулгүй байдлын салбарын ардчилсан хяналт, ил тод байдлыг сайжруулахад хэвлэл мэдээллийн салбар хувь нэмэр оруулж чадахгүй нь ойлгомжтой.

Интернэтийн хурдацтай хөгжлөөс үүдэн олон нийтээс албан ёсны мэдээлэлд нэвтрэх боломж асар ихээр нэмэгдсэн. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд албаны мэдээллийн ил тод, хариуцлагатай байдал, хүртээмж нэмэгдэх ерөнхий чиг хандлага бүрдэж байна. Иргэдийн мэдлэг мэдээллийг сайжруулж, бодлогын чухал асуудлаарх олон нийтийн хэлэлцүүлгийн чанарыг ахиулж, улмаар сайн засаглалыг бэхжүүлдэг учир энэ хандлагыг дэмжих нь зүйтэй. Үүний зэрэгцээ, интернэтийг хэт даврагсдын бүлэг ашиглах, тухайлбал, арьс өнгөөр эсвэл еврей үндэстнийг ялгаварлан гадуурхах үзлийг тараахад ашиглах зэрэг сөрөг талууд мөн бий. Сүүлийн үеийн зарим мөргөлдөөнд хэт даврагсад радио зэрэг мэдээллийн бусад хэрэгслийг өөрийн зэвсэг болгон нийгмийн янз бүрийн бүлгийн хооронд үзэн ядалтын уур амьсгалыг дэврээхэд ашиглах явдал цөөнгүй гарсан байна.

Аюулгүй байдалтай холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулах, түгээх

Ардчилал, сайн засаглалын үүднээс авч үзвэл хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой аюулгүй байдлын асуудлуудаар мэдээлэл цуглуулах, түгээх эрхтэй бөгөөд нөгөө талаас үнэн зөв, тэгш шударга хэм хэмжээний дагуу мэдээ мэдээлэл бэлдэж түгээх үүрэгтэй.

Засгийн газар, парламент өөрийн бодлого, шийдвэрийг иргэдэд ойлгуулан тайлбарлах, иргэд нь улс төрийн үйл явцын талаар мэдээлэл авах, түүндээ тулгуурлан тэдгээр үйл явцад оролцох эрхээ эдлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагууд тус дөхөм үзүүлэх боломжтой. Жишээлбэл, хэвлэл мэдээллийн байгууллага аюулгүй байдлын салбар дахь төрийн албан тушаалыг хэн хашдаг, аюулгүй байдлын ямар бодлого баримталдаг, хилийн чанадад цэргийн хүч илгээх, цэргийн номлол, зэвсэг техникийн ханган нийлүүлэлт болон холбогдох гэрээ хэлцлүүд, оролцогч талууд, цаашид учирч болох аюулгүй байдлын

сорилтууд болон холбогдох мэтгэлцээний талаарх мэдээллийг түгээх замаар иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах боломжтой. Гэхдээ нууцлалын зэрэг бүхий материал хэрэг болсон тохиолдолд дээрээс тогтоосон эсвэл байгууллагын дотоод хязгаарлалтыг мөрдөх шаардлага тулгарч болзошгүй.

Хэвлэл мэдээлэл болон аюулгүй байдлын асуудлаарх хууль тогтоомж

Дэлхийн бүх улс хэвлэлийн эрх чөлөөний талаар өөрийн гэсэн хууль тогтоомжтой байдаг. Энэ зарчмыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд тусгасан билээ. Үүнд:

“Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.”

Хэдийгээр энэ эрхийг хэрхэн хангах, хамгаалах талаар олон улсын тогтсон жишиг, заавар байхгүй ч дээрх зарчмыг ямар нэг хязгаарлалтгүйгээр томъёолсон бөгөөд аюулгүй байдлын асуудлуудтай хамаатай аливаа ерөнхий хязгаарлалтын талаар огт дурдаагүй болно.

Тодруулга №9

2001 оны 9 дүгээр сарын 11-нээс хойшхи хэвлэл мэдээллийн эрх чөлөө

Олон улсын хэвлэлийн эрх чөлөөний өдрийг жил бүрийн 5 дугаар сарын 3-ны өдөр тэмдэглэдэг. 2002 онд тус өдрийг тэмдэглэхдээ 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа үндэсний болон олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд хэрхэн нөлөөлсөн талаарх асуудлыг голлон авч үзсэн байна.

“Терроризмын аюул занал нүүрлэхэд хүний үндсэн эрх чөлөөг хэрэгжүүлэх хийгээд аюулгүй байдлыг хангах хэрэгцээ шаардлагын хооронд зөрчил бий болох нь маргаангүй. Гэхдээ терроризмын эсрэг ямар ч кампанит ажлын гол утга учир нь бидний эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах явдал мөн” хэмээн ЮНЕСКО-ын Ерөнхий захирал ноён Койчиро Мацура тэмдэглэсэн байна.

Эх сурвалж: Парламентын ертөнц, Дугаар №6, 2002 оны 5 дугаар сар, ОУПХ.

Парламентын зүгээс аюулгүй байдлын асуудлаар олон нийттэй харилцах нь

Парламентаар хэлэлцэгдэж байгаа томоохон асуудлуудын талаар олон нийт мэдэж байгаа нөхцөлд л сайн засаглалын нэгэн зарчим болох ардчилсан хяналт үр дүнтэй хэрэгжиж чадна.

Аюулгүй байдлын асуудлаар олон нийттэй харилцах харилцааны үр дүн нь засгийн газар болон парламентаас иргэдэд зориулан гаргаж буй мэдээллийн агуулга, үнэн бодит байдлаас хамаардаг. Тухайн асуудлын өнөөгийн бодит байдал болон парламентаас гаргасан шийдвэрийн үр дагаврыг ойлгоход хангалттай, чанартай мэдээллийг иргэд авч байгаа эсэхэд парламент онцгой анхаарах нь чухал.

Баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох нь

Парламентаас олон нийтийг мэдээллээр хангах нэг үр дүнтэй арга нь засгийн газартай хамтран буюу дангаараа, аюулгүй байдлын асуудлуудаарх төрөл бүрийн мэдээлэл, баримт бичгийг цаасан хэлбэрээр болон/буюу цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэх явдал юм.

Тодруулга №10

Парламентын цахим хуудас

2002 оны 5 дугаар сарын байдлаар дэлхийн 180 оронд 244 парламент үйл ажиллагаа явуулж байв (үүнээс 64 орны парламент хоёр танхимтай). ОУПХ-нд байгаа мэдээллээр бол 128 оронд парламентын 165 цахим хуудас ажилладаг байна (хоёр танхимтай парламент бүхий зарим орнуудад танхим тус бүр цахим хуудастай). Тус холбооноос 2000 оны 5 дугаар сард гаргасан «Парламентын цахим хуудсын агуулга, бүтцийн талаарх заавар»-ыг <http://www.ipu.org> цахим хуудсаас татаж авах боломжтой.

Олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хувилбараар гаргаж болох аюулгүй байдлын асуудалтай холбоотой мэдээллийн зарим жишээг дурдвал:

- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлого зэрэг стратегийн ач холбогдол бүхий баримт бичиг;
- ✓ Батлан хамгаалах төсөв (нууц хэсгүүдийг оруулалгүй);
- ✓ Аюулгүй байдалтай холбоотойгоор парламент дээр хэлэлцсэн бүх мэтгэлцээн, шийдвэр, тогтоол, хууль зэргийн хэвлэлийн мэдээ;

- ✓ Аюулгүй байдлын асуудлаар хуралдсан парламентын (хороодын) хуралдааны тэмдэглэл (хаалттай хуралдаанаас бусад); үүнд хаалттай хуралдааны хамрах хүрээ, хуралдааны ерөнхий мэдээлэл бүхий тайлан мөн багтана;
- ✓ Парламентаас аюулгүй байдлын асуудлаар хийх асуулгатай холбоотой нийтлэлүүд;
- ✓ Аюулгүй байдлын нийт албадын үйл ажиллагааны талаар парламентаас жил тутам хийдэг тайлан, дүгнэлт;
- ✓ Аюулгүй байдлын салбартай холбоотой асуудлаар Омбудсмэн болон ерөнхий аудиторос гаргасан тайлан; Омбудсмэн зарим тусгай шалгалтын дүгнэлтийг нийт танхимд бус холбогдох хороодод илгээнэ; засгийн газар Омбудсмэн болон ерөнхий аудиторовын тайлантай парламент танилцсаны дараа авсан арга хэмжээнийхээ талаар эргэж танилцуулах үүрэгтэй.
- ✓ Олон талт болон хоёр талын гэрээ хэлцлийн талаарх мэдээлэл;
- ✓ Парламентын гишүүн тус бүр эсвэл парламент дахь улс төрийн фракцууд аюулгүй байдлын асуудлаар ямар санал өгсөн талаарх мэдээлэл (төсөв, олон улсын эвсэл холбоонд нэгдэх, цэрэг татлагын асуудал, зэвсэг техникийн худалдан авалт зэрэг);
- ✓ Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж.

Парламентын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах нь

Зөвхөн парламент эсвэл засгийн газраас олон нийтэд чиглэсэн мэдээллийн ганц урсгал байх нь хангалтгүй. Олон нийтийн зүгээс аюулгүй байдлын асуудлаар парламентад хандах, харилцах боломжийг зэрэг олгосон байх ёстой. Ийм хоёр урсгалтай харилцаа дараах шалтгааны улмаас ач холбогдолтой байдаг. Үүнд:

- ✓ Иргэдийн оролцоо, байнгын хяналтыг хэрэгжүүлэх боломжтой;
- ✓ Парламентын үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлдэг;
- ✓ Удирдлагын алдаа зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр, тухайлбал парламентын омбудсмэнээр дамжуулан шалгалт хийх боломжийг олгоно;
- ✓ Хууль тогтоомж, засгийн газрын бодлого, үйл ажиллагааг олон нийтийн зүгээс дэмжих болон эрх зүйт байдлыг баталжуулан, ардчилсан тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.

Парламентын мэдээлэл, сонсгол, мэдээний мониторинг, телевизийн хэлэлцүүлэг, парламентын судалгааны албаны ажилтнуудаас хороодын гишүүдэд зориулж тусгайлан бэлтгэсэн мэдээний түүвэр зэрэг нь хоёр урсгалт харилцааг сайжруулахад тус дөхөм үзүүлнэ.

Тодруулга №11

Парламент ба хэвлэл мэдээлэл

“11. Дараах арга хэмжээг яаралтай авахыг Ассамблей үндэсний парламентуудад хандан уриалж байна. Үүнд:

- i. Парламентын үйл ажиллагаа, хороодын хуралдааныг улам нээлттэй болгож, үүнийг зөвхөн олон нийттэй харилцах бодлого бус ардчиллын үйл ажиллагаанд шууд нөлөө бүхий улс төрийн тэргүүлэх ач холбогдолтой асуудал хэмээн авч үзэх;
- ii. Харилцааны уламжлалт болон шинэ дэвшилтэт арга технологийг оновчтой ашиглах. Тухайлбал:
 - а. хэвлэл мэдээлэл, нэн ялангуяа парламентын сэтгүүлчдэд ажиллах боломжит хамгийн сайн нөхцлийг бүрдүүлэх;
 - б. хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг түргэн шуурхай цацах, үүний нэгэн адил, хуралдааны тэмдэглэл, тайланг шуурхай хэвлэж гаргах;
 - в. олон нийт, сэтгүүлчидтэй шууд харилцах цахим орчин бүрдүүлэх;
 - г. парламентын баримт бичиг, мэдээллийг бүрэн хэмжээнд нээлттэй болгож, аливаа хуулиар санал хураахын өмнө олон нийтийн хэлэлцүүлэг явуулахыг дэмжих;
- iii. Харилцаа холбооны мэргэжилтнүүдийн зөвлөгөөг ашиглах;
- iv. Хууль эрх зүйн баримт бичгүүдийг энгийн уншигчдад илүү хүртээмжтэй болгох;
- v. Хэлэлцүүлгийг шуурхай болгож, шийдвэр гаргах явцыг хурдасгахад тус дөхөм үзүүлэх гол чухал асуудлуудыг тодорхойлох зэргээр өөрсдийгөө улс төрийн мэтгэлцээний төвд байлгахад шаардлагатай алхмуудыг хийх;
- vi. Мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагааны хүрээнд, тухайн асуудалд хамгийн их анхаарал хандуулж буй сэтгүүлчид эсвэл мэргэжлийн хүмүүст хуулиудыг танилцуулж, тэдгээрийн хуулийн гол агуулгыг тайлбарласан мэдээллийн багц боловсруулах ажлыг дэмжих;
- vii. Хууль тогтоох үйл ажиллагаа болон парламентын хуралдаантай сэтгүүлчдийг танилцуулах, парламент болон олон улсын байгууллагуудын харилцааны талаарх тэдний мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт семинар зохион байгуулах. Ингэхдээ орон нутгийн болон бүс нутгийн сэтгүүлчдэд онцгой анхаарал хандуулах нь чухал;
- viii. Интернэтэд харилцаа холбооны сүлжээ үүсгэх замаар иргэд парламентын гишүүд болон парламентын мэдээллийн албадтай шууд харилцах боломжийг дээшлүүлэх;
- ix. Европын хэд хэдэн орон, АНУ болон Канадад байдгийн адил зөвхөн

парламентын үйл ажиллагааг сурвалжлан мэдээлэх зорилго бүхий телевизийн бие даасан сувгуудыг үүсгэх, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- х. Нийгэмд өндөр чанартай мэдээ мэдээллийг аливаа нөлөөлмөөс ангид хэлбэрээр хүргэхийг зорьсон, зах зээлээс шахагдах аюулд ороод буй хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдэд санхүүгийн болон бусад төрлийн тусалцаа үзүүлэх замаар хамгаалах.”

Эх үүсвэр: Европын зөвлөлийн Парламентын Ассамблейн Тогтоол 1142 (1997)

Ардчилсан тогтолцооны тогтвортой байдлыг урт хугацаанд хангахад олон нийтийн оролцоо нэн чухал. Эл оролцооны түвшин улс бүрт харилцан адилгүй байдаг. Зарим оронд парламентын хорооны хуралдаанд иргэд оролцох боломжтой байдаг нь хууль тогтоох үйл ажиллагааг сонирхогч аливаа иргэн болон ТББ-уудын үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдолтой. Хэдийгээр иргэд хуралдааны явцад хажуугаас оролцох эрхгүй ч, хуралдааны үйл ажиллагаанд биеэр байлцана гэдэг өөрөө чухал юм.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Албан бус тоглогчдын саналыг аюулгүй байдлын бодлогод тусгах

- ▷ Парламент аюулгүй байдал болон түүнтэй холбогдох асуудлаар иргэний нийгмийн санал бодлыг тусган авч, шаардлагатай тохиолдолд ажил хэрэг болгох механизмуудыг бий болгож, ажиллуулах.
- ▷ Мөн адил зорилгоор, хэрэв боломжтой бол эрх бүхий байгууллага, ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын хороодын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах эрхийг баталгаажуулсан хууль гаргах.

Олон нийтийн мэдлэг, мэдээлэл

- ▷ Парламентаас аюулгүй байдал, аюулгүй байдлын салбартай холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцын талаар олон нийттэй харилцах идэвхтэй бодлого баримтлах.

Аюулгүй байдал болон хэвлэлийн эрх чөлөө хоорондын уялдаа холбоо

- ▷ Аюулгүй байдалтай холбоотой асуудлаарх хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг хуулинд болон амьдрал дээр баталгаажуулж, үүнтэй холбоотой хязгаарлалтуудыг олон улсын хүний эрхийг хамгаалах баримт бичиг, үйл ажиллагаанд нийцүүлэх.
- ▷ Мэдээллийн эрх чөлөөг хангах хууль эрх зүйн орчин бүрдүүлэх.

Аюулгүй байдлын бодлого дахь хүйсийн асуудал

Хүйсийн тэгш эрхийн асуудал саяхнаас л олон нийтийн анхаарлын төвд орсон. Аливаа зэвсэгт мөргөлдөөний гол хохирогчид нь (дүрвэгсэд, дотоодын дүрвэгсэд г.м) хүүхэд, эмэгтэйчүүд байдгаас гадна дэлхийн хүн амын тал хувийг бүрдүүлж буй эмэгтэйчүүд аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэхэд эрчүүдийн адил оролцох эрхтэй гэсэн зарчмын үүднээс хүйсийн тэгш эрхийн асуудал өдгөө аюулгүй байдлын салбарын чухал үзүүлэлтүүдийн нэг болоод байна. Эмэгтэй хүний мөн чанар, авъяас билигт тулгуурлан илүү хүн-төвтэй, хүний аюулгүй байдлын чиг хандлагад нийцсэн, улмаар илүү тогтвортой аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг бий болгож чадна. Тийм ч учир аюулгүй байдлын бодлого дахь хүйсийн тэгш эрхийн асуудлыг авч үзэхдээ хоёр өөр өнцгөөс харах нь зүйтэй. Юуны өмнө аюулгүй байдлын бодлого нь хүйсийн холбогдолтой асуудлуудад анхаарч, тэднийг шийдвэрлэхийг зорих ёстой. Эмэгтэйчүүдийн эрх, эрх ашгийг хамгаалах, хангах боломжит шийдлүүд болон тогтолцоог нэвтрүүлэх нь чухал. Хоёрдугаарт, шийдвэр гаргах бүхий л түвшин, тэр дундаа аюулгүй байдлын бодлоготой холбоотой салбарууд дахь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь зүйтэй.

Эмэгтэйчүүд болон зэвсэгт мөргөлдөөний зохицуулалт

Мөргөлдөөнийг зохицуулах, энхийг сахиулах, энхийг байгуулах зэрэг үйл ажиллагаа нь зөвхөн дайн, зэвсэгт мөргөлдөөний шууд оролцогч болох эрчүүдийн хэрэг биш. Ийм мөргөлдөөний үед эмэгтэйчүүд өөрийн хүйсийн уламжлалт үүргээс хальж, ихэвчлэн эрчүүдийн гэгдэх үүрэг хариуцлагыг үүрч ирсээр атал энхийг тогтоох яриа хэлэлцээр дэх тэдний оролцоо өнөөг хүртэл хязгаарлагдмал хэвээр байна. Гэсэн хэдий ч энэ үйл явцад эмэгтэйчүүд нэн чухал ур чадвар, байр суурь, үзэл санааг нэмэрлэдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага улам бүр нэмэгдэх болжээ. Шийдвэр гаргах явц, хямралын зохицуулалт, энхийг бий болгох болон сахиулах ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн шууд оролцоог бодитоор нэмэгдүүлэхийн тулд нийгэмд хийгээд зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагын талаарх уламжлалт ойлголтыг өөрчлөх шаардлагатай юм.

Тодруулга №12

Энхийг тогтоох үйл явц дахь хүйсийн асуудал

“Эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага, үүрэг оролцоог умартсан энхийг тогтоох аливаа үйл явц хэвийн бус, улмаар уг чанартаа тогтворгүй байдаг.” ... “Мөргөлдөөний дараах шилжилтийн үед эмэгтэйчүүдийн эрх, оролцоог хангах нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг дахин эхлүүлэхэд зайлшгүй чухал. Эмэгтэйчүүд эрчүүдийн нэгэн адил дайн болон зэвсэгт мөргөлдөөний хохирогч ба оролцогч байдаг. Гэхдээ энэхүү оролцоо, амсах хохирлын арга, хэлбэр нь ялгаатай. Дайны үед эмэгтэйчүүд олон шинэ үйл ажиллагаанд шинэ үүрэгтэйгээр оролцож, хүлээх хариуцлага нь нэмэгддэг. Гэсэн хэдий ч хямралын дараах нийгэмд болон олон улсын энхийг сахиулах хүчний зүгээс энхийг байгуулах стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх үед тэдний оролцоог хязгаарлах нь элбэг.”

Хүний аюулгүй байдлын хүйсийн асуудал: Энхийг байгуулах ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоог хангаж, хязгаарлалтыг халах нь, 2001, Норвегийн олон улсын харилцааны хүрээлэн

Эмэгтэйчүүдийг зэвсэгт мөргөлдөөний хохирогч (хүчирхийлэл, хүчинг дайны зэмсэг болгон ашиглахыг оруулаад) төдий бус харин хямралыг зохицуулах, энхийг байгуулах, энхийг сахиулах үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн нэгэн адил эрхтэй оролцогч мөн гэсэн шинэлэг ойлголтод тулгуурлан 2000 онд баталсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг Тодруулга №13-т иш татав. Ойлголтыг ийнхүү өөрчлөхийн тулд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дайны өмнө, дайны явцад болон дайны дараа гүйцэтгэдэг үүргийг авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл хүйсийн тэгш эрх болон хүйсийн бусад асуудлуудыг бодлого боловсруулах эхний үе шатаас эхлэн үндэсний болон олон улсын түвшинд анхаарч, холбогдох хууль тогтоомжид суулгаж байх ёстой гэсэг үг юм.

Тодруулга №13

Энхийг тогтоох ажиллагаа, үйл явц дахь хүйсийн асуудал

Аюулгүйн зөвлөл (...)

“7. Холбогдох сан болон хөтөлбөрүүд, тухайлбал НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сан, Хүүхдийн сан, Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газар болон холбогдох бусад байгууллагаас хүйсийн асуудлаар зохион байгуулж буй сургалтад үзүүлэх санхүү, техник, логистикийн сайн дурын тусламжаа нэмэгдүүлэхийг Гишүүн орнуудад уриалж байна;

8. Энхийн гэрээ хэлэлцээр хийж, хэрэгжүүлэхдээ хүйсийн асуудал,

тухайлбал: (а) Эх оронд нь буцаах, нүүлгэн шилжүүлэх үе дэх охид, эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ шаардлага болон тэдний сэтгэл санаа, бие бялдрын нөхөн сэргэлт, нийгэмшүүлэлт, зэвсэгт мөргөлдөөний дараах сэргээн босголтын асуудал; (б) Тухайн улс, орон нутгийн эмэгтэйчүүдийн энхийн төлөөх санал санаачилга болон хямралыг зохицуулах үйл явцыг дэмжих, мөн энхийн хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог хангасан арга хэмжээ; (с) Охид, эмэгтэйчүүдийн хүний эрх, нэн ялангуяа Үндсэн хууль, сонгуулийн тогтолцоо, цагдаа, шүүхтэй холбоотой эрхийг дээдлэх, хамгаалахад чиглэсэн арга хэмжээ (...) зэргийг харгалзан үзэхийг оролцогч талуудад уриалж байна;

15. Дотоодын болон олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагуудтай зөвлөлдөх замаар Аюулгүйн зөвлөлөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хүйсийн асуудал болон эмэгтэйчүүдийн эрхийг харгалзан үзэх явдлыг баталгаажуулах эрмэлзлээ илэрхийлж байна;(...)"

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс 2000 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан 1325 дугаар тогтоолоос ишлэв

Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолын дагуу (2000), НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал” нэртэй илтгэл тавьж хэлэлцүүлсэн болно (2002 оны 10 дугаар сарын 16). Тус илтгэлд дайн, зэвсэгт мөргөлдөөн нь охид, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хэрхэн хөндөж байгаа, олон улсын хууль эрх зүйн зохицуулалтууд, энхийг тогтоох үйл явц, энхийг сахиулах ажиллагаа, хүмүүнлэгийн ажиллагаа, сэргээн босголт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа болон зэвсэг хураах, цэргийн дайчилгааг цуцлах, эргэн нийгэмшүүлэх ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо зэрэг асуудлыг тусгасан байна. Эдгээр нөхцлийн заримыг бүлгийн төгсгөл дэх санал зөвлөмжийн хэсэгт оруулсан болно.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн парламентын хороон дахь эмэгтэйчүүд

ОУПХ-оос эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар сүүлийн 25 жилийн туршид хийсэн судалгаанаас үзэхэд батлан хамгаалах асуудал эрхэлсэн парламентын хороонд эмэгтэйчүүдийн төлөөлөл ихэнхдээ байдаггүй эсвэл хангалтгүй тоогоор байдаг ажээ. Ийм хорооны дарга, орлогч дарга эсвэл илтгэгчийн үүргийг эмэгтэй хүн гүйцэтгэх нь тун ховор. Тус холбооноос 1997 онд хийсэн судалгаанд (Улс төр дэх эрчүүд ба эмэгтэйчүүд: Хөгжин буй ардчилал) хамрагдсан 97 орны парламентын дөнгөж 3%-ийнх нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн хорооны дарга эмэгтэй хүн байсан бол ерөнхийдөө парламентын

нийт хороодын дөнгөж 18.6% нь эмэгтэй даргатай байжээ. Үүнийг хоёр үндсэн шалтгаанаар тайлбарлаж болох юм. Юуны өмнө, дэлхийн хэмжээнд эмэгтэй парламентчдын тоо маш бага хэвээр байна (2002 оны 5 дугаар сарын байдлаар 14.3% байсан). Хоёрдугаарт, дайн ба энх тайван, аюулгүй байдлын асуудлууд нь ерөнхийдөө эрчүүдийн эрхлэх ажил үүрэг гэсэн сэтгэхүй дэлхийн ихэнх оронд давамгайлсан хэвээр байна. Дайн байлдаан ард түмнийг бүхэлд нь хамардаг бөгөөд үүнд эрчүүдийг бодвол эмэгтэйчүүд илүү хохирдог гэдгийг харгалзан үзвэл дээрх хандлага нь ихээхэн эргэлзээтэй юм.

ЗЭВСЭГТ ХҮЧИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮД

Зэвсэгт хүчний захиргаа, ар тал, хангалтын албадын түвшинд эмэгтэйчүүд ажиллах нь ихэнх улс оронд нийтлэг бөгөөд уламжлал болсон байдаг. Ар талын албан тушаалд эмэгтэйчүүд үүрэг гүйцэтгэх нь зөвхөн энхийн цагт төдийгүй, дайн, зэвсэгт мөргөлдөөний үед магадгүй бүр ч илүү ач холбогдолтой. Харин цэргийн анги болон операцийн түвшинд эмэгтэйчүүд алба хаших явдал харьцангуй саяхнаас эхтэй билээ. Олон улсын болон бусад харьцуулсан түвшинд цэргийн албан хаагч эмэгтэйчүүдийн талаар судалгаа, мэдээлэл тун хомс. Тодруулга N°14-т, НАТО-ын гишүүн орнуудын цэрэгт алба хааж буй эмэгтэйчүүдийн талаарх тоо баримтыг жишээ болгон харуулсан байна.

Тодруулга N° 14

Цэргийн эмэгтэй албан хаагчид: НАТО-ын гишүүн орнуудын жишээнээс

Улс	Тоон үзүүлэлт	Нийт хүчинд эзлэх %
Бельги	3,202	7.6%
Канад	6,558	11.4%
Чех	1,991	3.7%
Дани	863	5.0%
Франц	27,516	8.5%
Герман	5,263	2.8%
Грек	6,155	3.8%
Унгар	3,017	9.6%
Итали	438	0.1%
Люксембург	47	0.6%
Нидерланд	4,170	8.0%
Норвеги	1,152	3.2%
Польш	277	0.1%
Португаль	2,875	6.6%
Испани	6,462	5.8%
Турк	917	0.1%
Их Британи	16,623	8.1%
АНУ	198,452	14.0%

Эх сурвалж: НАТО-ын тойм сэтгүүл, 2001 оны зуны дугаар

Ерөнхийдөө, цэргийн хугацаат албанд болон/эсвэл мэргэжлийн анги салбарт эмэгтэйчүүдийг татах нь нэг бол улс төрийн удирдлагын санаачилга эсвэл аюулгүй байдлын салбарын өөрийн дотоод хөгжлийн явцаас үүдэлтэй байдаг. Энэ нь бие биенээсээ харилцан хамааралгүй хоёр үзэгдэлтэй холбоотой гэхэд болно. Үүнд:

- ✓ Үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд нийт хүн амыг дайчлах шаардлагатай болсон;
- ✓ Зэвсэгт хүчний шинэчлэл нь бусад салбарын нэгэн адил нийгмийн хөгжлийн үйл явцыг өөртөө тусгах бөгөөд тиймээс хүйсийн тэгш эрхийн асуудал улам чухал болж байгаа.

Тодруулга №15

Аюулгүй байдлын бодлого боловсруулахад эмэгтэйчүүд оролцох нь хүйсийн тэгш эрхийн томоохон чиг хандлага мөн

Засгийн газрын хүйсийн тэгш эрхийг хэрхэн хангаж байгаа талаас нь аюулгүй байдлын бодлогыг үнэлж болно. Бээжин хотод 1994 онд Эмэгтэйчүүдийн асуудлаар чуулсан НҮБ-ын IV бага хурлын үеэр хүйсийн тэнцвэрийн бодлогыг хүйсийн тэгш эрхийг хангах дэлхий нийтийн стратеги болгон тогтоожээ. НҮБ (ЭЗНЗ)-ын тодорхойлсноор, хүйсийн тэнцвэртэй байдал гэдэг нь “... бүхий л салбар, түвшинд төлөвлөж буй аливаа үйл ажиллагаа, тухайлбал, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр зэргийн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөллийг судлах явц юм. Өөрөөр хэлбэл энэ нь эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх явдлыг улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарын бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх явцын салшгүй хэсэг болгох замаар эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд адил тэгш ашиг тус хүртэх, тэгш бус байдлыг халах стратеги болно. Үүний туйлын зорилго нь хүйсийн тэгш эрхийг хангах явдал юм”.

Эх сурвалж: НҮБ-ын ЭЗНЗ-ийн Хүлээн зөвшөөрсөн дүгнэлтүүд 1997/2

Цаашилбал, зэвсэгт хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж буй нь уламжлалт батлан хамгааллаас хүний аюулгүй байдал руу шилжих, биеийн хүч, бэлтгэл сургалтаас гадна, заримдаа тэдгээрийн оронд судалгаа, мэдээллийн технологи (банкны үйл ажиллагааг мөн оруулна), тагнуулын ажлыг илүүтэй анхаарахад тус дөхөм үзүүлнэ. Эл чиг хандлага нь эмэгтэйчүүдэд, тэр тусмаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд боловсрол, мэргэжлийн сургалтад хамрагдах ижил тэгш боломжтой байдаг орнуудад цоо шинэ боломжуудыг бий болгож байна.

Тодруулга №16

Аюулгүй байдлын салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо: шинэ нөхцөл байдал хийгээд сорилтууд

Аюулгүй байдлын салбар, нэн ялангуяа цэрэг, цагдаагийн байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн оролцоо өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан сургалт (нэн ялангуяа бие бялдарын бэлтгэл), сахилга баттай холбоотой шаардлага эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд ижил байх ёстой эсэх асуудал урган гарна.

Түүнчлэн өнөөг хүртэл цэрэг, төрийн цэрэгжсэн болон цагдаагийн байгууллагуудад хатуу зааглаж ирсэн хүйсийн ялгааг зохицуулах шаардлага тавигдаж байгаа бөгөөд нэг дор, эсвэл өөр анги нэгжид алба хаадаг гэрлэсэн болон гэрлээгүй хүмүүсийн хэрэгцээ шаардлага, түүнчлэн жирэмсэн эмэгтэйчүүд болон эцэг эхийн эрх үүрэгтэй холбоотой асуудлуудыг харгалзан үзэх ёстой болоод байна.

Цаашилбал, дүрэмт хувцасны асуудал, гадаад үзэмж ба хэт дур булаам байдал зэрэгт анхаарал хандуулж, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дүрэмт хувцас нэг ижил байх ёстой юу, эсвэл бүгд ялгаагүй эрэгтэй загвар хийштэй байх ёстой юу зэрэг асуултыг бодолцох ёстой.

Дээр дурдсан асуудлуудад шинэлэг сэтгэлгээгээр хандах нь зөв. Үндэсний хууль тогтоомж, цэрэг, төрийн цэрэгжсэн бусад байгууллага, цагдаатай холбоотой зохицуулалтуудыг шинэ нөхцөл байдалд тохируулан боловсруулах, шинэчлэх шаардлагатай.

Энхийг сахиулах ажиллагаа болон батлан хамгаалах яам дахь эмэгтэйчүүдийн оролцоо

НАТО-ын Тойм сэтгүүлийн 2001 оны зуны дугаарт дурдсанчлан, Дэлхийн II дайнаас хойш энхийг сахиулах ажиллагаанд оролцсон эмэгтэйчүүдийн тоо хэмжээ маш цөөн байна. Канад, Унгар, Франц, Нидерланд, Португаль зэрэг цөөн хэдэн орны энхийг сахиулах хүчний 5 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Гэтэл НҮБ-ын туршлагаас үзэхэд, холбогдох орон нутгийн хүн ам энхийг сахиулах ажиллагаанд дахь эмэгтэйчүүдийн оролцоог нааштайгаар хүлээн авдаг бөгөөд эл оролцоо нь энхийг сахиулах ажиллагааны үр дүнд эергээр, тухайлбал хүйсийн болон хүчирхийллийн асуудалд илүү анхаарал хандуулах зэргээр нөлөөлдөг байна.

Эмэгтэй хүнийг батлан хамгаалахын сайд, тэр байтугай дэд сайдаар томилох явдал ховор хэвээр байна. ОУПХ-оос 2000 оны 3 дугаар сард хийсэн судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдсан орнуудын дөнгөж 1.3% нь батлан хамгаалах

аюулгүй байдлын асуудал эрхэлсэн эмэгтэй сайдтай, 3.9% нь эмэгтэй дэд сайд болон яамны бусад албан тушаалтан, үүний дотор тухайн салбарын асуудал хариуцсан парламентын нарийн бичгийн даргатай байжээ (ОУПХ, НҮБ-аас хамтран гаргасан Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо: 2000 судалгааг үз).

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Мэдээлэл

- ▶ Цэрэг, төрийн цэрэгжсэн бусад байгууллага, цагдаа, тагнуулын албадын салбар нэгж, түүнчлэн тэдний сургалтын төв тус бүр дэх эмэгтэй албан хаагчдын тоо, хувь хэмжээний талаарх статистик мэдээллийг гаргуулж авах. Түүнчлэн, өндөр болон шийдвэр гаргах түвшний албан тушаал дахь эмэгтэйчүүд болон НҮБ, НАТО болон олон улсын аюулгүй байдлын асуудал хэлэлцдэг бусад байгууллагад танай улсаас суух төлөөлөлд эмэгтэйчүүдийн оролцооны талаар тоо баримт, мэдээлэл авах.

Хүйс болон хямралын зохицуулалт, сэргээн босголт*)

- ▶ Хэлэлцээрийн багийн бүрэлдэхүүнийг аль болох хүйсийн тэнцвэртэйгээр бүрдүүлэх;
- ▶ Зэвсэгт мөргөлдөөнөөс эмэгтэйчүүдэд учрах хор уршиг, энхийн төлөөх үйл явцад тэдний оруулах хувь нэмэр, хямралын дараах үе дэх эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдолтой асуудлуудыг энхийн хэлэлцээ, тохиролцоонд баттай тусгах;
- ▶ Хямралын үед эмэгтэйчүүдийн олж авсан мэдлэг, туршлага, чадавхыг сэргээн босголтын үйл ажиллагаанд оновчтой ашиглах.

Хүйс болон энхийн төлөөх ажиллагаа*)

- ▶ Энхийн төлөөх ажиллагаа болон хямралын дараах сэргээн босголд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих;
- ▶ Энхийг сахиулагчид болон олон улсын бусад ажиллагааны бие бүрэлдэхүүнийг соёлын болон хүйсийн эрхийн талаарх сургалтад хамруулах асуудлыг баталгаажуулах, боломжтой бол хууль тогтоомжид тусгах.
- ▶ Эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчсөн энхийг сахиулагч болон олон улсын бусад ажиллагааны албан хаагчийн шийтгэлийн биелэлтэд хяналт тавих.

Засгийн газар

- ▷ Батлан хамгаалахын яаманд, тухайлбал сүүлийн 10 жилийн хугацаанд, эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хашиж ирсэн албан тушаал, үүрэг хариуцлагын харьцааг тэнцвэржүүлэх. Өндөр болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд хүрэх эмэгтэйчүүдийн боломж бололцоог хууль тогтоомжид болон бодит байдал дээр эрэгтэйчүүдийнхтэй адил хэмжээнд хангасан эсэхийг хянаж үзэх.

Парламент

- ▷ Батлан хамгаалах болон аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын хорооны өмнөх болон/буюу одоогийн бүрэлдэхүүн дэх эмэгтэйчүүдийн оролцоо, эдгээр хороонд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагын түвшин ямар байгааг нягтлан үзэх.
- ▷ Эдгээр хороод хүйсийн асуудалд анхаарч байгаа эсэхийг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд хүйсийн тэнцвэр, хүйсийн мэдрэмжтэй байдлыг сайжруулах талаар шахаж ажиллах.

**) НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “Эмэгтэйчүүд хийгээд энх тайван, аюулгүй байдал” тайланд тулгуурласан зөвлөмжүүд.*

2002 оны 10 дугаар сарын 16.

Гуравдугаар хэсэг

Аюулгүй байдлын салбарын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд

Бүлэг 8

Цэрэг

Түүхийн аль ч үед цэргийн салбар оршин байсан бөгөөд цэрэг бол төр улсын илд, бамбай хэмээн үздэг. Тодруулга N°17-д үзүүлсэнчлэн 2002 оны байдлаар өөрийн гэсэн цэрэггүй улс дэлхийд тун цөөн байжээ.

Тодруулга N°17

Цэрэггүй улс орнууд

Дэлхийн зарим оронд зэвсэгт хүчин байдаггүй. Тухайлбал, Науру, Малдив, Кирибати, Самоа, Соломоны арлууд, Тувалу, Палау, Вануату зэрэг Өмнөд далайн зарим бичил орнууд; мөн Карибын тэнгисийн Сент Винсент, Гренадин, Сент Киттс, Невис, Сент Лучия, Доминика, Гренада зэргийг нэрлэж болно. Түүнчлэн, Коста Рика, Исланд, Маврикий, Панам, Зүүн Тимур, Сомали (арми бий болгох үе шатанд явж буй), Андорра, Сан Марино, Хайти зэрэг улс зэвсэгт хүчингүй боловч ихэнх нь цэрэгжсэн байгууллага, нэгжтэй (үндэсний гварди болон хил хамгаалах алба г.м).

Цэргийн чиг үүрэг

Хүйтэн дайн төгсгөл болсноор олон улсын аюулгүй байдлын орчинд үүссэн өөрчлөлт хөгжил нь дэлхийн даяарх цэргийн хүчинд ихээхэн нөлөө үзүүлсэн. Тэдэнд шинэ үүрэг хариуцлага ногдохын зэрэгцээ уламжлалт үндсэн чиг үүргээ шинэ арга барилаар гүйцэтгэх шаардлага тулгарсан юм. Өдгөө дэлхийн улс орнуудын цэргийн хүчин дараах таван чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцож байна. Үүнд:

- ✓ Өөрийн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал буюу илүү өргөнөөр авч үзвэл, өөрийн ард иргэдийг хамгаалах;
- ✓ Олон улсын энхийг сахиулах болон энхийг тогтоох ажиллагаанд оролцох;
- ✓ Гамшгаас авран хамгаалах, сэргээн босгох ажиллагаанд оролцох;
- ✓ Дотоод аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүрэг (нийгмийн хэв журам алдагдсан буюу онц байдал тохиолдсон үед түүнийг эргүүлэн тогтоож, сахиулахад иргэний хууль сахиулах байгууллагад туслалцаа үзүүлэх);
- ✓ Улс орныг төвхнүүлэхэд оролцох (нийгмийн чиг үүрэг).

Тухайн улсын хуулийн зохицуулалт, аюулгүй байдлын орчин нөхцлөөс хамаарч цэргийн хүчин эдгээр чиг үүргийг биелүүлэх түвшин нь улс бүрт харилцан адилгүй байдаг.

Бүрэн эрхт байдал, нийгмийг хамгаалах үүрэг

Аюулгүй байдлын орчны өөрчлөлт, шинэ төрлийн аюул заналаас үл хамааран цэргийн хүчний уламжлалт үүрэг болох эх орноо болон эвслийн бусад орныг гадны цэргийн халдлагаас хамгаалах үйл ажиллагаа эн тэргүүний чиг үүрэг нь хэвээр байна. Улс орны газар нутаг, улс төрийн бүрэн эрхт байдлыг хамгаалах асуудлаас гадна нийгмийг өргөн утгаар нь хамгаалах явдал үүнд мөн багтаж байгаа болно.

Хүйтэн дайнаас хойш улс үндэстний бүрэн эрхт байдалд зөвхөн гадны цэргийн хүч бус, мөн терроризм, иргэний дайн, зохион байгуулалттай гэмт хэрэг, кибер халдлага, авлига зэрэг шинэ, уламжлалт бус аюул занал эрсдэл учруулж болохыг улс төрийн удирдлага болон цэргийнхний аль аль нь сайтар ойлгох болсон юм (дэлгэрэнгүйг Тодруулга N°1-ээс үз). Өдгөө, бараг бүх орны зэвсэгт хүчинд шинэчлэл хийгдэж байна. Энэ шинэчлэлийн гурван үйл явцыг Тодруулга N°18-д тайлбарлав.

Тодруулга N°18

Батлан хамгаалахын шинэчлэл: Зорилго нь юу вэ?

Дэлхийн ихэнх орны цэргийн хүчин 1990-ээд оноос хойш эрс шинэчлэгджээ. Энэхүү шинэчлэлийн учир шалтгаан улс орон бүрт харилцан адилгүй. Ерөнхийдөө, шинэчлэлийн гурван зорилгыг тодорхойлж болно.

▷ Ардчилал

Коммунист болон дарангуйллын дэглэм, хямралын дараах олонх улс орны хувьд зэвсэгт хүчний шинэчлэлийн гол зорилго нь ардчилал байв:

- Цэргийн хүчинг ардчилсан сонгуулиар сонгогдсон улс төрийн удирдлагын өмнө хариуцлага хүлээдэг болгох; эсбөгөөс цэргийн хүчин нь эргээд ардчилалдаа заналхийлж эхэлдэг
- Цэргийн хүчинд шаардлагатай хөрөнгө мөнгийг нийгмийн бусад салбарын хэрэгцээ, шаардлагатай тэнцвэржүүлэх

▷ Аюулгүй байдлын шинэ орчин нөхцөлд дасан зохицох

- Цэргийн хэмжээ, төсвийг аюулгүй байдлын шинэ тутам аюул заналтай уялдуулах
- Энхийг сахиулах зэрэг шинэ үйл ажиллагаа явуулахад цэргийн хүчнийг бэлтгэх

Интернационалчлах

Цэргийн хүчин нь зөвхөн дотооддоо бус, бусад орны цэргийнхэнтэй хамтран үйл ажиллагаа явуулах нь ихэсч байна. Олон улсын эдгээр хамтын ажиллагаа нь тухай бүртээ НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа эсвэл аль нэг эвслийн хүрээндэх урт хугацааны ажиллагаа (НАТО г.м), эсвэл хоёр болон олон талт хэлбэртэй байж болох юм.

- Цэргийг (хэсэгчлэн) олон улсын командлал, зохион байгуулалтын бүтцэд багтаах
- Зэвсэг техник, бэлтгэл, сургалт, хэл, мэдээлэл, команд-хяналтын тогтолцооны хувьд бусад улсын цэрэгтэй хамтран ажиллах чадавхыг өсгөх (цэргийн харилцан ажиллагаа)

Олон улсын цэргийн байнгын анги нэгжүүд:

- Герман-Нидерландын I корпус
- Балтын батальон (Литва, Эстони, Латви)
- Польш-Дани-Германы Корпус
- Словак, Унгар, Румын, Украин улсын Олон улсын инженерийн нэгдсэн батальон ("TISA" батальон)

Олон улсын энх тайванд хувь нэмэр оруулах

Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн хүчин дор хаяж хоёр шалтгааны улмаас оролцдог. Нэгдүгээрт, хямралаас урьдчилан сэргийлж, бүс нутгийн тогтворгүй байдал, эдийн засгийн хэвийн хөгжлийг тасалдуулах, дүрвэгсдийн хяналтгүй урсгал үүсэх зэрэг сөрөг үр дагавар үүсэхээс зайлсхийх. Хоёрдугаарт, хүний аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулж, хямралт бүс нутаг дахь энгийн иргэдийг хамгаалах. Сүүлийн үед гарсан хямрал, зэвсэгт мөргөлдөөн улам хэрцгий шинжтэй болж, энгийн иргэд үлэмж хохирч байгаагаас үүдэн олон улсын хамтын нийгэмлэг хүний аюулгүй байдал, тэр дундаа хүний эрхийг хангах асуудлыг бодлогын шинж чанартай чухал зорилт болгон дэвшүүлэх болсон. Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны нэг давуу тал нь бодит нөхцөл байдалд цэргийн анги салбарыг сургах, туршлага хуримтлуулах боломж юм.

Гамшгаас авран хамгаалах, сэргээн босгох ажиллагаа

Аль ч улс газар хөдлөлт, үер, түймэр, нисэх онгоцны сүйрэл зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшигт өртөж байсан эсвэл өртөх магадлалтай байдаг. Ийм онцгой нөхцөл байдал үүссэн үед иргэний удирдлагууд гамшгаас авран хамгаалах, яаралтай тусламж хүргэх ажилд цэргийн хүчинг татан оролцуулдаг. Энэ үед цэргийнхэн нийгмийн дэг журам сахиулах, хүнс, эмнэлгийн болон бусад

тусламжийг хүргэх, харилцаа холбоо, тээврийн шугамыг хэвийн ажиллуулах зэрэг үүрэг гүйцэтгэдэг. Ийнхүү авран туслах ажиллагаанд оролцсоноор нийгэм дэх цэргийнхний үүрэг, үйл ажиллагаа ил тод харагдаж, эерэг сэтгэгдэл төрүүлэн, олон нийтийн дэмжлэг хүлээх зэрэг сайн талуудтай.

Хууль сахиулах байгууллагуудад дэмжлэг үзүүлэх

Зарим орны цэргийн хүчин хууль сахиулах иргэний байгууллагад тусалцаа үзүүлэх чиг үүрэгтэй байдаг. Гэхдээ ийм чиг үүрэг ихээхэн эргэлзээтэй. Зарим тохиолдолд нийгэмд учирч буй аюул занал нь цагдаа, иргэний байгууллагууд дангаараа сөрөн зогсож чадахааргүй дэндүү ноцтой бөгөөд цэргийн хүчний тусалцаа шаардлагатай байх нь бий. Тухайлбал, террорист халдлага, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа зэргийг дурдаж болно. Иргэний хууль сахиулах ажиллагаанд цэргийн хүч ашигласнаас үүсч болох зарим эрсдлийг дурдвал:

- ✓ Цэргийн хүчинд тавих иргэний хяналтыг алдагдуулах;
- ✓ Цэргийн хүчинг улс төржүүлэхэд хүргэдэг;
- ✓ Цэргийн хүчин нийгмийн дэг журмыг зөвхөн түр хугацаанд тогтоох боломжтой, харин хямрал, эмх замбараагүй байдлын улс төр, нийгэм, эдийн засгийн уг үндсийг арилгаж чадахгүй;
- ✓ Зэвсэгт хүчин байлдааны ажиллагаа явуулах бэлтгэлтэй байдаг бөгөөд дотооддоо улс төрийн зорилтуудыг хэрэгжүүлэх болон энгийн иргэдтэй холбоотой ажиллагаа явуулах зорилгоор бэлтгэгддэггүй;
- ✓ Чиг үүргийн давхцалаас үүдэн цагдаа, зэвсэгт хүчний хооронд сөргөлдөөн үүсэх эрсдэлтэй.

Тодруулга №19

Иргэний хууль сахиулах ажиллагаанд цэргийн хүчийг ашиглах нь: Өмнөд Африкийн жишээнээс

(...) үүсээд буй нийгмийг хамарсан эмх замбараагүй байдал нь Өмнөд Африкийн Цагдаагийн байгууллагын бүтцүүдийн чадавхаас давсан эсвэл үндэсний батлан хамгаалах онц байдал зарласан зэрэг онц ноцтой нөхцөлд л Өмнөд Африкийн Үндэсний Батлан хамгаалах Хүчин (ӨАҮБХХ)-г дайчилдаг байна (...). Цэргийн хүчийг дотооддоо ашиглах ажиллагааг парламентын хяналтын дор, хүний түгээмэл эрхийн талаарх үндсэн хуулийн заалтуудыг баримтлан явуулах бөгөөд хуулиар зохицуулагдана.

Эх сурвалж: “Ардчилсан орон дахь батлан хамгаалал”. Бүгд Найрамдах Өмнөд Африк Улсын Батлан хамгаалах цагаан ном. 1996 оны 5 дугаар сар.

Нийгмийн чиг үүргүүд

Цэргийн алба, нэн ялангуяа хугацаат цэргийн албанд үндэс угсаа, нийгмийн давхарга хамааралгүйгээр тухайн улсын өнцөг булан бүрээс татагдан ирсэн залуус (ихэвчлэн эрэгтэй) нэгэн дор цугларч, хамтран ажиллах нь улс үндэстэн бүрдэх, төлөвших үйл явцад хувь нэмэр оруулдаг гэж үздэг. Энэ нь нэн ялангуяа цагаачид эсвэл олон үндэстэн ястнаас бүрдсэн улсад нэн чухал бөгөөд хугацаат цэргийн алба “хайлуулах тогоо”-ны үүргийг гүйцэтгэдэг байна. Цэргийн албаны бас нэг үүрэг нь хүмүүст боловсрол эзэмших боломж олгодогт оршино. Хөдөлмөр эрхлэлтийн туршлага байхгүй эсвэл багатай хүмүүсийн хувьд цэргийн алба хаах нь хожоо болдог. Нэн ялангуяа хөгжиж буй орнуудад, цэргийн албаны нийгмийн бас нэг чиг үүрэг нь боловсрол, эрүүлийг хамгаалах, экологийн доройтлоос сэргийлэх зэрэгт ахмад дайчдыг ашиглах хэлбэрээр алслагдмал бүс нутгийн иргэний удирдлагад туслалцаа дэмжлэг үзүүлэх явдал байдаг.

Энэ төрлийн үйл ажиллагаа нь нийгэмд цэргийн хүчин хэрхэн бүтээлчээр хувь нэмэр оруулж болохын жишээ юм. Гэвч зарим оронд цэргийнхэн улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд сөргөөр оролцдог тохиолдол ч бий. Жишээ нь, зарим оронд тэд улс төрд хөндлөнгөөс оролцож, засгийн газартаа заналхийлдэг бол өөр бусдад арилжааны ажиллагаа явуулж, ардчилсан хяналт, төсвөөс гадуур нэмэлт ашиг хуримтлуулдаг муу туршлага байсаар байна.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Цэргийн үйл ажиллагааны талаар

- ▷ Цэргийн үйл ажиллагаа дараах шаардлага хангаж байгаа эсэхийг баталгаажуулах. Үүнд:
 - Хууль тогтоомж, цэргийн дүрэм журамд тодорхой заасан байх;
 - Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бодлоготой нийцэж байх;
 - Улс, нийгмийн аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагад тохирч байх.
 - Цэргийн бус чиг үүрэг нь улс орны бүрэн эрхт байдлыг хамгаалах, олон улсын дэг журмыг сахиулахад хувь нэмэр оруулах үндсэн үүргээ биелүүлэх бэлэн байдалд нь сөргөөр нөлөөлдөггүй байх.

Батлан хамгаалахын шинэчлэлийн талаар

- ▷ Эрх мэдэл бүхий парламентын хороо(д) нь төлөвлөж буй болон хэрэгжүүлсэн шинэчлэлийн талаар холбогдох дүгнэлт бүхий дэлгэрэнгүй тайлан, мэдээлэл хүлээн авсан байх, үүнтэй холбогдуулан асуудал дэвшүүлэх, тухайлбал асуулга зохион байгуулах зэрэг арга хэмжээ авах.

Иргэний хууль сахиулах ажиллагаанд цэргийн хүчийг ашиглах талаар

- ▷ Зарчмын хувьд иргэний хууль сахиулах ажиллагаанд цэргийн хүчийг татан оролцуулах нь зохисгүй хэдий ч, үүнээс өөр гарцгүй тохиолдолд парламент дараах арга хэмжээг авах шаардлагатай:
- ▷ Иргэний хууль сахиулах ажиллагаан дахь цэргийн оролцоог дараах хүчин зүйлийг харгалзан үзсэний дагуу яв цав тодорхойлж, хязгаар тогтоож, хуулиар зохицуулсан байх. Үүнд:
 - Ямар нөхцөл байдал тулгарсан үед хэрэглэх;
 - Оролцооны төлөв байдал, хязгаарлалт;
 - Оролцооны үргэлжлэх хугацаа;
 - Тухай бүрт ямар төрлийн анги, салбарыг дайчлах;
 - Цэргийн хүч оролцуулах, дайчилгааг дуусгавар болгох талаар шийдвэр гаргах эрх бүхий байгууллага (ууд);
 - Хуулийн аливаа зөрчил эсвэл хүний эрхийн аливаа зөрчлийг шүүн таслах эрх бүхий шүүх г.м.
- ▷ Байр, орон сууцанд нэгжлэг хийх, баривчилгаа үйлдэх, гал нээхийн өмнө эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах ажиллагааг хуульчлах.
- ▷ Иргэний хууль сахиулах ажиллагаан дахь цэргийн хүчний оролцоо нь олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомж, зарчмуудтай нийцэж байгаа эсэхэд хяналт тавих парламентын болон бусад төрлийн механизм байх асуудлыг баталгаатай болгох.

Бүлэг 9

Төрийн бусад цэрэгжсэн байгууллага

Ямар улс оронд, ямар нөхцөл байдалд хэрэглэгдэж байгаагаас хамаараад төрийн бусад цэрэгжсэн байгууллага (ТБЦБ) гэсэн нэр томъёо харилцан адилгүй утгыг илэрхийлж болно. Гэхдээ аль ч тохиолдолд ТБЦБ-ыг хувийн хэвшлийн цэрэгжсэн байгууллагаас ялгаж харах нь зүйтэй. Лондон хотноо төвтэй Олон улсын стратегийн судалгааны хүрээлэнгээс (ОУССХ) ТБЦБ гэсэн ойлголтод (заримдаа хагас цэргийн байгууллага гэх нь бий) цэргийн тактикт суралцсан, зэвсэг хэрэгслээр хангагдсан, дайны нөхцөлд цэргийн удирдлага дор ажилладаг бол “жандарм”, гаалийн байгууллага, хил хамгаалах алба зэргийг хамруулж болно гэжээ.

Дэлхийн ихэнх улс орнууд өөрийн үндсэн цэргийн хүчнээс гадна ТБЦБ-тай байдаг. Эдгээр байгууллагууд цэргийн байгууллагатай нягт холбоотой байх ба зарим тохиолдолд цэргийн хүчин тэднийг шаардлагатай техник хэрэгслээр хангаж, ТБЦБ-уудыг цэргийн баазад нэвтрүүлэх, шаардлагатай сургалт, бусад туслалцаанд хамруулах зэргээр хамтран ажилладаг.

ТБЦБ иргэний цагдаагийн ажиллагаанд тохиромжгүй цэргийн арга техник ашигласан болон/буюу хүний эрхийн ноцтой зөрчил үйлдсэн тохиолдол хэд хэд гарч байсан. Эдгээр байгууллагын хувьд иргэний цагдаагийн чиг үүрэг, цэргийн чиг үүрэг хоорондын зааг ялгаа бүдэг байдаг учир гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг нь урьдчилж нарийн тодорхойлсон байх ёстой. Ихэнх тохиолдолд дотоодын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тэднийг оролцуулахгүй байх нь зүйтэй. Энэ талаар парламент шаардлагатай хууль тогтоомжийг батлахын зэрэгцээ, засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих ёстой. Нөгөө талаас гүйцэтгэх эрх мэдлийг эдлэгч Ерөнхийлөгч буюу Ерөнхий сайд нь төрөөс санхүүжүүлж буй бүх хүчин парламентын хяналтад багтах ёстой гэсэн шалтгаанаас гадна, ТБЦБ-ын үйл ажиллагаа хяналтгүйгээр өргөн хүрээг хамарсан тохиолдолд үүсэх эрсдэл, аюул заналаас урьдчилан сэргийлэх үүднээс эдгээр байгууллагад парламентаас тавих хяналтыг дэмжих нь зүйтэй.

Тодруулга №20

Зарим орны төрийн цэрэгжсэн нэгжийн жишээнээс

Улс	Зэвсэгт хүчин дэх нийт идэвхтэй алба хаагчдын тоо	Төрийн бусад цэрэгжсэн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо	Төрийн бусад цэрэгжсэн нэгжийн төрөл
Финлянд	31,700	3,400	Хилийн гварди
АНУ	1,365,800	53,000	Иргэний агаарын эргүүл
ОХУ	1,004,100	423,000	Хил хамгаалах алба, Дотоод явдлын яамны цэрэг, ОХУ-ыг хамгаалах хүч, Холбооны аюулгүй байдлын алба, Холбооны харилцаа холбоо, мэдээллийн агентлаг, Төмөр замын цэрэг г.м.
Марокко	198,500	42,000	Жандарм, Нэмэлт хүч г.м.
Франц	294,430	94,950	Жандарм
Итали	250,600	252,500	Нэн ялангуяа 'Карабиниери' болон Дотоод явдлын яамны Олон нийтийн аюулгүй байдлын гварди
Турк	609,700	220,200	Жандарм /Үндэсний гварди, Эргийн хамгаалах алба
Буркина Фасо	10,000	4,450	Жандарм, аюулгүй байдлын компаниуд
Чили	87,000	29,500	'Карабинеро'-ууд
БНСУ	683,000	3,500,000	Иргэний батлан хамгаалах корпус, Тэнгисийн цагдаа
Индонез	297,000	195,000	Цагдаа, тэнгисийн цагдаа болон орон нутгийн цэргийн нэмэлт хүч

Эх сурвалж: ОУССХ, Цэргийн тэнцвэр 2000-2001, Лондон

Төрийн бусад цэрэгжсэн байгууллагын чиг үүрэг

ТБЦБ өргөн хүрээтэй чиг үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэдгээрээс хамгийн чухлыг дор жагсаалаа. Үүнд:

- ✓ Хилийн хяналт, хамгаалалт, үүнд бараа бүтээгдэхүүний хууль бус наймаа болон хүний наймаа орно;
- ✓ Эмх замбараагүй байдлыг хянах, таслан зогсоох;
- ✓ Онц байдалд нийгмийн хэв журам сахиулах, төрийн тэргүүн болон цөмийн эрчим хүчний станц зэрэг онц чухал объектын хамгаалалт.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Харилцан адил үйлчлэх тул өмнөх болон дараагийн бүлэг дэх мөн хэсгийг үзнэ үү.

Цагдаагийн бүтцүүд

Ардчилсан орны цагдаа

Цагдаа ямар ч нөхцөлд хууль сахих ёсыг даган биелүүлэх ёстой ба сахиулах ёстой тэр л хуулиндаа мөн захирагдаж байдаг. Улмаар цагдаагийн гол үүрэг нь эрүүгийн шүүн таслах тогтолцооны бусад байгууллагууд болох прокурор, шүүх, засан хүмүүжүүлэх нэгжээс ихээхэн ялгаатай. Сайн засаглалын үүднээс авч үзвэл, бүх орон хувь хүний эрх чөлөөг хүндэлж, хүний эрхийг дээдлэхийн сацуу олон нийтийн аюулгүй байдлыг хангаж байх ёстой. Ардчилсан орны иргэд цагдаа бүгдэд шударга, тэгш, нөлөөллөөс ангид, тогтсон хэм хэмжээний дагуу үйлчилнэ гэсэн хүлээлттэй байдаг. Цагдаагаас иргэдэд хэрхэн хандаж байгаа байдал нь тухайн улсын ардчиллын чанарын гол үзүүлэлт болж байдаг юм.

Тодруулга №21

Ардчилсан цагдаагийн үндсэн хэв шинж

- ▷ Цагдаагийн алба хууль дээдлэх ёсыг сахихын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн дүрмийн хүрээнд ажиллах ёстой;
- ▷ Ардчилсан цагдаа нь хүний эрхийг дээдлэхийн сацуу олон нийтийн аюулгүй байдлыг үр дүнтэйгээр хангахыг зорино;
- ▷ Цагдаагийн хариуцлагатай байдлыг хангахын тулд ил тод байдал, гадаад болон дотоод хяналтын тогтолцоо оршин байх ёстой;
- ▷ Ардчилсан цагдаа нь доороос дээшээ чиглэсэн үйл явц бөгөөд иргэн нэг бүрийн болон олон нийтийн нийгэмлэгүүдийн хэрэгцээ, шаардлагад хариу үйлдэл үзүүлж, олон нийтийн итгэл, зөвшөөрөл, дэмжлэгийг хүлээсэн байх ёстой. Тийм ч учир тэдний үйл ажиллагаа ил тод байдал, харилцан ярианд тулгуурласан байдаг бөгөөд олон оронд тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагад түргэн шуурхай нийцэж ажиллахын тулд төвлөрсөн бүтцийг задалсан байдаг.

Тусгайлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага

Цагдаагийн байгууллага нь гүйцэтгэх засгийн нэгэн салбар бөгөөд нийгэмд хууль ёсны дагуу албан хүч хэрэглэх эрхтэй цорын ганц байгууллага гэхэд болно.

Чухам энэ чадавхыг эзэмшдэг учир цагдаагийн байгууллага төрийн дарангуйлал, хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, авилгатай холбоотой зорилгоор ашиглагдах эрсдэл өндөртэй байдаг. Тийм ч учир, ардчилсан орнуудад цагдаагийн алба нь улс төрчид, хүнд сурталтнууд, байгууллагын өөрийн ашиг сонирхлын төлөө бус харин нийгэм, олон нийтийн ашиг сонирхолд үйлчилж байгааг баталгаажуулах тусгайлсан арга хэмжээ авсан байдаг. Цагдаагийн бүтэц нь онцгой эрхтэй бөгөөд үйл ажиллагааны хараат бус байдлаар хангагдсан байх ёстой хэдий ч хууль сахиулах ажиллагаандаа хөндлөнгийн нөлөөлөлд үл автаж, мэргэжлийн өндөр түвшинд ажиллах ёстой. Түүнчлэн цагдаагийн албан хаагчид албан болон албан бус мэргэжлийн ёс зүйн дүрмийг мэддэг, дагаж мөрддөг байх ёстой. Цагдаагийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн нэг чухал хэсэг нь хүний амьд явах эрхийг хүндэтгэх, зөвхөн хуулинд заасан зорилгын хүрээнд, зайлшгүй шаардлагатай бөгөөд зөвшөөрөгдсөн хэмжээнд хүч хэрэглэх зарчим юм. Мөн цагдаагаас хүч хэрэглэх тохиолдолд пропорциональ зарчмыг байнга харгалзаж үзэх ёстой. Гадаад буюу улс төрийн болон шүүхийн хяналтаас гадна (Бүлэг 3-ыг үз), дотоод буюу албан хариуцлагын бүтэц зайлшгүй байх ёстой. Цагдаагийн байгууллага, албан хаагчаас гаргасан зөрчил, олон нийтийн зүгээс гаргасан гомдлыг хянан шалгах тогтолцоо мэргэжлийн цагдаагийн үйл ажиллагаанд мөн заавал байна.

Тодруулга №22

Аюултай нөхцөл байдал ба завхруулга

“Аюулгүй байдлыг хангах хүчнүүд ардчилсан бус засаглалтай байх нь аюулгүй байдлын тэргүүлэх чиглэлүүдийг завхруулдаг. Олон оронд цэргийн аюулгүй байдалд өрөөсгөлөөр хандсаны улмаас цагдааг цэрэгжүүлэх (ингэснээр цэргийн хүчнээс ялгарах чиг үүргийн ялгааг улам бүр бүдгэрүүлж), эсвэл тэдний санхүүжилтийг хэт танаснаар иргэдийн аюулгүй байдлыг хангах чадавхыг хязгаарлах хандлага ажиглагддаг. Нэн ялангуяа буурай орлоготой орнуудад цагдаа болон аюулгүй байдлыг хангах бусад байгууллагын албан хаагчид амь зогоох төдий цалинтай, сургалт мэргэшил хязгаарлагдмал бөгөөд зарим тохиолдолд байдаггүй, удирдлагын түвшинд авлигад идэгдсэн, боловсролын түвшин доогуур байдаг.” ... “Шинэ залуу ардчилсан орнууд дахь улс төрийн албан тушаалтнууд өөрийн албан тушаал, байр сууриа хадгалахын тулд аюулгүй байдлыг хангах байгууллагууд, түүний дотор цэргийн хүчинд дулдуйдах нь олонтаа бөгөөд, энэ нь ихэвчлэн тэдгээр байгууллагууд нийгэмд хамгийн хүчирхэг байдагтай холбоотой. Эрх баригчид өөрийн эрх мэдлийг хадгалан үлдэх гэсэн мөн адил шалтгааны улмаас цэргийн хүчин дэх ил тод, хариуцлагатай байдлыг эсэргүүцэх магадлалтай.”

Хүний хөгжлийн тайлан, 2002

Олон нийтийн санаачлагууд

Цагдаагийн байгууллагад тавих ардчилсан хяналтыг хүний эрхийн чиглэлээрх олон нийтийн байгууллагууд зэрэг цагдаад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх албан бус, доороос дээшээ чиглэлтэй санаачлагуудын тусламжтайгаар сайжруулж болно. Түүнчлэн, иргэдийн гомдлыг хянан шийдвэрлэдэг омбудсмен зэрэг иргэний хяналтын байгууллагууд цагдаагийн хариуцлагыг өндөрсгөхөд тустай байдаг. Зарим тохиолдолд иргэний нийгэм, орон нутгийн удирдлагын төлөөллийг багтаасан орон нутгийн аюулгүй байдлын зөвлөл, түүнтэй төстэй бүтэц нь орон нутгийн цагдаагийн үйл ажиллагааг чанаржуулахад сайнаар нөлөөлөх нь бий. Үүний зэрэгцээ хөндлөнгийн мэдээлэгчид болон энэ чиглэлээр хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудад цагдаа, тагнуулын албад, цэргийн хүчнээс дарамт, заналхийлэл үзүүлэхээс сэргийлсэн хууль тогтоомжийг баталсан байх шаардлагатай.

Тодруулга №23

Эритрея Улсын цагдаагийн үйл ажиллагаа: хөгжил дэвшилт

Цагдаагийн байгууллагаас гадаад орчинтойгоо харилцах харьцаа нь ямагт олон талтай байдаг. Энэ байгууллага үйл ажиллагааныхаа хоёр үндсэн чиглэл болох хууль сахиулах зорилгоор хүч хэрэглэх болон олон нийтэд үйлчлэх гэсэн чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлдгээс үүнийг ажиглаж болно. Хөгжиж буй гэж нэрлэгддэг Эритрея зэрэг орнуудад энэ зөрчил бүр ч тод томруун харагддаг. Энэ улс Этиопоос тусгаарлахаар 30 жилийн турш тэмцсэн бөгөөд 1998, 1999 онуудад дахин мөргөлдөөн эхэлж, өнөөг хүртэл бүрэн дуусаагүй байна. Тус улс ойролцоогоор 5,000 хүний бүрэлдэхүүнтэй цагдаагийн албандаа 1990-ээд оны эхээр хуучин чөлөөлөх армийн офицеруудыг олноор оруулж эхэлжээ. Үүний шалтгаан нь маш энгийн буюу Засгийн газар хуучин дайчиддаа ямар нэг байдлаар санаа тавих ёстой байв. Удирдах түвшний зарим албан тушаалтнууд өмнөх Эритрея болон Этиопын нэгдмэл улсад цагдаагийн алба хашиж байсан туршлагатай хүмүүс байжээ.

Нидерландын Засгийн газрын бүрэн дэмжлэгтэйгээр гэмт хэргийг эрэн сурвалжлах, мөрдөн байцаах арга барилыг сайжруулах, цагдаагийн академи байгуулах, сургалтын хөтөлбөр зохиох зэрэг техникийн тусалцаа үзүүлсэн бөгөөд түүний зэрэгцээ ядаж хандивлагчид болон тус улсын цөөнх элит давхрагынхны хувьд цагдаагийн соёлыг өөрчлөх зайлшгүй шаардлага харагдаж байлаа. Өмнө цэргийн алба хааж байсан хүмүүс хүч хэрэглэх асуудалд, тухайлбал Английн жирийн цагдаагаас эрс ялгаатай байр суурьтай байсан. Нидерландын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн соёлын өөрчлөлтийн төсөл нь хамгийн бага хүчээр хууль, хэв журам сахиулах ардчилсан цагдаагийн үйл ажиллагааг ажил хэрэг болгох гол зорилготой байлаа.

Эх сурвалж: Каспер У.Вруум, Маастрихтын их сургууль, Нидерландын Вант Улс, Эритрея Улсын Цагдаагийн албаны соёлыг шинэчлэх төсөлд оролцож байсан, 2002.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Ардчилсан тогтолцоо

- ▷ Цагдаагийн байгууллага хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих.
- ▷ Цагдаагийн байгууллага бүх иргэдэд тэгш, шударга, тогтсон хэм хэмжээний дагуу үйлчлэх ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа баримталж байгаа эсэхэд хяналт тавих. Үүнтэй холбогдуулан, НҮБ-аас 1979 онд гаргасан Хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан Ёс зүйн дүрмийг (Тодруулга N°65-ыг үз) танай оронд баримталдаг эсэхийг судалж үзэх.

Сургалт

- ▷ Цагдаагийн мэргэжлийн болон дахин сургалтын агуулгад боломжит хамгийн бага хүчээр хууль, нийгмийн хэв журам сахиулах талаар, улмаар ардчилсан, ёс зүйн үнэт зүйлс, хүний эрхийн болон хүйсийн тэгш эрхийн асуудлыг тухайлан оруулахад анхаарах: Бүлэг 7-г үзнэ үү.

Үүний зэрэгцээ, Зургаа, Долоо, Наймдугаар хэсгүүдээс санхүүгийн, хүний нөөцийн болон эд материалын нөөцийн талаар дэлгэрүүлж үзнэ үү.

Нууц болон тагнуулын албад

Тагнуулын албад (заримдаа “аюулгүй байдлын алба” гэж нэрлэгддэг) нь ямар ч төр улсын үндсэн нэгж бөгөөд тухайн улсын аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хамгаалахтай холбоотой мэдээллийг аливаа нөлөөллөөс ангид байдлаар боловруулан, дүн шинжилгээ хийж нийлүүлэх үүрэгтэй байдаг. Тэдгээр байгууллагын гол үйл ажиллагааг засгийн газар хариуцдаг хэдий ч, түүнд нь хяналт тавих чухал үүргийг парламент гүйцэтгэдэг.

Олон улсын терроризм, мансууруулах бодисын наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус цагаачлал зэргээс үүдэлтэй дотоод аюулгүй байдлын шинэ аюул занал, эрсдлүүд нь тагнуулын чадавхыг сайжруулахыг шаардаж байна. Нэн ялангуяа 9 дүгээр сарын 11-ний халдлагын улмаас тагнуулын үйл ажиллагааны чадавх, чанар улам ч ач холбогдолтой болжээ. Халдлага гарсны дараа хэд хэдэн орны засгийн газар интернэт, утсан харилцаа холбоонд хяналт тавих онцгой эрхийг нэмж олгох зэргээр тагнуулын албадынхаа эрх мэдлийг өргөтгөсөн байна (терроризмын талаар Бүлэг 20-ийг үз).

Шинэ дэвшилтэт технологийн ачаар сэжигтэнг хянах, ажиглах, олж илрүүлэх, баривчлах нөөц бололцоо улам ихсэхийн зэрэгцээ тагнуулын албадын дотоод болон гадаад хамтын ажиллагаа өргөжиж байна. Эдгээр шинэ тутам чадавх, эрх мэдлийн хэрэгжилт нь олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль, зарчмуудтай зөрчилдөхгүй гэдэгт хяналт тавих үүрэг парламентад голчлон оногдож байгаа юм.

Тагнуулын албадын мөн чанар

Тагнуулын үндсэн мөн чанар нь мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхэд оршдог. Нэг талаас ийм ажиллагаа явуулахад нууцлалын өндөр шаардлагыг хангасан байх ёстой. Харин нөгөө талаас, энэ мэдээллийг дотоодын улс төрийн зорилгоор урвуулан ашиглах эрсдэл бий. Ингэснээр тагнуулын албад эргээд өөрсдийн хамгаалах ёстой нийгэм, улс төрийн байгуулалдаа заналхийлж эхэлдэг. Ийм ч учир гүйцэтгэх засгийн хяналтаас гадна, тагнуулын албадад ардчилсан, парламентын хяналт тавих хэрэгцээ зайлшгүй шаардлагатай юм. Хяналт шалгалтын ийм тэнцвэрт тогтолцоо л засгийн газар эсвэл парламентаас тагнуулын албыг улс төрийн зорилгоор ашиглахаас сэргийлж чадна.

Ардчилсан орны тагнуулын алба нь үйл ажиллагааны үр дүн өндөртэй, улс төрийн хувьд төвийг сахисан (нам бус), мэргэжлийн ёс зүйг баримталдаг, хуулиар олгосон эрх хэмжээ болон тухайн улсынхаа үндсэн хуулийн хэм хэмжээ, ардчилсан зарчмуудын хүрээнд ажиллах ёстой.

Тагнуулын бүтцэд тавих ардчилсан хяналт нь хуулийн хүрээнд нарийн тодорхой зохицуулагдсан байхын зэрэгцээ улсын хэмжээнд тагнуулын байгууллага шинээр байгуулах эсэхийг парламентаас баталдаг байх ёстой. Түүнчлэн, тагнуулын алба тус бүрийн эрх мэдэл, үйл ажиллагааны арга барил, хариуцлагын арга хэлбэр, тогтолцоог дээрх хуулиар зохицуулсан байх ёстой.

Тодруулга №24

Парламент ба тагнуулын албадын тусгай төсөв: Аргентины жишээ

“Үндэсний тагнуулын тухай хууль №25.520 (2001 оны 11 дүгээр сарын 27). 37 дугаар зүйл: “Үндэсний конгрессын дээд, доод танхимын төлөөлөөс бүрдэх Хороо нь Үндэсний тагнуулын үйл ажиллагааны зүйл бүрт хуваарилсан төсвийг хянах үүрэгтэй. Энэ зорилгоор, тус Хороо нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд шаардагдах аливаа үйл ажиллагааг явуулах эрхтэй байдаг. Тухайлбал:

1. Гүйцэтгэх засгаас Конгресст өргөн барьсан Төсвийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох. Энэ зорилгоор Гүйцэтгэх эрх мэдэл эдлэгч нь бүх шаардлагатай баримт бичиг, түүний дотор а) шүүх байгууллагаас өргөн мэдүүлсэн нууцын бүх зэрэглэлд хамаарах төсвийн хавсралт; б) зардлын зорилго, зарцуулалтын хөтөлбөр, үр дүнгийн талаарх хавсралтыг тус хороонд хүрүүлсэн байна.
2. Энэ хуульд нэр дурдсан, өөрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, өгөгдөл, тайлан өгөх үүрэг бүхий тагнуулын бүх нэгжээс туслалцаа хүсэх. Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 39 дүгээр зүйлд нэр дурдсан мэдээлэл, баримт бичгийг мөн шаардаж авах эрхтэй.
3. Төсвийн хуваарилалт Төсвийн тухай хуулинд заасан зорилгын дагуу хийгдэж байгаа эсэхийг хянах.
4. Үндэсний Конгресс болон Ерөнхийлөгчид дараах мэдээллийг агуулсан тайлан гаргаж өгөх. Үүнд: а) тагнуулын албадад хуваарилсан төслийн гүйцэтгэлд хийсэн шинжилгээ, үнэлгээ; б) Хорооноос хэрэгжүүлсэн хяналт, шалгалтын ажлын танилцуулга болон гаргасан санал зөвлөмжүүд.”

Эх сурвалж: Аргентины Үндэсний тагнуулын тухай хууль
№25.520, 2001 оны 11 дүгээр сарын 27.

Ихэнх орнуудад албан ёсны хяналтыг ямар нэг хэмжээнд, голдуу парламентын хяналтын хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг. Зарим тохиолдолд, батлан хамгаалах, зэвсэгт хүчний асуудал хариуцсан парламентын хороодын чиг үүрэгт тагнуулын хяналтыг багтаахаар өргөтгөсөн байдаг бол бусад оронд парламентын хороо буюу дэд хороог тусгайлан байгуулж, тагнуул, нууц албадын хяналтыг хариуцуулдаг байна.

Парламентын хяналтын хороод нь шаардлагатай мэдээлэлтэй танилцах, тагнуулын байгууллагын удирдлагын томилгоонд оролцох, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх эрхээр хангагдсан байх ёстой (төсвийн тусгай зүйл, заалтын талаар Тодруулга №24-ийг үз).

Мөн зарим оронд Парламентын хороо байхгүй тохиолдолд, эсвэл түүнтэй зэрэгцүүлэн засгийн газрын бүтцээс гадна орших тагнуулын хяналтын хороог албан ёсоор байгуулдаг байна. Засгийн газрын түвшинд тагнуулын албадад хяналт тавих үүрэгтэй нэгжүүд нь улс төрийн олон талт төлөөллөөс бүрдсэн парламентын хороодыг бодвол бие даасан, хараат бус байдал харьцангуй багатай байдаг.

Тодруулга №25

Парламентын хороод нууц баримт бичигтэй ажиллах зарим туршлага

- ▷ Шаардлагатай бол хорооны хуралдааныг хаалттай явуулна.
- ▷ Хороо нь нууц биш асуудлаар эхлээд парламентын танхимд, дараа нь олон нийтэд мэдээлэл өгдөг.
- ▷ Хороо нь тухайн үед явагдаж буй ажиллагаатай холбогдолгүй, тагнуулын албаны албан хаагчдын нэрийг задлаагүй гэсэн нөхцлийг хангах аливаа мэдээллийг гаргуулж авах эрхтэй байна.
- ▷ Хорооны гишүүдийн энгийн олонх, эсвэл тодорхой хувийн олонхийн саналаар тухайн мэдээллийг ил болгосноор олон нийтийн эрх ашиг хангагдана хэмээн үзсэн тохиолдолд Хороо нь аливаа мэдээллийг ил болгох эрхтэй байна.
- ▷ Хороо нь өөрийн шаардах мэдээлэлд хязгаарлалт тавихгүй. Тухайн асуудлыг бүрэн ойлгоход шаардлагатай бол тагнуулын албадыг хариуцсан сайд өөрийн санаачилгаар Хороонд мэдээлэл гаргаж өгнө.

Ардчилсан орны тагнуулын албанд тавигдах шалгуур үзүүлэлтүүд

Аливаа улсын тагнуулын албадад тавих хяналтын хэлбэр нь тухайн орны хууль эрх зүйт ёсны уламжлал, улс төрийн тогтолцоо, түүхэн хүчин зүйлсээс хамаарна. Жишээ нь, Английн нийтийн хуулийн уламжлал бүхий зарим оронд шүүхийн хяналтыг илүүд үздэг бол эх газрын Европын орнууд болон орчин үеийн түүхэндээ цагдаагийн дарангуйлах тогтолцоотой байсан орнууд эсрэгээр хууль тогтоох байгууллагын хяналтыг илүүд үздэг. Америкийн Нэгдсэн Улсын хувьд хяналтын тогтолцоог холбооны гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх салбарууддаа тараан суулгасан байдаг. Мөн зарим ардчилсан орнууд тагнуулын албадын хүний эрхийн зөрчлийг хянан шалгаж, үр дүнг олон нийтэд мэдээлэх эрхтэй омбудсмэнийг байгуулсан байдаг (омбудсмэний талаар Бүлэг 16-г үз).

Хамрах хүрээ

Тагнуулын албанд тавих хяналтын хамрах хүрээ ихэвчлэн хязгаарлагдмал байдаг. Энэ хязгаарлалтыг тагнуулын үйл ажиллагааны төрөл (дотоод/сөрөх тагнуул буюу гадаад тагнуул), эсвэл хариуцах чиглэлийн дагуу тогтоож болно (ажиллагааны арга барил, нууц ажил).

Парламент дахь нээлттэй болон хаалттай хэлэлцүүлэг

Ерөнхийдөө ардчилсан орнууд дахь тагнуулын хяналт төрийн үйл ажиллагааны бусад салбарыг бодвол илүү хаалттай, буурай хөгжилтэй хэвээр байна. Жишээ нь, парламентын хяналтын хорооны хуралдаан ихэвчлэн олон нийтэд хаалттай явагддаг бөгөөд тус хорооны гишүүд мэдээллийн нууцын баталгаа гаргах буюу тангараг өргөж, танилцсан мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээдэг. Гэхдээ хяналтын арга хэлбэрээс үл хамааран ардчилсан орнууд дахь тагнуулын хяналт нь, нэг талаас тогтмол хяналт шалгалтаар дамжуулан тагнуулын албадын үйл ажиллагааны зүй зохист, хууль ёсны, хариуцлагатай байдлыг хангах, нөгөө талаас тэдгээр байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор явуулж буй үйл ажиллагааны нууцлал, ашигт байдлыг хангах хоёрын тэнцвэрийг хангахыг зорьдог юм.

Чиг үүргийн хуваарилалт

Тагнуулын хяналтын тогтолцооны гол зорилго нь тагнуулын чиг үүргийн хэрэгжилтэд нэг байгууллага, эсвэл агентлаг хэт давамгайлахаас зайлсхийх явдал юм. Зэвсэгт хүчин ба цагдаа, эсвэл дотоод болон гадаад тагнуул зэрэг бие даасан, тусдаа нэгжүүдийн дор тагнуулын чиг үүргийг тархаан байрлуулах

нь үйл ажиллагааны үр дүнг сааруулж, байгууллага хоорондын өрсөлдөөнийг дэврээж болох хэдий ч ерөнхийдөө ардчилсан хяналтыг хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой гэж үздэг. Тиймээс дэлхийн олон оронд дотоод болон цэргийн тагнуулын чиг үүргийг хариуцсан байгууллагууд тусдаа байдаг байна. Ардчилсан хяналтын үүднээс ингэж салгах нь тустай хэдий ч, тагнуулын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг тарамдуулах сөрөг талтай гэдгийг АНУ-д болсон террорист халдлага харуулсан билээ.

Тагнуулын албан хаагчдын сургалт

Тагнуулын мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэжлийн хувьд төлөвшүүлэх нь тагнуулын хяналтын үндсэн хэсэг мөн. Нэн ялангуяа, мэргэжлийн ур чадвар, ардчилсан хэм хэмжээ, хүний эрхийг дээдлэх зарчим болон иргэний үүрэг хариуцлагын мэдрэмжийг бий болгож төлөвшүүлэх нь тагнуулын албан хаагчдын сургалтын чухал хэсэг юм. Ардчилсан орнууд тагнуулын салбарыг цэргийнхэнд үлдээх бус, харин энгийн хүмүүсийг сурган авч ажиллуулахыг эрхэмлэдэг.

Мэдээлэл, баримт бичгийг нууцлалын зэргээс гаргах

Хяналт, хариуцлагатай байдлыг сайжруулахад нөлөөлж болох тогтолцооны шинжтэй бас нэг хүчин зүйл нь тагнуулын аливаа ажиллагааны талаарх мэдээлэл тодорхой хугацааны дараа олон нийтэд нээлттэй болох явдал юм. Энэ жишгийг мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж болон нууц баримт бичиг, мэдээллийг тодорхой хугацааны дараа нууцлалын зэргээс гаргах дүрэм журмаар дамжуулан хэрэгжүүлж болно. Ил тод байдлыг ингэж тодорхой хугацаагаар хойшлуулах, олон нийтийн дунд аажмаар дэлгэх нь ардчилсан хяналтыг хэрэгжүүлэхэд мөн нөлөөлдөг байна (Бүлэг 21-ийг үз).

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Парламентын хяналтын тогтолцоо

- ▷ Өөрийн улсын парламентад тагнуулын нийт албадыг хянах тусгай эрх бүхий хороо буюу дэд хороо байгуулах (парламентын хороодын харьцуулалтыг Бүлэг 15-аас үз).
- ▷ Хорооны эрх үүрэг нарийн тодорхой, аль болох бага хязгаарлалттай байж, гишүүд нь шаардлагатай баримт мэдээлэлтэй танилцах эрх, мэргэжлийн зөвлөгөө авах боломжоор хангагдсан байгаа эсэхийг баталгаажуулах.

Парламентын хороо нь шаардлагатай арга хэмжээ авдаг, өөрийн үйл ажиллагааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжөө заасан хугацаанд тогтмол танилцуулдаг байх.

Ардчилсан болон хуулийн хэм хэмжээний хүрээнд

- ▷ Тагнуулын албадыг зохицуулсан хууль тогтоомжид дараах асуудлыг зайлшгүй

хамруулах: албадын эзлэх байр суурь, эрх үүрэг, үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, үүрэг даалгаварын төрөл, үйл ажиллагаагаа тайлагнах үүрэг болон тэдгээр албадад тавих хяналтыг нарийвчлан тодорхойлсон байх. Түүний зэрэгцээ, мэдээлэл олж авах, хувь хүний мэдээлэл бүхий бүртгэл хөтлөх зорилгоор тусгай арга хэрэгсэл ашиглах талаар болон тагнуулын албан хаагчийн эрх зүйн байдлын талаар тусгасан байх ёстой.

- ▷ Тагнуулын алба нь улс төрийн нөлөөлөөс ангид, ардчилсан хэм хэмжээ, иргэний үүрэг хариуцлагад тулгуурласан мэргэжлийн ёс зүйн дүрмийн дагуу ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих.
- ▷ Парламентын хяналтын хороо нь тагнуулын албан хаагчдын ардчилсан зарчим, хүний эрхийн хууль тогтоомжийн талаарх сургалтад хамруулж, мэдлэг эзэмшүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч буй эсэхэд анхаарах.

Засаглалын гурван салбарт харилцан уялдаа бүхий үүрэг хариуцлага ноогдуулсан хууль тогтоомжийг парламентаас батлах. Үүнд:

- Гүйцэтгэх засаг нь тагнуулын албадын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, үүрэг даалгавар өгөх эрх, үүрэгтэй;
- Парламент холбогдох хууль тогтоомжийг батлах, төсөв болон засгийн газрын гүйцэтгэх үүрэг, түүнчлэн тагнуулын албадын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд харин тагнуулын бодит ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ЁСГҮЙ;
- Шүүхээс тагнуулын албадад хувийн өмчид нэвтрэх, харилцаа холбоог хянах зөвшөөрөл олгох бөгөөд хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавина.

Ил тод, хариуцлагатай байдал

- ▷ Засгийн газраас тагнуулын чиглэлээр баримтлах бодлогын талаар парламентын хороонд мэдээлэл өгөх, эсвэл түүнтэй зөвшилцөж байгаа эсэхэд хяналт тавих.
- ▷ Парламентын хяналтын хороо нь тагнуулын албад хуулийн дагуу, зохистой хэм хэмжээний хүрээнд, хариуцлагатай ажиллаж байгаа эсэхэд хяналт тавихын сацуу шаардлагатай нууцлал, үр дүнтэй байдлыг хадгалах. Үүнд утсан болон цахим харилцаа холбоонд хяналт тавих талаарх хуулийн зохицуулалтууд ч мөн багтана.
- ▷ Хорооны гишүүд тагнуулын байгууллагын үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлтэй бөгөөд тагнуулын байгууллагын удирдлагын томилолтод тодорхой хэмжээгээр оролцдог байх.

Нууцлалтай холбоотой асуудлууд

- ▷ Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг тагнуулын албадын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар хяналт тавих, хариуцлага тооцох нэгэн арга хэрэгсэл болгон ашиглах.
- ▷ Нууцлал болон хариуцлагын тэнцвэрийг хангах зорилгоор гүйцэтгэх ажлын нууц төсвийн аудитын тусгай чиг үүргийг бий болгох.
- ▷ Нууцлалын зэрэг бүхий баримт, мэдээллийг нээлттэй болгох шалгуур үзүүлэлт, хугацааг тодорхой болгох замаар ил тод байдлыг аажмаар баталгаажуулах, түүний боломжийг өсгөх. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу танилцаж болох баримт, мэдээллийн жагсаалтыг заасан хугацаанд тогтмол шинэчилж байх.

*Терроризмын талаарх Бүлэг 20, Санхүүгийн эх үүсвэрийн талаарх
Зургаадугаар хэсгийг үзнэ үү!*

Хамгаалалтын болон цэргийн чиглэлээрх хувийн компаниуд

Хууль ёсны дагуу хүч хэрэглэх эрхийг зөвхөн төр эдлэх бөгөөд дотоод аюулгүй байдлыг хангах, гадаад аюул заналаас хамгаалах үүргийг мөн төр хүлээдэг. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд дотоодын зөрчил хямралын шинэ давалгаа газар авах болсноор аюулгүй байдал хангах чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх шинэ үзэгдэл бий болоод байна. Аюулгүй байдал хангах төрийн бус зарим тоглогчид шинээр болон дахин үүсч, аюулгүй байдлын салбарт тавих ардчилсан хяналтын уламжлалт хэлбэрт бэрхшээл учруулах болжээ.

1990-ээд оноос хойш аюулгүй байдал хангах хамгаалалтын болон цэргийн чиглэлээр ажилладаг хувийн компаниуд олноор үүсч бий болсон. Тэдгээрийг хөлсний цэрэг, цэргийн чиглэлээрх хувийн компани, хамгаалалтын хувийн компани гэсэн гурван үндсэн төрөлд хувааж болно. Эдгээр байгууллагын үйл ажиллагаа төрийн хяналтад байх нь нэн чухал.

Хамгаалалтын болон цэргийн чиглэлээрх хувийн компаниудын үйл ажиллагаа ба тэднээс үүдэж болох аюул занал

Ихэвчлэн хямралын дараах буюу “төвхнөөгүй” гэгдэгч орнуудад хамгаалалтын болон цэргийн чиглэлтэй хувийн компаниудыг ашигладаг. Үүний гол шалтгаан нь эдгээр улс оронд өөрийн ард иргэд, нийгмийн бүлгүүдийн аюулгүй байдлыг хангах бэлтгэл, чадавхтай цэргийн хүчин дутагдалтай эсвэл эрх баригчид нь улс орны аюулгүй байдлын салбарт ардчилсан хяналтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж, хүч хэрэглэх төрийн монополь эрхийг хазаарлах хүсэлгүй байдагтай холбоотой.

Дээр дурдсан нөхцөл байдалд цэргийн/хамгаалалтын хувийн компаниудыг ашиглах нь үндэсний цэргийн хүчний мэргэжлийн чадавх болон бэлтгэл сургалтын чанарыг сайжруулах, зарим тохиолдолд өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг зарим сайн талтай байж болно. Гэхдээ Тодруулга N°26-д үзүүлсэнчлэн, энэ нь алс хэтдээ ардчиллын явцад гүн гүнзгий, олон талт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай юм.

Тэдний “үйлчилгээг авагч” улс орнуудын олон нийт, ардчилсан сонгуулиар сонгогдсон төрийн байгууллага, тэр дундаа парламент нь дан ганц төрийн аюулгүй байдлын байгууллагууд бус харин цэргийн/хамгаалалтын үйлчилгээ

үзүүлж буй мэргэжлийнхэнд мөн адил зохих ёсны үр дүнтэй ардчилсан хяналт тавих тогтолцоотой байх нь чухал.

Тодруулга №26

Хамгаалалтын болон цэргийн чиглэлээрх хувийн компаниуд ба тэдгээрийн зүгээс ардчилалд учруулж болзошгүй аюул занал

- ▷ Аюулгүй байдал хангах хувийн хэвшлийн тоглогчид тодорхой хугацаанд цэрэг/аюулгүй байдлыг ямар нэг хэмжээгээр тогтворжуулж чадах боловч зарим нэг засгийн газар алс хэтдээ цэргийн хүч хэрэглэхийг (дотоодын) зөрчил, асуудлыг шийдвэрлэх гол арга зам болгох магадлалтай;
- ▷ Цэрэг/аюулгүй байдлын мэргэжлийн этгээдийг гадаадаас хөлслөх нь тэдний цэрэг/аюулгүй байдал хангах үүрэг даалгаврын цар хүрээ, төсөв хөрөнгөтэй холбоотой олон асуудлыг бий болгодог бөгөөд ардчилсан, сайн засаглалын үүднээс авч үзвэл эдгээр асуултуудыг ямагт олон нийтэд нээлттэйгээр парламентын түвшинд авч хэлэлцэх нь зүйтэй;
- ▷ Хувийн хэвшлийн эдгээр тоглогчид ил харагдах /хууль ёсны/ ажил үүргийнхээ цаана зэвсгийн наймаа эрхлэх тохиолдол гардаг.

Хөлсний цэрэг

Хөлсний цэрэг ашиглах явдал эрт дээр үеэс эхтэй бөгөөд энэ туршлага олон оронд ашиглагдсан хэвээр байгааг сүүлийн үеийн зөрчил мөргөлдөөний түүх харуулж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 4-ний 44/34 дүгээр тогтоолоор баталсан Хөлсний цэрэг элсүүлэх, ашиглах, санхүүжүүлэх, сургахын эсрэг олон улсын конвенцын Нэгдүгээр зүйлд хөлсний цэрэг хэмээх ойлголтыг тодорхойлсон байдаг. Уг конвенц 2001 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон хэдий ч маш цөөн тооны орон соёрхон батлаад байна. Энэ конвенцоор 1949 оны Женевын конвенцуудын Нэмэлт нэгдүгээр протоколын 47 дугаар зүйлд заасан тодорхойлолтыг (тухайлбал, засгийн газрыг түлхэн унагаах эсвэл тухайн улсын үндсэн хуулиар тогтоосон дэг журам, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг ямар нэг хэлбэрээр алдагдуулах зорилго бүхий хүчирхийллийн аливаа ажиллагаанд хөлслөгдөн оролцож буй этгээдэд хамаарах) цаашид дэлгэрүүлсэн байна:

“Нэгдүгээр зүйл – Энэхүү конвенцын зорилготой холбоотойгоор,

1. Хөлсний цэрэг гэдэг нь: (а) зэвсэгт мөргөлдөөнд оролцуулах зорилгоор дотоод эсвэл гадаадаас тусгайлан хөлсөлсөн; (б) тухайн мөргөлдөөнд хувийн

ашиг орлогын сонирхлоор буюу үнэн хэрэгтээ мөргөлдөөнд оролцогч тал эсвэл түүний төлөөний этгээдээс тухайн талын ижил цол хэргэм, чиг үүрэг бүхий дайчдаас харьцангуй өндөр эд материалын нөхөн төлбөр өгөхөөр амласан; (в) Мөргөлдөөнд оролцогч талын хяналтад байгаа газар нутгийн оршин суугч эсвэл иргэн бус; (г) Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний албан хаагч бус; (д) Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчинд албан үүрэг гүйцэтгүүлэхээр аль нэг улсаас илгээгээгүй этгээдийг хэлнэ.

2. Түүнчлэн бусад аливаа тохиолдолд хөлсний цэрэг гэж: (а) дор дурдсан зорилго бүхий зохион байгуулалттай хүчирхийллийн ажиллагаанд оролцуулахаар дотоод болон гадаадаас хөлсөлсөн, үүнд: (i) засгийн газрыг түлхэн унагаах эсвэл тухайн улсын үндсэн хуулиар тогтоосон дэг журмыг алдагдуулах; (ii) тухайн улсын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах; (б) Хувийн ихээхэн ашиг орлого олохыг сонирхсон ба хөлслөгч талаас эд материалын нөхөн төлбөр амласан эсвэл төлсөн; (в) Мөргөлдөөний бай болж буй улсын иргэн эсвэл оршин суугч бус; (г) аль нэг улсаас албан үүрэг гүйцэтгүүлэхээр илгээгээгүй; (д) Газар нутаг дээр нь мөргөлдөөн болж буй улсын зэвсэгт хүчний албан хаагч биш этгээдийг хэлнэ.”

Хөлсний цэрэг элсүүлэх, ашиглах, санхүүжүүлэх, сургах аливаа ажиллагаа явуулсан, үүнд туслалцаа дэмжлэг үзүүлсэн аливаа этгээдийг олон улсын конвенцын дагуу онц хүнд гэмт хэрэг үйлдсэнд тооцдог. Гэхдээ тусгай үүрэг даалгавар гүйцэтгүүлэх зорилгоор гадны улсын цэргийн мэргэжилтэнг засгийн газар хөлсөөр ажиллуулах тохиолдол бий (тийрэлтэт онгоцны нисгэгч, террористуудын эсрэг ажиллагаа г.м.).

“Конвенцод элсээгүй байгаа бүх оронд хандан уг конвенцыг соёрхон батлаж, элсэн орох урилгыг Ерөнхий Ассамблейгаас илгээх нь зүйтэй. Үүний зэрэгцээ, Конвенцод элссэн гишүүн орнууд өөрийн хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн өөрчлөхийг уриалах хэрэгтэй” хэмээн НҮБ-ын Хүний эрхийн комиссын Хөлсний цэргийн асуудал хариуцсан тусгай илтгэгч тайландаа (70-р хэсэг) зөвлөжээ.

Цэргийн чиглэлээрх хувийн компани

Цэргийн чиглэлээрх хувийн компанийг орчин үеийн корпораци хэлбэртэй “хөлсний цэрэг” гэхэд болно. Тэд мөн ялгаагүй ашгийн төлөө ажиллах бөгөөд цэргийн сургалт, үйлчилгээ үзүүлэх буюу байлдааны болон байлдааны бус чиг үүрэг гүйцэтгэдэг. Хууль зүйн үүднээс авч үзвэл, тэд ихэвчлэн байнгын армиас чөлөөндөө гарсан цэргийн албан хаагчдаас бүрддэг учир хөлсний цэрэг гэх нарийвчилсан тодорхойлолтод багтдаггүй. Цэргийн чиглэлтэй хувийн компаниуд байлдааны болон операцийн түвшний дэмжлэг үзүүлэхээс эхлээд зөвлөгөө өгөх, сургалт явуулах, зэвсэг техник худалдан авах, тагнуулын мэдээлэл цуглуулах, барьцааны хүн аврах зэрэг өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлдэг. Ерөнхийдөө,

ямар төрлийн үйлчилгээ үзүүлдгээс нь үл хамааран тэдний нийтлэг шинж бол тэд тухайн орны засгийн газрын хүсэлтээр зэвсэгт мөргөлдөөний үед болон хямралын дараах сэргээн босголтын үйл ажиллагаа явуулдагт оршино.

Ийм компанийн нэг жишээ нь АНУ-д төвтэй “Цэргийн мэргэжлийн хүний нөөц” хувь нийлүүлсэн компани (MPRI) юм. Тус компани батлан хамгаалахтай холбоотой гэрээт ажил, тухайлбал хууль сахиулах ажиллагаа, манлайллын сургалт зэрэг чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг. Уг компанийг цэргийн дээд албан тушаалд ажиллаж байгаад чөлөөнд гарсан хүмүүс анх 1988 онд үүсгэн байгуулсан бөгөөд өдгөө ч бэлтгэл чөлөөндөө гарсан цэргийнхэн удирдсан хэвээр байна.

Хамгаалалтын компани

Аюулгүй байдал хангах хувийн хэвшлийн компаниуд хувийн өмч, бизнесийн үйл ажиллагааг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа үзүүлдэг бөгөөд энэ утгаараа гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тодорхой хувь нэмэр оруулдаг. Аюулгүй байдал хангах хувийн хэвшлийн компаниуд аль ч улсад байдаг хэдий ч ялангуяа хямралт бүс нутагт бизнес эрхлэгчид төрөөс хангалттай хамгаалалт авч чадахгүй байгаатай холбоотойгоор тоо нь өсөх хандлагатай байна. Ийм компаниуд мөргөлдөөний үед цэргийн үүрэг гүйцэтгэх гэхээсээ илүү эд хөрөнгө, хүний амь насыг хамгаалах зорилгод илүү ашиглагддаг гэж үздэг. Гэсэн хэдий ч бодит амьдрал дээр ийм бүс нутагт цэргийн болон хамгаалалтын мэдлэг туршлага аль аль нь чухал байдаг тул компаниуд энэ хоёр үүргийг хослуулан гүйцэтгэдэг байна. Чухам энэ шалтгааны улмаас цэргийн болон хамгаалалтын хувийн компаниудын зааг ялгаа багасах хандлагатай байдаг.

Аюулгүй байдал хангах хувийн хэвшлийн компаниудын ач холбогдол, тоо өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан ардчилсан институциуд, нэн ялангуяа парламентаас эдгээр шинэ тоглогчдод бага боловч хяналт тавих стандартыг тогтоох шаардлагатай бөгөөд эс тэгвэл тэдгээр нь эргээд ардчилсан зарчмуудад заналхийлж болзошгүй.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Хууль тогтоомж

- ▷ Танай улс 1989 оны Хөлсний цэрэг элсүүлэх, ашиглах, санхүүжүүлэх, сургахын эсрэг олон улсын конвенцод гишүүнээр элсэж, үүнтэй холбоотой хууль тогтоомжийг гаргасан эсэхэд анхаарах.
- ▷ Цэргийн болон хамгаалалтын хувийн компаниудад зориулсан хууль эрх зүйн орчин бий эсэхийг нягтлах.

Хэм хэмжээ, зэвсгийн наймааны хоригт захирагдах

- ▷ Цэргийн болон аюулгүй байдал хангах чиглэлтэй хувийн компаниуд нь хямралт бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс танай улсад бүртгэлтэй цэргийн болон хамгаалалтын хувийн компаниуд танай үндэсний аюулгүй байдлын стратеги, гадаад бодлого болон олон улсын холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээ, тогтоол шийдвэрт нийцсэн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд парламентаас хяналт тавих санал санаачилга дэвшүүлж ажиллах.
- ▷ Цэргийн болон хамгаалалтын чиглэлийн хувийн компаниуд зэвсгийн наймааны хоригт хамрагдсан аливаа бүс нутаг, улс оронд үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглох.

Ил тод байдал

- ▷ Засгийн газраас хүсэлт гаргасан, зөвшөөрөл өгсөн хэдий ч цэргийн чиглэлтэй болон аюулгүй байдал хангах чиглэлтэй гаднын хувийн компаниуд танай нутаг дэвсгэр дээр парламентаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр үйл ажиллагаа явуулах ёсгүй гэдгийг баталгаажуулах.
- ▷ Цэргийн чиглэлээрх болон аюулгүй байдал хангах хувийн компаниудыг хөлслөхөд зарцуулах засгийн газрын төсвийг парламентаас хянадаг байх.

Хариуцлага тооцох

- ▷ Цэргийн чиглэлээрх болон аюулгүй байдал хангах хувийн компаниудын гадаад, дотоод дахь бүхий л үйл ажиллагааг засгийн газар хуулийн дагуу болон бодит амьдрал дээр бүрэн хариуцах ёстой гэдгийг баталгаажуулах.

Дөрөвдүгээр хэсэг

Үндэсний аюулгүй байдал ба парламентын хяналт:

Нөхцөл болон механизмууд

Бүлэг 13

Парламентын хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нөхцөл

Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтын үр дүн засгийн газар болон аюулгүй байдлын албадтай холбогдуулан эдлэх парламентын эрх мэдлээс шууд хамаарна. Энэ хүрээнд, эрх мэдэл гэдгийг ард түмнээс парламентаар уламжлан илэрхийлсэн хүсэл эрмэлзлийн дагуу засгийн газрын бодлогын хувилбарууд, чиг хандлагад нөлөөлөх чадавх хэмээн ойлгож болно. Түүнчлэн, бодлого, хууль тогтоомж, бусад шийдвэрийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлд парламентаас хяналт тавих чадавхыг ч мөн үүнд хамруулж ойлгодог. Энэ эрх мэдэл нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоос гадна парламентын дотоод дүрэм журам, тогтсон дэг жаяг дээр тулгуурлана.

Иймд парламентын хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нөхцөлд дараах асуудал багтана:

- ✓ Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон эрх мэдэл
- ✓ Тогтсон дэг жаяг
- ✓ Нөөц бололцоо, мэргэжлийн туслалцаа
- ✓ Улс төрийн хүсэл зориг

Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээний эрх мэдэл

Үндсэн хууль (эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг) нь парламентаас аюулгүй байдлын салбарт тавих хяналтын хууль эрх зүйн хамгийн чухал үндэс мөн. Улс орнуудын улс төр, соёл, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаас хамааран Үндсэн хууль нь харилцан адилгүй байж болох ч ихэвчлэн дараах зарчмыг нийтлэгээр тусгасан байдаг. Үүнд:

- ✓ Аюулгүй байдлын албад нь гүйцэтгэх засаг (тухайлбал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсвэл Батлан хамгаалахын сайд)-ийн удирдлагад байна;
- ✓ Гүйцэтгэх засаг нь парламентын өмнө хариуцлага хүлээнэ.

Үндсэн хууль нь хууль эрх зүйн хамгийн дээд баримт бичиг учир аюулгүй байдлын салбартай холбоотой парламентын эрх мэдлийг Үндсэн хуулинд тусган баталгаажуулах нь чухал. Үндсэн хуулийг зүгээр нэг өөрчлөх боломжгүй бөгөөд ингэхийн тулд парламентын гишүүдийн дийлэнх олонхийн санал шаардлагатай. Тиймээс Үндсэн хууль бол энэхүү эмзэг салбарт парламентын эрх мэдлийг хамгаалах үр дүнтэй арга мөн. Эдгээр эрх мэдлийг тухайн чиглэлийн хууль тогтоомж болон парламентын дэг, дүрэм журмаар давхар баталгаажуулж болно. Үүний зэрэгцээ, нийгмийн хэм хэмжээ, хариуцлага тооцох болон парламентын хяналтын хүлээн зөвшөөрөгдсөн дэг жаяг цаг хугацааны явцад хөгжсөөр ирсэн.

Парламентаас аюулгүй байдлын салбарт тавих хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглаж болох өргөн хүрээ бүхий арга хэрэгслийг Тодруулга N°27-д үзүүлсэн бөгөөд тэдгээрийг удаах бүлгүүдэд дэлгэрүүлэн авч үзэх болно.

Тодруулга N°27

Аюулгүй байдлын салбарт тавих ардчилсан хяналтыг баталгаажуулахад парламентын ашиглаж болох арга хэрэгслүүд

1. Нийтлэг эрх мэдэл

- а. Хууль санаачлах
- б. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах
- в. Гүйцэтгэх засгийн албан тушаалтнуудад асуулт тавих
- г. Гүйцэтгэх засгийн албан тушаалтнуудыг парламентын хуралдаанд дуудаж оролцуулах, мэдүүлэг авах
- д. Цэргийн албан тушаалтан, төрийн албан хаагчдыг парламентын хуралдаанд дуудаж оролцуулах, мэдүүлэг авах
- е. Иргэний экспертүүдийг парламентын хуралдаанд дуудаж оролцуулах, мэдүүлэг авах
- ё. Гүйцэтгэх засгийн байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай баримт бичиг гаргуулж авах
- ж. Парламентын асуулга явуулах
- з. Сонсгол хийх

2. Төсвийн хяналт

- а. Төсөв, түүнтэй холбоотой бүх баримт бичигтэй танилцах
- б. Батлан хамгаалах болон аюулгүй байдлын албадын төсөвтэй танилцах, өөрчлөлт оруулах
- в. Төсөл, хөтөлбөр, төсвийн зүйл тус бүрээр хяналт тавих
- г. Батлан хамгаалах, аюулгүй байдлын аливаа нэмэлт төсвийн төслийг батлах/буцаах эрх

3. Энхийн ажиллагаа/хилийн чанадад цэрэг илгээх шийдвэр гаргах эрх:

- а. Цэргээ хилийн чанадад илгээхийн өмнө шийдвэр гаргахад оролцох
- б. Ажиллагааны мандат, НҮБ-ын ажиллагааны мандатыг батламжлах
- в. Ажиллагааны төсөв
- г. Ажиллагаанд оролцох цэргийн бие бүрэлдэхүүнд учирч болзошгүй эрсдлүүд
- д. Ажиллагааны журам
- е. Удирдлага/хяналтын шат дамжлага
- ё. Ажиллагааны хугацаа
- ж. Ажиллагаанд оролцож буй цэргийн байдалтай газар дээр очиж танилцах эрх

4. Цэргийн хангалт

- а. Гүйцэтгэх засаг нь цэргийн хангалтын талаарх мэдээллийг парламентад бүрэн хэмжээгээр өгөх үүрэгтэй
- б. Гэрээг батламжлах/татгалзах эрх
- в. Хангалтын дараах үе шатанд хяналт тавих:
- i. Шинэ зэвсэг хэрэгслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- ii. Үйлдвэрлэгчдийг харьцуулах, сонгох
- iii. Төлбөр, тооцооны саналыг үнэлэх

5. Батлан хамгаалах, аюулгүй байдлын ерөнхий бодлого: батлах/татгалзах эрх

- а. Аюулгүй байдлын бодлогын үзэл баримтлал
- б. Хямралыг зохицуулах үзэл баримтлал
- в. Хүчний бүтэц
- г. Цэргийн стратеги/номлол

6. Батлан хамгаалах/аюулгүй байдлын албадын бие бүрэлдэхүүн

- а. Бие бүрэлдэхүүний орон тооны төлөвлөгөөг батлах/татгалзах
- б. Орон тооны дээд хязгаарыг тогтоох эрх
- в. Цэргийн удирдах дээд албан тушаалтны томилгоог батлах/татгалзах эрх болон томилгооны талаар зөвшилцөх эрх (зэвсэгт хүчний жанжин штабын дарга г.м.)

Тогтсон дэг жаяг

Бүх үйл ажиллагаа, харилцааг хуулиар зохицуулах боломжгүй. Тиймээс, харилцан хүндэтгэл, итгэлцэл зэрэг нийгмийн хэм хэмжээнд тулгуурласан дадал, дэг жаягийг бий болгож, төлөвшүүлэх нь түүнээс дутахгүй чухал. Жишээ нь, аюулгүй байдлын асуудлаар парламентын гишүүдийг цаг алдалгүй бүрэн мэдээллээр

хангах нь дан ганц ил тод байдал, хуулийн зохицуулалтын асуудал бус, харин хүн хоорондын харилцааны асуудал мөн.

Нөөц бололцоо ба мэргэжлийн чадавх

Парламентаас аюулгүй байдлын салбарт хяналт тавих чадавх нь ерөнхийдөө цаг хугацааны хүчин зүйлс хийгээд авч болох мэдээллийн цар хүрээ, мэргэжлийн чадавхаас хамаарна.

Цаг хугацааны хүчин зүйлс

Аюулгүй байдлын салбар болон аюулгүй байдлын асуудлуудтай холбоотой засгийн газрын байр суурь, шийдвэрийн талаар парламент цаг тухай бүрт нь мэдээлэл авч байх нэн чухал. Засгийн газар эцсийн шийдвэрээ гаргасныхаа дараа л парламентад мэдээлэл өгдөг бол олигтой үр дүн гарахгүй. Ингэснээр парламент 'тулгалтад орж' нэгэнт гарсан шийдвэрт нөлөөлөх боломж алдагдан, эсвэл зөвшөөрөх, эсвэл татгалзахаас өөр аргагүйд хүрдэг.

Үндэсний хэмжээний гамшиг, онц байдал тохиосон үед засгийн газар маш шуурхай ажиллах шаардлагатай байдаг тул ихэвчлэн үйл явдлын дараа л парламентад мэдээлэл өгөх нь бий. Гэхдээ энэ нь засгийн газар парламентаас урьдчилан тогтоосон хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Харин ердийн болон урт хугацааны бодлогын асуудал, тухайлбал батлан хамгаалахын төсөв, зэвсэг техникийн худалдан авалт, батлан хамгаалах салбарын үнэлгээ зэрэг чухал асуудлуудын хувьд парламент уг асуудалд дүн шинжилгээ хийх, нэг бүрчлэн хэлэлцэх хангалттай хугацаатай байх ёстой.

Парламентын гишүүдэд байнга тулгардаг бэрхшээлийн нэг болох цаг хугацааны дарамтыг хөнгөлөх нэг арга бол давшингуй стратеги хэрэгжүүлэх явдал юм. Аюулгүй байдлын салбарт хяналт тавих үйл ажиллагааны ийм стратегийн зарим бүрэлдэхүүн хэсгийг Тодруулга N°28-д дурдсан болно.

Тодруулга №28

Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтын давшингуй стратеги

Парламентын гишүүдийн ажлын ихэнх нь цаг үеийн асуудлуудад зарцуулагддаг тал бий. Түүнчлэн, тэдний ажлын дийлэнхийг засгийн газраас оруулсан асуудал эзэлдэг. Тиймээс, цаг хугацааны дарамтыг хөнгөвчлөх нэг арга бол парламентын хяналтын үйл ажиллагааны давшингуй стратегийг хэрэгжүүлэх байж болох юм. Аюулгүй байдлын салбарын хувьд эл стратеги нь дараах асуудлыг агуулж болно. Үүнд:

Бодлогын асуудлыг тодорхойлох: Парламентын гишүүд олон нийтийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээ шаардлагыг улс төрийн бодлогод тусгахыг байнга хичээх ёстой.

Сүүлийн үеийн үйл явц: Парламент нь цэрэг, аюулгүй байдлын салбарт үндэсний болон олон улсын хэмжээнд сүүлийн үед өрнөсөн үйл явдал, өөрчлөлтийн талаар байнга мэдээлэлтэй байх шаардлагатай. Мэдээллийг зөвхөн төрийн болон албан сувгуудаас гадна их дээд сургуулиуд, судалгааны байгууллагууд зэргээр дамжуулан авах боломжтой.

Сургамж: Бүтцийн хүрээнд тогтмол судалгаа хийх замаар парламент аюулгүй байдлын салбар дахь үйл ажиллагаанаас сургамж авч байх ёстой.

Байнгын хяналт: Аюулгүй байдлын бодлогыг шинэчлэх бүрт сүүлийн үеийн бүхий л зорилго зорилт, өөрчлөлт хөгжил, туршлага сургамжуудыг харгалзан үзэх ёстой гэсэн шаардлагыг парламентаас засгийн газарт тавих ёстой.

Мэдээлэл, мэргэжлийн чадавх болон парламентын ажилтнууд

Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналт үр дүнтэй байхын тулд парламентын дотоодод буюу түүний мэдэлд мэргэжлийн эксперт болон бусад шаардлагатай нөөц бололцоо байх ёстой. Гэхдээ парламентын дотоодод байгаа мэргэжилтний мэдлэг чадвар засгийн газар болон аюулгүй байдлын албадынхтай дүйцэх нь ховор. Парламентад ихэвчлэн судалгаа хариуцсан цөөн тооны ажилтан байхад /хэрэв ийм орон тоо байдаг бол/, харин засгийн газрын мэдэлд батлан хамгаалах яам, түүнчлэн аюулгүй байдлыг хариуцсан бусад яамдын бие бүрэлдэхүүн бүхэлдээ байдаг. Аргентин зэрэг зарим орны парламентын бүтцэд цэргийн асуудал хариуцсан алба байдаг бөгөөд парламентын гишүүд, албан хаагчид, ялангуяа батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал хариуцсан парламентын хороодыг шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөгөөр хангадаг байна. Түүнээс гадна, парламентын гишүүд зөвхөн тодорхой хугацаагаар л сонгогддог бол батлан хамгаалах яамны энгийн болон цэргийн албан хаагчид ихэвчлэн насан туршдаа уг ажил үүргийг гүйцэтгэдэг. Гэхдээ хамгийн гол нь парламентын

гишүүд өөрсдийн хянах ёстой засгийн газар, цэргийн байгууллагаасаа ирүүлж буй мэдээлэлд найдахаас өөр аргагүй байдаг. Ингэснээр парламент нь засгийн газар, цэргийн байгууллагуудтай харьцуулахад сул талтай болдог бөгөөд үүн дээр аюулгүй байдлын салбарын цэргийн шинжтэй явцуу үйл ажиллагаа, соёл, бэлтгэл сургалт, нууцлалт зэргээс үүдэлтэй хаалттай мөн чанарыг нэмж тооцох хэрэгтэй болно.

Аюулгүй байдлын салбарын талаарх парламентын гишүүдийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх зарим саналыг Тодруулга N°29-д оруулсан болно.

Тодруулга N°29

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын чадавхыг бэхжүүлэх арга хэрэгсэл: зарим санал

- ▷ Парламентын гишүүдийн аюулгүй байдлын асуудлаарх мэдлэг, чадавхыг төвлөрүүлсэн аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаарх тусгай хороо байгуулах: энэ хороог цаашдаа зэвсэг техникийн худалдан авалт, бие бүрэлдэхүүний асуудал, төсөв, энхийн ажиллагаа зэрэг асуудал хариуцсан дэд хороод болгон хуваах талаар бодож үзэх нь зүйтэй.
- ▷ Дотоодын болон олон улсын хурал, семинарт оролцох, туршлага судлах аялалд оролцох, аюулгүй байдлын албадын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах (нууц болон тагнуулын албадын талаар Бүлэг 11-ээс үз), парламентын гишүүдэд зориулсан сургалтад хамрагдах. Парламентын гишүүд хилийн чанадад энхийн ажиллагаанд оролцож буй цэргийн хүчнийхээ ажиллагаатай танилцах аялал хийхийг үүнд мөн хамруулж болно;
- ▷ Бусад улс орны парламентын гишүүдтэй туршлага солилцох, тухайлбал, олон улсын парламентын ассамблейн үеэр г.м;
- ▷ Парламент сайн бэлтгэгдсэн, хангалттай тооны ажилтантай байх;
- ▷ Орчин үеийн, тусгай номын сан, баримт бичиг/судалгааны төвүүд, цахим мэдээллийн сан зэрэгт нэвтрэх эрхтэй байх;
- ▷ Хөндлөнгийн, бие даасан шинжээчдээс зөвлөгөө авах (их дээд сургууль, тинк-танк судалгааны байгууллагууд г.м.), эсвэл чөлөөнд гарсан цэргийн офицерууд байж болно (иргэний нийгмийн талаар Бүлэг 6-аас үз);
- ▷ Аюулгүй байдлын асуудлаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, тэдгээрийг соёрхон батлах явц болон гэрээний хэрэгжилтийг хянах байгууллагуудаас гаргасан бусад холбогдох баримт бичиг, мэдээллийг орчуулж парламентын гишүүдэд хүргэх;
- ▷ Жил бүр аюулгүй байдалтай холбоотой 2-3 асуудлыг сонгон авч, нарийвчлан судлах (тухайлбал, дэд хороо тус бүрээр байж болно);

- ▷ Парламентад суудал бүхий бүх намын төлөөллөөс бүрдсэн аюулгүй байдал/батлан хамгаалах асуудлаарх бүлэг байгуулах (хос танхимтай бол аль аль танхимаас төлөөлөл оролцуулна): парламентын ийм бүлэг нь эдгээр асуудлуудыг хэлэлцэх албан бус тинк танк нэгжийн үүрэг гүйцэтгэж болох юм.

Улс төрийн хүсэл эрмэлзэл

Парламентаас аюулгүй байдлын салбарт хяналт тавих хууль эрх зүйн суурь бүрдсэн агаад тухайн асуудлаар нөөц бололцоо, мэргэжлийн мэдлэг чадавх парламентад хангалттай байж болох хэдий ч энэ нь парламентын хяналт хэрэгжих бүрэн баталгаа биш. Өөр нэг хүчин зүйл буюу эдгээр арга хэрэгслийг ашиглах парламентын гишүүдийн улс төрийн хүсэл эрмэлзэл бол аюулгүй байдлын салбарт үр дүнтэй хяналт тавих нэн чухал нөхцөл мөн. Аюулгүй байдлын салбарт хяналт тавих улс төрийн хүсэл эрмэлзэл дутагдах дараах шалтгаан байж болно. Үүнд:

- ✓ Улс төрийн намын сахилга бат: Тухайн үед эрх баригч намын парламентын гишүүд нь засгийн газраа хэвээр байлгах сонирхолтой бөгөөд олон нийтийн өмнө ил тод шүүмжлэхээс зайлсхийх хандлагатай байдаг.
- ✓ Сонгогчдын сонирхол/үл сонирхол: олон нийт аюулгүй байдлын асуудлыг ерөнхийдөө сонирхохгүй байх үзэгдэл олон оронд түгээмэл ажиглагддаг. Тиймээс парламентын гишүүд дахин сонгогдох үүднээс аюулгүй байдлын асуудалд их цаг зарцуулах хүсэлгүй байдаг.
- ✓ Парламентын гишүүд, тухайлбал тагнуулын хяналтын асуудал хариуцсан хорооны гишүүд, нууцлалтай холбоотой шалтгааны улмаас олж мэдсэн зүйлээ олон нийтэд дэлгэх аргагүй байдаг.

Эдгээр нөхцөл байдлын улмаас олон нийтийн анхаарлыг татсан шуугиан дуулиан гарах, эсвэл онц нөхцөл байдал үүссэнээс бусад нөхцөлд гүйцэтгэх засгийн бодлого, үйл ажиллагааг хянах парламентын арга хэрэгслийг идэвхгүй байдлаар ашиглах нь элбэг. Гэсэн хэдий ч гүйцэтгэх засгийн зорилго, үйл ажиллагааг шүүмжлэлтэйгээр хянах нь парламентын аль ч гишүүний Үндсэн хуулийн дагуу хүлээсэн үүрэг, нэн чухал ажил мөн.

Аюулгүй байдлын салбарт парламентын ашиглах арга хэрэгсэл

Хууль эрх зүйн аль ч тогтолцоонд бодлогын хяналтыг хэрэгжүүлэх, засаг захиргааг хянах, хувь хүнийг хамгаалах, шударга бус байдал, аливаа зүй бус ажиллагааг илрүүлэх, ил болгох, арилгах зорилгоор мэдээлэл авах олон төрлийн арга хэрэгслээр парламентыг хангасан байдаг. Үүний дээр, парламентын гишүүд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан эдгээр арга хэрэгсэлд хүч нэмэх хэвшмэл туршлага, албан бус арга хэрэгслийг ашиглах боломжтой.

Засгийн газраас мэдээлэл гаргуулж авах зорилгоор ашиглаж болох хууль эрх зүйн гурван боломж парламентад бий:

- ✓ Парламентын мэтгэлцээн
- ✓ Парламентын асуулт, асуулга
- ✓ Парламентын тусгай хяналт

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын мэтгэлцээн

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын мэтгэлцээн нь засгийн газрын зорилго, үйл ажиллагааны талаар санал солилцох, чухал шаардлагатай баримт мэдээлэл цуглуулах үндсэн арга юм. Ерөнхийдөө аюулгүй байдлын асуудлаарх парламентын мэтгэлцээн дараах таван нөхцөлд өрнөж болно. Үүнд:

- ✓ Гүйцэтгэх засгаас тухайн жилийн батлан хамгаалахын төсвийг өргөн барьж танилцуулсны дараа;
- ✓ Батлан хамгаалахын болон гадаад хэргийн сайд зэрэг засгийн газрын холбогдох гишүүдээс албан болон албан бус байдлаар мэдэгдэл хийсний дараа;
- ✓ Батлан хамгаалах салбарын жилийн тайлантай холбогдуулан, батлан хамгаалах цагаан ном буюу үндэсний батлан хамгаалахын томоохон баримт бичгүүдийг танилцуулах үеэр;
- ✓ Голдуу сонгуулийн дараа гардаг засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдуулан;

- ✓ Аюулгүй байдлын асуудлаар дуулиан шуугиан гарах, томоохон аюул занал, гамшиг зэрэг парламентын мэтгэлцээнээр орох шаардлагатай асуудал тохиох.

Тодруулга №30

Парламентаас гүйцэтгэх засгийг хянахад өргөнөөр хэрэглэгддэг бүтэц, горим

Ерөнхий мэтгэлцээн

“Зарим оронд гүйцэтгэх засаг нь өөрийн үйл ажиллагааны талаар парламентад тогтмол тайлагнах Үндсэн хуулийн заалттай байдаг. (...) Ихэнх оронд ерөнхий бодлогын шинжтэй асуудлуудыг тогтмол шалгах шаардлага байдаггүй бөгөөд ихэнхдээ хэн нэг гишүүнээс тусгайлан санал гаргасны дагуу хэлэлцдэг байна (...).”

▷ Асуулга

“(...) Асуулга нь мэдээлэл авах, хяналт хэрэгжүүлэх зорилгоор парламентын сонгодог тогтолцоонд ашиглагддаг хамгийн түгээмэл ажиллагаа юм. Асуулгыг парламентын гишүүнээс тухайн яамны үйл ажиллагаатай нь холбогдуулан хариуцсан сайдад, эсвэл ерөнхий бодлогын шинжтэй асуудлаар засгийн газрын тэргүүнд тавьдаг. Асуулга хоёр гол шинжтэй, үүнд: нэгдүгээрт, парламентын ерөнхий мэтгэлцээнийг өрнүүлдэг; хоёрдугаарт, мэтгэлцээний төгсгөлд засгийн газраас гаргасан тайлбар мэдээлэл хангалттай эсэх талаар санал хураалт явагддаг учир улс төрийн шинжийг агуулж байдаг. Хариуцсан сайд нарт нь шууд хариуцлага хүлээлгэдэг тул асуулга хамгийн үр дүнтэй арга юм. Нэг үгээр хэлбэл, энэ нь зөвхөн мэдээлэл авах хэрэгсэл төдий бус, харин шууд хяналтын нэг хэлбэр мөн (...).”

▷ Дараалал харгалзалгүй хэлэлцэх санал оруулах

“Британи хэлбэрийн тогтолцоонд асуулга гэж байдаггүй хэдий ч “яаралтай хэлэлцэх санал оруулах” нь үүнтэй төстэй гэж болно. Чуулган завсарлахаас өмнө энэ аргыг ашиглан засгийн газраас тодорхой асуудлаар тайлбар мэдээлэл авах боломжтой бөгөөд харин санал хураалт явагддаггүй. (...).”

▷ Асуулт

“Асуултын (...) зорилго нь засгийн газраас дэлгэрэнгүй мэдээлэл авах, тодорхой арга хэмжээ авахыг хүсэх, шаардлагатай тохиолдолд зүй бус үйл ажиллагааг ил болгох, засч залруулах арга хэмжээ авахад оршино. Түүнчлэн, парламентад өргөн барьсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг дэх мэргэжлийн нарийн зохицуулалтыг ойлгоход нь парламентын гишүүдэд туслахад хэрэглэнэ (...). Асуулт нь сөрөг хүчинд засгийн газрын сул талыг олж илрүүлэх боломж олгох бөгөөд олон нийтийн анхааралд хүргэснээр засгийн газарт алдаагаа олж засах, суралцах боломжийг олгож байдаг.

(...) Асуулт тавьж буй парламентын гишүүн нь асуулт тавих, хариулт авах эрхээ эдлэхдээ хэнээс ч хараат бус байдаг тул энэ арга хэрэгсэл түгээмэл ашиглагддаг. (...)”.

▷ **Хяналт шалгалтын хороод:** Тодруулга N°32-ыг үз.

Эх сурвалж, Парламентууд, Мишел Амеллер, Олон улсын парламентын холбоо, 1966

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын асуулт болон асуулга

Бичгэн болон аман асуултын аль аль нь парламентын мэдээлэл авах үйл ажиллагааны чухал хэсэг бөгөөд засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихад хамгийн өргөнөөр ашиглагддаг арга хэрэгслийн нэг мөн.

Чухам энэ үүргээсээ хамаарч асуулт нь аюулгүй байдлын салбарт үр дүнтэйгээр хяналт тавихад нэн чухал нөлөө үзүүлдэг. Аюулгүй байдалтай холбоотой парламентын асуултууд нь дараах үүрэгтэй. Үүнд:

- ✓ Парламентын гишүүдэд засгийн газраас баримталж буй батлан хамгаалах, аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын ерөнхий асуудлуудын талаар түргэн шуурхай, үнэн зөв, шинэлэг мэдээлэл авах боломж олгох;
- ✓ Парламентаас баталсан аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад туслах;
- ✓ Олон нийтийн анхаарлыг батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудалд хандуулах; нэн ялангуяа асуулт нь аман бөгөөд телевизийн буюу өөр бусад аргаар цацагдаж байгаа, парламентын мэтгэлцээний үеэр дахин хэлэлцэгдэж байгаа буюу үндэсний хэмжээний тайлан мэдээлэлд хэвлэгдэж байгаа бол (парламентын асуулт нь зөвхөн парламентын хүрээнд мэдээлэл авах төдийгээр хязгаарлагдахгүй бөгөөд хэвлэл мэдээлэл, ТББ-ууд болон иргэний нийгэмд бүхэлд нь мэдээлэл өгөх зорилгыг мөн агуулж байдаг);
- ✓ Аюулгүй байдлын асуудлаарх засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрт нөлөөлөх, чиглэлийг өөрчлөхөд нөлөө үзүүлэх;
- ✓ Сөрөг хүчний зүгээс аюулгүй байдалтай холбогдуулан өөрсдийн зовниж буй асуудлуудын талаар болон хангалттай мэдээлэл олж авч чадахгүй байгаа бусад асуудлуудтай холбогдуулан асуулт тавих боломж олгох.

Ихэнх тохиолдолд, аюулгүй байдлын салбартай холбоотой парламентын асуултууд нь эмзэг, нууц чанартай байдаг. Тухайн асуултад хариулах ёстой засгийн газрын гишүүн ихэнх тохиолдолд хариулахыг хүсэхгүй байх нь бий. Ийнхүү цааргалах нь аюулгүй байдлын салбарын үйл ажиллагааны нууцлалыг хадгалах шаардлагатай холбоотой байдаг. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой баримт

бичгүүд ихэнхдээ нууцын зэрэгтэй байдаг тул парламентын гишүүд болон олон нийтэд хаалттай байдаг.

Тодруулга №31

Парламентын асуултыг үр дүнтэй болгох

- ▷ **Нарийвчлан бэлтгэх:** аюулгүй байдлын салбартай холбоотой, нэн ялангуяа нарийн мэргэжлийн асуулт яригдаж буй үед цээжний пангаар ярих боломжгүй. Цэргийн албан тушаалтнууд (цэрэгт болон хагас цэрэгжсэн байгууллагад ажиллаж байсан туршлагатай хүн ч байж болно)-тай тогтоосон албан бус харилцаа үүнд тустай байж болно.
- ▷ **Асуудлыг тодорхой, ойлгомжтойгоор томъёолох:** асуултаа тодорхой бусаар томъёолох нь буруу ташаа ойлголт төрүүлж, хариуцсан сайдын зүгээс хангалтгүй эсвэл буруу хариулт өгөхөд хүргэж болзошгүй.
- ▷ **Цагаа олсон байх:** асуултыг цагаа олж тавих нь олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгын хүрээнд тухайн асуултын үр дүн, нөлөөнд чухал ач холбогдолтой.

Гэхдээ баримт бичгийг нууцын зэрэгт хамруулах засгийн газрын эрх мэдлийг хуулиар хязгаарласан байдаг. Түүнчлэн, баримт бичгийг нууцын зэрэгт оруулах үйл явц өөрөө ил тод бөгөөд хэн, аль баримт бичгийг нууцад хамааруулах шийдвэр гаргах эрхтэй болон нууцлалын үргэлжлэх хугацаа, нууцын зэрэглэлд хамруулах болон хасах нөхцлүүд зэрэг бүгд тодорхой байх ёстой.

Институцийн зүгээс авч үзвэл парламентын асуултын үр дүнд дараах хүчин зүйлс нөлөөлөх магадлалтай:

- ✓ Парламентын гишүүд хариултыг хангалтгүй гэж үзсэн эсвэл нэмэлт тодруулга шаардлагатай тохиолдолд нэмэлт асуулт тавих боломж;
- ✓ Асуултын цагийн үеэр тухайн асуулттай холбогдуулан парламентын гишүүдийн дунд мэтгэлцээн өрнүүлэх боломж;
- ✓ Асуулт тавих горимын боломжийг ашиглах хүсэл зориг;
- ✓ Асуултын цагт оролцох эсвэл телевиз радиогоор хүлээн авах олон нийтийн боломж;
- ✓ Асуулттай холбоотойгоор өрнөсөн мэтгэлцээнийг олон нийтэд хүргэх, цаашилбал аль ч тохиолдолд, асуулт хариултын баримт бичигтэй танилцах боломж олон нийтэд байх.

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын тусгай хяналт

Парламентын хороод нь хууль тогтоох ажилд тодорхой үүрэг гүйцэтгэхээс гадна засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавихад оролцдог. Хяналтыг хэрэгжүүлэхдээ мэдээлэл цуглуулах үүрэг бүхий түр бүтэц байгуулна. Үүнд нэг буюу түүнээс дээш хороод хамтран оролцох бөгөөд ажлын тайланг нийтлэн гаргана. Парламентын тусгай хяналт нь шүүхийн хяналттай адил заавал мөрдөгдөх ёстой.

Тусгай хяналтын хороодын үндсэн шинж болон давуу талууд

Аюулгүй байдал/батлан хамгаалахын асуудлаарх түр хороо онцгой ач холбогдолтой бөгөөд давуу тал ихтэй байдаг. Тухайлбал:

- ✓ Ийм хороог зөвхөн байгуулж буй нь л гэхэд олон нийтийн хувьд улс төрийн эерэг үзэгдэлд тооцогдоно;
- ✓ Аюулгүй байдлын салбартай холбоотой, улс төрийн хувьд эмзэг асуудлуудад хяналт тавихад хамгийн тохиромжтой хэрэгсэл юм;
- ✓ Уг хороод аюулгүй байдлын тодорхой асуудлаарх засгийн газрын бодлогыг үнэн зөвөөр үнэлж, шаардлагатай үед парламентын нийт танхим болон засгийн газрын аль аль нь хүлээн авахуйц засч залруулах арга хэмжээг санал болгох боломжийг олгоно.

Тодруулга №32

Парламентын хяналт шалгалтын хороодын үндсэн шинж

“(...) Хяналт шалгалтын хороодыг тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор өргөн хэрэглэдэг. Энэ зорилгын хүрээнд парламентаас өөрийн хяналтын үүргийг зохистойгоор гүйцэтгэх, тухайн асуудлаар үнэлэлт дүгнэлт гаргах, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд чуулганаар хэлэлцүүлж шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл цуглуулах үүргийг тодорхой тооны гишүүдэд өгдөг.

Тусгай хяналт шалгалт хийх эрх нь гүйцэтгэх засгийн үйл ажиллагааны аливаа асуудлын талаар бүрэн дүүрэн мэдээлэлтэй байх зарчмаас үүдэлтэй (...).

Зарим оронд хяналт шалгалтын хороодоос үр дүнтэй ажиллагаа явуулахад хүндрэл учирдаг. Учир нь тэд холбогдох албан тушаалтныг тусгай хяналтын асуулгад оролцохыг шаардах эрх байдаггүй тул шийдвэр гаргуулахаар шүүхэд хандахаас өөр аргагүй болдог. Ингэснээр уг асуудалд засгийн

газар оролцож, хорооны үйл ажиллагааг удаашруулан асуулгын үр нөлөөг бууруулдаг байна. (...) Гэсэн хэдий ч парламентын тусгай хяналтыг үр дүнтэй болгох хамгийн шилдэг арга бол мэдүүлэг өгөгчөөр тангараг өргүүлэх явдал юм. (...)

Төрийн албан хаагчдаас баримт мэдүүлэг авахад тулгардаг гол асуудал нь тэд тухайн чиглэл хариуцсан сайдын удирдлагад байдаг оршино. Парламентын гишүүдээс тавьсан асуултад хариуцахгүй байхыг даалгах сайдын эрх мэдэл хэр их вэ? (...) Зарим оронд төрийн албан хаагч мэдүүлэг өгөхийн тулд холбогдох яамнаасаа зөвшөөрөл авах ёстой байдаг. Гэхдээ шаардсан мэдээлэл нь “улсын аюулгүй байдалд хамааралтай, эсвэл төрийн албыг хэрэгжүүлэхэд эрсдэл, хүндрэл учруулах” аюултай гэдгийг тогтоогоогүй л бол нуун дарагдуулахыг хориглоно (...).

Тогтолцооны хэлбэрээс үл хамааран, парламентаас үүсгэн байгуулсан энэхүү хороо бол парламентын танхимд тайлагнах үүрэг бүхий зөвхөн судалгаа, баримт цуглуулах зориулалттай бүтэц гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тус хорооноос гаргаж өгсөн тайлан, мэдээлэлд үндэслэн холбогдох дүгнэлт хийх нь харин парламентын танхимын өөрийнх нь асуудал юм. (...).”

Эх сурвалж, Парламентууд, Мишел Амеллер, Олон улсын парламентын холбоо, 1966

Тусгай хяналтын хороодын хувьд өөр нэг чухал асуудал бол бүтэц. Эрх баригч намын болон сөрөг хүчний гишүүдийн тооны харьцаа нь тухайн хяналтын үр дүнд онц чухал ач холбогдолтой.

Орон орны парламент, хороодын чиглэлээс хамаарч уг хяналтын эрх хэмжээ харилцан адилгүй байдаг. Эдгээрээс хамгийн голыг нь дурдвал:

- ✓ Парламентын тусгай хяналтын сэдэв, хамрах хүрээг тодорхойлох;
- ✓ Армийн анги нэгтгэл болон аюулгүй байдлын бусад байгууламжид очиж танилцах (Бүлэг17-г үз);
- ✓ Ерөнхийлөгч, Засгийн газар, Зэвсэгт хүчний жанжин штаб зэргээс нууц, маш нууц зэрэглэлийг оролцуулан бүх мэдээллийг гаргуулж авах;
- ✓ Ерөнхийлөгч, Засгийн газар, цэргийн албан тушаалтнууд болон иргэний нийгмийн төлөөллөөс тангараг өргүүлсний үндсэн дээр баримт мэдүүлэг авах;
- ✓ Нээлттэй болон хаалттай сонсгол хийх.

Канадын цэргийн хүчинг Сомали руу илгээхэд явуулсан асуулгыг жишээ болгов (Тодруулга N°33-ыг үз).

Тодруулга № 33

Канадын цэргийн хүчинг Сомали руу илгээх асуудлаар байгуулсан хяналт шалгалтын хороо: Аюулгүй байдлын асуудлаар парламентаас гаргасан дүгнэлт ба олон нийтэд үзүүлэх нөлөө

1993 онд канадын цэрэг Сомалид үүрэг гүйцэтгэх үед нийт канадчуудыг цочролд оруусан хэд хэдэн хэрэг гарсан байна. Бэлэуэн дэх Канадын цэргийн баазад нэвтэрсэн сомаличуудыг буудсан, хоригдож байсан өсвөр насны Сомали хүүг канадын агаарын десантын хорооны хоёр албан хаагч зодож, амь насыг нь хөнөөсөн, тэдний нэг нь амиа хорлохыг завдсан, Сомали дахь ажиллагаа дууссаны дараа үүнтэй холбоотой чухал мэдээллийг нуун дарагдуулж, засварласан хэрэг гарчээ. Канадын агаарын десантын хүчний албан хаагчид шинэ цэргүүдэд зүй бусаар хандаж буйг харуулсан дүрс бичлэгүүд мөн илэрчээ. Эдгээр асуудлыг зөвхөн цэргийн мөрдөн байцаах зөвлөлөөс шалгах нь Канадын олон нийтийн хариуцлагын хэм хэмжээнд нийцэхгүй гэж засгийн газраас үзсэн тул Хяналт шалгалтын хуулийн дагуу Канадын парламент нээлттэй асуулга явуулсан байна.

Цар хүрээ ба эрх – гэрчүүдийг зарлан дуудах, мэдүүлэг авах, хөндлөнгийн мэргэжилтэн, зөвлөх хөлслөх, нотлох баримтыг үнэлэх зэрэг эрхийг Хяналт шалгалтын тухай хуулиар олгосон байдаг. Сомали улсад болон Батлан хамгаалах яаманд юу болж өнгөрснийг тодорхойлох гол арга бол байцаалт явуулах эрх байв. Канад даяар телевизээр шууд цацагдсан энэ нээлттэй асуулгын үеэр 116 гэрч мэдүүлэг өгсөн байна. Тус хяналтын хүрээ нь зөвхөн Сомалид болсон явдлаар хязгаарлагдаагүй бөгөөд Канадын зэвсэгт хүчний удирдлагын тогтолцоо, сахилга бат, үйл ажиллагаа болон үндэсний батлан хамгаалах яамны шийдвэр, үйл ажиллагааг ч мөн агуулгын хүрээнд хамарч байв. Нөгөө талаас, Сомалийн ажиллагаанд цэрэг илгээхийн өмнөх үе, ажиллагааны үе болон ажиллагааны дараах үе шаттай холбоотой тодорхой асуудлуудыг хяналтын хорооны гишүүд судлаж үзэх үүрэгтэй байлаа.

Шүүх хурал биш – Уг тусгай хяналтын асуулга нь шүүх хурлын үүрэг гүйцэтгэх зорилгыг агуулаагүй. Гэхдээ өмнө нь дээрх хүмүүсийг шүүн таслаж, ял шийтгэл ногдуулсан тухайн асуудлын институцийн түвшний шалтгаан, хариу арга хэмжээг асуулгын үеэр тодруулсан байна. Энэхүү тусгай хяналт шалгалтын гол анхаарлыг албан хаагчдын үйл ажиллагаанд бус, харин Канадын зэвсэгт хүчин, Батлан хамгаалах яамны бүтэц зохион байгуулалт, удирдлагатай холбоотой институцийн болон тогтолцооны түвшний асуудлуудад хандуулсан байна. Гэсэн хэдий ч удирдах түвшний албан тушаалтнуудын үйл ажиллагаа, удирдан чиглүүлэх үүргээ хэрхэн хэрэгжүүлснийг тодруулах нь зайлшгүй байв.

Үр дүн – Хоёр жил үргэлжилсэн энэхүү тусгай шалгалтын дүнд, Канадын зэвсэгт хүчин, Батлан хамгаалах яамны Сомалийн ажиллагааны үе дэх бүтэц, зохион байгуулалт; Канадын цэргийн командын тогтолцооны ач холбогдол; цэргийн соёл, ёс зүй; Канад дахь иргэн-цэргийн харилцаа зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамарсан дэлгэрэнгүй тайлан гаргажээ. Тайлангийн төгсгөлд Засгийн газрын болон Канадын цэргийн хүчний үйл ажиллагаа, бодлогыг өөрчлөхтэй холбоотой томоохон зөвлөмжүүдийг гаргасан. Эдгээр зөвлөмжийн ихэнх нь одоо хэрэгжилтийн шатандаа явж байна.

Эх сурвалж: Доктор, профессор Донна Уинслоу

Канадын Парламентын хяналт шалгалтын Техникийн зөвлөх, 1996.

Батлан хамгаалах болон аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын хороод

Аюулгүй байдал бол нарийн цогц салбар. Тиймээс энэ салбарт гүйцэтгэх засагт тавих хяналтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийн тулд чиглэл хариуцсан парламентын хороодын бүтэц зохион байгуулалт боловсронгуй, сайтар төлөвшсөн байх нь чухал. Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтыг ганц хороо дангаараа бус хэд хэдэн хороод хамтран хэрэгжүүлэх бөгөөд орон орны парламентад харилцан адилгүй нэрлэгдсэн (зарим тохиолдолд чиг үүргүүд нь нэгдсэн) байж болно.

Парламентын ийм хорооны тоонд ихэвчлэн дараах хороод орох ба хамтарсан хуралдаан хийж болдог. Үүнд:

- ✓ **Батлан хамгаалахын хороо.** (зарим тохиолдолд зэвсэгт хүчний, үндэсний батлан хамгаалахын, аюулгүй байдлын эсвэл гадаад хэргийн хороо гэсэн нэртэй байж болно). Тус хороо нь ерөнхийдөө цэргийн чиг үүрэг, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүн, ажиллагаа, санхүүжилт болон цэргийн алба хаах журам, зэвсэг техникийн ханган нийлүүлэлт зэрэг аюулгүй байдлын салбартай холбоотой бүх асуудлыг хамаардаг;
- ✓ **Гадаад хэргийн хороо.** Энэ хороо нь энхийн ажиллагаанд оролцох эсвэл нутаг дэвсгэр дээрээ энхийг сахиулах ажиллагаа явуулахыг зөвшөөрөх, олон улсын аюулгүй байдал, олон улсын/бүс нутгийн байгууллага, гэрээ хэлцэл зэрэгтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг;
- ✓ **Төсвийн буюу санхүүгийн хороо.** Энэ хороо нь аюулгүй байдлын салбарын бүх байгууллагуудын төсөвтэй холбоотой эцсийн шийдвэрийг гаргах; батлан хамгаалахын төсвийг оролцуулан нийт улсын төсвийн аудитын тайланг хянах төсвийн хяналтын хороо мөн үүнд багтаж болох юм;
- ✓ **Тагнуулын асуудал хариуцсан (дэд) хороо.** Энэ хороо ихэвчлэн хаалттай хуралддаг;
- ✓ **Аж үйлдвэр, худалдааны хороо.** Зэвсэг техникийн ханган нийлүүлэлт, худалдан авалттай холбоотой асуудлыг (төлбөр, баланс) голдуу хамаарна;

- ✓ Шинжлэх ухаан, технологийн хороо. (цэргийн эрдэм шинжилгээ, судалгаа);
- ✓ Дотоод хэргийн хороо нь цагдаа, хил хамгаалах алба, мөн ихэнх тохиолдолд цэрэгжсэн байгууллагуудын асуудлыг хариуцдаг.

Эрх мэдэл, арга хэрэгсэл

Гадны эх сурвалжаас нотлох баримт, шаардлагатай материал цуглуулах эдгээр хороодын эрх мэдэл харилцан адилгүй. Тухайлбал, Их Британийн Нийтийн танхимын түр хороо зэрэг парламентын хороод өөрсдөө мэдээлэл цуглуулах эрхгүй бол АНУ-ын Конгрессын хороод гадны эх үүсвэрээс нотлох баримт, мэдээлэл гаргуулж авах (тангаргийн дор) бараг хязгааргүй эрхтэй байдаг байна.

Зарим парламентын хороод шинэ хууль батлах, түүгээр ч зогсохгүй шинээр хуулийн төсөл боловсруулах, нэмэлт өөрчлөлт санал болгох зэрэг хууль тогтоох эрхтэй байдаг бол зарим нь зөвхөн гүйцэтгэх засгийн үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих эрхтэй байдаг.

Парламентын хорооны мэдэлд буй арга хэрэгсэл, мэргэжлийн мэдлэг, ур чадавхын түвшин, тухайлбал, ажиллагсдын тоо, чадавх, тогтвортой ажиллаж байгаа байдал; судалгаа шинжилгээний чадвар хийгээд чанар (мэргэшсэн эсвэл ерөнхий; бие даасан эсвэл парламентын судалгааны нэгжийн бүрэлдэхүүнд байдаг г.м.); мэдээлэлд нэвтрэх эрх болон холбогдох баримт бичгийн олдоц (мэдээлэл олж авах, дахин боловсруулах эрх); мэргэжлийн экспертүүдэд хандах боломж; сонсгол зохион байгуулах, хяналт шалгалтын ажиллагаа явуулах зэрэг нь тухайн хороо чиг үүргээ үр дүнтэйгээр гүйцэтгэхэд чухал нөлөөтэй. (Дэлгэрэнгүйг парламентын ажиллагааны механизм, арга хэрэгслийн талаарх Бүлэг 14-өөс үз).

Тодруулга №34

Батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын хорооны зарим жишиг үүрэг

Аюулгүй байдлын бодлого

- ▷ Батлан хамгаалах яамнаас гаргасан бодлогын томоохон санаачилгыг хэлэлцэх, санал дүгнэлт гаргах;
- ▷ Батлах хамгаалахын сайд бодлогын чиг үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг хянах;
- ▷ Батлан хамгаалах яам мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг даган мөрдөж байгаа эсэх, парламентад бүх шугамаар ирүүлж буй мэдээллийн чанарт хяналт тавих;

- ▷ Аюулгүй байдлын салбартай холбоотой асуудлаар цэргийн албан хаагч болон иргэдээс ирүүлсэн санал, гомдолтой танилцах, хянах.

Хууль тогтоомж

- ▷ Засгийн газраас парламентад өргөн барьсан хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх, санал дүгнэлт гаргах;
- ▷ Батлан хамгаалах яамны чиг үүрэгт хамаарах асуудлаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцлийг авч хэлэлцэх;
- ▷ Шаардлагатай бол батлан хамгаалахын сайдад шинэ хуулийн төсөл боловсруулах хүсэлт тавих, эсвэл өөрсдөө боловсруулах замаар шинэ хууль тогтоомж санаачлах.

Зардал

- ▷ Батлан хамгаалах яамны жил тутмын төсөв, гол зардлын төрлийг хянаж үзэх, санал дүгнэлт гаргах;
- ▷ Батлан хамгаалах яамнаас ирүүлсэн нэмэлт зардлын тооцоог нэг бүрчлэн хянаж үзэх, шаардлагатай тохиолдолд парламентаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх;
- ▷ Шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар аудит хийлгэх.

Удирдлага

- ▷ Гүйцэтгэх засгаас хийсэн холбогдох албан тушаалтны томилгоог авч хэлэлцэх, шаардлагатай тохиолдолд холбогдох баримт цуглуулан, санал дүгнэлт гаргах (цэргийн дээд удирдлага, дээд түвшний энгийн албан хаагчид);
- ▷ Парламенттай холбоотой ажилладаг омбудсмен зэрэг хөндлөнгийн бүтцээр дамжуулан батлан хамгаалах салбарын дотоод зохион байгуулалтыг авч үзэх, илэрсэн алдаа дутагдалд парламентын анхаарлыг хандуулах.

*Эх сурвалж: Парламентын хяналтын Хансард нийгэмлэгийн комиссын тайланд үндэслэв
Нэгдсэн вант улс, 2001*

Тодруулга N°35-д Норвегийн парламентын үйл ажиллагааны арга барилыг жишээ болгон авав.

Тодруулга N°35

Стортинг (Норвегийн парламент)-ийн Гадаад хэргийн хороо болон Батлан хамгаалахын хорооны хамтарсан хуралдаан.

“Гадаад хэргийн өргөтгөсөн хорооны үүрэг нь гадаад бодлого, худалдааны бодлого, үндэсний аюулгүй байдлын бодлогын чухал асуудлуудаар Засгийн

газартай зөвлөлдөхөд оршино. Эдгээр зөвлөлгөөнийг чухал шийдвэр гарахын өмнө хийх ба зарим шаардлагатай тохиолдолд өргөтгөсөн хорооноос зөвлөгөө боловсруулан Стортингээр хэлэлцүүлнэ.

Өргөтгөсөн хорооны бүрэлдэхүүнд Гадаад хэргийн байнгын хорооны энгийн гишүүд, Стортингийн Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгч (хэрэв гишүүн биш бол), Батлан хамгаалахын байнгын хорооны дарга, мөн Сонгуулийн хорооноос томилсон 11 хүртэл тооны гишүүд багтана. Бүрэлдэхүүнийг томилоход парламентад суудалтай намуудын бүлгийн төлөөллийн тэнцвэрийг харгалзан үзнэ.

Мөн адил зарчмын дагуу Сонгуулийн хороо нь гишүүний эзгүйд /ээлжийн амралтыг оролцуулан/ орны хүмүүсийг томилно.

Тус хорооны хуралдааныг хорооны дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, эсвэл Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайдын хүсэлтээр, эсвэл хорооны нийт гишүүдийн гуравны нэг хувийн хүсэлтээр зарлан хуралдуулна.

Өөрөөр тусгайлан заагаагүй бол Өргөтгөсөн хорооны хуралдааны хэлэлцэх асуудал нууц байна. Бусад хороотой хамтран хийх хуралдааныг мөн адил зарчмаар явуулна. Хорооны даргын шийдвэрээр Хорооны хуралдааныг нууцаар зарлан хуралдуулж болно.

Тухайн асуудлыг хэлэлцэж буй Гадаад хэргийн өргөтгөсөн хорооны хурал дээр 6-аас илүү гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд уг асуудлыг Стортингээр хэлэлцүүлнэ. Асуудлыг Стортингээр хэлэлцүүлэх бодит шаардлага байна гэж Хороо үзсэн бол энэ тухай Тэргүүлэгчдэд мэдэгдэнэ. Тус хуралдааныг нээлттэй эсвэл хаалттай горимоор хийх асуудлыг Стортинг шийднэ. Стортингээр хэлэлцүүлэх асуудлыг Засгийн газрын гишүүн танилцуулна. Тухайн асуудлаарх хэлэлцүүлгийг Стортингийн шийдвэрээр танилцуулгын дараа шууд эсвэл тусгай хурлаар хийнэ. Шийдвэрийн төслийг парламентын хороо боловсруулахгүй.

<http://www.stortinget.no/g>

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Танай улсын парламентын батлан хамгаалахын асуудал эрхэлсэн хорооны хамаарах асуудал

- ▷ Хороо болон түүний дэргэдэх дэд хороодын эрх үүрэг дараах шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхаарал хандуулах. Үүнд:
 - Нягт нарийн тодорхойлогдсон;
 - Хорооны хамаарах бүх асуудлыг бүрэн хамарч чадаж байгаа;
 - Аюулгүй байдлын бодлого болон гадаад хэрэг, агаарын/тэнгисийн аюулгүй байдал, аж үйлдвэр, эрчим хүчний хангамж зэрэг аюулгүй байдалд нөлөөтэй байж болохуйц бусад яамдын бодлоготой уялдсан.

Парламентын хорооны ажлын үр нөлөө

- ▷ Танай улсын парламентын эрх бүхий хороо болон дэд хороод Тодруулга №34-д заасан арга хэрэгслээр /хуулиар болон бодитоор/ хангагдсан байх.
- ▷ Батлан хамгаалахын тусгай чиглэлүүд, тухайлбал, төсөв, худалдан авалт, бие бүрэлдэхүүн, энхийг сахиулах ажиллагаа зэргээр дагнасан дэд хороо байгуулах асуудлыг судалж үзэх.
- ▷ Аюулгүй байдлын салбарын мэдээллийн бодлоготой холбоотой хууль тогтоомж, батлан хамгаалахын төсвийн зарцуулалттай тусгайлан танилцах ажлыг санаачлах.
- ▷ Тус хороо нь шаардлагатай нөөц, мэргэжлийн зөвлөгөө авах боломжоор бүрэн хангагдсан эсэхэд анхаарал хандуулах.
- ▷ Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтын талаар олон улсын хэмжээнд хуримтлуулсан шилдэг туршлагыг судлах.

Омбудсмэн

Аюулгүй байдлын салбарт хяналт тавих үүрэг бүхий хөндлөнгийн байгууллагууд дунд омбудсмэн онцгой байр эзэлдэг. Зарим оронд омбудсмэн нь захиргааны удирдлагын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй асуудлыг хамарсан өргөн хүрээний чиг үүрэгтэй байдаг. Мөн зарим оронд төстэй чиг үүрэг бүхий Комиссар эсвэл Олон нийтийн гомдлын хороо (Нигер) зэрэг өөр бүтэц байдаг бол заримд нь зэвсэгт хүчний асуудлаар дагнасан омбудсмэний байгууллага бий.

Тодруулга №36

Омбудсмэн

“(...) Омбудсмэн нь төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэлтэй холбогдуулан иргэдээс гаргасан гомдлыг авч хэлэлцдэг. Энэ алба хашигчийг парламентаас сонгох буюу төрийн тэргүүн, эсвэл засгийн газар парламенттай зөвшилцсөнөөр томилдог. Омбудсмэний гол үүрэг нь төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан аливаа эрхийн зөрчил, алдаа дутагдал, назгай байдал, шударга бус шийдвэрийн улмаас учрах хохирлоос иргэдийг хамгаалах, ингэснээр төрийн албаны чанарыг сайжруулах, засгийн газрын үйл ажиллагааг илүү нээлттэй, хариуцлагатай болгох явдал юм. Омбудсмэний байгууллага байгуулах талаар тухайн улсын Үндсэн хуулинд тусгаж, хууль эрх зүйн зохицуулалтаар дэмжих буюу хууль тогтоох байгууллагын шийдвэрээр байгуулж болно (...).

Иргэдийн эрхийг хамгаалах зорилгоор омбудсмэн дараах эрх мэдэл эдэлнэ:

- 1) засгийн газрын үйл ажиллагаа хууль зөрчиж байгаа эсвэл шударга бус байгаа эсэхийг шалгах;
- 2) тухайн шалгалтаар алдаа дутагдал илэрсэн тохиолдолд түүнийг засч залруулах зөвлөмж гаргах;
- 3) тодорхой асуудлаар явуулсан үйл ажиллагааныхаа талаар засгийн газар болон гомдол гаргагчид илтгэх ба гаргасан зөвлөмжийг нь засгийн газар хүлээж аваагүй тохиолдолд хууль тогтоох байгууллагад мэдэгдэх. Түүнчлэн, ихэнх омбудсмэн хууль тогтоох байгууллага болон олон нийтэд зориулан жил тутам тайлан гаргадаг.

Омбудсмэний гаргасан шийдвэр нь засгийн газрын хувьд заавал дагаж мөрдөх шийдвэр бус харин өөрчлөлт хийх зөвлөмж болно (...). Ерөнхийдөө, төрийн омбудсмэний чиг үүрэгт засгийн газрын олон байгууллага хамаардаг.

Зарим тохиолдолд, үүнд шүүх, цагдаа, цэргийн байгууллага хамаардаг бол зарим оронд аль нэгийг нь оруулаагүй байх нь бий.”

Эх сурвалж: Олон улсын омбудсмэний хүрээлэнгийн танилцуулга <http://www.law.ualberta.ca/centres/oi/>

Мөн үзэх нь: НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар,

Баримтын хүснэгт N°19, Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах үндэсний бүтцүүд

Батлан хамгаалахын омбудсмэн

Олон орны хуулинд батлан хамгаалахын омбудсмэнийг харилцан адилгүй нэртэй бие даасан бүтэц болгон оруулсан байдаг. Тухайлбал, Финлянд, Норвеги, Португаль, Герман зэрэг оронд Батлан хамгаалахын омбудсмэн, Израильд Цэргийн өргөдөл гомдол хариуцсан комиссар, Канадад Батлан хамгаалах яам, Канадын зэвсэгт хүчний омбудсмэн, Австралид Австралийн батлан хамгаалах хүчний омбудсмэн гэж нэрлэжээ.

Тодруулга N°37

Зарим орны батлан хамгаалахын омбудсмэний үйл ажиллагааны талаар

Улс	Эрх мэдэл	Чиг үүрэг	Тайлан
Австрали	- Батлан хамгаалах хүчний омбудсмэн - Сайдын шийдвэрээр томилдог	Австралийн батлан хамгаалах хүчний албан хаагчийн удирдлагын алдаа, зөрчил	- Жил тутмын тайлангаа сайдаар уламжлан парламентад илгээнэ
Канад	- Батлан хамгаалахын омбудсмэн - Сайдын шийдвэрээр томилдог	Батлан хамгаалах яам, Канадын зэвсэгт хүчний ажилтан, албан хаагчдын хүний эрхийг хамгаалах	- Тодорхой асуудлаар БХЯ болон КЗХ-д илтгэнэ. Үйл ажиллагааны жилийн тайлангаа сайдад танилцуулна. - Төвийг сахисан объектив чанартай зөвлөл. Батлан хамгаалахын сайдын удирдлагаас гадна байна.
Норвеги	- Батлан хамгаалахын омбудсмэн - Норвегийн парламентын дэргэд ажилладаг	Цэргийн алба хаагчийн ахуйг баталгаажуулах; батлан хамгаалах салбар хоорондын зөрчлийг шийдвэрлэх, харилцан итгэлцэл, нээлттэй байдлыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг	Зөвлөмж, дүгнэлт, шүүмж гаргах бөгөөд төрийн холбогдох байгууллагууд сайн дурын үндсэн дээр дагаж мөрдөнө.

Омбудсмэн нь иргэд болон/буюу парламентын нэрийн өмнөөс цэргийн салбарыг хянах нэмэлт механизм болдог. Цэргийн омбудсмэний гол үүрэг нь аюулгүй байдлын албад, түүний дотор цэргийн асуудал хариуцсан сайдын гаргасан маргаантай шийдвэр болон алдаа зөрчлийг хянан шалгах явдал юм.

Улс төрийн тогтолцоонд цэргийн омбудсмэний эзлэх байр орон бүрт харилцан адилгүй. Батлан хамгаалахын омбудсмэнийг парламентаас томилж, парламентад тайлагнадаг (Герман, Швед), эсвэл батлан хамгаалахын сайд томилдог (Израиль, Канад) байж болно. Зарим орны омбудсмэн парламентын бүтцэд ажилладаг (Германы парламентын Зэвсэгт хүчний асуудал хариуцсан комиссар, Тодруулга №38-ыг үз) бол зарим нь институцийн хувьд парламентаас гадуур (Швед) байдаг.

Цэргийн албан тушаалтан, байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон иргэн, албан хаагч омбудсмэнээр шалгалт хийлгүүлэхээр хандах эрхтэй. Түүнчлэн, зөрчил, гомдлын мөрөөр шалгалт хийхийг парламентаас омбудсмэнд даалгаж болно. Омбудсмэнээр шалгуулж буй хэргүүд голдуу цэргийн үүрэгт албанаас чөлөөлсөн, алба хаахыг хойшлуулсан, алба хаах хугацаанд өөр ангид шилжүүлсэн, албанаас халсан, чөлөө, сахилга баттай болон шийтгэл ногдуулахтай холбоотой асуудлууд байдаг. Тухайн гомдол үндэслэлтэй байна гэж омбудсмэн үзвэл зөвлөмж гаргаж холбогдох байгууллагыг шийдвэрээ эргэн харж өөрчлөхийг шаарддаг байна.

Омбудсмэн ба нууцлал

Аюулгүй байдлын салбарын өөрийн мөн чанараас хамааран үндэсний аюулгүй байдалтай холбоотой шалтгааны улмаас зарим мэдээллийг олон нийтэд ил гаргах боломжгүй байдаг. Олон оронд үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар омбудсмэний ажиллах горимыг хуулиар зохицуулсан байдаг. Ерөнхийдөө нууцлалын хамгийн өндөр зэрэглэлд хамаарах үед ч омбудсмэн шаардлагатай шалгалтыг явуулж, цэргийн баазад нэвтрэх, холбогдох баримт бичигтэй танилцах эрхтэй байдаг. Гэхдээ, энэ тохиолдолд омбудсмэн шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх эрхгүй.

Тодруулга №38

Германы парламентын Зэвсэгт хүчний асуудал хариуцсан комиссар

Герман 1950-иад оны үед зэвсэгт хүчнээ сэргээн байгуулсан ба ингэхдээ парламентын хяналтад ихээхэн анхаарал хандуулжээ. Бие хүнийг дээдлэх Үндсэн хуулийн заалтыг зэвсэгт хүчинд ч мөн адил хамааруулан баталгаажуулах үүднээс Үндсэн хуулинд 45б дэх заалтыг нэмж оруулжээ. Тус заалтад:

“... Зэвсэгт хүчний алба хаагчдын үндсэн эрхийг хамгаалах, парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд Бундестагт дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентын комиссарыг томилно.” Энэ заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх асуудлыг “Зэвсэгт хүчний асуудал хариуцсан Парламентын комиссарын тухай хууль”-ар зохицуулна” гэжээ.

Парламентын комиссар нь Парламент (Бундестаг)-ын дэргэдэх туслах бүтэц бөгөөд хууль тогтоох байгууллагын ажилтан юм. Тэрбээр Бундестаг болон батлан хамгаалах хорооноос даалгаснаар эсвэл өөрийн санаачилгаар хяналт шалгалтын ажиллагааг эхлүүлж болно.

Эрх мэдэл хуваах зарчмын дагуу комиссар нь батлан хамгаалахын сайдын үйл ажиллагааг хянадаг. Үүнтэй холбогдуулан, тэрбээр батлан хамгаалахын сайд, түүний удирдлагад ажилладаг агентлаг, албан хаагчаас шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гаргуулж авах эрхтэй. Түүнчлэн, зэвсэгт хүчний ямар ч анги, нэгдэл, төв, агентлаг, эрх барих албан байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр очих эрхтэй. Мөн зэрэг цол, албан тушаал хамааралгүйгээр цэргийн албан хаагчаас гомдол хүлээж авсан тохиолдолд өөрийн санаачилгаар хяналт шалгалтын ажиллагаа эхлүүлэх эрхтэй. Зэвсэгт хүчний ямар ч албан хаагч албан сувгаар дамжилгүй, гомдол гаргасантайгаа холбогдуулан шийтгүүлэх эсвэл гадуурхагдах эрсдэлгүйгээр өөрийн гомдлыг Комиссарт шууд хүргэх эрхтэй.

Эх сурвалж: <http://www.bundestag.de/>

Омбудсмэн: цэргийн албанд үзүүлэх итгэлийг бэхжүүлэх эх сурвалж

Цэргийн омбудсмэний туршлага, тухайлбал Шведийн Цэргийн омбудсмэний (1915 онд байгуулагдсан) жишээнээс үзвэл, энэхүү бүтэц нь батлан хамгаалах салбарт олон нийтийн зүгээс үзүүлэх итгэлийг нэмэгдүүлэх хүчирхэг хэрэгсэл болсон байна. Түүнээс гадна, омбудсмэн нь цэргийн албан хаагчдыг /эрэгтэй ба эмэгтэй/ хүчирхийлэл, зүй бус харьцаанаас сэргийлэх чухал хамгаалалт болдог. Ерөнхийдөө аюулгүй байдлын салбартай холбоотой омбудсмэний гол ололт нь цэргийн удирдлагын тогтолцоог алдагдуулж, цэргийн бэлэн байдлыг бууруулалгүйгээр удирдлагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, улмаар цэргийн салбарт үзүүлэх итгэлийг нэмэгдүүлсэнд оршино.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Омбудсмэний байгууллага

- ▷ Танай улсад ийм бүтэц хараахан байхгүй бол байгуулахад анхаарал хандуулах.
- ▷ Үүнтэй холбоотой, заавар зөвлөгөө, судалгааны материал, олон улсын сайн туршлага зэргийг дараах хаягаас авах боломжтой.

<http://www.ombudsmaninternational.com>

Батлан хамгаалах буюу аюулгүй байдлын омбудсмэн

- ▷ Танай улсад ийм бүтэц хараахан байхгүй бол байгуулахад анхаарал хандуулах.
- ▷ Батлан хамгаалахын омбудсмэн бүхий орнуудын туршлагаас судлах.
- ▷ Хэрэв танай оронд Батлан хамгаалахын омбудсмэн нэгэнт байгуулагдан ажиллаж байгаа бол түүний хууль эрх зүйн зохицуулалт, чиг үүрэг болон парламентад тайлагнах горим, нөлөөллийн үйл явц, нөөц бололцоо, төсөв зэргийг аюулгүй байдлын төстэй нөхцөл бүхий бусад орны холбогдох байгууллагатай харьцуулан судлах хүсэлт гаргах.

Аюулгүй байдлын албадтай очиж танилцах

Ач холбогдол

Аюулгүй байдлын салбарын талаар ул суурьтай мэдлэгтэй болох нь парламентын гишүүдийн хувьд нэн чухал. Аюулгүй байдлын албадын хэрэгцээ шаардлагыг илүүтэй ойлгох үүднээс онолын мэдлэгийг бодит туршлагаар баяжуулах ёстой. Энэ талаас нь авч үзвэл, парламентын гишүүд эдгээр байгууллагад очиж танилцах нь улс төрийн ба цэргийн удирдлагын хооронд яриа хэлцэл өрнүүлэх, ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх арга гэж үзэж болно. Мөн түүнчлэн цэргийн алба хаагчдын өдөр тутмын асуудлын талаарх парламентын гишүүдийн ойлголтыг нэмэгдүүлэх, улс төрийн удирдлагын зүгээс цэргийнхний үйл ажиллагаа болон ахуй амьдралыг сонирхож байгаа гэдгийг харуулах нэгэн боломж юм.

Тодруулга №39

Аргентины жишээ

Улс төрчид цэргийнхэнтэй санал бодлоо солилцох зорилгоор цэргийн анги, байгууллагад зочилдог. Ийнхүү зочлох талаар зэвсэгт хүчний удирдлагад мэдэгддэг бөгөөд харилцан үл итгэлцэл, таагүй сэтгэгдлийг арилгахад тустай байдаг. Парламентын гишүүд, зэвсэгт хүчний алба хаагчид хоорондын харилцаа өргөжсөнөөр цэргийн салбарын асуудлыг ойлгох ойлголтод ахиц гардаг. Аюулгүй байдлын асуудлууд дүрэм, цаг хугацааны хувьд бусад асуудлаас ихээхэн ялгаатай бөгөөд үүнийг ойлгоход улстөрчдөд эдгээр айлчлал тус болдог байна.

Эх сурвалж: Пабло Карлос Мартинез, “Зэвсэгт хүчний бүтцийн өөрчлөлт ба парламентын гүйцэтгэсэн үүрэг: Аргентины жишээ”

<http://www.pdgs.org>

Хорих анги болон шоронд байгаа хоригдлууд хамгаалалтын ажилтны бүрэн хараа хяналтад байдаг. Энэхүү онцгой нөхцөл байдлаас үүдэн тэд хүний эрхийн зөрчлийн хохирогч болох магадлал улам нэмэгддэг. Харамсалтай нь, хоригдлуудыг тамлах, зүй бусаар харьцах явдал хаа саагүй их гардаг. Тиймээс эдгээр байгууллагыг тусгайлан хянах тогтолцоо байх ёстой. Эдгээр байгууллагад гарч байгаа зүй бус харьцааны асуудлыг илрүүлэх, цаашид гарахаас сэргийлэх

зорилгоор парламентын гишүүд болон холбогдох мэргэжилтнүүд газар дээр нь очиж ажиллах үр дүнтэй арга мөн.

Тодруулга N°40-д хорих ангиудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах механизмийг НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод хэрхэн тусгасныг харуулав.

Тодруулга N° 40

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол нь аюулгүй байдлыг хангах байгууллагуудтай газар дээр нь танилцах боломжийг нэмэгдүүлж байна

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар болон хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн Нэмэлт протоколыг НҮБ-аас 2002 оны 12 дугаар сард баталсан. Уг протоколын дагуу гишүүн орнууд зүй бус харьцааг багасгах үүднээс өөрсдийн хорих ангиудыг эрх бүхий үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдэд нээлттэй болгох үүрэг хүлээсэн болно.

Дэлгэрэнгүйг дараах хуудаснаас үз: www.unhchr.ch

Танилцах ажлыг үр дүнтэйгээр явуулах нөхцлүүд

Парламентын гишүүд аюулгүй байдлыг хангах байгууллагууд, тухайлбал цэргийн анги, баазадтай танилцах талаар холбогдох яамтай /жишээлбэл, батлан хамгаалах яам/ нь урьдчилан холбогдож зохион байгуулах ёстой. Урьдчилан мэдэгдэж, бэлтгэл хангалгүй очих нь цэргийнхэнд итгэл үзүүлээгүйн илэрхийлэл гэж ойлгогдох, цаашилбал удирдлагын шат дамжлагыг алгассанаар цэргийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах ноцтой сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй. Түүнчлэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд парламентад суудалтай улс төрийн намуудын төлөөллийг хангах нь зүйтэй бөгөөд айлчлалын зорилго, зорилтын дагуу бэлтгэлээ сайтар хангасан байх ёстой.

Парламентын хорооны гишүүд зөвхөн тухайн байгууллагын удирдлагын харуулахыг хүссэн зүйлтэй л танилцахаас өөр аргагүй байдагт энэ ажлын сул тал оршино. Улмаар, ийм төрлийн танилцах айлчлал нь бодит асуудлын мөн чанарыг бүрэн илрүүлэхэд төдийлэн үр дүнтэй биш, харин ч цэргийн дарга нарт нөхцөл байдлыг, ялангуяа төсөв мөнгөтэй холбоотой асуудлыг өөрсдийн хүссэн зүгт эргүүлэх боломжийг олгодог. Энэ байдлыг бага боловч засах нэг арга бол танилцах ажлыг гурван төрөлд, тухайлбал, цэргийнхний санал болгосон айлчлал, парламентаас санал болгож урьдчилан мэдэгдсэн айлчлал болон парламентаас богино хугацааны дотор санал болгож (нэг өдрийн өмнө г.м.) мэдэгдсэн айлчлал гэж хуваах явдал юм.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Аюулгүй байдлыг хангах газруудад очиж танилцах асуудлыг зохицуулсан хууль тогтоомж

- ▷ Аюулгүй байдлыг хангах байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах (хилийн чанадад илгээсэн цэргийн ангийг оролцуулан) асуудлыг хуулийн зохицуулалтад оруулахаар ажиллах.
- ▷ Ийм хууль тогтоомж байхгүй тохиолдолд аюулгүй байдлыг хангах байгууллагуудтай танилцах айлчлалын бүрэлдэхүүнд парламентын гишүүд багтсансэх, тэдгээр гишүүдийг ямар журмаар оролцуулж байгаа, ямар шалгуур хэрхэн сонгож байгаа болон ямар үр дүнтэй байгааг судлах.
- ▷ Зохицуулалтын дүрэм журамд дараах асуудлыг багтаах. Үүнд:
 - аюулгүй байдлыг хангах ямар газруудад очиж танилцах боломжтой;
 - ямар нөхцөлд зочилж болох, өөрөөр хэлбэл аль ч үед очиж болох эсэх;
 - цэргийн анги, баазуудад парламентаас зочлох бодит боломж, давтамж,;
- ▷ Тухайн айлчлалын тайланг парламент буюу парламентын холбогдох хороонд бичгээр гаргаж өгөх, хэлэлцүүлэх;
- ▷ Өмнө хийгдсэн танилцах айлчлалуудын нөлөөлөл, үр дүнг үнэлж дүгнэх.
- ▷ Танай улс Эрүүдэн шүүхийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний Нэмэлт протоколд нэгдсэн эсэхийг тодруулах.

Парламентын танилцах айлчлалын бүрэлдэхүүн

- ▷ Айлчлалын бүрэлдэхүүнд намын бүлгүүдийн төлөөллийн харьцааг тэнцвэртэйгээр хадгалсан байх ёстой.
- ▷ Айлчлалын бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэрийг аль болох хангахыг эрмэлзэх.

Айлчлалын бэлтгэл

- ▷ Сөрөг үр дагавар гарахаас сэргийлэх үүднээс батлан хамгаалахын яаманд урьдчилан мэдэгдэж, холбогдох зохицуулалтыг хийх.

Парламентад тайлагнах

- ▷ Айлчлалын дэлгэрэнгүй тайланг парламент болон парламентын холбогдох хороонд бичгээр танилцуулах, хэлэлцүүлэхэд анхаарах.
- ▷ Аюулгүй байдлын эрх бүхий удирдлага айлчлалын тайлантай аль болох эрт танилцаж, санал бодлоо илэрхийлэх.

Олон нийтэд мэдээлэх, үр нөлөө

- ▷ Төлөөлөгчдийн үнэлэлт дүгнэлт болон парламентын холбогдох шийдвэр гарч, тэдгээрийг олон нийтэд мэдээлэх эсэхийг тухай бүрт нь хэлэлцэн шийдвэрлэж байх.

Тавдугаар хэсэг

Аюулгүй байдлын албадын үйл ажиллагаанд хяналт тавих:

Онцгой нөхцөл байдал ба тусгай ажиллагаа

Онцгой нөхцөл байдал

Дайн, дотоодын зэвсэгт мөргөлдөөн зэрэг төрөөс хямралыг зохицуулах тусгай эрх, горимын дагуу арга хэмжээ авах шаардлагатай онцгой нөхцөл байдал үүсч болно. Эдгээр хариу арга хэмжээ нь засаглалын ардчилсан тогтолцоонд сөргөөр нөлөөлөх ёсгүй.

Дайн болон өөр хэд хэдэн хямралын нөхцөл байдалд цэргийн ажиллагаа явуулах, түүгээр ч зогсохгүй, дайны байдал зарлах шаардлага тулгардаг. Ийм тохиолдолд цэрэг, аюулгүй байдлын салбар нь бүхэлдээ Олон улсын хүмүүнлэгийн хууль зэрэг олон улсын зарчим, баталгааг чанд баримтлах, мөн ардчилсан хяналтын дор хэвээр байх ёстой. Түүнчлэн, хүний эрхийг боломжит хамгийн дээд хэмжээнд хангаж байх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын конвенцийн 4 дүгээр зүйлийн талаар 2001 оны 8 дугаар сард гаргасан 29 дүгээр Ерөнхий тайлбарт заасанчлан, гажиж үл болох эдгээр зарчмаас хэзээ ч хазайх ёсгүй.

Дайны байдал

НҮБ-ын дүрмийн 2.4. дүгээр зүйлд зааснаар:

“Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн нь (...) хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний зорилгод харшлах ямарваа бусад үйлдлийг цээрлэнэ”.

Тиймээс бусад улс орны эсрэг хүч хэрэглэх явдлыг хатуу хориглоно. Дайн өдөөх, цэргийн хүчээр заналхийлэхийн эсрэг олон улсын эдгээр хоригийг гүйцэтгэх засаг сахин мөрдөж, хямралт нөхцөл үүссэн үед өөрийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглаагүйд хяналт тавих нь парламентын олон үүргийн нэг болно. Швейцарь зэрэг төвийг сахисан орнууд гадаад харилцааны хүрээнд үүссэн зөрчил, маргааныг цэргийн хүчээр шийдвэрлэхийг эрс буруушаадаг. Түүнчлэн, Үндсэн хуулиараа (1946) армитай байхыг хатуу хориглосон нэгэн улс байдаг нь Япон юм. Унгар зэрэг орнууд улс хоорондын маргааныг дайны аргаар шийдвэрлэхийг эрс эсэргүүцдэг.

Дайны байдал үүссэн үед, Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтаас хамааран парламент нь шийдвэр гаргах явцад дор хаяж дараах гурван аргаар оролцож болно (ач холбогдол нь буурах дарааллаар):

(1) Үндсэн хуулиар дайн зарлах, энх тайван тогтоох эрхийг парламентад олгосон байх. Гэхдээ өнөөдөр бодит амьдрал дээр аливаа дайн мөргөлдөөн ямар нэг анхааруулгагүйгээр эхлэх нь олонтаа бөгөөд парламент шийдвэр гаргахаас өмнө үйл явдал өрнөх магадлалтай тул энэ нөхцөл харьцангуй хийсвэр юм.

(2) Үндсэн хуулийн дагуу гүйцэтгэх засаг нь дайн зарлах, энх тайван тогтоохын өмнө парламентаас шуурхай зөвшөөрөл авах. Ийм заалт нь байлдааны ажиллагаа эхлүүлэх, хилийн чанадад цэргийн ажиллагаа явуулахаас өмнө асуудлыг хэлэлцэх боломжийг парламентад олгоно.

(3) Үндсэн хуулинд дайн зарлах шийдвэрийг парламентаас урьдчилан зөвшөөрөл авалгүй, зөвхөн мэдэгдэхээр заасан байх. Ихэнх орны Үндсэн хуулинд чухам ингэж заасан байдаг.

Онц байдал

Онц байдал буюу үндэсний хямралт байдал янз бүрийн нөхцлийн улмаас үүсч болно. Улс орны Үндсэн хуулийн болон бусад хуулийн зохицуулалтад онц байдал зарлах олон нөхцлийг тодорхойлсон байдгийн дотор Үндсэн хуульт тогтолцоо, олон нийтийн хэв журамд заналхийлсэн зэвсэгт ажиллагаа, байгалийн гамшиг, гоц халдварт өвчний тархалт, үндэсний хэмжээний санхүү-эдийн засгийн хямрал зэрэг багтдаг.

Онц байдлыг зөвхөн онцгой нөхцөл үүссэн тохиолдолд зарлах ба ардчилсан зарчмуудыг эрсдэлд оруулахгүйн тулд хэд хэдэн гол зарчмыг дагаж мөрдөх ёстой (Тодруулга N°41-ийг үз). Эдгээр онцгой нөхцөл байдлын тодорхойлолт нь улс орон бүрийн Үндсэн хууль, хууль эрх зүйн тогтолцооноос хамаарна. Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу аливаа нам өөрийн улс төрийн эрх ашгийн үүднээс онц байдал зарлахаас урьдчилан сэргийлсэн байх ёстой. Түүнчлэн, цэргийн эргэлт нь Үндсэн хуулийн эсрэг болохыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан байх ёстой.

Тодруулга N° 41

Онц байдал: Зорилго ба зарчим

“Онц байдал тохиолдсон үед авах тусгай арга хэмжээг эрх зүйн тогтолцоогоор тодорхойлсон байдаг. Гэхдээ тухайн хямралт байдлын улмаас аливаа эрхийг хязгаарлах нь зөвхөн түр хугацаатай бөгөөд хэв журам болон хүний суурь эрхийг хангах байдлыг эргүүлэн тогтоох зорилготой байх ёстой. (...)

Олон улсын зарчмууд

“Онц байдалтай холбоотой олон улсын зарчмуудыг дараах байдлаар багцалж болно:

Хуульд нийцэх зарчим буюу нэг талаас онц байдал зарлах ба онц байдлын арга хэмжээ, нөгөө талаас онц байдал зарлах ба тухайн улс орны дотоод хууль тогтоомж хоорондын зохицолдолгоо. Цаашилбал, дотоодын хууль тогтоомж нь олон улсын хууль тогтоомжид нийцэж байх ёстой.

Зарлан мэдээлэх зарчим буюу онц байдлыг олон нийтэд нээлттэй зарлан мэдэгдэх.

Харилцан мэдэгдэх зарчим буюу онц байдал зарласан тухай холбогдох гэрээнд оролцогч бусад улс оронд өөрт буй арга хэрэгсэл болон НҮБ-ын хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчээр уламжлан мэдээлэх үүрэг.

Түр хугацааны зарчим буюу онц байдал нь онцгой шинж чанартай, хугацааны тодорхой хязгаартай байх.

Онцгой аюулын зарчим буюу хямрал нь тухайн улсад бодит, цаг үеийн, шууд аюул занал учруулсан байх.

Тэнцлийн зарчим, хямралын эсрэг авсан арга хэмжээ нь учирч буй аюул заналын цар хүрээнд тохирсон байх.

Үл мэдрэгдэх зарчим буюу хүний үндсэн эрхийг хязгаарлахгүй байх.

“Хүний эрхийн үндсэн сахин хамгаалагч болох парламент нь түүнийг тараах, түдгэлзүүлэх эсвэл хууль тогтоох болон гүйцэтгэх засагт хяналт тавих эрх мэдлийг нь хязгаарласны улмаас онц байдлын анхны золиос болохгүй байх нь чухал. Түүнчлэн, онц байдал зарлах болох цуцлах шийдвэр гаргахад парламент өөрийн гэсэн үүргийг гүйцэтгэх боломжтой байх нь чухал. (...).

Онц байдлын эрх зүйн чанар

“(...) Онц байдал зарлахтай холбоотой (зарлах, батлах г.м.) үйл ажиллагаа болон онц байдал зарласан үед авсан арга хэмжээ (тодорхой зарим эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх г.м.) хуулийн засаглалд захирагдаж, хяналтын дор байх ёстой бөгөөд үүнд онц байдлын эрх зүйн чанар оршино (...)

Парламентын үйл ажиллагаа

“Тусгаар тогтнол болон засаглалын эрх мэдлийн хяналт-тэнцлийн зарчим нь (...) хуулийн засаглалын салшгүй хэсэг мөн. Тийм ч учир дэлхийн дийлэнх улс орны эрх зүйн тогтолцоонд онц байдал зарлах эсвэл гүйцэтгэх засгаас тогтоол гарсны дараа түүнийг батламжлахад парламент идэвхтэй оролцохоор зохицуулсан байдаг. Ингэхийн гол шалтгаан нь энэхүү нэн чухал шийдвэрийг гүйцэтгэх засаг дангаараа гаргахаас сэргийлэхэд оршино. (...)

Онц байдалтай холбоотой эрх зүйн зохицуулалтуудын зэрэглэл

“Туршлагаас үзэхэд онц байдлыг зохицуулж буй заалтууд нь Үндсэн хуулийн арга хэмжээтэй тэнцэхүйц зэрэглэлтэй байх нь чухал. Ихэнх хуулиар үүнийг шууд зохицуулсан байдаг ч заримд нь шууд бусаар буюу “онц байдал зарласныг үндэслэн аливаа эрх бүхий этгээд хууль тогтоох эрх мэдлийг өөртөө шилжүүлэн авахыг хориглоно” хэмээн заасан байдаг. (...).

Хүний эрх болон онц нөхцөл байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч ноён Л.Деспуагийн Олон улсын парламентын холбооны Парламент-Хүний эрхийн хамгаалал симпозиумд тавьсан илтгэлээс,

Будапешт, 1993

Урт хугацааны болон де факто онц байдал

Урт хугацааны буюу парламенаас жил дараалан эсвэл хэдэн арван жилээр сунган үргэлжилсэн онц байдлын улмаас аюулгүй байдлын салбарын байгууллагууд иргэний удирдлагад байх зарчим алдагдаж, тэдгээр байгууллагууд нэг ёсны халдашгүй эрхтэй болсноор ардчилал эрсдэлд орох магадлалтай. Ингэснээр парламент ихээхэн сул дорой, эмзэг байдалд орно. Зарим оронд өнөөг хүртэл үргэлжилж буй урт хугацааны де факто онц байдлаас үзэхэд аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналт алдагдаж, ингэснээр аюулгүй байдлын салбар бараг хязгааргүй эрх мэдлийг де факто эдлэж буй нь тод томруунаар харагдаж байна.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Онц байдлын талаарх хууль тогтоомж

- ▷ Онц байдлын ялгаа заагтай төрлүүдийг Үндсэн хууль болон бусад хуулиар нарийн тодорхойлсон байх.
- ▷ Парламентаар тусгайлан хэлэлцэж, санал хураалтаар сунгаагүй тохиолдолд онц байдал 3-6 сарын дараа автоматаар хүчингүй болох.
- ▷ Хуульд нийцэх, олон нийтэд зарлах, бусад улсад мэдэгдэх, түр хугацааных байх, онцгой аюул учирсан байх, тэнцвэртэй байх, хүний эрхэнд үл халдах зэрэг олон улсын зарчмуудыг онц байдлын тухай үндэсний хууль тогтоомжид зохих ёсоор тусгах.
- ▷ Онц байдлын үед хүмүүнлэгийн хууль, Үндсэн хуулиар олгогдсон баталгаа, хүний эрхийн хууль тогтоомжийг хүндэтгэх.
- ▷ Онц байдал зарлах, цуцлахтай холбоотой хууль тогтоох болон гүйцэтгэх засгийн эрх үүргийг Үндсэн хууль буюу холбогдох хууль тогтоомжид нарийн тодорхойлсон байх.

Онц байдлын үе дэх парламентын үйл ажиллагаа

- ▷ Онц байдлын аль ч төрлийн үед аюулгүй байдлын салбарт хамаарах гүйцэтгэх засгийн үйл ажиллагаа болон хүний үндсэн эрхийг хэрхэн хангаж буй талаар парламентаас хяналт тавих эрхийг бүрмөсөн хязгаарлахгүй байх.

Дотоод аюулгүй байдлыг сахин хамгаалах

Дотоод (буюу нийтийн) аюулгүй байдал болон нийгмийн хэв журам бол ард түмний сайн сайхны иш үндэс мөн. Энэ нь нийт ард түмэнд, үүний дотор тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач болон гадаадын иргэдийг ялгаварлалгүйгээр хамаарна. Дотоод аюулгүй байдал, нийтийн хэв журмыг улс төрийн удирдлага, ямарваа нэг хүчний хүсэл зорилгод нийцүүлэхийн тулд эсвэл аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй аюулгүй байдлын салбарын өөрийнх нь сонирхолд үйлчлэхээр гуйвуулах ёсгүй.

Дотоод аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийн нийтлэг үндэслэл, шинжүүд

Онц байдал зарлахуйц ноцтой биш хэдий ч шуурхай арга хэмжээ аваагүй тохиолдолд дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журамд заналхийлж болзошгүй нөхцөл байдлыг шийдвэрлэхэд зориулагдсан ямарваа хууль тогтоомж аль ч улс оронд байдаг.

Эдгээр хууль тогтоомж нь холбогдох хуулинд тодорхой заасан байх ёстой аливаа нөхцөл байдал тохиосон үед бусад илүү чухал суурь эрхийг хамгаалах зорилгоор зарим эрхийг хязгаарлах, бүр түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авах үүднээс гүйцэтгэх засагт тодорхой хэмжээний онцгой эрх олгоно.

Хязгаарлалт эсвэл түдгэлзүүлэлтэд хамгийн их өртдөг эрхийн тоонд мэдээлэл авах, жагсаал цуглаан хийх, эрх чөлөөтэй байх, орогнол хүсэх зэрэг орно. Харин амьд явах эрх болон эрүүдэн шүүх, тамлах, харгис хэрцгий, хүний ёсноос гадуур хандах, доромжлох зэрэгт өртөхгүй байх эрх мэт үндсэн эрхийг хязгаарлахыг олон улсын хууль тогтоомжоор хориглодог. Тусгайлсан хориг арга хэмжээнд хамгийн их өртдөг хүмүүс бол цагаачид, сэтгүүлч, улс төрийн идэвхтнүүд, хүний эрхийг хамгаалагчид, улс төрийн орогнол хүсэгчид, дүрвэгсэд, шашны болон үндэсний цөөнх байдаг.

Холбогдох эрсдлүүд

Дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах хууль тогтоомжтой холбоотой эрсдлүүдийг дурдвал:

- ✓ Аюул заналыг хэт ерөнхий томъёолсны улмаас гүйцэтгэх засаг өөрийн хэрэгцээ шаардлагад тохируулан тайлбар хийх цоорхой үлдээх;
- ✓ Гүйцэтгэх засаг, улмаар түүний бүтэц дэх аюулгүй байдлын байгууллагуудад урт хугацааны, хэт давуу эрх мэдлийг зохих хяналт шалгалтын тогтолцоо, удирдлагын болон шүүхийн оролцоогүйгээр олгох;
- ✓ Зарим тохиолдолд дотоодын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахиулах ажиллагааг хүн амын нэг эсвэл хэсэг бүлгийн, улс төрийн удирдлага эсвэл аюулгүй байдлын салбарын өөрийнх нь ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор олон нийтийн эрхийг хязгаарлах, үйл ажиллагааг нь хянах арга хэрэгсэл болгож урвуулан ашиглах;
- ✓ Дотоодын хэв журмыг сахиулагч цагдаагийн албыг хэт цэрэгжүүлэх нь цагдаа болон гадаад аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий зэвсэгт хүчин хоорондын зааг ялгааг алдагдуулж болно. Нэн ялангуяа цагдаагийн байгууллагын санхүүжилт хангалтгүйн улмаас аюулгүй байдлын нөхцөл байдлаар шалтаглан аливаа хориг, ял зэмлэлгүйгээр авлига авах нөхцөл бий болох аюултай. Цагдааг хэт цэрэгжүүлэхийн бас нэг эрсдэл нь эрх баригчид цагдаа (болон зарим тохиолдолд тагнуул болон бусад цэрэгжсэн байгууллагууд)-г дотоод аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хамгаалах бус харин сөрөг хүчнээ дарах хэрэгсэл болгох ашиглах явдал юм. Түүнээс гадна, цэргийн хүчийг нийгмийн хэв журам сахиулахад олонтаа ашиглах нь цэргийн байгууллагыг улс төржүүлэхэд хүргэж болзошгүй.
- ✓ Парламент болон шүүхийн эрх мэдэл бодит байдал дээр гүйцэтгэх засгийн эрх мэдлээс доогуур бол тэдгээрийн эрх мэдэл цуцлагдана.

Тиймээс аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор авсан арга хэмжээ нь зарим нөхцөл байдалд аюулгүй байдлын албадын албан хаагчдын зүгээс хүний эрхийг зөрчих, түүгээр ч үл барам үүнийхээ төлөө огт ял шийтгэлгүй өнгөрөхөд хүргэх болзошгүй. Ийм нөхцөлд хамгийн их зөрчигддөг эрхийн тоонд: амьд явах эрх; эрүүдэн шүүх, харгис хэрцгий, хүний ёсноос гадуур хандах, гутаан доромжлохоос ангид байх эрх; дур зоргоороо баривчлахаас ангид байх эрх; хуулийн дагуу байгуулагдсан, хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх эрх; өөрийн үзэл бодолтой байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эвлэлдэн нэгдэх эрх ордог байна.

Тодруулга №42

Аюулгүй байдал, ардчиллыг тэгш хангах

Түүхэнд болон өнөө ч гэсэн, хөгжиж буй олон орны дарангуйлагч засаглал нь олон нийтийн хэв журам, хувь хүний аюулгүй байдалтай ардчилал нийцэхгүй хэмээн ардчилалд чиглэсэн аливаа алхмыг жадлан эсэргүүцсээр ирсэн. Гэвч энэ мэдэгдэл буруу ташаа болохыг бодит байдал харуулж байгаа бөгөөд аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төрийн байгууллагуудад ардчилсан, иргэний хяналт тавих нь хувь хүний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй бус, харин ч зайлшгүй шаардлагатай. Ийм хяналтгүйгээр хувь хүний аюулгүй байдлыг сахин хамгаалагч хүч нь эсрэгээрээ хамгийн том заналхийлэгч болдог. (..)

Эх сурвалж: НҮБ-ын Хүний хөгжлийн тайлан, 2002 (хуудас 87)

Зарим оронд ардчиллыг хамгаалах зорилго бүхий хууль тогтоомжийг тусгайлан баталжээ. Тухайлбал, Аргентинд “Ардчиллыг сахин хамгаалах тухай” 23.077 тоот хуулийг 1984 онд баталж, эрүүгийн хуулийг шинэчилж, ардчилал, Үндсэн хуулийн эсрэг аливаа хууль бус нэгдлийг хориглох нэмэлт заалтуудыг оруулсан байна.

Дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журамд заналхийлсэн гэх үндэслэлээр баривчлан саатуулах

Дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах тухай бүх хууль тогтоомжид тэдгээрт заналхийлэгч этгээдийг баривчлан саатуулах тухай заасан байдаг. Үүнд дор хаяж хоёр төрлийн хууль багтана. Үүнд:

- ✓ Үндэсний аюулгүй байдалд бодитоор заналхийлж буй аливаа этгээдийг саатуулах зохицуулалт бүхий хууль тогтоомж: ийм шийдвэрийг ихэвчлэн шүүхээс олгодог боловч зарим онцгой тохиолдолд гүйцэтгэх засаг өөрөө шийвэр гаргадаг;
- ✓ Гүйцэтгэх засгаас үндэсний аюулгүй байдалд заналхийлэх боломжтой хэмээн үзэж буй аливаа этгээдийг саатуулах зохицуулалт бүхий хууль тогтоомж буюу үндэсний аюулгүй байдлыг эрсдэлд оруулж болзошгүй нөхцөл байдлаас өөрийн үзэмжээр сэргийлэх эрхийг олгосон хууль тогтоомж.

Британийн Хамтын нөхөрлөлд багтах ихэнх орнуудын хууль хоёр дахь төрөлд багтах бөгөөд энэ хуулийн дагуу гүйцэтгэх засаг нь хууль тогтоох болон шүүх байгууллагын урьдчилан зөвшөөрөл, оролцоогүйгээр үндсэн хуулийн зарим баталгааг түдгэлзүүлэх өргөн хүрээтэй эрх мэдлийг эдэлдэг байна. Үүнтэй

холбоотой нэг гол асуудал бол үндэсний аюулгүй байдалд заналхийлж болзошгүй этгээдийг захиргааны журмаар саатуулах гүйцэтгэх засгийн эрх юм. Тус этгээдийг гүйцэтгэх засгийн мэдэлд тодорхой хугацаагаар саатуулан хорих ба энэ хугацааг тодорхой эсвэл бүр тодорхойгүй хугацаагаар ч сунгах боломжтой. Эдгээр хуулиудын заримд нь зөвлөх, эсвэл эсрэгээр саатуулагдсан этгээдийг суллахыг гүйцэтгэх засагт тушаах эрхтэй хяналтын бүтэц байхаар заасан байдаг. Хяналтын байгууллагын бүрэлдэхүүн нь ямар нэг хэмжээгээр гүйцэтгэх засагтай холбоотой байж болдог ажээ.

Олон оронд эдгээр хууль тогтоомж нь колоничлолын үеэс уламжилж ирсэн бөгөөд гүйцэтгэх засаг болон аюулгүй байдлын байгууллагууд, нэн ялангуяа цагдаагийн байгууллагад үлэмж хэмжээний эрх олгодог, түүнчлэн иргэний болон улс төрийн эрхийн хангалтад сөргөөр нөлөөлдөг гэсэн шалтгаануудын улмаас уг хуулиудыг эргэж харах, өөрчлөх санал санаачилгууд ихээр гарах болсон байна.

Тодруулга №43

Ноштой үр дагавар бүхий гажуудлууд

Төр аюулгүй байдлыг өөрийн эрх мэдлийн тулгуур гэж үздэг нөхцөлд аюулгүй байдлын албад нь тухайн улсын ард иргэд болон хөрш зэргэлдээ орнуудын хувьд хамгийн том аюул занал болдог. (...) Дотоод явдлын яамны цэрэг, зэвсэгт цагдаа, тагнуулын хүчинг дотоодын улс төрийн тэмцэлд татан оролцуулдаг бол ардчилсан иргэний хяналтыг сайжруулах хүчин чармайлт мөхөсдөнө.

НҮБ-ын Хүний хөгжлийн тайлан, 2002 (хуудас 87 ба 92)

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах хууль тогтоомж

- ▷ Аюулгүй байдал, нийгмийн хэв журам нь ард иргэдийн төлөө бөгөөд хүмүүсийг дарангуйлах, улс төрийн намын хүсэл зоригийг гүйцэлдүүлэх арга хэрэгсэл огт биш гэдгийг ямагт санах. Цагдааг хэт цэрэгжүүлэх, дарангуйлах зорилгоор ашиглахаас зайлсхийх;
- ▷ Гүйцэтгэх засгийг парламентын өмнө хариуцлага хүлээдэг болгож, эрх мэдэлд нь хууль эрхийн тодорхой хязгаар тогтоох;

- ▷ Аюулгүй байдлын салбараас хүч хэтрүүлэн ашигласан тохиолдолд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээдэг байх зохицуулалтыг нэвтрүүлэх;
- ▷ Ардчиллыг сахин хамгаалах тухай хуулийг өөрийн оронд баталж хэрэгжүүлэх боломжийг судалж үзэх.

Парламентын хяналт

- ▷ Дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журамтай холбоотой асуудлуудыг парламентаар тогтмол хэлэлцэж, хууль тогтоомжийн холбогдох хэрэглээг анхаарах.
- ▷ Парламентын холбогдох хороод нь дотоод аюулгүй байдал, нийгмийн хэв журамтай холбоотой мэдээллийг гаргуулж авах, хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд бүх нөөц бололцоогоо дайчлан ажиллах. Шаардлагатай бол шинжээчийн дүгнэлт гаргуулах зэргээр тухайн хороодын бололцоо, чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
- ▷ Шаардлагатай хийгээд боломжтой үед энэ чиглэлээр нээлттэй сонсгол зохион байгуулах.
- ▷ Дотоод аюулгүй байдал, нийтийн хэв журам болон энэ чиглэлээр гаргасан шийдвэр хүний эрх, үндсэн эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж буйг судалдаг ТББ-уудтай албан болон албан бус байдлаар санал солилцох.

Терроризм

“Төрийн ард иргэдээ хамгаалах ёстой аюул заналын нэг бол терроризм мөн. Ингэх нь төрийн эрх төдийгүй үүрэг юм. Гэхдээ терроризмын эсрэг арга хэмжээг хүний эрхийн зөрчлийг халхлах, зөвтгөх үндэслэл болгон хувиргахгүйн тулд төр ихээхэн анхаарал болгоомжтой хандах ёстой.»

“Дотоодод тулгардаг нэг аюул бол аюулгүй байдал хангахыг эрмэлзэхдээ бид нэн чухал эрх, эрх чөлөөг золионд гаргаж, ингэснээрээ өөрсдийн нийтлэг аюулгүй байдлаа бэхжүүлэх бус харин сулруулан, улмаар ардчилсан засаглалыг дотроос нь ганхуулдаг явдал юм.»

*Кофи Аннан, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга,
2001 оны 11 дүгээр сарын 21*

Терроризм нь дотоодын болон бүс нутаг, олон улсын аюулгүй байдлын томоохон аюул заналын нэг мөн. Терроризм ихэвчлэн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотой байдаг учир түүний эсрэг арга хэмжээ цогц байх ёстой. Үүнд цагдаа, хил хамгаалах албанаас эхлээд тагнуулын ажиллагаа; санхүүгийн салбараас эхлээд эрүүгийн хууль, мэдээллийн технологийн салбар дахь арга хэмжээ хүртэл хамаарна.

Есдүгээр сарын 11-ний халдлагаас хойш олон орон дээрх чиглэлээр хууль эрх зүйн зохицуулалтаа чангалах шаардлагатай гэж үзсэн. Түүнээс гадна, тагнуулын мэдээлэл солилцох, мэдээллийн технологийн чиглэлээр улс хоорондын хамтын ажиллагаа мөн бэхэжсэн. Мэдээж энэ нь хүний эрх, иргэний эрх чөлөөнд ихээхэн эрсдэл давхар авчирсан юм.

Терроризмыг хянах олон улсын хамтын ажиллагаатай холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан 1373 тоот тогтоол (2001 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр баталсан; Тодруулга N°44-ийг үз)-д санхүүгийн хяналтад онцгой анхаарал хандуулжээ. Мөн тус тогтоолоор террористууд, террорист бүлэглэлүүдийн дотоод болон хил дамнасан хөдөлгөөнийг сэргийлэх зорилгоор хилийн хамгаалалт, биеийн байцаалт, аяллын бичиг баримтад тавих хяналтын ач холбогдлыг онцолсон байна. Түүний зэрэгцээ уг тогтоол террорист бүлэглэлүүдэд шинээр гишүүн элсүүлэх, зэвсэг, осолтой материал нийлүүлэх явдлыг таслан зогсоох, улс хоорондын хамтын ажиллагаа болон бусад арга замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн зөвлөмжийг агуулжээ. Түүнчлэн, террорист ажиллагааг санхүүжүүлэх, төлөвлөх, түүнд бэлдэх, санаархах, мөн террорист ажиллагааг дэмжсэн этгээдэд зохих шийтгэлийг ноогдуулахын

зэрэгцээ ийм ажиллагааг дотоодын хууль тогтоомжид ноцтой гэмт хэрэг гэж үзэн яллах заалтыг оруулах ёстой хэмээн заажээ. Мөн олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, шүүхийн асуудлаар мэдээлэл солилцоог эрчимжүүлэх замаар террорист ажиллагаа үйлдэхээс урьдчилан сэргийлэхийг уриалсан байна. Улмаар уг тогтоолын хүрээнд шаардлагатай мэргэжилтнүүдийн тусламжтайгаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Аюулгүй зөвлөлийн бүх гишүүдийн төлөөллөөс бүрдсэн Тусгай хороо байгуулжээ.

Тодруулга N°44

Есдүгээр сарын 11-ний үйл явдалтай холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс авсан хариу арга хэмжээ

Аюулгүйн зөвлөлөөс (...)

3. Бүх улсыг:

(а) Ажиллагааны мэдээлэл солилцоо, нэн ялангуяа террорист этгээд болон сүлжээний шилжилт хөдөлгөөн, дуураймал болон хуурамч биеийн байцаалт, зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, бусад осолтой материалын наймаа, террорист бүлэглэлүүдийн харилцаа холбооны технологийн хэрэглээ, үй олноор хөнөөх зэвсэг террорист бүлэглэлүүдийн гарт орох аюул занал зэргийн талаарх мэдээлэл солилцоог эрчимжүүлэх;

(б) Олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, шүүхийн асуудлаар мэдээлэл солилцоог эрчимжүүлэх замаар террорист ажиллагаа үйлдэхээс урьдчилан сэргийлэх;

(в) Хоёр болон олон талт хамтын гэрээ хэлцлээр дамжуулан террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн ийм ажиллагаа хийхээр санаархагчдын эсрэг арга хэмжээ авах зорилгоор хамтран ажиллах;

(г) 1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц зэрэг терроризмтэй холбоотой олон улсын конвенц, пактуудад аль болох шүүрхай элсэх;

(д) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1269 (1999) болон 1368 (2001) дугаар тогтоолууд болон терроризмтэй холбогдох олон улсын конвенц, пактуудын хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлж, эдгээр баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн хангах;

(е) Дүрвэгч гэсэн статусыг олгохын өмнө тус статусыг хүсэгч нь террорист ажиллагаа төлөвлөх, холбон зуучлах, оролцох үйлдэл гаргаагүй гэдгийг баталгаажуулах зорилгоор үндэсний болон олон улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээ авах; ингэхдээ хүний эрхийн олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөх;

(ё) Дүрвэгч гэсэн статусыг террорист үйл ажиллагаа явуулагч, холбон зуучлагч, зохион байгуулагчид урвуулан ашиглаагүй гэдгийг баталгаажуулах арга хэмжээг олон улсын хууль тогтоомжийн дагуу авах, мөн терроризмын хэрэгт сэжиглэгдэгч этгээдийг өөрийн улсаас албадан гаргах хүсэлтэд улс төрийн зорилгоор татгалзах хариу өгөх; (...).

Эх сурвалж: НҮБ-ын Аюулгүйн зөвлөл, Тогтоол 1373, S/RES/1373, 2001 оны 9 дүгээр сарын 28 <http://www.un.org/Docs/scres/2001/sc2001.htm>

НҮБ-аас 1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталсан Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенцийн дагуу оролцогч талууд нь терроризмыг санхүүжүүлэх ажиллагаанд сэжиглэгдсэн аливаа этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээс албадан гаргах, сэжигтэй гүйлгээг шалгах үүрэг хүлээдэг. 2002 оны 4 дүгээр сарын 2-ны байдлаар тус конвенцид 132 орон гарын үсэг зурсан бөгөөд 26 орон соёрхон батлах явцыг гүйцэлдүүлснээр Оролцогч улс болжээ. Уг конвенц 2002 онд хүчин төгөлдөр болсон.

Есдүгээр сарын 11-ний халдлагын үр дагавар

Парламентын гишүүдийн хувьд засгийн газраас террорист халдлагын асуудлаар арга хэмжээ авахдаа тэнцвэртэй хандаж, аюулгүй байдал, хүний эрхийн аль алиныг хангаж байгаа эсэхэд хяналт тавих нь чухал. Гишүүдийн хувьд терроризмтэй холбогдуулан авч үзэх асуудлууд бол аюулгүй байдал болон терроризмын эсрэг шинэ цогц чиг хандлагыг тусгасан хууль тогтоомж гаргах, мөн аюулгүй байдал хийгээд хүний эрх, эрх чөлөөний хооронд зохист тэнцвэрийг хангаж олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийн зарчмуудыг баталгаажуулах явдал юм.

Терроризмыг хуулийн хүрээнд тодорхойлох

Олон улсын хэмжээнд терроризмын тухай нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт өнөөг хүртэл байхгүй байна. Ийм тодорхойлолт бий болох хүртэл терроризмыг янз бүрээр тайлбарласан хэвээр байх болно. Олон улсын хууль цаазанд гадаадын эзлэн түрэмгийллийн эсрэг үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг хууль ёсны хэмээн үздэг бөгөөд террорист ажиллагаанд хамруулдаггүй. Цаашилбал, олон улсын хамтын нийгэмлэг, үүний дотор ОУПХ-оос террорист ажиллагааг ямар нэг шашин, үндэстэн эсвэл иргэншилтэй холбож үзэх ёсгүй бөгөөд тэдгээрийн нэрийг барих үндэслэлгүй гэдгийг тэмдэглэсээр ирсэн. Терроризмыг тодорхойлох бас нэг арга зам бол олон улсын хамтын нийгэмлэгээс эрс буруушаасаар ирсэн террорист халдлагын хэлбэрүүд буюу гэм зэмгүй энгийн иргэдийг үл ялгаварлан бүх нийтийг хамарсан харгис халдлага эсвэл үндэстний хэсэг бүлэг этгээд, нууц бүлгэмийн явуулсан нийтийг хамарсан алан хядах аливаа ажиллагаа зэргийг хамааруулах явдал юм.

Террорист халдлагын ялгарах гол онцлог нь энгийн иргэдийн эсрэг ялгаваргүй хүчирхийлэл үйлдэх, хүмүүний үнэт зүйлсийг үл ойшоох, олон нийтийн анхаарлыг татах сонирхол маш өндөр байдаг зэрэг болно. Тэднээс өргөнөөр хэрэглэдэг аргууд гэвэл барьцаалах, автомашинд тэсрэх бөмбөг суурилуулах, амиа золиослогчдыг ашиглах, олон нийтийг хамарсан аллага үйлдэх зэргийг дурдаж болно. Алан хядах ажиллагаа тасралтгүй явуулахад санхүүгийн дэмжлэг, зэвсэг хэрэгслийн байнгын хангалт, түүнчлэн олон улсын зохион байгуулалттай сүлжээ зайлшгүй шаардлагатай. Террористуудыг орогнуулдаг, туслалцаа үзүүлдэг этгээд

нь ихэвчлэн гуравдагч орон байдаг. Жагсаал цуглаан хийх хууль ёсны эрхийг хамгаалахын сацуу терроризмын эсрэг арга хэмжээний хэрэгцээ шаардлагын аль алиныг тэнцвэржүүлэх зарим чухал санааг Тодруулга N°45-д харуулсан болно. Тухайлбал, тус тодруулгын 37 дугаар зүйлд терроризмын эсрэг тэмцэл нь зөвхөн терроризмтэй шууд тэмцэхээс гадна террористуудын шинэ залуу үеийн өлгий болсон улс орнуудыг нийгэм, улс төр, эдийн засгийн хувьд хөгжүүлэхэд мөн анхаарах ёстой гэсэн санааг өгсөн байна.

Тодруулга N°45

Терроризмын эсрэг тэмцэл

34. (...) Гадаадын түрэмгийллийн эсрэг үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл нь олон улсын тогтоол шийдвэрт туссан хууль ёсны эрх мөн агаад уг зорилт нь террорист ажиллагаанд хамаарахгүй гэдгийг Бага хурал иш үндэс болгож байна. Гэхдээ ямар ч тэмцэл нь олон нийт, нэн ялангуяа энгийн ард иргэдийг үл ялгаварлан хамарсан аллага эсвэл төрөөс дэмжлэгтэй зохион байгуулалттай терроризмыг зөвтгөх үндэслэл болохгүй гэдгийг Бага хурал онцлон тэмдэглэж байна.

37. Терроризмын эсрэг аюулгүй байдлын аливаа арга хэмжээг эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн бүтцийн арга хэмжээтэй хослуулах ёстой хэмээн Бага хурал онцлон тэмдэглэж байна.

Эх сурвалж: Газар дундын тэнгисийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны талаарх ОУПХ-ны 3 дугаар бага хурлын төгсгөлийн баримт бичиг. Валетта, Мальта, 1995 оны 11 дүгээр сар

Австри (Эрүүгийн хуулийн 278б дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл), Герман (Эрүүгийн хуулийн 129а дугаар зүйл), Канад (С-36 дугаар акт) зэрэг орны терроризмын эсрэг хуулиудад дараах нийтлэг зохицуулалт туссан байдаг. Үүнд:

- Террорист үйл ажиллагааны тодорхой жагсаалт, тухайлбал, аллага, хүн барьцаалах, нисэх онгоц булаан авах, дэлбэлэх, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилго бүхий аливаа үйлдэл, эс үйлдэл, заналхийлэл. Эдгээрийн ихэнх нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хууль бус гэж заасан гэмт хэргийн жагсаалтад хамаарна (Герман, Австри, Канадын терроризмын эсрэг хууль);
- Террорист байгууллага, бүлэглэлийг удирдах, дэмжлэг (санхүүгийн болон бусад төрлийн) үзүүлэхийг хуулиар мөн хориглосон байдаг (Герман, Канад, Австри);
- Улс төрийн, үзэл суртлын, шашны гэхчилэн террорист үйл ажиллагааны шалтгаан (Канад);
- Террорист үйл ажиллагааны зорилго буюу олон нийтийг айлган сүрдүүлэх,

эсвэл олон нийт, засгийн газрын үйл ажиллагаанд нөлөөлөх, тэднийг ямар нэг үйлдэл, эс үйлдэл хийхэд хүргэх (Канад);

- Террорист үйл ажиллагааны шууд зорилго буюу хүчирхийллийн арга хэрэгсэл ашиглан хүний амь хороох, бусад хэлбэрээр хохироох, амь насанд заналхийлэх болон нийтийн болон хувийн хэрэгцээний чухал үйлчилгээ, дэд бүтцийг сүйтгэх, саатал учруулах (Канад).
- Ардчилал, хуулийн засаглалыг тогтоох буюу сэргээн тогтоох, хүмүүнлэгийн хууль тогтоомжийг сахиулахад чиглэсэн үйл ажиллагааг террорист ажиллагаа гэж тооцохгүй байх (Австри). Хуулийн ийм зохицуулалт нь хууль ёсны дагуух жагсаал цуглаан, эсэргүүцлийг яллахаас сэргийлдэг.

Эдгээр хууль тогтоомжид хүчирхийлэл, хувь хүн болон тогтолцоонд хохирол учруулах зорилгыг терроризмын гол тодорхойлогч болгон авч үзсэн байна. Түүнээс гадна эдгээр хуулинд терроризмд хамааруулах үйлдлийн нарийвчилсан жагсаалтыг гаргажээ. Террорист ажиллагааг зөвхөн гардан үйлдэх бус, террорист бүлэглэлтэй холбоотой байх (гишүүн, дэмжигчийн эсвэл удирдагчийн хувиар)-ыг мөн адил террорист үйлдэл гэж үзсэн байна.

Терроризмын эсрэг шинээр боловсруулж буй хууль тогтоомжид терроризм гэж чухам юу болохыг оновчтой тодорхойлсон байх нь парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд нэн чухал. Нэг талаас, тодорхойлолт хэт явцуу байвал террорист бүлэглэлүүдийн явуулж болох үйл ажиллагааны боломжит бүх хувилбарыг хамарч чадахгүй байх эрсдэлтэй. Нөгөө талаас, хууль ёсны, ардчилсан эсэргүүцэл, жагсаал цуглааныг яллахуйц хэт өргөн хүрээг хамрах ёсгүй. Үүнд хамгийн чухал асуулт бол ардчилсан нийгэмд хүчирхийллийг чухам ямар хэр хэмжээнд зөвтгөж болох вэ? Орон орны хууль тогтоогчид энэ асуултад харилцан адилгүй хариулт өгдөг нь түүхийн явцад улс орон бүрт хүчирхийллийг эрх зүйн дагуу хүлээн зөвшөөрөх ялгаатай хэм хэмжээ бүрэлдэн тогтсон байдагтай холбоотой. Энэ асуултыг тунгааж үзэхдээ юуны өмнө тухайн хүчирхийллийн зорилго нь хууль зүйд нийцэж байгаа эсэхийг харгалзах шаардлагатай. Хүчирхийллийн учруулж болох аюул заналын хэмжээ, зорилгыг тооцож байж л зөвтгөх боломжтой.

Харгалзаж үзэх дараагийн асуудал бол терроризмын эсрэг аливаа арга хэмжээ нь террорист аюул заналын цар хүрээнд тохирсон, түүнтэй уялдсан байх зарчим юм. Терроризмын эсрэг хууль тогтоомжийн гол зорилго бол террорист үйл ажиллагаанд оролцогч этгээдийн эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авахад цагдаа болон аюулгүй байдлын бусад албадад тус дөхөм үзүүлэх явдал гэдгийг анхаарах хэрэгтэй. Эдгээр хууль тогтоомж нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх суурь эрх чөлөөг хязгаарлах, хууль ёсны улс төрийн сөрөг хүчин эсвэл өөрчлөлтийг хаан боогдуулах зорилгыг агуулах ёсгүй.

Терроризмын эсрэг арга хэмжээний гурван чиглэл

Нийгэм болон төрийн институцийг террорист халдлагаас хамгаалахын тулд аюулгүй байдлын албад дараах гурван хариу үйлдлийг хэрэгжүүлж болно. Үүнд:

- ✓ **Терроризмын эсрэг арга хэмжээ:** ард иргэд, олон нийтийн ахуй амьдрал, барилга байгууламж, дэд бүтцийн эмзэг байдлыг сайжруулах.
- ✓ **Терроризмын эсрэг сөрөг арга хэмжээ:** террористуудыг олж илрүүлэх, таслан зогсоох замаар халдлагаас урьдчилан сэргийлэх.
- ✓ **Хямралын зохицуулалт:** террорист халдлагын дараах нөхцөл байдлыг шийдвэрлэж, тогтворжуулах (гамшиг, онц байдал).

Судалгаанаас үзэхэд, терроризмын эсрэг дийлэнх арга хэмжээ нь (1) үндэсний хууль тогтоомж, нэгдсэн зохицуулалт, төсөв санхүү, (2) дотоодын аюулгүй байдал, (3) гадны этгээд, (4) аялал, хилийн хяналт, (5) санхүү, (6) олон улсын хамтын ажиллагаа (7) атомын, биологийн, химийн (АБХ) аюул заналтай холбоотой байдаг байна. Эхний байдлаар гаргасан энэ жагсаалтыг терроризмын эсрэг боломжит арга хэмжээний лавлах гэхэд болно.

Үндэсний хууль тогтоомж, нэгдсэн зохицуулалт, төсөв санхүү:

- Терроризмын эсрэг хууль тогтоомжийг тусгайлан боловсруулж батлах, эсвэл хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг одоогийн нөхцөл байдалд тохируулан шинэчлэх;
- Холбогдох байгууллага, үйл ажиллагаанд зориулан хуваарилах төсвийг нэмэгдүүлэх (цагдаа, хил хамгаалах алба, үндэсний агаарын тээвэр, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд, шуудан холбоо, цэрэг);
- Дотоодын аюулгүй байдлын албад хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах;
- Аюулгүй байдлын албадад (цагдаа, цэрэг, тагнуул, хил хамгаалах алба) чиглэсэн бодлого, тэдгээрийн хэрэгжилтийг орон нутгийн болон холбооны/үндэсний хэмжээнд уялдаа холбоогоор хангах үүрэг бүхий хүний нөөц, нэгдсэн зохицуулалтын байнгын төвүүд;
- Гааль, татварын албадын мэдээллийн сан дахь хувь хүний мэдээлэлтэй танилцах эрхийг тагнуул, хууль сахиулах байгууллагын холбогдох албан тушаалтнуудад олгох.

Дотоод аюулгүй байдал

- Интернэт, утсан болон цахилгаан холбоог чагнах, хянах (шүүх зэрэг холбогдох хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр);
- Цахилгаан холбооны операторууд үйлчлүүлэгчдийнхээ харилцаа холбооны

мэдээллийг (нэг жилийн хугацааны г.м.) хадгалж, хууль сахиулах албадыг цахилгаан холбооны мэдээлэлд нэвтрэх боломжоор хангах;

- Банк, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч, зээлийн товчоо зэрэг байгууллагаас хувь хүний цахим мэдээллийг сэжигтэн этгээдэд мэдэгдэлгүйгээр авах;
- Иргэдийн талаарх мэдээлэл бүхий мэдээллийн сангуудыг холбох замаар компьютерийн хайлтын үр дүнг сайжруулах;
- Цагдаагийн байгууллагын мэдээлэл боловсруулах систем дэх хувь хүний бүртгэлтэй цагдаагийн бус албан тушаалтнууд танилцах боломжийг олгох;
- Илүү мэдээлэл олж авах зорилгоор сэжигтэнг саатуулан хорих хугацааг сунгах;
- Цахим үнэмлэх нэвтрүүлэх зэргээр үндэсний хэмжээнд байршил тодорхойлох тогтолцоог бий болгох.

Гадны этгээд (цагаачид, орогнол хүсэгчид, гадаадын иргэд)

- Аюулгүй байдлын албадад гадаадын иргэд/этгээдийн мэдээллийн санд нэвтрэх эрх олгох;
- Зарим үндэстний гарал үүсэлтэй хүмүүст онцгой анхаарал хандуулах;
- Орогнол хүсэгч нь террорист үйл ажиллагаанд оролцсон байж болзошгүй хэмээн сэжиглэгдэж байгаа бол тухайн этгээдийн шүүхэд хандах эрхийг хасах;
- Орогнол хүсэгч нь үндэсний аюулгүй байдалд заналхийлнэ гэж холбогдох албан тушаалтан (сайд) дүгнэсэн тохиолдолд орогнол хүссэн хүсэлтэд татгалзсан хариу өгөх боломжтой байх;
- Цагаачлагч болон орогнол хүссэн этгээдүүдийн хурууны хээг (10 хүртэл жилийн хугацаанд) хадгалах;
- Террорист аюул учруулж буй боловч өөрийн орноос албадан гаргах боломжгүй байгаа этгээдийг саатуулан хорих;
- Виз олгох ажиллагааны явцад хяналт шалгалтыг чангатгах; тухайлбал, виз мэдүүлэгч болон орогнол хүсэгчийн улс төрийн намтрыг илүү нухацтай шалгах.

Аялал, хилийн хяналт

- Хилийн хяналтыг чангатгах;
- Иргэний агаарын хөлгийн нисэх багийг зэвсгээр хангах;
- Нисгэгчдийн бүхээгэнд сум үл нэвтрэх хаалга суулгах;
- Нисэх буудал дахь ачаа тээшийг 100% шалгалтад хамруулдаг болох;
- Цахим үнэмлэх/паспортод биометрийн үзүүлэлтүүдийг тусгадаг болох;
- Хилийн эмзэг цэгүүд (усан боомт, хонгил, нисэх буудал) дэх хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлж, нарийвчлалыг сайжруулах;
- Хил нэвтрэх цэгүүдэд гадаад төрх байдалд үндэслэн шалгалт хийх.

Санхүү

- Санхүүгийн гүйлгээг хянах;

- Мөнгө угаах, луйврын гэмт хэргээс сэргийлэх зорилгоор банк болон зээлийн байгууллагуудад тавих хяналтыг чангатгах; террорист үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэгдсэн дансны гүйлгээг зогсоож, битүүмжлэх;
- Банкуудад өөрийн бүх данс, үнэт цаасны мэдээллийг төв мэдээллийн санд шилжүүлэх (банкны дансны мэдээлэл солилцоо) шаардлага тавих, террорист зорилготой байж болзошгүй хэмээн мэдэж байсан буюу сэжиглэсэн гүйлгээний талаар мэдээлээгүй тохиолдолд тухайн банкныг хариуцлагад татах;
- Санхүүгийн тагнуулын албыг байгуулах, чадавхыг нэмэгдүүлэх (сангийн яамны бүтцэд)

Олон улсын хамтын ажиллагаа

- Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, жишээ нь Европын баривчилгааны эрх эсвэл гэмт хэрэгтний шуурхай шилжүүлэг г.м.;
- Терроризмын эсрэг олон улсын гэрээ хэлэлцээрийг үндэсний хууль тогтоомжид тусгах;
- Афганистан дахь Олон улсын аюулгүй байдлыг дэмжих хүчинд цэрэг илгээх;
- Терроризмын эсрэг НҮБ-ын конвенцид элсэн орох, соёрхон батлах;
- Аюулгүй байдлын байгууллагуудтай олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох;
- Терроризмын уг үндсийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах, тухайлбал, терроризмын үүр уурхай болсон орнуудад хөгжлийн тусламж үзүүлэх.

Атомын, биологийн, химийн аюул занал

- Цөмийн, биологийн, химийн, радиологийн халдлагын эсрэг төвүүдийг байгуулах, байгаа төвүүдийг бэхжүүлэх; энэ чиглэлээрх үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, төрөл бүрийн вакцин (салхин цэцэг өвчний г.м.) үйлдвэрлэх, нөөцлөх;
- Эрүүлийг хамгаалах байгууллагуудын бэлэн байдлыг сайжруулах; эм, хэрэгслийн зохих нөөцийг бий болгох;
- Цөмийн байгууламжийн хамгаалалтыг сайжруулах (хэт нам өндөрт нисч буй биетийг илрүүлэх радарын төхөөрөмж суурилуулах г.м.)

Хүний эрх болон аюулгүй байдлын зохист тэнцвэр

Улс орнуудад хэрэгжиж байдаг эдгээр арга хэмжээ нь түр зуурын бус, харин урт хугацааны шинжтэй байх нь илүүтэй. Тиймээс терроризмын эсрэг арга хэмжээ нь онцгой үзэгдэл бус, харин нийгмийн өдөр тутмын амьдралын нэгэн хэсэг мөн. Тэдгээр арга хэмжээний улмаас үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хувийн мэдээллээ нууцлах зэрэг иргэний эрхүүд хөндөгдөж байгаа тохиолдолд энэ нь бүр ч ач холбогдолтой юм. Терроризмын эсрэг арга хэмжээ өөрөө урт хугацааны зорилготой байдаг тул онц байдал, онцгой нөхцөл байдал зэрэгт хамааруулах нь тохиромжгүй.

Түүний зэрэгцээ, хууль сахиулах болон тагнуулын чиг үүрэг хоорондын уламжлалт зааг ялгаа терроризмын эсрэг арга хэмжээн дээр бүдгэрдэг. Цагдаа зэрэг хууль сахиулах байгууллага болон тагнуулын албадын зорилго харилцан адилгүй. Тагнуулын албад нь болзошгүй аюул заналтай холбоотой мэдээлэл цуглуулдаг бол цагдаагийн байгууллагын үүрэг нь хууль, хэв журам сахиулах байдаг. Ерөнхийдөө тагнуулын албанаас сэжигтэнг саатуулах, баривчлах ажиллагаа үйлддэггүй бол нөгөө талд цагдаагийн байгууллага гэмт хэрэг үйлдэгдсэн гэх баттай нотлох баримт олдохоос өмнө ‘урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тагнуулын ажиллагаа’ авч явуулдаггүй. Ардчилсан засаглалын үүднээс үзвэл тагнуулын албад өөрийн иргэдийг ‘тагнаж чагнах’ аливаа ажиллагаанд оролцох ёсгүй. Гэсэн хэдий ч олон оронд терроризмын эсрэг тэмцлийн ач холбогдол өсөхийн хэрээр (гадаад) тагнуулын арга хэрэгслийг дотоодын эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах хязгаарлалт буурч, улмаар чиг үүргийн нарийн тодорхой хуваарилалт хийхэд улам бүр хүндрэлтэй болж байна.

Гуравдахь асуудал гэвэл, аюулгүй байдлын албад шүүх зэрэг хөндлөнгийн хяналтын байгууллагад урьдчилж мэдэгдэлгүйгээр иргэдийг мөрдөх, ажиглах эрхтэй байх явдал улам нэмэгдэж байна. Энэ нь иргэний эрхийн ноцтой зөрчил бөгөөд иргэд, омбудсмэний байгууллагууд, ТББ-ууд энэ талаар мэдээлэл аваагүй байдаг учир засгийн газар, түүний харъяа байгууллагуудтай хариуцлага тооцох боломжийг хязгаарлаж байгаа юм.

Дөрөвдүгээрт, терроризмын эсрэг арга хэмжээний гол бай нь цагаачид, орогнол хүсэгчид болон гадны иргэд болох өндөр магадлалтай. Ингэснээр нийгэм дэх үндэстэн, ястан хоорондын зөрчлийг хурцатгахын зэрэгцээ хүн бүр хуулийн дор адил тэгш байна гэсэн зарчмыг үгүйсгэх аюултай байдаг.

Хэдий энэ бүх арга хэмжээ нь терроризмын эсрэг тэмцлийг үр дүнтэйгээр явуулахад шаардлагатай байж болох ч үүнд парламентын гүйцэтгэх гол үүрэг нь эдгээр арга хэмжээ нь олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомж, зарчмуудад нийцэж буй эсэхэд хяналт тавих явдал юм. Өөрөөр хэлбэл, үнэмлэхүй аюулгүй байдалд тэмүүлэх нь биелэшгүй зорилго бөгөөд улмаар олон улсын болон өөрийн улс орны өмнө хүлээх үүрэг хариуцлагаа умартахад хүргэж болзошгүй. Түүнээс гадна, энэ зорилгын араас ардчиллын үзэл баримтлалын эсрэг туйл болох үнэмлэхүй эрх мэдэл дагалдаж явах нь олонтаа. Чухам ийм учраас хуулийн аливаа тогтолцоонд гүйцэтгэх засагт өгсөн тусгай эрх мэдлийг ямар нэг байдлаар заавал хязгаарласан байдаг. Өнөө үед терроризмын эсрэг хийж буй тэмцэл дэх эрх чөлөө болон аюулгүй байдал хоорондын зөрчил нь орон орны парламентад ихээхэн бэрхшээл авчирч байна. Гэсэн хэдий ч парламент нь ард түмний төлөөлөл, хүний эрхийг баталгаажуулагч болохын хувьд эрх чөлөө болон аюулгүй байдлын тэнцвэрийг хангах хариуцлагыг зөвхөн гүйцэтгэх засагт орхилгүйгээр нягт нарийн хяналт хэрэгжүүлж байх нь амин чухал асуудал болоод байна.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Терроризмын эсрэг тэмцэл

- ▷ Зөвхөн хамгаалалт, аюулгүй байдалд анхаарах бус дотоодын зөрчил, хямрал зэрэг суурь шалтгаантай нь тэмцэх терроризмын эсрэг өргөн хүрээтэй хандлагыг баримтлах. Бүс нутгийн хямралыг энх тайванч аргаар шийдэх, соёл хоорондын харилцан солилцоо, ойлголцлыг өргөжүүлэх нь терроризмаас сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэдгийг санах.
- ▷ Бүс нутгийн дийлэнх хямралын уг үндэс нь үндэстэн ястны олонх, цөөнх хоорондын зөрчил, эсвэл шашны асуудлаас үүдэлтэй байдаг. Ийм зөрчлийн үед зэвсэгт хүчинг зохих ёсоор болон зүй бусаар ашиглаж болно. Парламент дахь нийгмийн аливаа цөөнхийн төлөөлөл батлан хамгаалах, тагнуулын, хууль шүүхийн асуудал эрхэлсэн парламентын хорооны гишүүн байх ёстой. Түүнчлэн, парламентад цөөнхийн эрх ашгийг хамгаалах тусгай хороо болон шүүн таслах бүтцийг байгуулах ёстой.
- ▷ Танай улс 1999 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц зэрэг олон улсын холбогдох конвенц, протоколын гишүүн эсэхэд анхаарал хандуулах. Шаардлагатай бол, эдгээр арга хэрэгслийг соёрхон батлах эсвэл даган мөрдөхөд чиглэсэн арга хэмжээ авч, шаардлагатай хууль тогтоомж, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх.
- ▷ НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас цөмийн терроризмын эсрэг конвенц болон терроризмын эсрэг цогц конвенц батлан гаргахад чиглэсэн үйл явцыг анхааралтай ажиглах.
- ▷ Үндэсний эв нэгдлийн илэрхийлэл болгож террорист ажиллагааны хохирогчдод нөхөн төлбөр олгоход чиглэсэн хууль тогтоомжийг батлан гаргах чиглэлээр ажиллах.
- ▷ Терроризмын эсрэг хууль тогтоомж нь аюулгүй байдлын хэрэгцээ шаардлага болон иргэний хийгээд улс төрийн эрх хоорондын зохистой тэнцвэрийг хангасан байхад анхаарах; энэхүү хуулийн холбогдох бүх салбарт үзүүлэх нөлөө болон хэрэгжүүлэх зардлыг судлах.
- ▷ Онц нөхцөл байдлын талаарх Бүлэг 18 болон дотоод аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахин хамгаалах талаарх Бүлэг 19 дэх холбогдох тодруулгуудыг мөн үз.

Аюулгүй байдал ба мэдээллийн технологи: Шинэ арга хэрэгсэл болоод сорилтууд

Мэдээллийн шинэ технологиуд хэрэглээнд нэвтрэх болсноор нэг талаас аюулгүй байдлыг сахин хамгаалахад тустай болсон хэдий ч нөгөө талаас шинэ аюул заналыг дагуулах болсон. Өмнөх бүлэгт хэдийнэ дурдсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоол (2001) (Тодруулга N°44-ийг үз) нь мэдээллийн технологийг олон улсын терроризмтэй холбогдуулан давхар ашиглах болсон хийгээд үүнээс үүдэн аюулгүй байдал, олон улсын энх тайванд учрах аюул заналын талаар олон улсын хамтын нийгэмлэг ухамсарлаж эхэлсэн гэдгийг харуулж байна.

Олон улсын байгууллагууд сүүлийн гуч орчим жилийн турш мэдээллийн технологийг нэг талаас гэмт хэрэг, олон улсын аюулгүй байдалд заналхийлэх бусад зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх, нөгөө талаас улс орнуудын засгийн газраас хүний эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөх байдлаар ашиглахгүй байх чиглэлээр ажиллаж ирсэн.

Эдгээр сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хууль тогтоомж боловсруулахдаа парламентын гишүүд дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй.

Кибер гэмт хэрэг

Интернэт сүлжээн дэх гэмт хэрэг гэж юу болох талаарх тодорхойлолт өнөөг хүртэл эцэслэгдээгүй хэдий ч энэ нэр томъёо ерөнхийдөө мэдээллийн технологи ашиглан үйлдэж болох өргөн хүрээтэй гэмт хэрэг, зөрчлийг хэлдэг. Тэдгээрийн хамгийн нийтлэг жишээ болгон компьютерын вирус, хакеруудтай холбоотой хэргүүдийг дурдаж болно. Сүүлийн жилүүдэд энэ талаарх сонирхол огцом өсч буй хэдий ч компьютерийн гэмт хэрэг нь цоо шинэ зүйл биш бөгөөд энэ төрөлд хамаарах хэргүүд компьютер дөнгөж үүсч хөгжиж байсан үеэс эхтэй гэхэд болно. Харин тэр үеэс ялгарах гол ялгаа нь интернэтийн өргөн дэлгэр хэрэглээний улмаас ийм төрлийн гэмт хэрэг үйлдэхийг санаархагчид өргөн хүрээг хамрах боломжтой болсон явдал юм. Интернэт болон Дэлхийн цахим сүлжээ (World Wide Web)-ний ашиг тус өндөр тул олон нийт өргөнөөр ашиглах болсон билээ. Гэвч хэрэглээ ийн өргөжих нь араасаа олон асуудлыг дагуулсан бөгөөд кибер гэмт хэрэг гарсан талаар өдөр өнжихгүй мэдээлэх болжээ.

Европын зөвлөлөөс 2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Кибер гэмт хэргийн тухай конвенцыг соёрхон батлахаар гаргасан бөгөөд таван улс, түүний дотор Европын зөвлөлийн гишүүн дор хаяж гурван улс соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох юм. (2002 оны 5 дугаар сарын байдлаар тус конвенцод Европын зөвлөлийн гишүүн 29 улс, гишүүн бус 4 улс гарын үсэг зурсан байв). Тус конвенц нь зохистой хууль тогтоомж батлан гаргах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар нийгмийг бүхэлд нь хамгаалахад чиглэсэн гэмт хэргийн нийтлэг бодлого баримтлах хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрсөн байр сууринд тулгуурласан байна.

Мэдээллийн системийн аюулгүй байдал

Мэдээллийн системүүдийг боломжит бүх салбарт, боломжит бүхий л зорилгоор хэрэглэх болсонтой холбогдуулан түүнийг дагалдан үүсэх эрсдлүүдэд олон улсын байгууллагууд анхаарал хандуулж эхэлсэн. Энэ хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зөвлөлөөс 1992 онд мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах дараах зорилтууд бүхий дэлгэрэнгүй заавар гаргасан. Үүнд:

- ✓ Мэдээллийн системүүдтэй холбогдон үүсч болох эрсдлүүд болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслүүдийн талаарх ойлголтыг сайжруулах;
- ✓ Төрийн болон хувийн хэвшил дэх мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн харилцан уялдаа бүхий арга хэмжээ, үйл ажиллагаа боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээсэн мэргэжилтнүүдэд туслах ерөнхий загвар бий болгох;
- ✓ Дээр дурдсан арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;
- ✓ Мэдээллийн систем болон мэдээллийн системийн үйлчилгээ үзүүлэх, ашиглах явц дахь итгэлцлийг нэмэгдүүлэх (...);
- ✓ Мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Энэ зааврыг хэрэгжүүлснээр “улс орнуудын засгийн газраас үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журамтай холбогдуулан эдлэх эрхэд нөлөөлөхгүй бөгөөд тэдгээр нь дотоодын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдах асуудал мөн” хэмээн ЭЗХАХБ-ын зөвлөлөөс мэдэгдсэн байна.

Хувийн мэдээллийн цахим файл

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1990 оны 12 дугаар сард Хувийн мэдээллийн цахим файлтай холбоотой заавар гаргасан. Үүнээс хэдэн жилийн өмнө буюу 1980 оны 9 дүгээр сард ЭЗХАХБ-аас хувь хүний нууцлал болон хувийн мэдээллийн хил дамнасан шилжүүлгийн аюулгүй байдлын талаарх зааварчилгааг мөн гаргасан байв. Үүний зэрэгцээ, Европын зөвлөлөөс 1981 онд Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбогдуулан хувь хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенцыг батлан гаргасан юм. Тодруулга N°46-г үз.

Тодруулга N° 46

Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбогдуулан хувь хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц (ETS no. 108)

“Энэхүү конвенц нь хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахтай холбогдуулан гарч болох аливаа зүй бус үйлдлийн эсрэг хувь хүмүүсийг хамгаалах зорилгоор гарч буй олон улсын анхны хэрэгсэл бөгөөд хувийн мэдээллийг хил дамнуулан шилжүүлэх ажиллагааг мөн зохицуулна. Энэ конвенцын дагуу хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахтай холбоотой баталгаа хангагдахаас гадна хувь хүний арьс өнгө, улс төр, эрүүл мэнд, шашин шүтлэг, бэлгийн амьдрал, гэмт хэргийн түүх зэрэг “эмзэг” мэдээллийг хууль эрх зүйн зохистой хамгаалалтгүйгээр боловсруулахыг хориглож байгаа юм. Түүнчлэн, хувь хүн өөрийн мэдээлэлтэй танилцах, шаардлагатай бол засвар оруулах эрхийг тус конвенцоор хангасан бөгөөд зөвхөн түүнээс давамгайлах эрх ашиг (үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах г.м.) хөндөгдсөн тохиолдолд л эдгээр эрхийг хязгаарлахыг зөвшөөрнө. Мөн хувийн мэдээллийг хууль эрх зүйн адил тэнцүү хамгаалалт бүрдүүлээгүй улс руу хил дамнуулан шилжүүлэхийг тус конвенцын дагуу хориглож байгаа юм”.

Эх сурвалж: Европын зөвлөл, цахим хуудас <http://conventions.coe.int>

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Мэдээллийн технологийн талаарх хууль тогтоомж

- ▷ Мэдээллийн технологи, кибер гэмт хэрэгтэй холбоотой хууль тогтоомж батлан гаргахад санаа тавих, мөн эдгээр технологи нь хурдтай хувьсан өөрчлөгдөж байдаг тул холбогдох хууль тогтоомжийг тогтмол хянан үзэж, шаардлагатай тохиолдолд шинэчилж байх.
- ▷ Танай улс олон улсын болон бүс нутгийн холбогдох конвенцод гишүүнээр элсэхэд анхаарах, дотоодын хууль тогтоомжоо тэдгээрт нийцүүлэн шинэчлэх.
- ▷ Мэдээллийн технологийн ашиглалт, кибер гэмт хэрэгтэй холбоотой бодлого, хууль тогтоомж нь нарийн тодорхой бөгөөд хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчөөгүй байхад анхаарах.
- ▷ Шаардлагатай нөхцөлд, тухайлбал засгийн газарт асуулт, асуулга илгээх замаар зохисгүй нөхцөл байдлыг өөрчлөх арга хэмжээ авах.

Парламентын нөөц бололцоо, арга хэрэгсэл

- ▷ Мэдээллийн технологи, тэдгээрийн хэрэглээтэй холбоотой асуудлыг парламентын хороо эсвэл дэд хороонд тухайлан хариуцуулах.
- ▷ Шаардлагатай бол энэ асуудлаар парламентын хороо буюу дэд хороо байгуулах арга хэмжээ авах, эсвэл одоо үйл ажиллагаа явуулж буй парламентын хорооны чиг үүрэгт нэмж оруулах.
- ▷ Энэ асуудлыг хариуцсан парламентын бүтэц нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай нөөц бололцоо, мэргэжлийн чадавхтай байхад анхаарах.
- ▷ Энэ талаар мэтгэлцээн өрнүүлэх, үйл явцын өрнөлийг ажиглах албан бус бүлэг байгуулах талаар бодолцож үзэх. Ийм бүлэг нь намын харьяалал харгалзахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд парламентын дээд, доод танхимыг хамарсан байх нь зүйтэй.

Олон улсын энхийн ажиллагаа

Өнөө үед олон улсад зөрчил, хямралыг НҮБ-ын дүрмийн VI Бүлэг (Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх) буюу VII Бүлэг (Энх тайванд заналхийлэх, энх тайвныг бусниулах)-т зааснаар шийдвэрлэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж байна. Эдгээр заалтуудад тулгуурлан НҮБ-аас хэд хэдэн үзэл баримтлал, ажиллагаа (тодорхойлолтыг Тодруулга N°47-оос үз) болон тийм ажиллагаа зохион байгуулж, явуулах зааварчилгааг (НҮБ-ын энхийг бүрдүүлэх ажиллагааг алхам алхамаар үзүүлсэн Тодруулга N°48 болон НҮБ-ын энхийг сахиулагчдын бэлтгэл, сургалтын талаарх Тодруулга N°50-ийг үз) боловсруулан гаргажээ. Олон улсын аюулгүй байдалд нөлөөлөхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд улс орнуудыг эдгээр ажиллагаанд оролцуулахаар уриалж болдог.

Хилийн чанад дахь энхийн ажиллагаанд хувь нэмэр оруулах нь

Энхийг сахиулах болон энхийг тогтоох, энхийг бүрдүүлэх ажиллагаа нь гишүүн орнуудын оролцоо нь Аюулгүйн зөвлөлөөс зөвшөөрсний дагуу явагддаг. Улс орнууд тогтворгүй байдал үүссэн бүс нутгуудад цэрэг илгээж, энх тайван, аюулгүй байдлыг сэргээн тогтоох ажиллагаа явуулах үзэгдэл улам ихэссээр байна. Хилийн чанад дахь ажиллагаа бүр олон улсын дүрэм журам, зарчмуудад захирагдах ёстой гэдгийг дурдах нь зүйтэй. Эдгээр дүрэм журмын хамгийн чухагийг Үндэсний аюулгүй байдлын бодлого ба олон улсын эрх зүйн зохицуулалтууд гэх Бүлэг 5-д дурдсан билээ.

Сайн засаглалын үүднээс үзвэл, парламент болон засгийн газрын эрх мэдлийг тэнцвэржүүлэх, хяналт тавих үүднээс парламент нь зэвсэгт хүчинг хилийн чанадад илгээх шийдвэр гаргахад оролцох боломжтой байх нь зүйтэй.

Тодруулга N° 47

**Энхийг бүрдүүлэх, энхийг сахиулах, энхийг тогтоох, энхийг байгуулах:
НҮБ-ын түгээмэл хэрэглэгддэг зарим тодорхойлолтууд**

Энхийг бүрдүүлэх

Энхийг бүрдүүлэх гэдэг нь дипломат арга хэрэгсэл ашиглан дайсагнагч талуудыг түрэмгийллээ зогсоон, энхийн аргаар маргаанаа шийдвэрлэхэд

хүргэхийг хэлнэ. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ тул зөвхөн мөргөлдөөнд оролцогч талууд ингэхийг зөвшөөрсөн тохиолдолд л НҮБ-аас аливаа үүрэг гүйцэтгэх боломжтой болно. Энхийг бүрдүүлэх ажиллагааны хүрээнд талуудын аль нэгний эсрэг хүч ашиглах замаар мөргөлдөөнийг зогсоохыг хориглодог.

Энхийг сахиулах

НҮБ 1948 оноос хойш нийт 54 удаа энхийг сахиулах ажиллагаа явуулсан. Эдгээрийн 41-ийг Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр сүүлийн 12 жилийн хугацаанд хэрэгжүүлжээ. Өнөөгийн байдлаар НҮБ-ын энхийг сахиулах 15 ажиллагаа явагдаж байна.

Энхийг сахиулах ажиллагаа нь анх улс хоорондын мөргөлдөөнийг хянах, шийдвэрлэх зорилгоор хэд хэдэн орон цэргээ НҮБ-ын удирдлага дор илгээх байдлаар үүссэн. Харин өнөөдөр энхийг сахиулах ажиллагааг улсын дотоод мөргөлдөөн, иргэний дайны улмаас явуулах болжээ. НҮБ-ын энхийг сахиулагчид болох цэргийн хүчин, иргэний цагдаа болон иргэний бусад бие бүрэлдэхүүний чиг үүрэг нь дайсагнагч талуудын хоорондох мөргөлдөөнийг зогсоохоос эхлээд энх тайванч байдлаар хамтран ажиллахад нь туслах хүртэл өргөн хүрээг хамардаг.

Тухайлбал, энхийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, гал зогсоох гэрээний хэрэгжилтийг хянах, “жийрэг” бүсүүд байгуулах, түүнчлэн улс төрийн институциудыг бий болгох, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн бүлгүүдтэй хамтран ажиллах замаар яаралтай хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хуучин цэргийн хүчний зэвсгийг хураах, дайчилгааг зогсоох, эргээн нийгэмшүүлэх, газрын мина устгах, сонгууль зохион байгуулах, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг сүүлийн үед өргөнөөр дэлгэрэх болсон чиг үүргүүд үүнд багтах болжээ. НҮБ-д өөрийн гэсэн арми, иргэний цагдаагийн хүч байхгүй бөгөөд гишүүн орнууд сайн дурын үндсэн дээр хүн хүч, тоног төхөөрөмж нийлүүлдэг. Ихэнх тохиолдолд дүрэмт хувцастай цэргийн хүчний дэргэд сонгуулийн ажиглагчид, хүний эрхийн хянагчид болон иргэний бусад бүрэлдэхүүн ажиллаж байдаг. Энхийг сахиулагчдын хамгийн гол “зэвсэг” нь тэдний төвийг сахисан байр суурь мөн. Гэвч энэ нь энхийг сахиулах ажиллагаа огт аюулгүй гэсэн үг биш бөгөөд 1948 оноос хойш НҮБ-ын 1,650 гаруй цэргийн болон иргэний албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэх үедээ амиа алджээ.

Энхийг тогтоох: Энхийг сахиулах ажиллагаанаас юугаар ялгаатай вэ?

Энхийг тогтоох ажиллагааны үед Аюулгүйн зөвлөл тухайн ажиллагааны зорилгыг биелүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээ авах эрхийг оролцогч орнуудад олгох бөгөөд талуудын зөвшөөрлийг заавал авах шаардлагагүй байдаг. Энэхүү ажиллагааг явуулсан хэд хэдэн тохиолдол бий. Үүнд, Персийн булангийн дайн, Сомали, Руанда, Хайти, Босни Герциговени, Албани, Зүүн Тимур зэргийг дурдаж болно. Эдгээр ажиллагааг НҮБ бус харин нэг буюу хэд хэдэн орны бүлэг удирдан явуулдаг. Тухайлбал, Зүүн Тимурын ажиллагааг

(1999) Австрали, Босни Герциговени, Косовогийн ажиллагааг НАТО (1995 оноос хойш болон 1999 онд) удирдаж, харин Түр удирдлагын төвийг НҮБ удирдаж байсан.

НҮБ-ын дүрэмд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалах нь энхийг сахиулах, энхийг тогтоох ажиллагааны аль алины үндэс суурь хэмээн заасан байдаг.

Энхийг байгуулах

Энхийг байгуулах гэж мөргөлдөөний дараа улс орнуудад энх тайвныг тогтооход туслахад чиглэсэн үйл ажиллагааг хэлдэг. Ийм ажиллагаа нь төр улс байгуулах, сэргээн босгох чиг үүрэгтэй байдаг учир өргөн хүрээний эрхтэй байдаг.

Хүмүүнлэгийн ажиллагаа

Эдгээр ажиллагаа нь иргэний дайн, өлсгөлөн, үер, ган, салхи шуурга, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгийн үед хүмүүнлэгийн тусалцаа үзүүлэх зорилготой. Төрийн болон төрийн бус байгууллагууд (ТББ), НҮБ-ын салбар нэгж зэрэг олон байгууллагаас гамшгийн нэн төвөгтэй ийм нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах зорилготой байдаг бөгөөд зарим үед цэргийн хүчнээс логистик тусалцаа авах нь тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх цорын ганц арга байх нь бий.

Эх сурвалж: НҮБ-ын цахим хуудсаас түүвэрлэн авав <http://www.un.org>

Хилийн чанадад цэрэг илгээх асуудалд парламентын оролцоог аль болох өргөн хүрээнд хангах нь засгийн газар, ард түмний аль алиных нь сонирхолд нийцэх бөгөөд парламентын мэтгэлцээн, санал хураалт нь тухайн ажиллагааны хууль ёсны шинж чанарыг өргөж, олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлдэг.

Хилийн чанадад цэргийн хүч илгээх үйл явц дахь парламентын оролцоо

Хэдийгээр хилийн чанадад цэрэг илгээх нь шинэ аюул заналд хариу арга хэмжээ авах, олон улсын хямралыг шийдвэрлэхэд улам бүр ач холбогдолтой болж буй ч, энхийн ажиллагаанд цэрэг илгээх шийдвэр гаргахад зарим орны парламентын оролцоо хязгаарлагдмал буюу огт байхгүй хэвээр байна. Аюулгүй байдлын асуудалд тавих ардчилсан хяналтыг хэрэгжүүлэхийн тулд энэ байдлыг дор хаяж хэсэгчлэн өөрчлөх боломжтой хийгээд шаардлагатай юм.

Үүнтэй холбогдуулан харилцан адилгүй гурван нөхцөл байдал үүсч болох ба тус бүрт нь парламентын үүрэг, шууд оролцоог сайн засаглалын үүднээс сайжруулах боломжтой гэхэд буруудахгүй.

Парламентын урьдчилсан буюу дагалдах зөвшөөрөл (нөлөө бүхий үүрэг оролцоо)

Урьдчилсан зөвшөөрөл шаардлагатай тохиолдолд зэвсэгт хүчинг хилийн чанадад зөвхөн парламентаас гаргасан шийдвэрийн дагуу илгээнэ. Гэхдээ парламент тухайн асуудлыг хэлэлцэж санал хураах эрх (АНУ) болон ажиллагааны үндэслэл, эрх, үүргийг тодорхой заасан тусгай хууль батлах эрх (Швед) хоёрыг хооронд нь ялгаж салгах ёстой. Дээрх хоёр туршлагын аль аль нь хүмүүнлэгийн оролцоо болон энхийг сахиулах ажиллагааны ардчилсан хууль ёсны шинжийг агуулсан байдаг юм.

Батлан хамгаалахын аливаа асуудал цаг хугацаагаа олсон байх нь нэн чухал бөгөөд парламентын үйл ажиллагаа түргэн шуурхай явагдах нь ховор учир парламентаас урьдчилан зөвшөөрөл авах зарчим хэрэгжихэд амаргүй. Тийм ч учир, хилийн чанадад цэрэг илгээх ихэнх тохиолдолд парламентын зөвшөөрөл дагалдаж гардаг. Жишээлбэл, АНУ-ын “Дайны эрхийн тогтоол”-д 92-оос дээш хоногийн хугацаагаар хилийн чанадад цэрэг илгээх тохиолдолд Конгресс дагалдаж зөвшөөрөл гаргах ёстой. Энэ нь ихэвчлэн парламент зөвшөөрөл гаргахаас өмнө цэргийн хүч гадагшаа илгээгдсэн тохиолдолд үйлчилдэг юм. Харин эсрэгээр Нидерландын Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд зааснаар зэвсэгт хүчин гадаадад илгээх тохиолдолд парламент, засгийн газрын хамтын ажиллагаа эртнээс эхлэх бөгөөд тухайн ажиллагаатай холбогдох шаардлагатай бүх мэдээлэл, олон улсын хууль тогтоомжийг биелүүлэх болон сахиулахад зэвсэгт хүчний бэлтгэл хангагдсан эсэх талаарх мэдээллийг парламентад урьдчилан илгээх ёстой байдаг. Үүнд зэвсэгт мөргөлдөөний үеийн хүмүүнлэгийн туслалцаа мөн хамаарна.

Хилийн чанадад цэрэг илгээх явц дахь мэтгэлцээний үүрэг бүхий парламентууд (хязгаарлагдмал үүрэг оролцоо)

Энэ тохиолдолд, парламентын хүлээх үүргийг Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хязгаарласан байдаг. Хилийн чанадад цэрэг илгээх асуудлыг парламент хэдий хэлэлцэх ч гүйцэтгэх засгаас нэгэнт гаргасан шийдвэрийг өөрчлөх эрхгүй байна. Улмаар, парламент энэ асуудлаар санал хураадаггүй аж. Энэ үед засгийн газар өөрийн шийдвэрийг гаргасны дараа парламентад мэдээлнэ. Хэдийгээр парламент санал хураалт явуулж чадахгүй ч, энэ асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх нь хилийн чанадад цэрэг илгээх шийдвэрийн ардчилсан, хууль ёсны шинжийг дээшлүүлдэг юм.

Дээрх тохиолдлуудад парламентын эрх ихээхэн хязгаарлагдмал бөгөөд хилийн чанадад цэрэг илгээх шийдвэр гаргахад оролцох албан ёсны тогтолцоо байхгүй байж болно. Гэсэн хэдий ч хэвшсэн жишгийн дагуу парламент болон засгийн газар нь энэ асуудлыг хэлэлцэх, тэр ч байтугай санал хураалт явуулах боломжтой байх нь бий.

Шийдвэр гаргах явцад парламент оролцохгүй байх (ямар нэг үүрэггүй)

Энэ тохиолдолд парламент тухайн асуудлыг хэлэлцэх эрх ч байхгүй бөгөөд дагалдан зөвшөөрөл гаргах шаардлагагүй байна. Хилийн чанадад цэрэг илгээх асуудлыг гадаад бодлогын шийдвэр хэмээн үзэж гүйцэтгэх засгийн эрх үүрэгт бүрэн хамааруулна. Парламент шийдвэр гаргах явцад оролцдоггүй тул энхийн ажиллагаанд хяналт тавих чадавхыг ихээхэн хязгаарладаг байна.

Парламентын мэдэлд байх бусад арга хэрэгсэл

Парламент шийдвэр гаргах явцад оролцдоггүй болон маш хязгаарлагдмал үүрэг гүйцэтгэдэг үед ч засгийн газарт шууд бус байдлаар шахалт үзүүлэх дор хаяж дөрвөн арга бий. Үүнд:

- ✓ Хилийн чанадад цэрэг илгээх шийдвэртэй холбогдуулан засгийн газрын хүлээх хариуцлагын талаар парламент тайлбар авах шаардлага тавьж болно. Гэхдээ парламент засгийн газрын байгуулсан олон улсын гэрээ хэлцлийн талаар бүрэн мэдээлэлгүй байгаа тохиолдолд түүний шийдвэртэй холбогдуулан зохих шаардлага тавихад бэрхтэй.
- ✓ Засгийн газар төсвийн өөрчлөлт өргөн мэдүүлэх үед парламент өөрийн шаардлагыг тавьж болно. Төлөвлөгдөөгүй, гэнэтийн энхийн ажиллагаанд зориулан парламент тухайн үед төсөвт тусгаагүй байсан нэмэлт санхүүжилтийг батлах шаардлагатай болно. Иймд, парламент өөрийн байр суурийг “хэтэвчний эрх мэдэл”-ээр дамжуулан илэрхийлэх боломжтой болох (жишээ нь Франц).
- ✓ Парламентын оролцоо нь зөвхөн хэлэлцүүлэг өрнүүлэх, санал хураах үед чухал байдаггүй. Энхийн ажиллагааны талаарх мэдээллийг парламентын гишүүд асуулт илгээх болон засгийн газрын мэдээллийн үеэр асуулт хариултын аргаар олж мэдэх боломжтой. Түүнээс гадна, парламентын гишүүд хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй цэргүүд дээр зочлон очиж, ажиллагаатай газар дээр нь танилцаж болно (Бүлэг 17-г үз).
- ✓ Ажиллагааны дараах хариуцлагын үүднээс үзвэл, энхийн ажиллагаа дууссаны дараа парламент хянан шалгах ажиллагаа явуулах буюу засгийн газарт тухайн ажиллагааг үнэлж дүгнэлт гаргах хүсэлт хүргүүлж болно.

Тодруулга №48

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны үе шат

НҮБ өөрийн гэсэн армигүй. Энхийг сахиулах ажиллагаа бүр тухайн нөхцөл

байдлаас үүсэн гарсан хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх ба Аюулгүйн зөвлөлөөс шинэ ажиллагаа зарлах бүрт бүрэлдэхүүн хэсгүүдийг шинээр боловсруулдаг.

Арван таван гишүүн бүхий Аюулгүйн зөвлөл нь энхийг сахиулах ажиллагаа явуулах шийдвэрийг гаргаж, эрх үүргийг нь тодорхойлдог. Ийм шийдвэр гаргахын тулд дор хаяж есөн гишүүн дэмжсэн байх ёстой ба тус зөвлөлийн байнгын гишүүн таван орны (Хятад, Франц, ОХУ, Их Британи, АНУ) аль нэг нь эсрэг санал өгсөн тохиолдолд хориг тавигдана. Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн ажиллагааг хэрхэн эхлүүлэх болон явуулах зөвлөмж гаргах ба дэлхий даяарх энхийг сахиулах ажиллагааны өдөр тутмын үйл ажиллагааны чиглэл, удирдлага зохион байгуулалт, логистикийн тусалцааг НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газар хариуцдаг.

Ерөнхий нарийн бичгийн дарга Хүчний командлагчийг сонгох ба цэрэг, иргэний цагдаа болон бусад бүрэлдэхүүнд шаардлагатай хүний нөөцийг хүссэн хүсэлтийг гишүүн орнуудад илгээнэ. Бусад шаардлагатай нөөц, тоног төхөөрөмж, тээвэр болон логистикийн дэмжлэгийг гишүүн орнууд болон хувийн гэрээлэгчдээс авдаг. Иргэний туслах бүрэлдэхүүн нь НҮБ-ын салбар байгууллагуудаас томилогдсон болон гишүүн орнуудаас түр шилжин ажиллаж буй албан хаагчид, түүнчлэн тусгай орон тоонд зориулан олон улсаас болон тухайн орон нутгаас элсүүлсэн ажилтнуудаас бүрдэнэ.

Ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангах хугацаа харилцан адилгүй ба тухайн ажиллагаанд хувь нэмэр оруулах гишүүн орнуудын хүсэл эрмэлзлээс голлон хамаардаг. Санхүүгийн нөөц бололцооны бэлэн байдал, стратегийн шилжилт хийх чадавх ажиллагааны бэлтгэл хугацаанд мөн нөлөөлнө. Жишээлбэл, 1973 онд НҮБ-ын Хоёрдугаар Шуурхай хүчний бүрэлдэхүүн (UNEF II)-ийг Ойрхи дорнодод 24 цагийн дотор илгээж байв. Харин нарийн төвөгтэй эрх үүрэг, хүнд бэрх логистик бүхий, эсвэл энхийг сахиулагчдад нүүрлэх эрсдэл өндөртэй зарим ажиллагааны хувьд шаардлагатай иж бүрдлийг цуглуулах болон илгээхэд хэдэн сараар тоологдох хугацаа ч шаардагдаж болох юм.

Эх сурвалж: НҮБ-ын цахим хуудас <http://www.un.org>

Тодруулга №49

Энхийг сахиулах ажиллагааны дүрэм журам

Парламент хилийн чанадад цэрийн хүч илгээх шийдвэр гаргахдаа зэвсгийн ямар түвшний хүчийг, ямар нөхцөлд хэрэглэхийг тодорхойлсон, нэг үгээр хэлбэл ажиллагааны дүрэм журмыг дагалдуулан гаргаж болно.

Ажиллагааны дүрэм журам (АДЖ) гэдгийг бид тухайлсан ажиллагааны үеэр үхэлд хүргэх хүчийг ялгаваргүй хэрэглэх хэм хэмжээ гэж ойлгодог. Энэ хэм хэмжээг ажиллагаа тус бүрт тухайлан тогтоох бөгөөд хүч хэрэглэхийг

аль болох хязгаарлахыг хичээхийн сацуу цэргүүдэд дор хаяж өөрийгөө хамгаалах хангалттай боломж олгохыг зорьдог. Нэг үгээр хэлбэл, бие бүрэлдэхүүн өөрийгөө хамгаалах үндсэн зарчмыг ямагт баримтлах ёстой. АДЖ нь цэргүүдэд дэмжлэг болох хүчин зүйл болохын зэрэгцээ ажиллагааны буюу тактикийн түвшний параметр мөн. Тэднийг боловсруулахдаа тухайн ажиллагаатай холбоотой асуудлууд, улс төрийн шинжтэй хүндрэлүүд, түүнчлэн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоол зэрэг олон улсын дүрэм журамд нийцсэн эсэхэд ихээхэн анхаарах ёстой.

АДЖ нь хүч хэрэглэх шалгуурыг нарийвчлан тогтоох замаар нөхцөл байдлыг саармагжуулах эсвэл эрчимжүүлэх болон өөр бусад аргаар мөргөлдөөнийг эцэслэхэд шаардлагатай тэнцвэрийг тогтоож байх ёстой. АДЖ-ыг хариу үйлдлийн үүднээс тодорхойлох нь хүчирхийллийн харилцан адилгүй түвшинд зохицсон хүч хэрэглэхийн сацуу хохирлыг аль болох бага байлгахуйц тактикийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бэлэн байлгах тустай. Энэ хүрээнд АДЖ-д хүч хэрэглэх дараах түвшинг ашиглаж болно (эрчим нь багаас их рүү):

- Цэргүүдийн өөрийн хамгаалалтын зорилгоор
- Цэргүүдийн өөрийн хамгаалалт болон энгийн иргэдийн амь насыг хамгаалах зорилгоор
- Цэргүүдийн өөрийн хамгаалалт, энгийн иргэдийн амь нас болон чухал ач холбогдолтой объектыг хамгаалах зорилгоор (гүүр, эмнэлэг г.м.)
- Тухайн ажиллагааны зорилгыг биелүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах.

Үүний зэрэгцээ, АДЖ-д тухайн энхийн ажиллагаанд хэрэглэхийг зөвшөөрсөн зэвсгийн төрлийг тусгасан байх ёстой. Энэ зөвшөөрөл нь огт зэвсэггүйгээс эхлээд хөлөг онгоц, нисэх онгоц, пуужингийн технологи зэрэг хүнд зэвсэглэл ашиглах хүртэл хамарч болно.

Энхийн ажиллагаанд цэргүүдийг бэлдэх нь

Энхийн ажиллагаанд оролцох нь цэргийн ямар ч хүчний хувьд амаргүй даалгавар бөгөөд ердийн бэлтгэлээс гадна нэмэлт сургалт зааварчилгаа зайлшгүй шаардлагатай.

Энэ нь операцын түвшинд ч мөн хамаарах бөгөөд цэргүүдэд газрын мина аюулгүй болгох, энгийн иргэдтэй харьцахад шаардлагатай эвлэрүүлэн зуучлах зэрэг бодит ур чадвар (зарим тохиолдолд орон нутгийн хэлний мэдлэг)-аас гадна тухайн орон нутгийн зан заншил, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж, нэн ялангуяа ажиллагааны дүрэм журмын талаар цогц мэдлэг мэдээлэл шаардлагатай болно. АДЖ-ын тухайд, энхийн ихэнх ажиллагааны үеэр зэвсэг хэрэглэхийг хориглодог

бөгөөд зарим тохиолдолд энхийн ажиллагаанд оролцогч цэргүүд огт зэвсэггүй байх нь бий гэдгийг дурдах нь зүйтэй.

Энхийн ажиллагаанд оролцох зэвсэгт хүчин ихэвчлэн өөрийн орноос алс хол, ажиллаж болзошгүй гэж өмнө нь төсөөлж ч байгаагүй газар илгээгддэг учир тусгайлсан бэлтгэлийн асуудлыг төлөвлөлтийн шатанд авч үзэх нь мөн дутахгүй ач холбогдолтой байдаг. Ийм нөхцөлд, цэргүүдийн тээвэр, хангамжийн асуудал ихээхэн хүндрэлтэй болж, зарим орны материаллаг нөөц бололцооноос давж гарах нь бий.

Командлалын болон логистикийн түвшинд нэмэлт бэлтгэл, сургалт мөн шаардлагатай. Олон орны цэргүүд нэг цэгт, нэгдсэн удирдлагын дор ажиллагаа явуулах тул батлан хамгаалах яам төвтэй командын уламжлалт, шулуун шугаман загвар өөрчлөгддөг. Тиймээс харилцан адилгүй орны зэвсэгт хүчин хоорондын төдийгүй Олон улсын улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах уялдаа холбоо нэн чухал болдог юм.

НҮБ-аас явуулж буй энхийн ажиллагааны хувьд цэргийн команд нь зөвхөн Аюулгүй зөвлөлийн тогтоолуудаар зогсохгүй, ажиллагааны дүрэм журам, НҮБ-ын ажиллагааны дүрэм, НҮБ-ын ёс зүйн дүрэм болон НҮБ-ын олон улсын хүчинтэй холбоотой удирдлагын бүхий л хэм хэмжээгээр хязгаарлагдаж байдаг.

Тодруулга №50

Энхийг сахиулагчдад зориулсан НҮБ-ын сургалт

Энхийг сахиулах ажиллагааны газрын бүрэлдэхүүнд байгуулагдсан Сургалтын нэгж нь энхийг сахиулах сургалтад хамрагдаж буй гишүүн орнуудыг заавар зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа, мэдээллээр хангадаг. Тус нэгж нь он удаан жилийн энхийг сахиулах ажиллагааны туршлага дээр тулгуурласан, мэдлэг туршлага, ажиллагааны нийтлэг жишгийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн сургалтын загвар болон бусад материалыг боловсруулдаг. Түүнчлэн уг нэгж нь энхийг сахиулах ажиллагаанд оролцож байсан болон бусад орнууд дахь цэргийн коллеж, үндэсний болон бүс нутгийн сургалтын төвүүдтэй хамтран ажилладаг байна. НҮБ-ын Сургалтад дэмжлэг үзүүлэх багууд болон “сургагч бэлдэх” дамжаанууд нь энхийг сахиулах сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд гишүүн орнуудад туслах зорилгоор бий болсон. Ёс зүйн дүрэм болон бусад гарын авлага, зааварчилгааг энхийн ажиллагаанд тавигдах үндсэн стандартын нийтлэг түвшинд хүргэх зорилгоор боловсруулсан байдаг.

Эх сурвалж: НҮБ-ын цахим хуудас <http://www.un.org>

Хилийн чанад дахь хүмүүнлэгийн ажиллагаанд цэрэг илгээх шалгуур үзүүлэлт

Парламент болон засгийн газраас хилийн чанадад цэрэг илгээх шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргах боломжтой. Нарийн тодорхой боловсруулсан шалгуур үзүүлэлт нь шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулж, улмаар энхийн ажиллагаанд үзүүлэх олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлдэг. Ингэхдээ хоёр төрийн шалгуур үзүүлэлтийг ашиглаж болно (хайрцагласан хэсгийг үз). Эхний багц нь улс төрийн нөхцөл байдал хийгээд ажиллагааны төрөлд хамаарах бол дараагийн багц үзүүлэлт нь тухайн ажиллагаа, түүний эрх үүрэг, команд, үргэлжлэх хугацаа, цэргийн төрөл зэрэгт голлон төвлөрдөг.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Энхийн ажиллагааны нөхцөл, төрөлтэй холбоотой ерөнхий шалгуур үзүүлэлтүүд

- ▷ Парламентын холбогдох хороо(д) дараах асуудлыг судалж үзэх нь зүйтэй:
 - олон улсын хэмжээнд танай улсын хүлээх үүрэг;
 - энхийн ажиллагааны хүрээнд цэрэг илгээх/хүлээн авах нь зохистой эсэх;
 - тусгайлсан аливаа оролцооны үндэслэл буюу шалтгаан (тухайлбал, тухайн улсад хүний эрхийн өргөн хүрээтэй ноцтой зөрчил гарч буй эсэх г.м.);
 - бүс нутгийн буюу олон улсын энхийн ажиллагааны үндсэн дүрэм журам;
 - бүс нутгийн буюу олон улсын энхийн ажиллагаанд оролцогч цэргүүдийн баримтлах үндсэн дүрэм, журам;
 - цэргийн хүчний тэнцвэртэй ашиглалт;
 - улс төрийн үр дүнтэй шийдвэр гаргахтай холбоотой заалтууд;
 - улсын эрх мэдэлд тавигдах хязгаарлалтууд;
 - энхийн ажиллагаанд оролцохтой холбогдуулан олон нийтийн зүгээс үзүүлж буй дэмжлэг буюу эсэргүүцэл;
 - ажиллагааг дагалдан үүсч болон асуудлын хяналт, үнэлгээ болон холбогдох бусад асуудлууд;
 - ажиллагааны төгсгөлд ажиллагааг бүхэлд нь үнэлж, дүгнэлт хийх зорилгоор бүрэн хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл авах парламентын хэрэгцээ шаардлага.

Тухайлсан энхийн ажиллагаанд тавигдах тусгай шалгуур үзүүлэлтүүд

- ▷ Парламентын холбогдох хороо(д) дараах асуудлыг судалж үзэх нь зүйтэй:
 - энхийн ажиллагааны цар хүрээ, эрх үүргийн тодорхойлолт;
 - ажиллагаанд оролцох цэргийн анги нэгжийн төрлүүд;
 - цэргийн үүднээс үзэхэд тухайн ажиллагааг гүйцэтгэх боломжтой эсэх;
 - цэргийн анги нэгж, эд материалын тохиромжтой байдал болон бэлэн байдал;
 - ажиллагаанд оролцох цэргийн бие бүрэлдэхүүнд учирч болзошгүй эрсдлүүд;
 - ажиллагааны үргэлжлэх хугацаа болон шаардлагатай тохиолдолд тус хугацааг сунгах шалгуур үзүүлэлтүүд;
 - төсөвт үзүүлэх нөлөө;
 - тухайн асуудлаарх олон нийтийн хандлага.

Энхийн ажиллагаатай холбогдуулан парламентын хэрэглэж болох арга хэрэгслүүд

- ▷ Шаардлагатай тохиолдолд парламент дараах арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй:
 - энхийн ажиллагааны талаар нээлттэй сонсгол хийх;
 - улмаар, энхийн ажиллагаа хийхтэй холбогдуулан хянан шалгах ажиллагаа явуулах;
 - энхийн ажиллагааны оролцогч, хүний эрхийн зөрчилд сэжиглэгдэж буй аливаа этгээдийг эгүүлэн татаж холбогдох арга хэмжээ авахыг хүсэх.
- ▷ Одоо үргэлжилж буй энхийн ажиллагааны талаар асуулт илгээх, сонсгол зохион байгуулах зэрэг шаардлагатай хэмээн үзэж буй арга хэмжээ авахаас бүү тээнэгэлз.

Зургаадугаар хэсэг

Санхүүгийн эх үүсвэр:

Аюулгүй байдалтай холбоотой төсөвт үр дүнтэй
хяналт тогтоох

Аюулгүй байдал ба санхүүгийн нөөц

Парламент ба аюулгүй байдалтай холбоотой төсвийн хяналт

Дэлхийн хаа ч гэсэн хуулийн дагуу парламент аюулгүй байдалтай холбоотой төсвийг батлах, хянахад гол үүрэг гүйцэтгэдэг. Харин энэ үүргийг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэл, боломж бололцоо орон бүрт харилцан адилгүй байдаг. Харин амьдрал дээр шийдвэрлэх нөлөө үзүүлэх арга хэрэгсэл парламентад хомс байдаг ба аюулгүй байдалтай холбоотой төсвийн зарим хуваарилалт, зарцуулалтын нууцлал болон тодорхойгүй байдал ихээхэн бэрхшээл учруулдаг. Аюулгүй байдлын салбар дахь гүйцэтгэх засгийн давамгайлал нь аль эртнээс улбаатай бөгөөд парламентын үйл ажиллагааг хязгаарлаж, батлан хамгаалахын төсөвтэй холбоотой бүхий л санаачилгыг гүйцэтгэх засаг болон зэвсэгт хүчний мэдэлд үлдээхэд хүргэдэг.

Гэсэн хэдий ч, аюулгүй байдлын салбарын хяналт хийгээд тус салбарыг нийгмийн хэрэгцээ шаардлагад тохируулан шинэчлэхэд улсын төсвийн гүйцэтгэх үүргийг парламентын гишүүд дутуу үнэлэх ёсгүй. “Хэтэвчний хүч” нь төсвийн зарцуулалтыг олон нийтийн тусын тулд, тэдгээрийн хяналтын дор зарцуулахад ашиглагдсаар ирсэн бөгөөд тэгэх ч ёстой билээ.

Тодруулга №51

Төсөв: Ардчилсан засаглалын үндсэн арга хэрэгсэл

“Улсын төсөв нь орлого төвлөрүүлж, зардал төлөвлөх төдий техникийн хэрэгсэл бус, харин гүйцэтгэх засгаас тухайн жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын хамгийн том мэдэгдэл билээ. Өөрөөр хэлбэл, төсөв нь улс орны бодлогын суурь болсон үнэт зүйлсийг харуулж байдаг бөгөөд засгийн газраас улсынхаа нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлж буйг илэрхийлдэг. Түүнчлэн, засгийн газрын мөнгө, санхүү, эдийн засгийн зорилтуудын тунхаг бөгөөд нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийг харуулдаг. (...) Төсвөөр дамжуулан засгийн газрын хэтийн зорилго, өнгөрсөн ажлыг мөнгөн дүнгээр үнэлж цэгнэх боломжтой.

“Төсөв нь ил тод, хариуцлагатай, цогц байдал хийгээд сайн засаглалыг хангах нэн чухал баримт бичиг мөн. Зардлын төлөвлөгөөг дэлгэрэнгүй, тодорхой байдлаар санал болгосноор парламент болон олон нийт мөнгө хаашаа, юунд зарцуулагдаж буйг мэдэж, ингэснээр ил тод байдал нэмэгдэнэ. Түүнээс гадна, засгийн газар зардал гаргах, орлого төвлөрүүлэхийн өмнө төсвийг парламентаар батлуулах хэрэгтэй байдаг тул засгийн газрын гишүүд парламент, түүний хороодын өмнө хариуцлага хүлээнэ гэсэн үг.

“Ил тод, хариуцлагатай байдал нь, нэн ялангуяа төсвийн бүхий л үе шатанд, Үндсэн хуулиар тавигдсан шаардлага байх ёстой. Төсвийн бүх үе шат дахь ил тод байдал, түүнтэй хосолсон хариуцлагатай байдал нь ардчиллын гол цөм мөн.”

Ишлэл: Парламент ба төсвийн үйл явц, Хүйсийн тэгш эрх сэдэвт семинарын ерөнхий тайлан, ОУПХ, Найроби, 2000 оны 5 дугаар сар

Парламент төсвийн циклийн үндсэн 4 үе шат бүрт аюулгүй байдлын салбар болон асуудлуудад анхаарал хандуулах боломжтой. Үүнд:

Төсвийн төлөвлөлт: энэ үе шатанд гүйцэтгэх засаг тодорхой зорилгуудын дагуу төсөв хуваарилах санал дэвшүүлэх бөгөөд парламент, парламентын гишүүд албан болон албан бус механизмаар дамжуулан өөрсдийн саналаа нэмэрлэх боломжтой.

Төсөв батлах: энэ үе шатанд парламент төсвийн хуваарилалтыг судлан үзэж, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж буй эсэхийг болон зохист байдлыг тодорхойлох бөгөөд зарим нөхцөлд аюулгүй байдалтай холбоотой хуваарилалтад зориулсан нарийвчилсан зааварчилгаа гаргаж болно.

Төсвийн зарцуулалт: энэ шатанд парламент засгийн газрын зарцуулалтыг хянан үзэх бөгөөд ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ (дор дурдсан холбогдох хэсгийг үз). Нэмэлт зарцуулалтын хүрээнд төсвийн тодотгол хийх шаардлага гарсан тохиолдолд парламент төсвийн зарлагыг хэтрүүлэхгүйн тулд эдгээр шаардлагыг сайтар судлан үздэг.

Аудит, үнэлгээ: энэ үе шатанд парламент засгийн газрын хуваарилсан төсвийг зүй бусаар зарцуулсан эсэхийг хянан үздэг. Үүнээс гадна, хариуцлагатай, үр дүнтэй, оновчтой байдлыг баталгаажуулах зорилгоор парламент нийт төсөвт болон аудитын явцад тогтмол үнэлгээ хийнэ.

Тодруулга №52

Төсвийн асуудлаар парламент яагаад идэвхтэй байр суурь баримтлах ёстой вэ?

- ▷ Сөрөг хүчнээс төсвийн хэлэлцүүлгээр дамжуулан бодлогын өөр хувилбарууд санал болгох боломжтой.
- ▷ Эрх баригч хүчин төсвийн тухай хуулийг баталснаар гүйцэтгэх засгийн үйл ажиллагаанд итгэл үзүүлж буйгаа харуулах бөгөөд ингэхдээ чухам тэр итгэлийг зөвтгөх үндэслэлүүдээ цохон тэмдэглэж, өөрийн сонгуулийн мөрийн хөтөлбөр хийгээд засгийн газрын бодлогын хэрэгжилт хоорондын уялдаа холбоог онцгойлон харуулдаг.
- ▷ Төсвийн хяналт нь засгийн газрын бодлогод нөлөөлөх хамгийн чухал арга замын нэг мөн.
- ▷ Төсвийн хяналтын хуулийн дагуу парламент нь гүйцэтгэх засагт төсөв зарцуулах эрх олгосноор төсвийн цикл дуусгавар болно.

Ишлэл: Парламент ба төсвийн үйл явц, Хүйсийн тэгш эрх сэдэвт семинарын ерөнхий тайлан, ОУПХ, Бамако, 2001 оны 11 дүгээр сар, Бамако, Мали

Батлан хамгаалах зардал

Дараах тодруулгад дэлхийн зарим орны батлан хамгаалах зардлыг тоймлон харуулав. Хүйтэн дайны дараа батлан хамгаалах зардал буурсан ба олон орон “энхийн ноогдол ашиг”-ийг хүртэж буй нь харагдана. Гэсэн хэдий ч мөн хугацаанд Ази, Африкийн бусад орнууд батлан хамгаалахын зардлаа нэмэгдүүлсэн байна.

Тодруулга №53

Дэлхийн бүс нутгууд болон зарим орны ДНБ-д батлан хамгаалах зардлын эзлэх хувь

	1985	2000	2001
НАТО	4.0	2.2	2.2
АНУ	6.5	3.0	3.2
Их Британи	5.2	2.4	2.5
Франц	4.0	2.6	2.6
Герман	3.2	1.6	1.5
НАТО-ын бус Европ	4.3	2.8	2.3
ЗСБНХУ/Орос	16.1	5.0	4.3
Ойрхи Дорнод, Хойд Америк	11.9	6.7	7.2
Төв болон Өмнөд Ази	4.3	5.2	3.8

Зүүн Ази, Австралиази	6.4	3.5	3.3
Япон	1.0	1.0	1.0
Карибын тэнгис, Латин Америк	3.2	1.7	1.7
Сахарын цөл, Африк	3.1	3.8	3.4
Эритрея	-	30.0	20.9
Нийт дэлхийн хэмжээнд	6.7	3.6	3.5

Эх сурвалж: Цэргийн хүчний тэнцвэр 2002-2003, ОУССХ, Лондон.

Аюулгүй байдлын салбарын үр дүнтэй төсөвлөлт

Хариуцлагатай, ил тод байдал нь үр дүнтэй төсөвлөлтийн чухал суурь нөхцлүүд. Харин хариуцлагатай байдлыг хангах хамгийн шилдэг арга нь төсвийн үйл явцыг ил тод байлгах явдал мөн. Хариуцлагатай болон ил тод байдлыг төсвийн үр дүнтэй ажиллагааны зарчмын дагуу ажил хэрэг болгох боломжтой. Үүнд:

Урьдчилж зөвшөөрөл олгох – гүйцэтгэх засаг аливаа зардал гаргахын өмнө парламентаас зөвшөөрөл авна.

Тэнцэл – төсвийн бүх зарлага, орлогыг нэг баримт бичигт нэгтгэн парламентад өргөн барина.

Цаг хугацааны хувьд тогтмол байх – Гүйцэтгэх засаг парламентад төсвийн төслийг жил бүр тогтмол хугацаанд багтаан өргөн мэдүүлэх ёстой. Түүнчлэн, хуваарилсан төсвийг зарцуулах цаг хугацааны хязгаарыг заасан байна.

Тодорхой байх – Төсвийн зүйл заалт бүрийн тоо хэмжээ, тодорхойлолт нь засгийн газрын зардлыг бүрэн харуулж байх ёстой. Тиймээс, төсвийн зүйл заалтын тодорхойлолт ойлгомжгүй бүрхэг, тухай бүрт хамаарах төсөв хэт том байх ёсгүй.

Хуулийн дагуу байх – Бүх үйл ажиллагаа, зарлага хуулийн дагуу байх ёстой.

Бүтэц ойлгомжтой байх – Ихэнх тохиолдолд парламент харилцан адилгүй мэргэжил, мэргэшил, туршлага бүхий гишүүдээс бүрддэг тул гүйцэтгэх засаг төсвийн төслийг өргөн барихдаа аль болох хялбар, ойлгомжтой хэлбэрээр боловсруулсан байх ёстой.

Иж бүрэн байх – Улсын төсөв дэх аюулгүй байдлын салбартай холбоотой хэсэг нь холбогдох бүх зардлыг агуулсан, иж бүрэн байх ёстой. Ямар ч зардлыг төсөвт тусгалгүй өнгөрөөх ёсгүй бөгөөд үүнд цэрэг, төрийн цэрэгжсэн бусад байгууллага, цагдаа, тагнуулын албад, гүйцэтгэх засгаас гэрээлсэн хувийн хэвшлийн цэрэгжсэн байгууллагуудын төсөв зэрэг бүгд багтана.

Олон нийтийг мэдээллээр хангах – Иргэн бүр (хувь хүн, эсвэл зохион байгуулалтад орж нэгдсэн бүлэг гэх мэт) төсөвтэй танилцах, түүгээр ч зогсохгүй төсвийн талаарх өөрийн байр суурийг илэрхийлэх боломжтой байх ёстой. Ингэхийн тулд төсөвтэй холбоотой бүх баримт бичгийн бүтэц, агуулга ойлгоход хялбар, өргөн хүртээмжтэй байх ёстой (жишээ нь, хувийг орон нутгийн номын санд илгээх г.м.).

Уялдаа холбоотой байх – Бодлого, төлөвлөгөө, төсвийн эх үүсвэр, гүйцэтгэл зэргийн хооронд нягт нарийн уялдаа холбоо байх ёстой.

Арга зам ба үр дүн – Төсвийн тайлбар нь а) эх үүсвэр, б) гүйцэтгэл буюу хүрэх зорилтууд, в) төлөвлөгөөний хэмжигдэхүйц үр дүн зэргийг агуулсан, ойлгомжтой ба тодорхой байх ёстой. Төсөв уян хатан байснаар энэ гурван үзүүлэлтийн алинд ч өөрчлөлт оруулах боломж бүрдэнэ.

Дээрх зарчмуудыг орчин үеийн төсвийн зохистой үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт гэж болно. Парламентын гишүүд аюулгүй байдлын салбарын талаар хангалттай мэдээлэлгүй бол батлан хамгаалах төсвийн цикл дэх нийгэм, эдийн засаг, хөгжлийн үр дагаврын талаар асуудал дэвшүүлэх боломжгүй байна.

Аюулгүй байдлын салбарын төсөвлөлт үр дүнтэй байх нөхцлүүд

Аюулгүй байдлын салбарын төсөвт тавих парламентын хяналтыг сайжруулах боломжтой төсвийн зохистой ажиллагааны олон элемент бий. Эдгээрээс Үндсэн хуулийн болон эрх зүйн орчин тодорхой байх, зарцуулалтын ашигт байдал, төсвийн сахилга бат, цагаа олсон байх, иргэний нийгэмтэй хамтран ажиллах зэргийг хамгийн ач холбогдолтой гэж үздэг байна.

Үндсэн хуулийн болон эрх зүйн орчин тодорхой байх

Аюулгүй байдлын салбарт хяналт тавих парламентын эрхийг Үндсэн хууль болон дагалдах бусад хууль тогтоомжид тодорхой тусгасан байх ёстой. Үүнээс гадна, парламент засгийн газраас мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг батлан гаргах ёстой бөгөөд засгийн газраас мэдээлэл гаргуулж авах эрх мэдэл нь тэдгээр хууль тогтоомжийн дагуу хэрэгжих ёстой. Улмаар, төсвөөр дамжуулан аюулгүй байдлын салбарт тавих хяналтыг парламентын улс төрийн хэвшмэл заншил болгох ёстой. Үүний тулд ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай.

Зарцуулалтын ашигт байдал

Төсөвлөлтийн явцад зарцуулалтын ашигт байдлын хоёр үндсэн зарчмыг мөрдөх ёстой:

- ✓ Үр дүнтэй байдал: бодлогын зорилгуудаа биелүүлэх (“Зөв зүйлийг хийх”)
- ✓ Үр ашигт байдал: боломжит хамгийн бага хөрөнгө зарцуулах замаар бодлогын зорилгуудаа биелүүлэх (“Зөв зүйлийг хэмнэлттэйгээр хийх”)

Тодруулга N° 54

Төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв боловсруулах систем (ТХТБС)

“(...) Төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв боловсруулах систем (ТХТБС)-ийг анх АНУ-д [1960-аад оны эхээр] батлан хамгаалах төсөв боловсруулахад хэрэглэсэн [өнөөдөр дэлхийн олон оронд хэрэглэгдэж байна] (...) ТХТБС-ийн циклийн эхний үе шат буюу төлөвлөлтийн үед аюулгүй байдлын орчин, үндэсний ашиг сонирхол, аюул заналд дүн шинжилгээ хийх замаар зэвсэгт хүчний чиг үүрэг, бүрэлдэхүүн, бүтцийг тодорхойлдог. Улмаар эдгээр нэн чухал хүчин зүйлст тулгуурлан хөтөлбөр боловсруулна. Бизнес төлөвлөгөөний нэгэн төрөл болох хөтөлбөр нь биелүүлэх шаардлагатай бодит зорилтуудыг агуулдаг. Энэ үе шатанд зорилтуудыг санхүүгийн нөөц бололцоотой уялдуулдаг тул циклийн хамгийн чухал хэсэг юм. Энэ утгаараа ТХТБС нь хэрэгцээ шаардлагад тулгуурлан нөөцийн хуваарилалт хийдэг өмнөх жишгийн оронд төсвийн өнөөгийн болон болзошгүй хязгаарлалтуудад тулгуурлан төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулдаг байна. Тиймээс, хөтөлбөрийг зэвсэгт хүчний хамгийн тулгамдсан хэрэгцээ шаардлагыг хангах байдлаар тэргүүлэх чиглэлүүдэд тулгуурлан боловсруулах нь чухал. Тухайн зорилтыг биелүүлээгүй тохиолдолд үүсч болох эрсдлийн үнэлгээг хийх замаар тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж болно. Энэхүү циклийн төгсгөлд гүйцэтгэлийг хэмжих үе шат байх ба хариуцсан яам болон нийгэм бүхэлдээ тухайн жилийн эцэст зорилтууд хэр биелсэн болохыг үнэлнэ. Энэ бүхний дүнд нөөцийн оновчтой, үр дүнтэй хуваарилалт хийх боломжтой болдог юм...”

*Эх сурвалж: Интернэт дэх батлан хамгаалах төсвийн ил тод байдал,
Кэйт Старки ба Андри ван Мэни
Мэдээлэл ба аюулгүй байдал, Тавдугаар хэвлэл, 2000.
Дахин инженерчлэлийн хамгаалалт дахь С4.*

Орчин үеийн төсвийн онолын дагуу батлан хамгаалах төсвийн зарцуулалтын ашигт байдлыг үнэлэхийн тулд зардал нь зорилт, хөтөлбөрүүдтэй (Тодруулга N°54-ийг үз) буюу холбогдох бодлогын чиглэл, зорилгуудтай (энхийн ажиллагаа, боловсрол г.м.) уялдсан байх ёстой байдаг. Түүнчлэн бүх зардлыг үйл ажиллагааны төрлөөр ангилан багцалсан байх ёстой. Улмаар парламент нь аудитын байгууллагын тусламжтайгаар зарцуулалтын ашигт байдлыг тодорхойлж чаддаг байх нь чухал (дараагийн бүлгийг үз). Өөрөөр хэлбэл, засгийн газар нь парламентад орцод суурилсан бус харин гарц буюу үр дүнд суурилсан төсвийг өргөн барина гэсэн үг. ТХТБС-тэй ижил төстэй системчилсэн төсвийн тогтолцоо нь аюулгүй байдлын

албад төлөвлөгөөгөө ил тод байдал, нууцлалын шаардлагын аль алиныг хангахуйц байдлаар хийсэн тохиолдолд л хэрэгжих боломжтой.

Төсвийн сахилга бат

Засгийн газар хуулийн хэм хэмжээнд ажиллаж, төсвийн гүйцэтгэлийг анх парламентаас баталсны дагуу хийхэд төсвийн сахилга бат нэн чухал. Парламент төсвийн сахилга батын дараах бүрдэл хэсгүүдэд анхаарал хандуулах нь зүйтэй:

- ✓ Батлан хамгаалах төсөв (зардлын тооцоо) хийгээд үнийн түвшний өөрчлөлт;
- ✓ Мониторинг хийх, зарлага хэтрэх, дутах дээд доод хязгаарыг тогтоохдоо батлагдсан хэм хэмжээг ашиглах;
- ✓ Төсвийн хэрэгжилтийн үед зохих арга хэмжээ авах замаар зарлага хэтрэх болон дутахаас зайлсхийх;
- ✓ Батлан хамгаалах төсвийн зарлага хэтэрсэн эсвэл дутсан тохиолдолд сангийн сайд, засгийн газарт мэдэгдэх;
- ✓ Батлан хамгаалах төсвөөс давсан зарлагыг нөхөх үндсэн нөхцөл: хэтэрсэн зардлыг батлан хамгаалахын төсөв дотроос эсвэл засгийн газрын бусад төсвөөс нөхөн олгох.

Цагаа олсон хийгээд тогтмол байх

Аюулгүй байдлын салбарын төсвийг оновчтой хийж, түүнээс боломжит хамгийн өндөр үр дүнг хүртэхийн тулд санал хураахаас өмнө батлан хамгаалах төсвийн төслийг судлах хангалттай хугацаатай байх нь чухал. Парламентын гишүүдэд батлан хамгаалах нарийн цогц төсвийг нарийвчлан судлаж үзэх дор хаяж 45 хоногоос гурван сарын хугацаа байхыг хамгийн боломжит хугацаа гэж үздэг.

Батлан хамгаалах төсвийн бодлогын талаар үнэн зөв, иж бүрэн, цагаа олсон мэдээлэл нь дараах хэдэн шалтгааны улмаас их чухал. Үүнд:

- ✓ Олон нийтийг мэдээллээр хангах, хэлэлцүүлэг өрнүүлэх нэн чухал нөхцөл;
- ✓ Сул талуудыг тодорхойлох, шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага болон аюулгүй байдал ба засгийн газрын бусад зардал хоорондын тэнцвэрийг ил болгодог;
- ✓ Аюулгүй байдлын салбарын төсвийн ил тод менежмент нь олон нийтийн хийгээд парламентын өмнөх засгийн газрын хариуцлагатай байдлыг сайжруулж, засгийн газарт итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг.

Иргэний нийгэмтэй хамтран ажиллах

Парламент нь санхүүгийн хяналт, мониторингийн ажиллагаанд иргэний нийгмээс төсвийн болон санхүүгийн төлөвлөлтийн мэргэжилтнүүдийг татан оролцуулж болох бөгөөд тэр бүр энгийн, ойлгомжтой байгаад байдаггүй аюулгүй байдалтай холбоотой төсвийн хувьд энэ нь илүү ач холбогдолтой байж болох юм. Төсөв боловсруулах ажиллагааны ил тод байдал нь нэн түрүүнд мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжид тулгуурласан байх ёстой.

Сургалт, мэргэшил

Эцэст нь онцлоход, олон орны парламент мэргэшсэн ажилчдаа сургалт, судалгаанд хамруулах замаар парламентын гишүүд болон бусад албан хаагчдын чадавхыг сайжруулах шаардлагатай байдаг. Энэ хүрээнд, ардчилсан засаглалыг дэмжих, парламентын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор ОУПХ-ноос бүсийн болон дэд бүсийн семинарыг парламентын гишүүд, албан хаагчдад зориулан зохион байгуулдаг (www.ipu.org хуудсыг үз) бөгөөд энэ номтой адил гарын авлага гаргахаар ажиллаж байгаа юм.

Тодруулга №55

Батлан хамгаалах төсвийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд: 2002 оны Испанийн батлан хамгаалах төсөв

Бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээ

Хүнс

Дэд бүтцийн засвар үйлчилгээ

Түлш шатахуун

Үйлчилгээ: цахилгаан, ус, утсан холбоо г.м.

Хувцас

Цалин хөлс

Тээвэр

Сургалт

Эмнэлгийн үйлчилгээ

Үйл ажиллагааны бусад зардал

Санхүүгийн бусад зардал

Шилжүүлэг

Олон улсын байгууллага

Бие даасан бүтцүүд

Бусад шилжүүлэг

Бодит хөрөнгө оруулалт

Зэвсэгт хүчний шинэчлэл

Зэвсэг, материалын засвар үйлчилгээ

Судалгаа, шинжилгээ

Бусад хөрөнгө оруулалт

Хөрөнгийн шилжүүлэг

Санхүүгийн актив

Эх сурвалж: Испанийн батлан хамгаалах төсөв 2002, Испанийн Батлан хамгаалах яам.

Аюулгүй байдлын салбарын төсвийн ил тод, хариуцлагатай байдал

Ил тод байдал ба нууцлал

Шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал нь тухайн шийдвэрийг дагалдаж гарах үр дагавар олон нийтийн хүсэл эрмэлзэл, бодлогын зорилтуудтай нийцэж байх гол баталгаа мөн. Батлан хамгаалах төсвийн ил тод байдал нь парламент хяналтаа үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд тусалж, аюулгүй байдлын салбарт үзүүлэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг. Батлан хамгаалах төсөвт ил тод байдал дутмаг байх нь төсвийн хоцрогдсон загвар эсвэл аюулгүй байдлын зорилтуудыг ойлгомжгүй, болхи байдлаар томъёолсонтой холбоотой байдаг. Түүнчлэн, үндэсний аудитын байгууллагад төрөл бүрийн салбарыг хамарсан мэргэжлийн мэдлэг чадавх дутмаг байх, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл авах эрхийг хангасан үндсэн хуулийн зохицуулалт сул байх, улмаар нууцлалыг хариуцлагатай байдлаас илүүд үзсэн хүнд сурталтай холбоотой байдаг. Эрх бүхий аудитын байгууллага болон хууль тогтоогчдын зүгээс тогтолцооны шинжтэй эдгээр сул талыг олж тогтоон, шийдвэрлэх хэрэгтэй (дараагийн бүлгийг үз).

Тодруулга №56

Аюулгүй байдлын төсвийн ил тод байдлыг хангахад тулгардаг гол бэрхшээл

“Аюулгүй байдлын бодлого, хөрөнгө мөнгөтэй холбоотой шийдвэрийг гүйцэтгэх засгийн цөөн хэдэн эрх мэдэлтэн гаргадаг бол төсвийн ил тод, хариуцлагатай байдал асуудалд орно. Сангийн яам болон гүйцэтгэх засгийн бусад бүтэцдэх гол албан тушаалтнуудыг шийдвэр гаргах явцад оролцуулахгүй байх эсвэл тэдний шийдвэрийг үл ойшоох явдал түгээмэл байдаг. Тэр ч

байтугай Үндсэн хуулиар хяналт хэрэгжүүлэх эрх олгосон парламентын бүтцүүд болон хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд ихэвчлэн энэ талаар ямарваа мэдээлэл, ойлголтгүй байх нь бий.” ...

“Аюулгүй байдлын албадын бие бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн зэрэг бүх зардлыг төсөвт тусгасан байх ёстой. Эдгээр зардлыг хэрхэн санхүүжүүлэхийг төсөвт мөн адил заасан байна. Гэсэн хэдий ч ихэнх орны аюулгүй байдалтай холбоотой төсвүүд энэ хоёр нөхцлийн аль алийг хангадаггүй. Төсвийн дотоод хуваарилалт бүрхэг, ойлгомжгүй бөгөөд хэд хэдэн яамыг хамарсан байж болох нийт зарцуулалт тодорхойгүй байдаг. Төсвөөс гадуурх үйл ажиллагаа ихтэй орнуудын засгийн газар өөрөө ч энэ талаар хангалттай, үнэн зөв мэдээлэлтэй байх нь ховор. Тийм ч учир хариуцлагатай байдлын үндсэн шалгуур болох төлөвлөгөөг гүйцэтгэлтэй нь харьцуулах аргыг энд ашиглах боломжгүй байдаг байна. Батлан хамгаалах яам болон гүйцэтгэх засгийн бусад бүтэц дэх албан тушаалтнууд батлан хамгаалах бодлого, төсөв, худалдан авалттай холбоотой оновчтой шийдвэр гаргахын тулд батлан хамгаалах салбарын мэргэжлийн мэдлэгтэй байх шаардлагатай. Төсвөөс гадуурх үйл ажиллагаатай холбоотой асуудал ихэвчлэн маш улс төржсөн байдаг бөгөөд иргэн-цэргийн харилцааны урт хугацааны суурь өөрчлөлтүүдийг шаарддаг.

Эх сурвалж: Хүний хөгжлийн тайлан, 2002 (Хуудас 89 ба 91)

Батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарын хянагдах болон үл хянагдах зардлууд

Парламент аюулгүй байдлын салбарт хяналт тавихын зэрэгцээ аюулгүй байдлын болон бусад салбарт санхүүжилт олгох эсэхээ оновчтойгоор шийдэхийн тулд төсвийн холбогдох баримт бичигтэй танилцах эрхтэй байх ёстой. Парламентад төсвийн зөвхөн нийт дүнг танилцуулах нь төсвийн зохистой ажиллагааны үндсэн зарчмуудын нэг болох тодорхой байх зарчмыг зөрчсөн явдал болно (дэлгэрэнгүйг дээрээс үз). Нарийн тодорхой мэдээлэл аваагүй тохиолдолд батлан хамгаалах төсвийг хянах тухай Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ парламент биелүүлэх боломжгүй.

Парламент батлан хамгаалах төсөвтэй холбоотой бүхий л баримт бичигтэй танилцах эрхтэй байх ёстой. Зарим орны парламент (тухайлбал, Дани болон Люксембург) нь төсвийн зүйл заалт бүрийн талаар буюу хамгийн дэлгэрэнгүй түвшний мэдээллээр хангагддаг. Харин зарим орны парламент дахь (тухайлбал, Франц, Грек, Польш) батлан хамгаалах асуудал хариуцсан хороо л батлан хамгаалах төсвийн мэдээлэлтэй танилцах эрхтэй байдаг. Сайн засаглалын үүднээс үзвэл, парламент, түүний хороо (шаардлагатай бол хаалттай хуралдаанаар) хоёрын аль нэг нь төсвийн бүхий л баримт бичигтэй танилцах эрхтэй байх ёстой. Мөн адил дүрэм журам аюулгүй байдлын бусад албад, тэр дундаа тагнуулын байгууллагад хамаарна.

Аюулгүй байдлын албадын төсвийн нууцлал нь хуулийн дагуу, тэр тусмаа мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжтой нийцэж байх ёстой. (Тодруулга №57-г үз).

Парламент аюулгүй байдалтай холбоотой төсвийг хэлэлцэж, санал хураахдаа төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрх нь тогтмол зардал (өмнөх жилүүдэд байгуулсан худалдан авалтын гэрээ г.м.) болон халамжийн хөтөлбөрүүд (цэргийн бие бүрэлдэхүүний тэтгэвэр тэтгэмж, эрүүл мэндийн үйлчилгээ г.м.)-ээр хязгаарлагддаг. Эдгээр зардлыг зөвхөн урт хугацааны дараа өөрчлөх боломжтой болно.

Тодруулга №57

Аюулгүй байдалтай холбоотой төсвийн нууцлалын гурван зэрэглэл

Парламентын гишүүд тусгай нөхцөл дэх мэдээллийн нууцлал, батлан хамгаалах төсвийн холбогдох хуваарилалт болон хариуцлагатай байдал хоорондын тэнцвэрийг хангаж ажиллах ёстой. Ингэх нэг арга бол төсвийн төслийг нууцлалын харилцан адилгүй түвшинд дор дурдсан байдлаар хуваан үзэх юм. Үүнд:

Парламентад өргөн мэдүүлсэн батлан хамгаалах ерөнхий төсөв;

Батлан хамгаалах төсөв, цэргийн зардлын асуудал хариуцсан дэд хороо танилцах эрхтэй хөрөнгийн болон ажиллагааны зардлын нууц мэдээлэл;

Хяналтын хорооны сонгогдмол гишүүдийн бүлэг танилцах эрхтэй нууцлалын өндөр зэрэглэл бүхий зардлын мэдээлэл. Энэ бүлэг нь нууцын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу нууц баримт бичигтэй танилцах эрхтэй байна.

Эх сурвалж: Равиндэр Пал Сингх, Зэсвгийн худалдан авалтын шийдвэр гаргах үйл явц,

Нэгдүгээр хэвлэл, Оксфорд, 1998.

Ил тод байдал – төрийн өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулах болон авилгын эсрэг

Засгийн газар төрийн өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулаагүй гэдгийг баталгаажуулахад парламент гол үүрэг гүйцэтгэнэ. Аюулгүй байдлын салбар өөрөө нарийн мэргэжлийн асуудал олонтой, стратегийн аюулгүй байдлын шаардлага гэх мэт өвөрмөц шинжийг агуулдаг тул энэ салбарт ноогдсон төсвийг зүй бусаар зарцуулах явдал гарах магадлал өндөртэй.

Батлан хамгаалах төсвийн ажиллагааны ил тод, хариуцлагатай байдал нь аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх суурь

нөхцлийн нэг мөн. Цаашилбал, ил тод байдал нь сайн засаглалын үндэс суурь болох хариуцлагатай байдлын урьдчилсан нөхцөл. Тиймээс энэ хоёр ойлголт нь нийт төсвийн циклд гол үүрэг гүйцэтгэдэг.

“Батлан хамгаалах төсвийн ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдал дутагдах нь [...] улс орны зэвсэгт хүчний хэмжээ, чадавх, зорилгын талаарх эргэлзээг нэмэгдүүлдэг тул ил тод байдлыг сайжруулах нь олон нийтийн анхаарлыг цэргийн зардалд хандуулж, хямрал зөрчилд хүргэж болзошгүй тодорхойгүй байдал, үл ойлголцлыг бууруулдаг юм...”

Пол Жорж, “1990-ээд оны батлан хамгаалах зардал: Хөгжиж буй орнуудын төсөв, мөнгөний бодлогын асуудлууд”, 2002.

Цэргийн хэт өндөр зардал нь ядуурлыг бууруулж, нийгмийн хөгжлийг урагшлуулахад зарцуулагдах ёстой хөрөнгө мөнгийг сорж байдгийг бүгд мэднэ. Нэгэнт ард түмний татварын мөнгөөр санхүүждэг тул нийгмийн аюулгүй байдлыг яаж, хэрхэн хангахаар төлөвлөж буйгаа гүйцэтгэх засаг ард түмний төлөөлөлд тайлагнах нь зүй ёсны хэрэг. Хөгжиж буй орнуудын хувьд нөөц баялгийг зүй бусаар ашиглах нь нэн уршигтай байдаг. Сайн засаглалын зорилтуудад хүрэх үүднээс засгийн газар аюулгүй байдлын салбартай холбоотой аливаа асуудалд олон нийтийн санал бодлыг тусгах үүрэгтэй. Батлан хамгаалах төсөвт хөгжлийн болон аюулгүй байдлын хэрэгцээ шаардлага тэнцвэртэй хангагдсан эсэхэд парламент хяналт тавьж ажиллах ёстой. Аюулгүй байдлын салбарт төсвийн хяналтыг хэрэгжүүлэхэд парламентад тулгарч болох олон асуудал байдгийг удаах тодруулгад харуулсан болно.

Тодруулга №58

Аюулгүй байдлын салбарын төсөвт үр дүнтэй хяналт тавихад учирдаг гол асуудлууд

- ▷ **Үндсэн хуулийн зохицуулалт байхгүй байх** – Парламентын гишүүдэд аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих эрх олгосон Үндсэн хуулийн нарийн тодорхой зохицуулалт байхгүйн улмаас хүндрэл үүсч болно.
- ▷ **Мэдээлэл хомс байх** - Өмнөхтэй нягт холбоо бүхий бас нэг асуудал бол нууц, эмзэг мэдээлэлтэй танилцах үйл явцыг зохицуулсан мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж дутмаг байх явдал юм. Хууль эрх зүйн зохицуулалт төгс бус, тодорхойгүй байх нь парламентын үр дүнтэй хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах эрсдэлтэй. Үүний дүнд, эрүүл ардчилсан тогтолцооны үед байх ёстой хариуцлагатай байдал олон нийт болон парламентын хувьд алдагддаг.

- ▷ **Аюулгүй байдлын салбарын төсвийн гадуурх ажиллагаа хийгээд орлогын эх үүсвэр** – Аюулгүй байдлын салбарын тусгай ажиллагааны төсвөөс гадуурх орлогын эх үүсвэрийн (нэн ялангуяа арилжааны шинжтэй үйл ажиллагаа буюу цэргийн компанийн үйлчилгээ үзүүлсэн хөлс г.м.) мөн чанар, ашиг орлогыг парламент, тэр ч бүү хэл яамны албан тушаалтнууд хүртэл тэр бүр мэддэггүй. Эдгээр үйл ажиллагааг, аюулгүй байдлын салбарын санхүүжилтийн бусад бүх асуудлын нэгэн адил парламентад танилцуулж байх ёстой.
- ▷ **Батлан хамгаалах зардлыг нуун дарагдуулах** – Аюулгүй байдлын төсөв дэх тэтгэвэр тэтгэмж, дэд бүтэц, тээврийн зэрэг зардлуудыг нийгмийн халамж, орон сууц, төмөр зам зэрэг бусад яам/салбарын төсөв рүү шилжүүлсэн байх нь олон тохиолддог. Ингэснээр батлан хамгаалах төсвийг буруу зөрүү харуулж, батлан хамгаалах бодит зардлын талаар олон нийт болон парламентын зүгээс зохистой дүгнэлт хийх боломжийг боогдуулдаг.
- ▷ **Хэвлэл мэдээлэл сул дорой байх** – Олон орны хэвлэл мэдээллийн салбар сул дорой (мэргэжлийн мэдлэг, нөөц бололцооны хувьд) байдаг бөгөөд аюулгүй байдлын салбар ба парламентын асуудлыг тэр бүр анхааралтай ажиглаад байдаггүй. Ингэснээр олон нийт өөрсдийн төлөөлөл болон аюулгүй байдлын салбартай холбоотой түргэн шуурхай мэдээлэл авах боломжгүй болдог.
- ▷ **Зохистой хяналт шалгалт явуулах цаг хугацаа давчуу байх** - Өмнө дурдсанчлан, батлан хамгаалах зардлыг хянан судлах цаг хугацаа хангалтгүй байх нь парламентын хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг.
- ▷ **Дэд бүтэц, хүн хүч, мэргэжлийн чадавх дутмаг байх** – Олон орны парламентад гүйцэтгэх засаг ард түмний өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавихад шаардагдах дэд бүтэц, хүн хүч, мэргэжлийн чадавх дутмаг байдаг.

Ардчилалд шилжиж буй орнууд дахь төсвийн хяналт

Европ даяар 1990-ээд онд түгэн тархсан ардчиллын давалгаа нь парламентын хяналтын үзэл санаа ба хэрэгжилт ардчилалд шилжиж буй орнуудын хувьд онцгой ач холбогдолтой болохыг харуулсан. Тодруулга N°59-д улс төрийн тогтолцоогоо илүү ил тод, хариуцлагатай хэлбэрт шилжүүлэхээр идэвхтэй хүчин чармайлт гаргасаар ирсэн Зүүн өмнөд Европын орнуудын туршлагаас харуулсан болно.

Тодруулга №59

Зүүн өмнөд Европын зарим орны батлан хамгаалах төсвийн жишээ (2001 оны байдлаар)

- ▷ **Албани:** Төсвийн менежментийн албыг 2000 оны 10 дугаар сард байгуулсан. 2008 он хүртэлх батлан хамгаалахын шаардлагуудыг агуулсан батлан хамгаалах бодлогын баримт бичиг хэвлэгдэн гарсан бөгөөд батлан хамгаалах яам нь төсвийн ажиллагааг хариуцдаг.
- ▷ **Болгар:** Сүүлийн 10 жил Үндэсний ассамблей (Болгарын парламент) улс орны батлан хамгаалах төсвийг хэлэлцэж байгаа. Үндэсний ассамблей нь хяналтын чадавхаа аюулгүй байдлын салбарт тавих бүрэн хэмжээний парламентын хяналт болгох чиглэлд улам бүр бэхжүүлж байгаа гэсэн ерөнхий хүлээлт буй.
- ▷ **Хорват:** Төсвийн төслийг засгийн газраас парламентад өргөн барьж “Төрийн мэдээлэл”-д нийтэлдэг. Төсвийн ажиллагаа 7-11 дүгээр сард явагдах ба сангийн болон батлан хамгаалах яамдаар дамждаг байна. Парламент батлан хамгаалах төсвийн нийт хэмжээг батлах ба түүний бүтэцтэй холбоотой аливаа эрх эдэлдэггүй.
- ▷ **Македоны Бүгд Найрамдах Улс (хуучнаар Югослав):** Төсвийн төслийг батлан хамгаалах яам боловсруулж, сангийн яаманд шилжүүлдэг. Энэ үе шатанд улс орны нөөц бололцооны талаар бусад яамтай зөвлөлдөж, санал авдаг байна. Дараа нь төсвийн төслийг засгийн газарт мэдүүлнэ. Шаардлагатай засварыг хийсний дараа төсвийг парламентад оруулах бөгөөд батлан хамгаалахын сайд нь төсвийн танилцуулгыг Дотоод бодлого, батлан хамгаалахын хороонд хийдэг. Санал хураалт явагдсаны дараа төсвийг ерөнхийлөгчийн зарлиг хэлбэрт оруулна. Батлан хамгаалах төсөв нь ДНБ-ий 2.12% байдаг аж.
- ▷ **Румын:** 2000 оны 1 дүгээр сараас эхлэн батлан хамгаалах яам Төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв боловсруулах, үнэлгээ хийх систем (ТХТБҮХС)-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Гол зорилгын нэг нь батлан хамгаалах салбарын бүхий л үйл ажиллагаан дахь ил тод байдлыг сайжруулах. Төсвийн ажиллагаанд парламентын хэд хэдэн хороо оролцдог. Үүнд: Батлан хамгаалах, Нийгмийн хэв журам, Үндэсний аюулгүй байдал, Төсөв, Санхүү болон банкны асуудал хариуцсан хороод. Батлан хамгаалах яамны холбогдох нэгжүүдийн тоонд Парламенттай харилцах, Хууль тогтоомж, Уялдуулан зохицуулах, Олон нийттэй харилцах хэлтсүүдийг нэрлэж болно. Батлан хамгаалахын төлөвлөлтийн гол баримт бичгийг интернэтэд байрлуулсан байдаг.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Төсвийн цикл дэх аюулгүй байдлын салбар

- ▷ Төсвийн циклийн дөрвөн үндсэн үе шат - төсвийн төлөвлөлт; төсөв батлах; төсвийн гүйцэтгэл; зардлын аудит - бүрт парламентын зүгээс аюулгүй байдлын салбарт анхаарал хандуулах.
- ▷ Эрх бүхий аудитын байгууллагаас тавих хяналтыг баталгаажуулах.
- ▷ Парламент болон хяналтын бусад байгууллагаас явуулж буй аудит нь бодлогын зорилтыг төсвийн хэрэгцээ шаардлага болон үр дүнтэй уялдуулах ёстой (гүйцэтгэлийн аудит).

Аюулгүй байдлын төсөвлөлтийн ил тод байдлыг хангахад чиглэсэн парламентын үйл ажиллагаа

- ▷ Төсвийн төслийг энэ бүлэгт дурдсан төсвийн үр дүнтэй ажиллагааны зарчмуудын дагуу боловсруулах шаардлага тавих.
- ▷ Аюулгүй байдалтай холбоотой төсвийн хуваарилалтууд нь ач холбогдолтой бөгөөд ил тод байдлаар төлөвлөгдсөн эсэхэд хяналт тавихад парламентад эсвэл өөртөө туслалцаа авах зорилгоор хөндлөнгийн шинжээчдийн дэмжлэгийг авах.
- ▷ Аюулгүй байдлын албад нь санхүүгийн төлөвлөлт, төсвийн орчин үеийн арга зүйг ашиглаж байгаа эсэхэд анхаарал хандуулах. Ингэснээр парламентын зүгээс батлан хамгаалах зардлыг зохих ёсоор үнэлж, зорилт, санхүүгийн эх үүсвэр, гүйцэтгэлийн үр дүн зэргийн хоорондох уялдаа холбоог ойлгох боломж бүрдэнэ.
- ▷ Тодруулга N°58-д дурдсан заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон өөрийн орны парламент дахь өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, сул талыг арилгах арга хэмжээг өөрийн орны улс төрийн нөхцлийг харгалзан авч хэрэгжүүлэх.

Аюулгүй байдалтай холбоотой үндэсний төсөвт хийх аудит

Парламент болон үндэсний аудитын газар

Аюулгүй байдлын төсөвтэй холбогдуулан парламентын гүйцэтгэх үүрэг зөвхөн түүнийг баталснаар төгсгөл болдоггүй. Парламент өөрийн хяналт, аудитын чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, эрх бүхий байгууллагаас санхүүгийн бүх баримт бичигт аудит хийж парламентад мэдээлэх нь ардчилсан үйл явцын нэгэн хэсэг бөгөөд аудитын ажиллагаа нь тоон үзүүлэлт, гүйцэтгэл хоёрын аль алиныг хамрах ёстой гэдгийг санах нь зүйтэй. Парламентын хувьд аюулгүй байдлын албадын жил тутмын тайлан тооцоо нь өмнөх санхүүгийн жилд төсвийн зарцуулалт хэр үр дүнтэй явагдсан талаар үнэлгээ хийх чухал эх сурвалж юм.

Парламент хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад үндэсний аудитын газар (зарим тохиолдолд Ерөнхий аудитор, Үндэсний аудитын газар, Төсвийн алба, Тайлан, тооцооны танхим зэргээр нэрлэгддэг) түүнд туслалцаа үзүүлэх ёстой. Уг байгууллагыг Үндсэн хуулийн дагуу гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засгаас тусад нь байгуулна. Ерөнхий аудиторын дараах эрхтэй холбоотой дараах асуудлыг парламент хамаарна. Үүнд:

- ✓ Парламентаас томилогдох бөгөөд бүрэн эрхийн хугацаа тодорхой байх;
- ✓ Ажил үүргээ хараат бусаар гүйцэтгэх хуулийн бөгөөд бодит нөөц боломжтой байх;
- ✓ Шаардлагатай гэж үзсэн үедээ зардалтай холбоотой асуудлаар парламент болон төсвийн асуудал хариуцсан парламентын хороонд илтгэх эрхтэй байх.

Албан тушаалтан, улс төрийн аливаа байгууллага авлигын болон улсын өмчийг шамшигдуулсан хэрэгт холбогдсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх асуудлыг хуулиар зохицуулсан байхад парламент санаа тавих ёстой. Түүнчлэн, хохирлыг барагдуулах тогтолцоонд анхаарал хандуулах нь зүйтэй.

Тодруулга №60

Ерөнхий аудитор

“Гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх байгууллагын алины дор байхаас үл хамааран Аудитын газрын бүрэн хараат бус, бие даасан байдал жинхэнэ утгаараа хангагдсан байх нь чухал. Аудитын байгууллагын мэдэлд ажил үүргээ биелүүлэхэд хангалттай нөөц чадавх байх ёстой. Тус байгууллага нь гурван талт чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

Санхүүгийн хяналт

Аудитын байгууллага нь гүйцэтгэх засгийн харьяа болон төрийн бусад байгууллагын санхүүгийн үнэн зөв, найдвартай, нягт нямбай байдлыг нягтлан шалгах ёстой. Түүнчлэн санхүүгийн бүх ажиллагаа төрийн өмч хөрөнгөтэй холбогдуулан баталсан дүрэм журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих ёстой. Хяналтын энэхүү чиг үүргийн хүрээнд Аудитын газар нь төрийн байгууллагын нягтлан бодогчид болон гүйлгээ хийх зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнуудыг хамарсан эрх мэдэл эдлэх ёстой. Тэдгээр нь халагдсан эсвэл хариуцлагаас чөлөөлөгдсөнөөс бусад тохиолдолд санхүүгийн хариуцлага хүлээнэ. Өмч хөрөнгө шамшигдуулсан болон авлигын хэрэг илэрсэн тохиолдолд Аудитын газар шалгалтынхаа үр дүнг Шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.

Хуулийн хяналт

Аудитын газар нь төрийн бүх орлого, зарлага төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

Төрийн өмчийн зохистой ашиглалтыг баталгаажуулах

Сайн засаглалын эрх ашгийн үүднээс үйл ажиллагаа явуулдаг орчин үеийн Аудитын газар нь дараах гурван шалгуур үзүүлэлтийн дагуу төрийн өмч хөрөнгийн зохистой ашиглалтад хяналт тавих ёстой:

- (i) **Зарцуулалтын ашигт байдал:** хөрөнгийг тоон болон чанарын хувьд хамгийн үр ашигтай зарцуулах;
- (ii) **Үр дүн:** зорилго, зорилтуудын биелэлтийн түвшин;
- (iii) **Үр ашиг:** тухайн үр дүнд хүрэхийн тулд нөөц хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар зарцуулсан байдал.

Энэхүү дагалдах хяналтын ажиллагааг Аудитын газар өөрийн санаачилгаар эсвэл Парламентын хүсэлтийн дагуу явуулдаг.”

Ишлэл: Парламент ба төсвийн үйл явц, Хүйсийн тэгш эрх сэдэвт семинарын ерөнхий тайлан, ОУПХ, Бамако, 2001 оны 11 дүгээр сар, Бамако, Мали

Аюулгүй байдлын салбарын төсвийн аудитын практик ажиллагаа

Аюулгүй байдалтай холбоотой төсөвт аудит хийх нь парламентын хувьд нарийн, цогц ажиллагаа бөгөөд аюулгүй байдалтай шууд холбоотой асуудлуудаас гадна шууд бусаар холбогдох худалдаа, аж үйлдвэр, харилцаа холбоо, мөнгөн шилжүүлэг зэрэг асуудлын аудитын тайлан тооцоонд дүн шинжилгээ хийх шаардлагатай байдаг. Энд хамгийн гол хүндрэл бол өнгөн талаасаа огт хамааралгүй мэт харагдах үйл ажиллагаануудын уялдаа холбоог олж тогтоох явдал юм.

Аюулгүй байдалтай холбоотой голлох яамд буюу батлан хамгаалах, дотоод хэрэг, худалдаа аж үйлдвэр, мөн сүүлийн үед харилцаа холбоо, санхүүгийн асуудал хариуцсан яамдаас өөрт хуваарилагдсан төсвийн зарцуулалтын талаарх бүрэн хэмжээний тайланг парламентад тогтмол илгээх ёстой. Энэ хүрээнд парламентын ашиглах боломжтой арга хэрэгслүүд гэвэл: парламентын хороодоос яам, газруудын жилийн тайлан, тэдгээрийн үнэлэлт дүгнэлтийг хянан үзэх, санхүүгийн аудит хийсэн жилийн тайланг яам, газар тус бүрээр парламентад хэлэлцүүлэх.

Ерөнхийдөө аудитын ажиллагаа нь төсвийн ажиллагаа хууль журмын дагуу явагдсан, зардлын ашигт байдал, дэвшүүлсэн зорилтууддаа үр дүнтэйгээр хүрэх зарчмыг эрхэмлэсэн эсэхэд хяналт тавих боломжийг парламентад олгох ёстой.

Тодруулга №61

Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд Их Британийн Үндэсний аудитын газрын гүйцэтгэх үүрэг

Анх 1983 онд байгуулагдсан Их Британийн Үндэсний аудитын газар нь Хянагч болон Ерөнхий аудитчийн (Х ба ЕА) удирдлага дор ажил үүргээ гүйцэтгэдэг бөгөөд төв засгийн газрын төсвийн зарцуулалтын талаар парламентад мэдээлдэг. ҮАГ нь санхүүгийн аудит хийж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлдэг байна.

▷ Санхүүгийн аудит

Хуулийн дагуу Х ба ЕА болон ҮАГ нь засгийн газрын харьяа бүх байгууллагын тайлан тооцоонд аудит хийж, үр дүнг парламентад мэдээлэх үүрэг хүлээдэг. Бусад аудитчдын нэг адил Х ба ЕА нь тухайн тайлан тооцоо нь алдаа мадаггүй эсэх талаар өөрийн саналыг боловсруулах үүрэгтэй. Түүнчлэн Х ба ЕА нь тайлан тооцоонд тусгагдсан гүйлгээ нь парламентын зохих зөвшөөрлийн дагуу явагдсан эсэхийг баталгаажуулах ёстой. ҮАГ-аас бодит алдаа дутагдал илрүүлсэн тохиолдолд Х ба ЕА мэргэжлийн дүгнэлт гаргана. Бодит алдаа, зөрүү илрээгүй ч гэсэн Х ба ЕА бусад ач холбогдол бүхий асуудлуудын талаар

тайлан боловсруулж парламентад өргөн мэдүүлнэ. Тус тайланг Парламентын Нийтийн танхимын Улсын тайлан тооцооны хороогоор хэлэлцүүлж болно.

▷ Үр ашгийн аудит

Хянагч болон Ерөнхий аудитороос парламентад засгийн газрын харьяа байгууллагууд болон төрийн бусад байгууллагын төсвийн зарцуулалтын үр ашгийн талаар 50 орчим тайланг нэг жилд гаргаж өгдөг. ҮАГ нь төсвийн хэмнэлт, үр ашиг, үр дүнгийн талаар хяналт явуулж, тайлан гаргадаг. Тайланд санхүүгийн үйл ажиллагааны сайн ба муу талуудыг дурдахын зэрэгцээ үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх талаар санал зөвлөмж мөн өгдөг байна. ҮАГ-ын үзэж буйгаар сүүлийн гурван жилийн хугацаанд тус байгууллагаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр Засгийн газар 1.4 тэрбум фунт стерлинг хэмнэж чадсан аж. Батлан хамгаалахын төсвийн үр ашгийн аудитын хамгийн сүүлийн тайланд Нисдэг тэрэгний логистик, Байг тодорхойлох чадавх, Хуурай замын цэргийн зэвсэг техникийн засвар үйлчилгээ, Зэвсгийн нөөцийг багасгах, Батлан хамгаалах яамны төв байрны засвар зэрэг олон асуудлыг хамруулжээ. Түүнчлэн зэвсэг техник худалдан авах хамгийн том 30 төслийн талаар ҮАГ-аас тайлагнасан байна.

▷ Парламенттай харилцах харилцаа болон тайлангийн цикл

Парламент, тэр дундаас Улсын тайлан тооцооны хороотой харилцах харилцаа нь тус газрын үйл ажиллагаанд гол байр суурь эзэлдэг. Хуулийн дагуу Х ба ЕА нь Нийтийн танхимын албан хаагчийн статустай бөгөөд хийж гүйцэтгэсэн ажлаа бүхэлд нь парламентад тайлагнадаг байна. Тайлагнах цикл энэ байдлаар хэрэгждэг байна. Төв засгийн газраас төсвийн мөнгийг зарцуулсан бүх тохиолдолд Х ба ЕА нь түүний давтамж, зүй зохист байдал, үр ашгийн талаар парламентад мэдээлэх эрхтэй байна. Төрийн тайлан тооцооны хороо нь төрийн тухайн байгууллага дахь хамгийн ахлах албан тушаалтнаас тайланг хүлээн авч, санал зөвлөмж хүргүүлэх ба засгийн газраас тэдгээр санал зөвлөмжид хариу хүргүүлэх үүрэгтэй. Түүнээс гадна Үндэсний аудитын газар нь парламентын гишүүдээс төсвийн зарцуулалттай холбогдуулан ирүүлсэн 400 гаруй өргөдөл, хүсэлтэд хариу илгээдэг юм.

Эх сурвалж: Том МакДоналд, Батлан хамгаалахын асуудлаарх Ахлах аудитор, Үндэсний аудитын газар, Их Британи, 2002

Аудитын газрын үндсэн шинж

Аудитын газар нь парламентын хяналтыг хэрэгжүүлэх хамгийн чухал хэрэгслийн нэг мөн. Аудитын газар үр дүнтэйгээр үйл ажиллагаа явуулахын тулд дараах шинж чанарыг агуулсан байх ёстой:

- ✓ Эрх бүхий аудитын байгууллага нь парламентын тайлан тооцооны хороонд тайлагнах бөгөөд уг хороо нь төсвийн асуудал хариуцсан хорооноос тусдаа байна;
- ✓ Тухайн шийдвэрийн үндэслэлийг ухаж ойлгохын тулд нууц баримт бичигтэй танилцах эрхтэй байх хэдий ч тухайн баримт бичигтэй холбогдох мэдээллийг ил болгохын хориглоно;
- ✓ Аюулгүй байдлын салбар, батлан хамгаалахын удирдлага, техник, санхүү, хууль эрх зүй зэрэг олон салбарт мэргэшсэн мэргэжлийн чадавх бүрдсэн байх.

Тодруулга №62

Гүржийн парламент ба төсвийн хяналт

Гүржийн парламентын гишүүд 2001 оны сүүлчээр 2002 оны төсвийн тухай хуулийн хэлэлцүүлгийг нэг сараар хойшлуулжээ. Энэ нь төсвийн төслийн зарим үндсэн тоон үзүүлэлт дээр санал зөрөлдсөн, мөн засгийн газраас төслийг хэт орой өргөн мэдүүлсний улмаас түүнийг судлан үзэх хугацаа хангалтгүй байсан зэрэгтэй холбоотой байв. Түүний зэрэгцээ, батлан хамгаалах яам америкийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар түүхэндээ анх удаа батлан хамгаалах төсвийн хөтөлбөрийг боловсруулсан байна. Парламентын гишүүд зэвсэгт хүчний үндсэн бүтэцтэй танилцаж, батлан хамгаалах төсвийн талаар ул суурьтай санал гаргах боломжтой болжээ. Үүний дээр, төсвийн төслийг НАТО-ын стандартад нийцүүлэн боловсруулсан бөгөөд нийт зардлыг бие бүрэлдэхүүн, байлдааны бэлэн байдал, хөрөнгө оруулалт гэсэн гурван хэсэгт хуваасан байв.

Парламентын хяналтын үүднээс авч үзвэл, гол асуудал нь парламент төсвийг 2002 оны 1 дүгээр сарыг сүүлээр баталсан бөгөөд а) ерөнхийлөгч, сангийн сайд, батлан хамгаалахын сайд нар төсвийн үр ашигтай зарцуулалтын талаар өөр өөр байр суурь илэрхийлсэн; б) төсвийн тоон үзүүлэлтүүдэд хугацаа тулгаж өөрчлөлт хийсэн бөгөөд үндэслэлийг хууль тогтоогчдод тайлбарлаагүй; в) батлан хамгаалах яамны боловсон хүчинд хийх цомхотголын хуваарь, түүний санхүүгийн үр дагаврын талаар гишүүд мэдээлэлгүй зэрэгт оршиж байв. Үүний зэрэгцээ, төсвийн тухай хуульд тусгаагүй засгийн газрын зарим агентлагийн төсөв парламентын хяналтаас гадуур үлдсэн байна.

Энэ бүхний эцэст, батлан хамгаалах зардалд парламент ердөө 38 сая ГЕЛ баталсан нь батлан хамгаалах төсвийн хөтөлбөрт ноцтой нөлөөлсөн. Гэтэл уг хөтөлбөрт нийт 71 сая ГЕЛ шаардлагатай байжээ. Энэ хүрээнд ерөнхийлөгч болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл төсвийн хөрөнгийг засгийн газрын бүтцүүдийн хооронд хэрхэн хуваарилахыг шийдэх ёстой. Парламент энэ ховор боломжийг ашиглан мэтгэлцээн өрнүүлж, төсөв батлах үйл ажиллагааг ашиглан ардчилсан хяналт хэрэгжүүлж болох байв.

Эх сурвалж: Давид Дарчиашвили, Гүржийн Парламентын Судалгааны албаны дарга, 2002.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Бие даасан, үр дүнтэй аудит

- ▷ Эрх бүхий аудитын дээд байгууллага байгуулах талаар Үндсэн хууль буюу бусад хууль тогтоомжид зааж, дараах асуудлыг зохицуулсан байх:
 - Парламент болон үндэсний аудитын газрын харилцааны мөн чанар, цар хүрээ;
 - Үндэсний аудитын байгууллага, түүний гишүүд, албан хаагчдын хараат бус байдлын шаардлагатай түвшин болон санхүүгийн хараат бус байдал;
 - Парламент нь аудитын газар болон төрийн тайлан тооцооны асуудал хариуцсан парламентын хорооноос өгсөн тайлангийн дагуу засгийн газраас авсан хариу арга хэмжээний хэрэгжилтийг хянах ёстой.
- ▷ Олон улсын аудитын байгууллагын цахим хуудаснаа www.intosai.org тавигдсан Аудитын ажиллагааны зарчмын чиглэлийн тухай Лимагийн тунхаглалын зарчмууд танай улсын хууль тогтоомж, үйл ажиллагаанд туссан эсэхэд анхаарах.

Хууль эрх зүй, тогтмол байдал болон гүйцэтгэлийн аудит

- ▷ Үндэсний аудитын байгууллага аюулгүй байдлын салбартай холбоотой ажиллагаандаа дээрх гурван чиглэлийг баримталж буй эсэхэд анхаарч ажиллах.
- ▷ Аюулгүй байдалтай холбоотой зардлын аудит дагалдаж хийгдсэн хэдий ч парламент зохих дүгнэлт хийж, энэ салбарт дараа дараагийн төсвийн хуваарилалт хийхдээ ашиглах.
- ▷ Аудитын ихэнх тайлан санхүүгийн асуудлаар хязгаарлагддаг. Эрх бүхий аудитын байгууллага нь тодорхой зарим төслийн гүйцэтгэлд дэлгэрэнгүй аудит хийхэд зохих чадавх дутмаг байгаа бол хөндлөнгийн экспертүүд ашиглан хараат бус үнэлгээ хийлгэх боломжтой байх ёстой.
- ▷ Эрх бүхий аудитын байгууллага нь аюулгүй байдлын албадын санхүүгийн нэгж, хэлтсийн үйл ажиллагаанд мөн адил аудит хийх ёстой.

Долоодугаар хэсэг

Аюулгүй байдлын салбарын хүний нөөц:

Мэргэжлийн ур чадвар ба ардчилсан хяналт

Аюулгүй байдлын салбарт ардчилсан үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх нь

Зэвсэгт хүчний ардчилсан боловсрол болон чиг хандлагыг сайжруулах замаар цэргийн хүчийг нийгэмшүүлэх, улмаар ардчилалд аюул занал учруулах боломжийг хаах нь чухал. Зохистой удирдлагаар хангаж, ардчилсан хяналт хэрэгжүүлээгүй, эсвэл нийгмийн амьдралд бүрэн нийцүүлээгүй цэргийн хүч ардчилалд олон төрлийн аюул занал учруулах эрсдэлтэй. Үүнд:

- ✓ Үндсэн хуульд харш үйл ажиллагаа явуулах, улмаар цэргийн эргэлт хийхийг оролдох;
- ✓ Зөвшөөрөлгүйгээр цэргийн буюу арилжааны үйл ажиллагаа явуулах;
- ✓ Нийгмийн бусад салбарт хэрэгцээтэй байгаа хөрөнгө нөөцөөс өөртөө хэт ихийг зарцуулах;
- ✓ Төрийн өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулах;
- ✓ Хүний эрхийг зөрчих (тонуул, дээрэм, хууль бус үйлдэл, хүчирхийлэл).

Аюулгүй байдлын салбарын бие бүрэлдэхүүнд ардчилсан чиг хандлага төлөвшүүлэх тогтолцоо

Зэвсэгт хүчинд ардчилсан чиг хандлага төлөвшүүлнэ гэдэг нь ардчиллын үнэт зүйлс, институци, хүний эрхийн зарчмуудыг ухамсарлаж, хүндлэхэд хувь нэмэр оруулах тогтолцоог цэргийн байгууллагуудад бий болгож хөгжүүлнэ гэсэн үг. Байгууллагын дотоод дахь эдгээр тогтолцоо нь зэвсэгт хүчинд тавих парламентын, засгийн газрын, иргэний хяналтыг бэхжүүлэхэд нэн шаардлагатай. Бие бүрэлдэхүүний ардчилсан чиг хандлагыг сайжруулахад дараах асуудлууд тус дөхөм үзүүлнэ.

Үндсэн хууль, төрийн байгууламжийг дээдлэх

Хуульт ёс, Үндсэн хууль, төрийн байгууламжийг дээдлэх нийтийн албаны үнэт зүйлс, ёс зүйг аюулгүй байдлын салбарт төлөвшүүлэх нь сайн засаглалд мөн хамаарна. Цэргүүд болон ардчилсан нийгмийг хамгаалагч бусад хүчний бие бүрэлдэхүүн нь улс төрийн аль нэгэн эрх мэдэлтэн бус харин Үндсэн хууль болон төрийн байгууламжид үнэнч байх тангараг өргөх ёстой. “Хэн нэгэн этгээдэд хамааралгүйгээр” үнэнчээр зүтгэх тухай ийм тангараг бол аюулгүй байдлын албад тухайн үеийн эрх баригч засгийн газарт бус, харин хүн ардын зүй ёсны төлөөллөөс баталж хүчин төгөлдөр болсон Үндсэн хууль, хууль тогтоомжид үнэнч байхаа илэрхийлж буй хэрэг. Аюулгүй байдлын салбарт тавих иргэний хяналтад цэргийн тангарагийн мөн чанар, түүнийг биелүүлэх зорилгоор ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаарх ойлголтыг мөн агуулах ёстой.

Аюулгүй байдлын салбарын нарийн тодорхой дотоод зохион байгуулалт

Аюулгүй байдлын салбарын дотоод зохион байгуулалтад хамаарах хууль эрх зүйн цар хүрээ нэгдмэл байх нь ардчилсан хяналтад нэн чухал. Үүнд дараах зүйлс багтана:

- ✓ Цэргийн албан хаагчдын Үндсэн хуулийн эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлах;
- ✓ Цэргийн алба хаах тухай, цэргийн албаны тухай, цэргийн гэмт хэргийн тухай хууль тогтоомжийг батлах, шинэчлэх, хууль эрх зүйн орчинг Женевийн конвенцод нийцүүлэх;
- ✓ Хууль бус тушаалыг дагаж мөрдөхгүй байхыг цэргийн албан хаагчдын үүрэг болгож хуульчлах.

Ихэнх улс оронд нийт иргэдийн эрх, үндсэн эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг хэдий ч цэргийн тусгай чиг үүрэгт шаардлагатай байгаа бол цэргийн албан хаагчдын эдгээр эрхийг салбарын нэмэлт хууль тогтоомжоор хязгаарлах боломжтой байдаг. Зарчмын хувьд албан хаагч нь дүрэмт хувцастай иргэн учир бусад иргэдийн нэгэн адил эрхтэй. Гэхдээ нөгөө талаас нууц баримт бичигтэй танилцах эрхтэй байдаг тул үг хэлэх эрх чөлөө нь, цэргийн/аюулгүй байдлын бэлэн байдлыг хангах үүднээс шилжилт хөдөлгөөн үйлдэх эрх чөлөө нь, мөн улс төрийн албан тушаалд сонгогдох эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан байдаг. Гэхдээ цэргийн албан хаагчдын иргэний эрхийн хязгаарлалтын хэмжээ бүх улс оронд харилцан адилгүй. Жишээ нь, Скандинавын орнууд, Герман болон Нидерландад аюулгүй байдлын албадын албан хаагчид үйлдвэрчний эвлэл байгуулах, түүнд нэгдэх эрхтэй байдаг. Харин зарим орны албан хаагчид зөвхөн төлөөллийн холбоодод нэгдэх эрхтэй. Гэхдээ энэ бүх хязгаарлалтыг дагалдах хуулиудад тодорхой заасан байх бөгөөд цэргийн албан

хаагчийн тодорхой албан тушаал болон үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой байдаг.

Цэргийн төлөөллийн байгууллага болон холбоод

Олон улс оронд сайн дурын болон/буюу хугацаат цэргийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах, түүнд нэгдэхийг хориглосон байдаг. Цэргийн албан хаагчдын холбоог эсэргүүцэх гол үндэслэл нь зэвсэгт хүчний сахилга бат, зохион байгуулалтад сөргөөр нөлөөлж болзошгүй гэх болгоомжлол юм. Бусад орны хувьд Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенцын 11 дүгээр зүйлийн дагуу цэргийн алба хаагчдад төлөөллийн холбоо, тэр ч байтугай үйлдвэрчний эвлэл байгуулах, элсэх эрх олгосон байдаг. Эдгээр орны тоонд Австри, Бельги, Чех, Дани, Финлянд, Герман, Унгар, Ирланд, Люксембург, Нидерланд, Норвеги, Португаль, Орос, Словак, Словени, Швед, Швейцарь улсууд багтана. Эдгээр оронд цэргийн албан хаагчдын төлөөллийн холбоо болон эвлэл нь төрлөөсөө хамааран харилцан адилгүй эрх эдэлдэг. Тэд бүгд батлан хамгаалахын сайдтай зөвлөлдөх, түүгээр ч зогсохгүй зарим нь ажил эрхлэлтийн нөхцлийн талаар хэлэлцээ хийх эрхтэй байдаг. Аль ч тохиолдолд, эдгээр байгууллага нь албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд анхаарал тавин ажилладаг бөгөөд тухайлбал, ажил олгогч, цэргийн албан хаагчийн хооронд эрх зүйн маргаан гарсан тохиолдолд албан хаагчдад туслалцаа үзүүлдэг байна. Европт цэргийн албан хаагчдыг хамарсан хоёр үндсэн байгууллага байдаг. Брюссельд төвтэй EUROMIL нь албан тушаал хамаарахгүй цэргийн албан хаагчдыг хамарсан Европын цорын ганц байгууллага юм. Хоёр дахь байгууллага болох Европын хугацаат цэргийн албан хаагчдын байгууллагуудын зөвлөл нь Стокхольм хотод байрладаг байна.

Тодруулга № 63

Европын зөвлөл: Зэвсэгт хүчний мэргэжлийн бие бүрэлдэхүүний эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх зөвлөмж

1. Парламентын ассамблей нь (...) хэвийн нөхцөл байдлын дор зэвсэгт хүчний мэргэжлийн бие бүрэлдэхүүнд эвлэлдэн нэгдэх эрхийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд үүнд ажил хаялт зохион байгуулах, түүнд оролцох эрх хамаарахгүй болно (...)

4. Сүүлийн жилүүдэд, зарим гишүүн орны арми хугацаат албаны тогтолцооноос мэргэжлийн цэргийн тогтолцоонд бүрэн шилжсэн. Үүний улмаас цэргийн бие бүрэлдэхүүн нь Батлан хамгаалах яам гэх ажил олгогч бүхий “ердийн” албан хаагч болон хувирч буй бөгөөд энэ хэрээр тэд Хүний эрхийн тухай Европын конвенц болон Европын нийгмийн дүрэмд тусгасан ердийн ажилтны эрхийг эдлэх бүрэн эрхтэй болж байна.

5. Зэвсэгт хүчний албан хаагчид нь “дүрэмт хувцастай иргэд” болохын хувьд, цэрэг арми дайны ажиллагаанд оролцоогүй үед ажил үүргээ гүйцэтгэх хугацаандаа ардчилсан институцийн хүрээнд өөрсдийн мэргэжлийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тодорхой холбоо байгуулах, түүнд элсэх, үйл ажиллагаанд нь идэвхтэйгээр оролцох эрхээ бүрэн хэмжээгээр эдлэх ёстой.

6. Цэргийн албан хаагчид нийтлэг эрхүүд, түүний дотор улс төрийн намд элсэх эрх эдлэх ёстой.

7. Тиймээс Ассамблейгаас гишүүн орнуудын Сайд нарын хороонд хандан дараах зүйлсийг уриалж байна:

i. зэвсэгт хүчний албан хаагчид, цэргийн бие бүрэлдэхүүн зохион байгуулалтад орж төлөөллийн нийгэмлэг байгуулан цалин хөлс, ажлын нөхцлийн талаар хэлэлцээр хийхийг зөвшөөрөх;

ii. зэвсэгт хүчний албан хаагчдын эвлэлдэн нэгдэх эрхийг боогдуулсан өнөөгийн хэрэгцээгүй хязгаарлалтыг халах;

iii. зэвсэгт хүчний албан хаагч, цэргийн бие бүрэлдэхүүнд улс төрийн намын гишүүн байх эрх олгох;

iv. эдгээр эрхийг гишүүн орнуудын цэргийн дүрэм журам, зохицуулалт, хууль тогтоомжид тусгах;

v. цэргийн бие бүрэлдэхүүнээс хөдөлмөрийн болон албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой бусад асуудлаар хандах омбудсмэний байгууллага байгуулах боломжийг судлах.

8. Түүнчлэн Ассамблейгаас Сайд нарын хороонд хандан Европын нийгмийн дүрмийн 5 дугаар зүйлийг дараах байдлаар шинэчлэн найруулах боломжийг судалж үзэхийг уриалж байна. Үүнд: “Ажилтан болон ажил олгогчид өөрсдийн эдийн засаг, нийгмийн эрх ашгаа хамгаалах үүднээс орон нутгийн, үндэсний болон олон улсын байгууллага байгуулах, түүнд элсэх эрх чөлөөг баталгаажуулах буюу дэмжих зорилгоор Талууд өөрсдийн үндэсний хууль тогтоомжоор энэ эрх чөлөөг боогдуулах эсвэл боогдуулах байдлаар ашиглахгүй болохоо үүгээр батламжилж байна. Энэхүү зүйлийн дагуу олгогдсон баталгаа нь цагдаа, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд үйлчлэх хүрээг үндэсний хууль тогтоомж, зохицуулалтаар тодорхойлно.”

*Зөвлөмж 1572 (2002) Европын зөвлөлийн Парламентын ассамблей,
2002 оны 9 дүгээр сарын 3*

Суурь үнэт зүйлс, хэм хэмжээний талаарх мэдлэг боловсролыг дэмжих

Аюулгүй байдлын албадын албан хаагчдын боловсрол нь чиг үүргээ гүйцэтгэхэд бэлэн, мэргэжлийн албан хаагчдыг бэлдэх зорилготой. Эл боловсрол нь улс төрийн хувьд төвийг сахисан байх ба улс төрийн үзэл суртал, суртал ухуулгын аливаа асуудлыг агуулах ёсгүй. Сургалтын хөтөлбөрт ардчилал, Үндсэн хууль, олон улсын болон хүмүүнлэгийн хууль тогтоомж, хүний эрхийн тухай агуулга орно. Аюулгүй байдлын салбарт олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомжийн талаар хичээл сургалт явуулах нь тус салбарт ардчилсан үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй. Парламентын гишүүд олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн талаар мэдээлэл авахыг хүсвэл 1999 онд парламентын гишүүдэд зориулан ОУПХ болон Олон улсын улаан загалмайн нийгэмлэгээс хамтран гаргасан “Олон улсын хүмүүнлэгийн хуулийг хүндлэх нь” сэдэвт гарын авлагатай танилцах боломжтой (Гарын авлага N°1). Түүнчлэн, Олон улсын улаан загалмайн нийгэмлэг (ОУУЗН) болон НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (НҮБХЭДКГ)-аас олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийн чадавхаа бэхжүүлэхийг эрмэлзэж буй орнуудад техникийн тусалцаа үзүүлдэг.

Улс төрийн төвийг сахисан байдал болон идэвхгүй оролцоог хангах нь

Аюулгүй байдлын албад улс төрийн хувьд төвийг сахисан байр суурьтай байх ёстой учир улс төрийн намууд цэргийн анги байгууллагад кампанит ажил явуулах хориотой байдаг. Зарим оронд ажил үүргээ гүйцэтгэж буй цэргийн албан хаагчид улс төрийн намын гишүүн болохыг зөвшөөрдөг бол бусад, нэн ялангуяа пост-коммунист орнуудад цэргийн албан хаагчдыг улс төрийн намд элсэхийг хориглодог. Жишээ нь, Польшид тагнуул, цагдаа зэрэг дотоод хэргийн яамны харьяа байгууллагын ажилтнуудыг улс төрийн намд элсэхийг хориглодог. Ихэнх оронд цэргийн албан хаагчид үндэсний парламентын гишүүний алба хашихыг хориглодог. Харин Нидерланд, Герман зэрэг оронд албан үүргээ гүйцэтгэж буй цэргийн албан хаагчид орон нутгийн болон бүс нутгийн хурлын гишүүн болох боломжтой байдаг.

Аюулгүй байдлын албад нийгмийн тусгал болох нь

Зарчмын хувьд аюулгүй байдлын албадын бүх албан тушаалд иргэд нас, хүйс, улс төрийн итгэл үнэмшил, анги давхарга, арьс өнгө, шашин шүтлэгээс үл хамааран ажиллах боломж нээлттэй байх ёстой. Хамгийн чухал албан тушаалд хамгийн шилдэг нь ажиллах гэсэн гол шалгуур үзүүлэлт байх ёстой. Олон оронд аюулгүй байдлын албадын, тэр тусмаа цагдаа болон зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь нийгмийнхээ тусгал байх ёстой гэдгийг ухамсарласан байдаг. Эдгээр орнуудад

аюулгүй байдлын албадын бүрэлдэхүүнд харьцангуй бага төлөөлөл бүхий нийгмийн бүлгүүдийг тэдгээр байгууллага дахь ажлын байранд өрсөлдөхийг урамшуулж, дэмжих тусгай бодлого хэрэгжүүлдэг.

Хууль бус, зохисгүй тушаалыг даган биелүүлэхгүй байх эрхийг хуульчлах

Аюулгүй байдлын нийт албадын нийгэм дэх байр суурь, цар хүрээ, үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, чиг үүргийн хуваарилалт, тайлагнах үйл явц, үүрэг хариуцлага, хяналт зэрэг нь бүгд хуулиар зохицуулагдах бөгөөд аюулгүй байдлын албадад хуулиас гадуурх эрх байхгүй. Цэргийн байгууллагын хувьд Цэргийн албаны тухай хууль, эсвэл Цэргийн гэмт хэргийн тухай хууль зэрэг баримт бичигт цэргийн албан хаагчдын дагаж биелүүлэх үүрэгтэй тушаалын цар хүрээг тодорхойлсон байдаг. Олон оронд захирагч дарга тушаал өгөхдөө хууль ёсыг дээдлэх хуультай ба ингэснээр түүний эрх мэдэлд зохих хязгаарлалт тавьсан байдаг. Өөрөөр хэлбэл, цэргийн албан хаагчид хууль бус (гэмт хэргийн шинжтэй) тушаалыг биелүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд гүйцэтгэсэн тохиолдолд тухайн тушаал нь өөрийгөө зөвтгөх үндэслэл болдоггүй байна. Түүнчлэн, цэргийн албан хаагчид ажил үүрэгтэй нь холбоогүй эсвэл хүний ёсноос гажууд тушаалыг даган биелүүлэхгүй байх эрхтэй. Нэг үгээр хэлбэл, албан хаагчид даргаас тушаал авсан хэдий ч хийсэн үйлдлийнхээ төлөө өөрсдөө хариуцлага хүлээх ёстой.

Цэрэг хүн ардчилсан бус, Үндсэн хууль зөрчсөн буюу түүний эсрэг, ёс суртахуунгүй тушаал, үйлдэл хийдэггүй гэдгийг цэргийн дээд шатны удирдлага өөрийн үлгэр жишээгээр олон нийтэд харуулж байх ёстой. Хуучин цэргийн дарангуйллын тогтолцоотой байсан орнуудын хувьд энэ нь онцгой ач холбогдолтой. Тухайлбал, Аргентин улс ардчиллыг сэргээн тогтоосны дараа тус улсын генералууд “үр дүн нь ашигласан бүх арга хэрэгслийг зөвтгөхгүй” бөгөөд “ёс суртахуунгүй тушаал өгсөн, тэр тушаалыг даган биелүүлсэн хэн боловч хууль зөрчсөн болно” хэмээн тунхагласан байна. Энэ мэдэгдлийг хийснээр цэргийн удирдлага хийсэн гэмт хэрэг, зөрчлийнхөө хариуцлагыг цэрэг бүр өөрөө хүлээх бөгөөд тушаал \хууль бус\ биелүүлсэн гэх үндэслэл үгүй гэдгийг тодорхой илэрхийлсэн байна.

Үүнтэй холбогдуулан, ял шийтгэлээс мултарч үлдэх явдлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор мэргэжлийн зүй бус үйлдэл, олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомжийн зөрчилд эрх бүхий захиргааны болон шүүхийн байгууллагаас зохих шийтгэлийг зайлшгүй оноодог байх нь чухал.

Аюулгүй байдлын салбарын удирдах албан тушаалтныг томилох шалгуур үзүүлэлтүүд

Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, тагнуулын байгууллагын дарга зэрэг аюулгүй байдлын албадын удирдах албан тушаалтныг засгийн газар буюу

батлан хамгаалахын сайд томилдог. Зарим оронд эдгээр томилгоог парламентын хэлэлцүүлэг, зөвшөөрлөөр хийдэг. Удирдах албан тушаалтны томилгоог иргэний улс төрийн удирдлага хийх хэдий ч сонголтын явцад мэргэжлийн шалгуур үзүүлэлт хамгийн чухал.

Аюулгүй байдлын салбарын энгийн дээд удирдлага

Сайн засаглалын үүднээс үзэвэл, зэвсэгт хүчин зэрэг аюулгүй байдлын албадын дээд удирдлагын бүрэлдэхүүнд энгийн албан тушаалтан байх ёстой. Шийдвэр гаргах явцын тэнцвэрт байдлыг хангахын тулд сайдад цэргийн генералуудаас гадна энгийн албаны хүн зөвлөх ёстой юм.

Мэргэжлийн ёс зүй

Мэргэжлийн ёс зүй нь практик ажиллагаа, дүрэм журам, бодлогод тулгуурладаг. Аюулгүй байдлын албадын албан хаагчид нь төрийн байгууллагуудтай хамтран ажиллахдаа үл цааргалах, Үндсэн хуулийг дээдлэх, төрийн албанд хоёргүй сэтгэлээр зүтгэх, албан үүргээ үр дүнтэй, үр ашигтай гүйцэтгэх, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн өмч хөрөнгийг шамшигдуулахгүй байх үүрэгтэй. Мэргэжлийн ёс зүй нь дан ганц албадан гүйцэтгэл бус харин өөрийн хүсэл эрмэлзэл дээр тулгуурлах ёстой. Нийгмийн ардчилсан үнэт зүйлсийн тусгал болсон Үндсэн хууль болон төрийн байгууламжийг цэргийн албан хаагч эрхэмлэн хүндэтгэхийг сайн дурын гүйцэтгэл гэж ойлгоно.

Олон орны аюулгүй байдлын албадын албан хаагчид өөрийн гэсэн ёс зүйн дүрэмтэй байдаг. Германы зэвсэгт хүчний мэргэжлийн ёс зүйн жишээг Тодруулга N°64-д үзүүлэв.

Тодруулга N°64

Германы зэвсэгт хүчин дэх манлайлал ба иргэний боловсрол: “Innere Führung”-ийн зарчмууд

“(…) Дэлхийн 2 дугаар дайны дараа Бундесвер буюу Холбооны зэвсэгт хүчин байгуулах эсэх талаарх мэтгэлцээний үед Innere Führung (ёс суртахууны манлайлал ба иргэний боловсрол)-ийн үзэл баримтлалыг хуучин хэв загвараас ухамсартайгаар салах замаар зэвсэгт хүчнийг шинэчлэх гол арга хэмээн үзсэн. (...) Innere Führung-ийн зарчмууд нь нэг талаас Холбооны зэвсэгт хүчний дотоод зохион байгуулалт, нөгөө талаас түүнийг нийгэмшүүлэх үндсэн заавруудыг агуулсан гэхэд болно.

(...) Innere Führung нь зэвсэгт хүчний албан хаагчийн иргэний эрх, эрх чөлөө болон цэргийн албан үүргийн хооронд үүсэх аливаа зөрчлийг боломжит

түвшинд хүргэж бууруулах зорилготой. Дээд тушаалын офицеруудын зан төлөв, хандлагад манай үндсэн хуульт тогтолцооны үндэс суурь болсон хүний нэр төрийг хүндэтгэх үзэл бүрэн шингэсэн байх ёстой (...).

Гадаад талаасаа, Бундесверийг институцийн хувьд болон зэвсэгт хүчний албан хаагч нэг бүрийг иргэн хүний хувьд төр, нийгэмд нэгтгэх зорилт тавигдаж байна. (...) Үүний гол зорилго бол Бундесвер нь “улсын доторх улс” болон хувирна гэсэн айдсыг арилгах явдал – ийм аюул бүхий л зэвсэгт хүчинд нийтлэг тохиолддог (...).

Innere Führung-ийн зорилтууд:

Зэвсэгт хүчний албан хаагчдад Бундесверийн улс төрийн болон хууль эрх зүйн үндэс суурь, цэргийнхний үйл ажиллагааны зорилго, мөн чанарын талаар ойлголт, мэдлэг олгох;

Холбооны зэвсэгт хүчин, түүний албан хаагчдыг төр улс, нийгэмд нэгтгэх явцыг дэмжих, тэдний зорилго, үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулах;

Албан хаагчид албан үүргээ ухамсартайгаар гүйцэтгэх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний сахилга бат, нэгдмэл байдлыг хадгалах;

Зэвсэгт хүчний дотоод бүтэц нь хүний нэр төрийг хүндэтгэх, үндсэн хуульт тогтолцоог дээдлэх үзэлд тулгуурласан байхыг баталгаажуулж, зэвсэгт хүчин өөрийн зорилгоо үр дүнтэйгээр биелүүлэхэд дөхөм болох.

Цэргийн өдөр тутмын амьдрал дахь Innere Führung-ийн агуулга, зарчмуудыг хэд хэдэн хууль, тушаал, цэргийн албаны дүрэмд тусгасан байдаг. (...)”

Эх сурвалж: Германы Холбооны парламентын цахим хуудас www.bundestag.de

Өнөөгийн байдлаар олон улсын түвшинд ардчилсан нийгэм дэх аюулгүй байдлын албадын албан хаагчдын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг заасан ёс зүйн хоёр дүрэм бий. Ерөнхий Ассамблейгаас 1979 онд Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын олон улсын дүрмийг гаргасан (Тодруулга N°65-ыг үз). Энэ дүрмийн агуулга ерөнхий бөгөөд зөвхөн дүрэмт хувцастай бие бүрэлдэхүүнд бус хууль сахиулах байгууллагын энгийн албан хаагчдад мөн хамаарна.

Тодруулга N°65

Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм

Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны 34/169 тоот тогтоолоор батлав

1 дүгээр зүйл – Хууль сахиулах байгууллагын албан хаагчид ямагт ажил мэргэжлийн хариуцлагатай байдлаа чандлан сахиж, олон нийтэд үйлчлэн,

нийт ард иргэдийг хууль бус үйлдлээс хамгаалах замаар хуулиар ногдуулсан өөрийн үүргийг гүйцэтгэнэ.

2 дугаар зүйл – Ажил үүргээ гүйцэтгэхдээ хууль сахиулах байгууллагын албан хаагчид нь аливаа хүний нэр төрийг хүндэлж, хамгаалахын зэрэгцээ хүний эрхийг дээдэлнэ.

3 дугаар зүйл – Хууль сахиулах байгууллагын албан хаагчид зөвхөн зайлшгүй тохиолдолд, албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хэмжээнд хүч хэрэглэнэ.

4 дүгээр зүйл – Хууль сахиулах байгууллагын албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай болон шүүхээс шаардлага тавьснаас бусад тохиолдолд өөрсдийн мэдэлд буй нууц мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

5 дугаар зүйл – Хууль сахиулах байгууллагын аливаа албан хаагч эрүүдэн шүүх, хэргийг, хүнлэг бус харьцах, гутаан доромжлох, залхаан цээрлүүлэх ажиллагааг үйлдэх, санаачлах, хүлцэн өнгөрөөх ёсгүй бөгөөд удирдах даргын тушаал, дайны байдал, дайны аюул, үндэсний аюулгүй байдалд учирсан аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал зэрэг бусад онц нөхцөл байдал нь хууль сахиулах байгууллагын албан тушаалтны ийм үйлдлийг зөвтгөх үндэслэл болохгүй.

6 дугаар зүйл – Хууль сахиулах байгууллагын албан хаагч өөрийн баривчлан саатуулсан этгээдийн эрүүл мэндийг хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ нэн даруй үзүүлэхэд анхаарна.

7 дугаар зүйл - Хууль сахиулах байгууллагын албан хаагч авлига авах ёсгүй бөгөөд ийм үйлдлийг эсэргүүцэж, тэмцэх бүх арга хэмжээг авна.

8 дугаар зүйл - Хууль сахиулах байгууллагын албан хаагч хууль тогтоомж болон энэхүү Дүрмийг хүндэтгэх ба тэдгээрийг зөрчсөн аливаа үйлдлээс урьдчилан сэргийлж, эсэргүүцэх боломжтой бүх арга хэмжээг авна. Энэ Дүрмийг зөрчсөн буюу зөрчиж болзошгүй гэж хууль сахиулах байгууллагын албан хаагч үзэж байгаа бол өөрийн шууд удирдах дарга буюу шаардлагатай тохиолдолд тэр үйлдлийг хянан шалгах, засч залруулах эрх бүхий холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

Жич: Дүрмийн заалтын тайлбарууд энэ тодруулгад багтаагүй бөгөөд баримт бичигтэй бүхэлд нь дараах хуудаснаас танилцана уу: www.UN.org

Хоёрдахь баримт бичиг бол ЕАБХАБ-ын Аюулгүй байдлын улс төр-цэргийн хүрээний ёс зүйн дүрэм (Тодруулга N°66) юм. Энэ дүрэм аюулгүй байдлын салбарын бүх байгууллагын албан хаагчид, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд зориулсан зааврыг агуулдаг. Аюулгүй байдлын салбарын албан хаагчид нь хууль ёс, ардчилал, төвийг сахих, хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг дээдлэх зарчимд захирагдах ёстойг уг дүрэмд заасан байна.

Түүнчлэн, хүмүүнлэгийн хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэлдээ цэргийн албан хаагчид өөрсдөө биечлэн хариуцлага хүлээх аж. Гэхдээ өмнө нь тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор зохицуулагдаж, төрийн эрх мэдлээр хамгаалагдаж байсан асуудлуудыг энэ дүрэмд хамарсан тул энэ чиглэлээр чухал ахиц дэвшил гаргасан байна. ЕАБХАБ-ын гишүүн орнууд 1994 онд энэ дүрэмд гарын үсэг зурснаас хойш тус байгууллага цэргийн бие бүрэлдэхүүнээ хэрхэн элсүүлэх, сургах, захирах хэм хэмжээг сайжруулах ажлыг үргэлжлүүлсээр байгаа юм. Энэ нь тус дүрэмд зэвсэгт хүчний мэргэжлийн чиг хандлагыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх чиг хандлагыг зэвсэгт хүчинд тавих зохистой ардчилсан хяналттай нийцүүлнэ гэсэн чухал заалттай холбоотой.

Тодруулга №66

ЕАБХАБ: Аюулгүй байдлын салбарын улс төр-цэргийн хүрээний Ёс зүйн дүрэм (1994) – гол агуулга

- ▷ Дотоодын цэрэг гэдэгт өргөн утгаараа тагнуулын алба, цэрэгжсэн байгууллага, цагдаагийн алба хамаарна. Уг дүрмээр гишүүн орнууд хууль ёсны дагуу эрх мэдэл олгогдсон ардчилсан байгууламжаар дамжуулан эдгээр хүчинд үр дүнтэй ардчилсан хяналт тавих үүрэг хүлээсэн байдаг. (20, 21 дүгээр зүйл);
- ▷ Хууль тогтоох байгууллагаас батлан хамгаалах төсвийг батлах, цэргийн зардлыг хязгаарлахыг дэмжих заалт. Зэвсэгт хүчинтэй холбоотой мэдээллийн ил тод, олон нийтэд нээлттэй байдал (22 дугаар зүйл);
- ▷ Зэвсэгт хүчин улс төрийн хувьд төвийг сахисан байна (23 дугаар зүйл); Зэвсэгт хүчний албан хаагч олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд биечлэн хариуцлага хүлээнэ (31 дүгээр зүйл);
- ▷ Дайны болон энхийн цагт зэвсэгт хүчнийг олон улсын хууль тогтоомжийн дагуу захирч, бүрдүүлж, сургаж, зэвсэглэнэ (34 дүгээр зүйл);
- ▷ Дотоод аюулгүй байдлыг хангахад хүч хэрэглэх нь тухайн ажиллагааны хэрэгцээ шаардлагатай нийцсэн байна. Зэвсэгт хүчин энгийн иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас зайлсхийх бүх арга хэмжээг авна (36 дугаар зүйл);
- ▷ Зэвсэгт хүчин ашиглах нь иргэд хүний болон иргэний эрхээ тайван, хууль ёсны дагуу эдлэхэд хязгаарлалт болох ёсгүй бөгөөд тэдний үндэсний, шашны, соёлын, хэл ярианы эсвэл үндэс угсааны хэв шинжийг өөрчлөхгүй (37 дугаар зүйл).

Эх сурвалж: ЕАБХАБ-ын Ёс зүйн дүрэм. VII ба VIII хэсэг. ЕАБХАБ-ын цахим хуудас: www.osce.org болон ЕАБХАБ-ын Ёс зүйн дүрмийн цахим хуудсыг үз:

http://www.osce.org/docs/english/1990-1999/summits/buda94e.htm#Anchor_COD_65130

Цэргийн шүүх

Цэргийн сахилга батын шаардлага нь тэдний ажил үүргийн өвөрмөц шинж чанараас урган гардаг. Жишээ нь, цэргийн албан хаагчдын гэмт хэрэг энгийн иргэдийнхээс ихээхэн ялгаатай. Энгийн ажилтан албан байраа орхиж явах буюу ажил үүргээ зохистой гүйцэтгэж чадаагүйн улмаас эрүүгийн хариуцлага хүлээдэггүй. Ажил олгогч нь муу ажилласан хүнийг ажлаас халж, өөр бусад газарт ажилд ороход нь тодорхойлолт гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй хэдий ч эрүүгийн хэрэг үүсгэдэггүй. Харин эсрэгээр, аюулгүй байдлын албадын албан хаагчид ажлын байраа орхих, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүйн төлөө эрүүгийн хариуцлага хүлээдэг. Энэ нь тэдгээрийн ажил үүргийн тусгай стандарт, шаардлагатай холбоотой. Ийм үйлдэл нь зөвхөн албан үүргээ цалгардуулж буй явдал бус харин цэргийн бусад албан хаагчдын амь нас, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж буй гэмт хэрэг мөн. Энгийн иргэдийн хувьд үйлчилдэггүй цэргийн гэмт хэргийн бусад жишээг дурдвал, залилан мэхлэх аргаар цэргийн албанд элсэх, албанаас оргох, зөвшөөрөлгүйгээр анги байрлалаа орхих, шилжилт хөдөлгөөнөөс хоцрох, ахлах цолтой офицерыг үл хүндэтгэх, бослого гаргах, дайсны талд туслах, харуулын байран дээр унтах зэрэг болно.

Үүнтэй холбогдуулан ямар гэмт хэрэг цэргийн шүүхээр, ямар нь иргэний шүүхээр шийдэгдэх ёстой вэ гэсэн асуудал урган гарна. Зарчмын хувьд цэргийн шүүхийг хязгаарлагдмал байдлаар хэрэглэж, иргэний шүүхийн ажиллагаа аль болох давамгайлж байх ёстой. Цэргийн хэргийн шүүх нь цэргийн ажил үүрэг гүйцэтгэх үед үйлдэгдсэн гэмт хэргээр хязгаарлагдах ёстой бөгөөд цэргийн албаны дүрмийн заалтууд нь иргэний эрүүгийн хуультай аль болох бага давхцах ёстой.

Ихэнх улс оронд цэргийн шүүх нь шүүх бус харин гүйцэтгэх засгийн нэгэн хэсэг болох зэвсэгт хүчний захиргааны тусгай шүүх гэж тооцдогийг дурдах нь зүйтэй. Тиймээс цэргийн шүүхийн шүүгчдийг үндсэн хуулийн зүйл заалт, шүүгч томилох шалгуур үзүүлэлтийн дагуу томилох нь их байдаг. Гэсэн хэдий ч ямар ч нөхцөлд цэргийн шүүх нь шүүх засгийн хяналтад байх ёстойг анхаарах хэрэгтэй. Энэ зорилгоор олон оронд цэргийн шүүхийн давж заалдах шат нь иргэний давж заалдах шүүх байдаг.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Дараах асуудлыг анхаарах:

1. Цэргийн бие бүрэлдэхүүн тангараг өргөхдөө хувь хүмүүст бус харин Үндсэн хууль, хуулийн засаглал, төрийн байгуулалд үнэнч байхаа илэрхийлэх.
2. Цэргийн сургалтын агуулгад ардчиллын гол үнэт зүйлс, иргэний эрх ба хүмүүнлэгийн хууль тогтоомжийн заалт тусгагдсан байх.
3. Цэргийн албан хаагч парламентын гишүүн байхыг хориглох.
4. Цэрэг, офицеруудыг шинээр сонгохдоо мэргэжлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурлах.
5. Цэргийн албан хаагч нь хууль бус болон зүй бус тушаалыг үл биелүүлэх үүрэгтэйг хуульчлах.
6. Цэргийн ёс зүй нь цэргийн албаны зохих дүрэм дээр тулгуурлан өөрийн хүсэл зоригоор үүрэг гүйцэтгэхэд оршино.
7. Цэргийн шүүхийн үйлчлэх хүрээ аль болох хязгаарлагдмал байх бөгөөд шийдвэрийг нь иргэний шүүхэд давж заалдах боломж нээлттэй байх.
8. Аюулгүй байдлын албадын төрийн үндсэн бүтцүүдийн өмнө хүлээх хариуцлагыг хууль тогтоомжид тодорхойлсон байхын сацуу бодитоор хэрэгждэг байх нь чухал (энэ бүлгийн эхэнд албан хаагчдын хүлээх хариуцлагын талаарх хэсгийг үз) бөгөөд аюулгүй байдлын албадын дотоод хариуцлагын тогтолцоог хуулиар тодорхойлж, зүй бус үйлдэл, иргэдээс гаргасан гомдлыг хянан шалгах ажиллагааг дотооддоо явуулж, буруутай этгээдэд зохих шийтгэл ноогдуулах, эдгээр арга хэрэгсэлийг үр дүнтэй ашиглаж байгаад хяналт тавих боломжийг хуулиар олгосон байх ёстой. Үүнтэй холбоотойгоор парламент хараат бус хяналт шалгалт явуулахыг шаардаж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага тооцох явдлыг баталгаажуулах.

Албан хаагчдын иргэний эрх

- ▷ Цэргийн албан хаагчдын иргэний эрхийг хуулиар хязгаарлах замаар (цэргийн) бэлэн байдал, улс төрийн төвийг сахисан байдлыг хангах.
- ▷ Үүний сацуу, иргэний эрхийн аливаа хязгаарлалт нь аюулгүй байдлын албадын онцлог шинж чанар, чиг үүрэг, тухайлбал, нийгэмд хүч хэрэглэх давамгайл эрхтэй шууд уялдаатайгаар хэрэгжүүлэх ёстойг санах.
- ▷ Гомдол, санал хүсэлтийн үр дүнтэй өөр бусад сувгаар шийдвэрлэх замаар иргэний эрхийн хязгаарлалтыг тэнцвэржүүлэх.

Тушаал биелүүлэх

- ▷ Хууль бус, ёс зүйд харш, олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн хууль тогтоомжийг зөрчсөн аливаа тушаалыг цэргийн албан хаагчид, үүний дотор хугацаат цэргийн албан хаагчид биелүүлэхгүй байх үүргийг хуульчлах.
- ▷ Дээрх үүргийг аюулгүй байдлын албадын сахилга батын дотоод тогтолцоогоор баталгаажуулах.

Эрх мэдлээ урвуулан ашиглах ба авлига

- ▷ Аюулгүй байдлын албадын бие бүрэлдэхүүнтэй холбоотой авлига, зүй бус үйлдлийн талаар дуулиан дэгдсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах.
- ▷ Нарийвчилсан хянан шалгах ажиллагаа явуулж, шаардлагатай бол эрх бүхий этгээд ногдуулах арга хэмжээг түргэн шуурхай тодорхойлж, хариуцлага хүлээлгэхэд анхаарах.
- ▷ Цэргийн болон аюулгүй байдлын бусад албадын албан хаагчид бие даан буюу зохион байгуулалтайгаар бүлэглэж давхар ажил эрхлэх, арилжааны үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглох.

Аюулгүй байдлын салбарын хүний нөөцийн бодлого

Цэргийн байгууллагад ажиллах нь бие махбодид учрах эрсдэл, байнгын шилжилт хөдөлгөөн, гэр бүлээсээ хол байх зэрэг мэргэжлийн зарим онцлогийг дагуулдаг. Тиймээс парламент цэргийн албыг “байдаг л нэг ажил” биш гэдгийг ойлгох ёстой. Албан хаагч элсүүлэх, сонгох, цалин хангамж, боловсрол, шагнал урамшууллын тогтолцоо зэргийг агуулсан хүний нөөцийн оновчтой бодлого нь ардчилсан зарчмыг дагаж мөрддөг, хуулийн засаглал, иргэний давамгайл байдлыг дээдэлсэн аюулгүй байдлын мэргэжлийн салбарыг бий болгож хөгжүүлэхэд нэн чухал.

Парламент аюулгүй байдлын мэргэжлийн албадыг бий болгож хөгжүүлэх ажиллагааг хянах ёстой. Өөрөөр хэлбэл, ардчилсан, мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг бий болгож, төлөвшүүлэхэд чиглэсэн хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж буй эсэхэд анхаарал тавьж ажиллана. Улмаар цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, тэтгэвэр тэтгэмж зэрэг асуудлаар төр сайн ажил олгогч байж чадаж байгаа эсэхэд хяналт тавих ёстой.

Тодруулга N° 67

Хүний нөөцийн удирдлага: Парламентын гишүүдийн анхаарах гол асуудлууд

Аюулгүй байдлын албадын хүний нөөцийн бодлоготой холбоотой засгийн газраас мэдүүлж буй төсөл хөтөлбөрийн талаарх дараах асуудлуудад парламентын гишүүд анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:

Бодлогын ерөнхий асуудлууд

- ▷ Аюулгүй байдлын албадын хүний нөөцийн бодлогыг батлахад парламент жилийн төсвийн хэлэлцүүлэг эсвэл тусдаа баримт бичиг хэлэлцэх журмаар оролцдог уу?
- ▷ Хүний нөөцийн бодлого, хүчний бүтцийн бодлого зэрэг нь төсөв, үндэсний эдийн засгийн үүднээс бодитоор хэрэгжих боломжтой юу?

Хүчин чадал ба ерөнхий нөхцөл

- ▷ Парламент зэвсэгт хүчин, цагдаа, тагнуулын албадын бие бүрэлдэхүүний тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоодог уу?
- ▷ Парламент цол бүрт дээд хязгаар тогтоодог уу?
- ▷ Хүний нөөцийн бодлого олон нийтэд нээлттэй байдаг уу?
- ▷ Парламент тухайн цол бүхий албан хаагчдын тоо, цалин, үйл ажиллагаа,

ажлын байртай холбоотой бүх мэдээллийг хүлээж авдаг уу?

- ▷ Аюулгүй байдлын салбарын шинэчлэлийн бодлогод албан хаагчдыг халснаас үүсч болох нийгмийн үр дагаврын талаар тусгасан уу?

Цэргийн албанд сонгох, татах

- ▷ Бүх ажлын байр нь нийт иргэдэд (эмэгтэйчүүдийг оруулаад) нээлттэй байдаг эсэх, тийм бол тэр нь хуульчлагдсан эсэх?
- ▷ Аюулгүй байдлын албадын хүний нөөц бүрдүүлэх тогтолцоо нь нийт иргэдэд нээлттэй, эсвэл нийгмийн зөвхөн тодорхой хэсэгт үйлчилдэг хаалттай эсэх?
- ▷ Нэр дэвшигчдээс сонгоход мэргэжлийн шалгуур үзүүлэлтийг чухалчилдаг эсэх?
- ▷ Аюулгүй байдлын албадад нээлттэй ажлын байр олон байдаг эсэх?
- ▷ Ажилд орсны дараа удалгүй ажлаас гарах түвшин хэр өндөр вэ?

Албан хаагчдад чиглэсэн бодлого

- ▷ Албан хаагчдыг чадвар, чансаанд тулгуурлан ажилд авах, тушаал дэвшүүлэх зарчмыг бодитоор хэрэгжүүлдэг эсэх?
- ▷ Мэргэжлийн чадварын үнэлгээ тогтмол хийгддэг эсэх?
- ▷ Энэ тогтолцоо ил тод, бодитой, шударга эсэх?
- ▷ Аюулгүй байдлын албад сэтгэл татахуйц, ирээдүйтэй ажлын байр санал болгодог эсэх?
- ▷ Албан хаагчдыг цалинтай өөр ажил давхар эрхлэхийг хориглодог эсэх?
- ▷ Дээд түвшний удирдлага өөрөө бодит ажиллагааны туршлагатай, хилийн чанад дахь энхийн ажиллагаанд оролцдог эсэх?
- ▷ Зэвсэгт хүчний ерөнхий командлагч зэрэг дээд түвшний томилгоо хийхдээ батлан хамгаалахын сайд (эсвэл холбогдох бусад сайд) парламент буюу парламентын холбогдох хороотой зөвшилцдөг эсэх?

Цалин урамшуулал

- ▷ Албан хаагчдын цалин бусад ажил мэргэжилтэй харьцуулахад өндөр, хөдөлмөрийн зах зээл дээр хувийн аж ахуйн нэгжтэй өрсөлдөхүйц байж чаддаг эсэх?
- ▷ Цалинг цаг хугацаанд нь тавьдаг эсэх?
- ▷ Албан хаагчдын чадвар, чанарт тулгуурлан урамшуулал олгодог эсэх?
- ▷ Албан хаагчдын бодит гүйцэтгэл тэдний цалинд нөлөөлдөг эсэх?
- ▷ Цалин урамшууллын тогтолцоо нь хэрэглэгчид болон олон нийтэд ил тод байдаг эсэх?
- ▷ Тэтгэвэрийн тогтолцоотой холбоотой ямар асуудал байдаг вэ?
- ▷ Албан хаагчдын цалин тэтгэмжийн тухайд тэтгэвэрийн шаталбар шаардлага хангадаг эсэх? Албан хаагчид тэтгэвэрт гарснаар алдах зүйл бий эсэх?

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Аюулгүй байдлын албадын бие бүрэлдэхүүний чиг үүрэг, хэмжээ

- ▷ Зэвсэгт хүчинд ноогдуулсан чиг үүрэг болон бие бүрэлдэхүүний хэмжээ нь үндэсний эдийн засгийн нөөц бололцоотой дүйцэхүйц байх.

Аюулгүй байдлын албадын бие бүрэлдэхүүний цалин тэтгэмж

- ▷ Албан хаагчдын цалин нь эдийн засгийн хувьд тогтвортой байхын сацуу хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхүйц хэмжээтэй, боломжийн амьжиргаанд хангалттай байх.
- ▷ Цалин хөлсийг тогтмол олгодог байх.
- ▷ Цалин хөлс доогуур байх нь аюулгүй байдлын албадын сул тал болж, өндөр чадавхтай залуу боловсон хүчний сонирхлыг бууруулах эрсдэлтэйг анхаарах.
- ▷ Тодорхой нөхцөл байдалд цалин тэтгэмж хангалтгүй, тогтмол бус байх нь албан хаагчдыг авлига, улмаар сүрдүүлэг, хүчирхийлэл рүү түлхэх эрсдэлтэй.
- ▷ Аюулгүй байдлын албадын удирдлага, албан хаагчдын санхүүгийн давуу тал, онцгой эрх нь далд ашиг сонирхлыг төрүүлж, улс төрд нөлөөллөө тогтоох эрмэлзлийг аюулгүй байдлын албадад бий болгох хэмжээнд байх ёсгүй. Харин олон нийтэд ил, засгийн газрын бусад албан хаагчдад олгодог санхүүгийн дэмжлэг, давуу талтай тэнцвэртэй байх ёстой. Аюулгүйн албаны ажилтны эрх дарх нь гүйцэтгэх ажлын өвөрмөц, аюултай нөхцөл байдлын хэрэгцээнд тохирсон байх ёстой.
- ▷ Тэтгэвэрийн тогтолцоо шаардлага хангахуйц эсэхэд анхаарал хандуулах.

Бүлэг 27

Цэргийн үүрэг ба алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах

Бараг бүх орны Үндсэн хуулинд улс орноо батлан хамгаалах нь иргэн бүрийн үүрэг, ёс суртахууны хариуцлага гэж заасан байдаг. Зарим оронд тухайн улсын засгийн газраас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд иргэн бүр зэвсэгт хүчинд алба хаахад бэлэн байх албан үүргийг хуульчилсан байдаг. Иргэд (ихэвчлэн эрэгтэйчүүд)-ийн хугацаат цэргийн алба заавал хаах үүргийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байх нь олонтаа бөгөөд дараах асуудлыг хамарсан нэмэлт хуулиар мөн зохицуулагддаг байна:

- ✓ Цэргийн үүрэгт албыг хэн хаах ёстой
- ✓ Алба хаах хугацаа
- ✓ Хойшлуулах/чөлөөлөх үндэслэл
- ✓ Цэрэг татлагын ажиллагаа
- ✓ Цэрэг татлагаас зайлсхийсэн тохиолдолд оноох шийтгэл
- ✓ Насны дээд, доод хязгаар.

Түүнээс гадна, олон орны хуулинд зэвсэг агсахаас татгалзах эрх буюу итгэл үнэмшлийн дагуу татгалзах болон дүйцүүлэх албаны талаар оруулсан байдаг.

Хугацаат цэргийн албаны хэрэгцээ шаардлага, давуу тал

Олон оронд хугацаат цэргийн алба хэвээр байгаа. Үүний нэг гол шалтгаан нь хугацаат цэргийн албыг ардчилал, үндэсний соёлын чухал хэсэг гэж үздэгтэй холбоотой. Гэсэн хэдий ч дэлхийн өнцөг булан бүрт зэвсэгт мөргөлдөөний шинэ мөн чанартай холбогдуулан хугацаат цэргийн албаны хэрэгцээ шаардлага, давуу талын талаар маргаан өрнүүлэх болжээ. Хэд хэдэн оронд хугацаат цэргийн албыг халсан буюу ойрын хугацаанд халахаар төлөвлөж байгаа бөгөөд шинэ үеийн түүхэнд хугацаат албыг “бий болгосон” гэгддэг Франц Улс хүртэл 2001 онд уг албанаас татгалзжээ. Ойрын ирээдүйд олон хүнтэй арми гэж байхгүй болох ба оронд нь сайн дурын, цомхон, дэвшилтэт техник технологи, хөдөлгөөний өндөр чадвар бүхий арми бий болно гэсэн таамаг ч бий.

Тодруулга № 68

Дэлхийн улс орнуудын цэргийн алба

Алба хаах үүрэг: ихэнх оронд цэргийн албыг 18 наснаас эхэлж хаадаг боловч зарим тохиолдолд 16, 17, 19 эсвэл 20 гэсэн насны доод хязгаар бий. Өнөө үед зарим орон эмэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татдаг болсон.

Алба хаах хугацаа: ихэвчлэн 6 сараас 3 жил хүртэлх хугацаатай байдаг.

Алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах ба дүйцүүлэх алба: нийт улс орны тал хувь орчимд цэргийн алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах боломжтой бөгөөд дүйцүүлэх алба байдаг.

Ихэнх тохиолдолд, цэргийн алба хаахаас зайлсхийгчдэд хорих ял оноодог.

Эх сурвалж: Хорооны 1995/83 тогтоолын дагуу Ерөнхий нарийн бичгийн даргын тайлан.

НҮБХЭХ, 1997. E/CN.4/1997/99

Хугацаат цэргийн албаны эерэг ба сөрөг тал

Парламентын гишүүд хугацаат цэргийн албаны эерэг, сөрөг талуудыг судалж үзэхдээ дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй:

Хугацаат цэргийн албыг яагаад үргэлжлүүлэх ёстой вэ?

Хугацаат цэргийн албыг үргэлжлүүлэх үндэслэлүүд:

- ✓ Хугацаат цэргийн алба хаагчид нь нийгмийн гарал байдал, шашин шүтлэг, арьс өнгө ялгаварлалгүйгээр, зарим орны хувьд хүйс хамаарахгүйгээр нэгэн гараанаас эхэлж, цэргийн алба хаах үүрэг хүлээдэг учир түүнийг нийт иргэд (ихэвчлэн эрэгтэй)-ийн хуулиар хүлээсэн үүрэг, ёс суртахууны хариуцлага, улмаар ардчиллын нэгэн хэсэг гэж үздэг.
- ✓ Хугацаат цэргийн албан хаагчид нь дүрэмт хувцастай иргэд тул зэвсэгт хүчнийг “улсын доторх улс” болохоос урьдчилан сэргийлдэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл хугацаат албыг нийгэм ба зэвсэгт хүчний хоорондох гүүр гэхэд болно.
- ✓ Ерөнхийдөө хугацаат цэргийн албан хаагчдын хөлс сайн дурын армийн цалингаас бага байдаг учир зардлын хувьд хэмнэлттэй.
- ✓ Хугацаат цэргийн албанд нийгмийн бүх анги давхрага, нутаг усныхны төлөөлөл нэг дор цуглардаг. Тиймээс зэвсэгт хүчинд нягтлан бодогчоос эхлээд инженер, слесарь, фермер зэрэг олон төрлийн мэргэжил боловсрол, мэдлэг чадвар бүхий бүрэлдэхүүн орж ирдэг. Энхийн ажиллагаанаас эхлээд хямралын дараах орны дэд бүтэц, төрийн байгууллыг сэргээх зорилготой, хугацаат албан хаагчдын оролцох боломжтой олон ажиллагаанд зэвсэгт хүчин тэдний мэдлэг чадвар, хувь нэмрийг ашиглах боломжтой.

Хугацаат цэргийн албыг яагаад халах ёстой вэ?

Дэлхийн улс орнууд дахь хугацаат цэргийн албаны талаарх манай судалгаагаар олон хүнтэй арми, улмаар хугацаат албаны тогтолцоог халах дараах үндсэн шалтгаануудыг олж тогтоосон:

- ✓ Сүүлийн 25 жилийн хугацаанд, нэн ялангуяа Хүйтэн дайнаас хойш олон орны зэвсэгт хүчин цомхон болж, ингэснээр армид алба хаах шаардлагатай хугацаат цэргийн албан хаагчдын тоо буурсан (энэ нь заримдаа хугацаат албаны үүргийг ялгавартай ногдуулж буй талаар олон нийтийн шүүмжлэлийг дагуулах болсон). Тухайлбал, Евро-Атлантын бүсийн орнууд армийнхаа хэмжээг бууруулсан бол харин Африк, Азийн орнууд Хүйтэн дайны дараа армийн цомхотголоос олох “энх тайвны ноогдол ашиг”-аа харьцангуй бага хүртэж байна гэхэд болно.
- ✓ Зэвсэгт хүчин улам бүр мэргэжлийн чиг хандлагатай болохын хэрээр дэвшилтэт технологиос хамааралтай болж байна. Цэргүүд орчин үеийн цогцолбор зэвсгийн систем ашиглахын тулд урт хугацааны сургалтад хамрагдах шаардлагатай болсон. Хугацаат цэргийн албан хаагчид энэ түвшний чадвар эзэмшихүйц хугацаагаар алба хаадаггүй тул олон орны армид сайн дурын мэргэжлийн цэргүүд давамгайлах болсон байна.
- ✓ Энхийн ажиллагаанд цэргийн суурь чадвараас гадна хэлэлцээ хийх зэрэг нэмэлт ур чадвар шаардлагатай байдаг. Хугацаат цэргийн албан хаагчдын алба хаах хугацаа хэт богино тул хямралын дараах орнуудад нарийн төвөгтэй энхийг дэмжих ажиллагаанд оролцоход шаардлагатай түвшний чадвар, туршлагыг эзэмшиж чаддаггүй аж.
- ✓ Зарим орны Үндсэн хуулиар хугацаат цэргийн албан хаагчдыг зөвхөн өөрийн нутаг дэвсгэрийг хамгаалахад ашиглаж, харин хилийн чанадад илгээхийг хориглосон байдаг.

Тодруулга №69

Хугацаат цэргийн албан хаагчдад дарамт учруулах

Ихэнх армид хуучин, шинэ цэргүүдийн хооронд албан бус зэрэглэл оршдог. Хуучин албан хаагчид нь шинээр ирэгсдэд цэргийн дүрэм журам, уламжлалын талаар зааж сургадаг учир энэ тогтолцоо нь цэргийн нийгмийн хэв шинжид хувь нэмэр оруулах чухал ач холбогдолтой. Гэвч хуучин албан хаагчид шинэ цэргүүдийг хувийн сонирхлын үүднээс дарамтлах, өөрийн өмнөөс үүрэг даалгавар гүйцэтгүүлэх зэрэг тохиолдол мөн олон гардаг. Дээд тушаалын офицерууд сайтар хяналт тавиагүй тохиолдолд энэ нөхцөл байдал улам даамжирч, шинэ албан хаагчдыг дарамтлах, бие махбодийн гэмтэл учруулах, айлган сүрдүүлэх үзэгдэл газар авах эрсдэлтэй. Европын хугацаат цэргийн албаны зөвлөлийн мэдэгдсэнээр (EXCIA3), хугацаат цэргийн шинэ албан хаагчдад хамгийн түгээмэл нүүрлэдэг асуудал нь энэ бөгөөд зарим

тохиолдолд бие махбодийн ноцтой гэмтэл, улмаар үхэл, амиа хорлолтод хүргэдэг байна. Хугацаат албан хаагчдыг хамгаалах, цэргийн албаны нэр хүндийг хадгалах үүднээс дээд тушаалын офицерууд чанд хатуу хяналт тавих замаар дарамтаас урьдчилан сэргийлэх ёстой. Үүнээс гадна, дотоод болон гадаад хяналтын бүтцүүд нь онц ноцтой хэргийг хянан шийдвэрлэж, цэргийн албан дахь хуулийн засаглалыг эргүүлэн тогтоох ёстой.

Эх сурвалж: Илона Кисс, Энхийн үе дэх хугацаат цэргийн албан хаагчдын эрх, 2001

www.dcaf.ch болон ELIXA3 (Төв болон Зүүн Европын хугацаат цэргийн албан хаагчдын эрхийн Хар ном, 1996, <http://www.xs4all.nl/~ecco/>)-өөс үз

Цэргийн алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах (ИҮДТ) ба дүйцүүлэх алба

Зарим хүмүүсийн хувьд шашин (“чи хүний амь егүүтгэхгүй”) болон хувийн итгэл үнэмшил (хүчирхийллийн эсрэг) зэрэг ёс суртахууны хэм хэмжээний улмаас улс орноо батлан хамгаалах үүрэгтээ эргэлзэх явдал гардаг. Үүний улмаас төрийн үүрэг даалгаврыг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр ноцтой шийтгэл, тэр ч байтугай ялын дээд хэмжээ авах тохиолдол гардаг билээ.

Өнгөрсөн зууны сүүлийн хагаст итгэл үнэмшлийн дагуу зэвсэгт хүчинд алба хаах, зэвсэг агсахаас татгалзах эрхийн тухай үзэл санаа ихэд дэлгэрч, уг санааг хүлээн зөвшөөрөх болсон бөгөөд зарим оронд энэ эрхийг хуульчилсан байна. Энэ чиг хандлага зарим улс орон (Их Британи, Герман, Ирланд, Нидерланд, Бельги, Люксембург, Франц, Испани, Итали, Португаль) цэргийн үүрэгт албаас татгалзсантай давхцсан байна.

Зэвсэг агсах, цэргийн бэлтгэл, цэргийн албыг эсэргүүцэгч хүмүүсийг итгэл үнэмшлийн дагуу татгалзагчид гэж тодорхойлж болно. Бүх татгалзагчид итгэл үнэмшлийн дагуу шийдвэрээ гаргадаг хэдий ч шашин, гүн ухаан, улс төрийн харилцан адилгүй шалтгаантай байж болно.

Парламентын шийдвэр

ИҮДТ үзэгдэл улам бүр дэлгэрч буйтай холбогдуулан зарим орны парламентаас цэргийн үүрэгтнийг чухам ямар тохиолдолд энэ үүргээс нь чөлөөлөх асуудлыг хуульчилсан. АНУ, баруун Европын бүх орнууд болон хамгийн сүүлд Грек 1997 онд энэ жишгийг дагасан байна.

ИҮДТ-ыг хүлээн зөвшөөрдөггүй орнуудын хувьд ихэвчлэн тэдгээрийг цэргийн албанаас оргосон буюу эх орноосоо урван тэрсэлсэн гэх үндэслэлээр голдуу маш хүнд ял шийтгэл ногдуулдаг. Харин зарим оронд гэмт хэргийн тусгай зүйл анги (санаатайгаар тушаал биелүүлээгүй)-ийг цэргийн хууль тогтоомжид тусгасан байдаг.

ИҮДТ: Хэн, ямар үндэслэлээр шийддэг вэ?

ИҮДТ гэсэн ангилалд хамрагдахын тулд энэ итгэл үнэмшил тухайн хүнд хэрхэн бүрэлдэж бий болсон, түүний амьдралд хэрхэн нөлөөлсөн хийгээд энэ нь цэргийн албатай хэрхэн зөрчилдөж буй талаар тайлбар гаргах шаардлагатай байдаг. Цэргийн үүрэгтний эдгээр үндэслэлийг хүлээн авч, ИҮДТ ангилалд хамааруулах эрхийг хөдөлмөрийн яам (Швейцарь, Болгар), дотоод яам (Словени), эсвэл хууль зүйн яам (Хорват)-ны харьяа хороо шийддэг байна.

ИҮДТ бол хүний эрх

НҮБ-ын Хүний эрхийн хорооноос 1998/77 тоот тогтоолдоо тусгасан зарчмуудын дагуу 2000 оны 4 дүгээр сард 2000/34 тоот тогтоолыг санал хураалтгүйгээр баталсан. Уг тогтоолд хувь хүн итгэл үнэмшлийнхээ дагуу цэргийн алба хаахаас татгалзах нь Хүний эрхийн түгээмэл тунхаг болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад дурдсан чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ хууль ёсны дагуу эдэлж буй хэрэг болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Өмнө нь буюу 1993 онд НҮБ-ын Хүний эрхийн хороо “үхлийн аюултай хүч хэрэглэх нь чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй ноцтой зөрчилдөж буй” учир ИҮДТ нь Пактын 18 дугаар зүйлээс урган гарсан эрх гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Улмаар тус хорооноос “Энэ эрхийг хуулиар болон практик амьдрал дээр хүлээн зөвшөөрсөн бол итгэл үнэмшлийнхээ дагуу цэргийн алба хаахаас татгалзагч этгээдийн итгэл үнэмшлийн мөн чанарын хооронд ялгаа байхгүй бөгөөд үүний нэгэн адил ухамсраараа татгалзаж буй этгээдийн эсрэг цэргийн алба хаах үүргээ гүйцэтгээгүй гэх үндэслэлээр ялгаварлан гадуурхах явдал гаргаж үл болно” хэмээн тэмдэглэсэн байна.

Тодруулга №70

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1998/77 тоот тогтоол: Цэргийн алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах нь

Хороо нь, (...)

Хүний эрхийн түгээмэл тунхаг болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй, аюулгүй байх, чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх, ялгаварлан гадуурхах аас ангид байх эрхтэй хэмээн тунхагласныг анхаарч, (...)

Цэргийн албанаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах нь шашин, ёс суртахуун, ёс зүй, хүмүүнлэгийн болон бусад ижил төстэй шалтгаанаас үүдэлтэй гүн гүнзгий итгэл үнэмшил зэрэг ухамсрын зарчим ба шалтгаанаас үүдэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, (...)

1. Цэргийн алба хаахаас итгэл үнэмшлийн дагуу татгалзах эрх нь хүн бүрийн

Хүний эрхийн түгээмэл тунхагийн 18 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 18 дугаар зүйлд тус тус тунхагласан чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө хууль ёсоор эдэлж буй хэрэг гэдэгт анхаарал хандуулж;

2. Зарим орон итгэл үнэмшлийн дагуу татгалзах явдлыг үндэслэлтэй хэмээн үзэж, аливаа эргэлзээгүйгээр хүлээн зөвшөөрдөг жишгийг талархаж;

3. Тухайн тохиолдолд итгэл үнэмшлийн дагуу татгалзаж буй нь үндэслэлтэй эсэхийг тогтоох бие даасан, хараат бус, шийдвэр гаргах байгууллага байхгүй улс орнуудад хандан, итгэл үнэмшлийн дагуу цэргийн албанаас татгалзагчдыг тухайн хүний итгэл үнэмшлийн мөн чанараас үүдэн ялгаварлан гадуурхахгүй байх шаардлагыг харгалзан ийм байгууллага бий болгохыг уриалж;

4. Итгэл үнэмшлийн дагуу татгалзагчдад зориулан тэдний татгалзаж буй үндэслэлтэй нь зөрчилдөхгүй, байлдааны бус, иргэний шинжтэй, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, шийтгэлийн бус чанартай дүйцүүлэх албыг бий болгох тухай зөвлөмжөө цэргийн үүрэгт албатай боловч дээрх тогтолцоог хараахан нэвтрүүлээгүй байгаа орнуудад сануулж;

5. Улс орнууд итгэл үнэмшлийн дагуу татгалзагчдыг цэргийн үүрэг биелүүлээгүй гэх үндэслэлээр хорих, ял шийтгэлийг давтан оноохгүй байх бүх арга хэмжээ авах ёстойг онцлон тэмдэглэж, аливаа хувь хүн тухайн Улсын холбогдох хууль тогтоомж, байцаан шийтгэх ажиллагааны дагуу нэгэнт шийтгэгдсэн хэргийнхээ төлөө дахин ял эдлэх ёсгүй гэдгийг сануулж байна; (...).

1998/77 тоот тогтоол, НҮБХЭХ

Дүйцүүлэх алба

ИҮДТ-ыг хүлээн зөвшөөрөгч ихэнх улсад цэргийн дүйцүүлэх албыг хуулиар тодорхойлсон байдаг. Энэхүү дүйцүүлэх алба нь дараах хоёр хэлбэртэй байж болно:

- ✓ Зэвсэгт хүчинд зэвсэг агсалгүйгээр алба хаах;
- ✓ Эмнэлэг, асрах төв, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төв, нийгмийн халамжийн байгууллагууд болон зарим тохиолдолд ТББ болон засгийн газар хоорондын байгууллагад ажиллах.

Дүйцүүлэх албаны үргэлжлэх хугацаа ихэвчлэн цэргийн алба хаах хугацаанаас урт байдаг. Жишээ нь, Францад цэргийн алба 10 сар байхад дүйцүүлэх алба 20 сар; Австрид цэргийн алба 7 сар байхад дүйцүүлэх алба 12 сар; Болгарт цэргийн алба 6-9 сар байхад дүйцүүлэх алба 24 сар байдаг байна.

Тодруулга №71

Дүйцүүлэх алба: Швейцарийн жишээнээс

Швейцарь бол өнөөг хүртэл хугацаат цэргийн албыг үргэлжлүүлж буй баруун Европын цөөн орны нэг. Хугацаат цэргийн алба нь Үндсэн хууль (59.1 дэх зүйл) болон 1995 оны Цэргийн байгууллагын тухай хууль, мөн 1995 оны Цэргийн албаны тухай хуулиар зохицуулагддаг. Цэргийн алба нь 20-42 насны, дээд албан тушаалын хувьд 55 хүртэлх насны бүх эрэгтэйчүүдийг хамрах ба цэргийн албаны үндсэн хугацаа 4 сар, дээр нь 2 жил тутамд 3 долоо хоног ба мөн жил тутам буудлагын дасгал хийдэг байна.

Дүйцүүлэх албаны тухай 1996 оны хуулиар ёс зүй, ёс суртахуун - үзэл бодол болон шашны итгэл үнэмшлийн дагуу цэргийн албанаас татгалзах эрхийг хуульчилсан. Аж үйлдвэр, Хөдөлмөрийн яам энэ төрлийн хүсэлтийг хүлээн авах бөгөөд сонины зарын дагуу бүртгүүлсэн 120 комиссараас сонгож авсан гурван хүний бүрэлдэхүүнтэй хороо эцсийн шийдвэрийг гаргадаг. Цэргийн үүргийн насны нийт иргэдийн 5 орчим хувь нь ИҮДТ гэсэн ангилалд хамаардаг байна. ИҮДТ гэсэн ангилалд хамрагдах хүсэлт нь батлагдаагүй байхад цэргийн албанаас татгалзсан этгээдийг 4-5 сарын хорих ялаар шийтгэдэг аж.

ИҮДТ нь цэргийн албаны оронд энгийн алба хаших үүрэг хүлээдэг. Ингэхдээ олон нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн ямар ч байгууллагад 450 хоног алба хаах боломжтой бөгөөд үүнд эмнэлэг, хүүхдийн төв, их дээд сургуулийн судалгааны төв, ой үржүүлгийн газар зэрэг багтаж болно.

*Эх сурвалж: Итгэл үнэмшлийн дагуу татгалзах асуудал эрхэлсэн Европын товчоо (EBCO),
Парламентын гишүүний хувьд та юу хийж чадах вэ*

Хугацаат цэргийн алба байх эсэх?

- ▷ Өөрийн орны онцлогтой холбогдуулан бүх давуу, сул талыг нарийвчлан дэнслэх.
- ▷ Үүнтэй холбогдуулан, энэ бүлэгт дурдсан асуудлуудыг судалж, өөрийн орны онцлог нөхцөлд хэр ач холбогдолтой болохыг дүгнэх.

Хугацаат цэргийн албан хаагчдыг дарамтлах, зүй бусаар харьцах асуудлаар

- ▷ Хугацаат цэргийн албан хаагч хүчирхийлэл, дарамтад өртсөн мэдээллийн дагуу түргэн шуурхай арга хэмжээ авах.
- ▷ Нарийвчилсан хянан шалгах ажиллагаа явуулах, шаардлагатай үед эрх бүхий байгууллагаас зохих шийтгэлийг цаг алдалгүй ноогдуулахад анхаарах.
- ▷ Танай оронд батлан хамгаалахын омбудсмэний бүтэц байдаггүй бол хугацаат цэргийн албан хаагчдыг дарамтлах, зүй бусаар харьцах асуудлыг шийдэх зорилгоор эрх бүхий ийм байгууллага байгуулах асуудлыг судалж үзэх, санал болгох.

ИҮДТ-ын статус

- ▷ Өөрийн улс оронд ИҮДТ-ын эрх зүйн байдлыг судалж үзэх, шаардлагатай тохиолдолд статусыг хуулиар тодорхойлох эсвэл хуучин хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авах.
- ▷ Энэ асуудлаар бусад улс орны туршлага, хууль эрх зүйн болон бодит зохицуулалтын талаар шинэ мэдээлэл олж авах.

Дүйцүүлэх алба

- ▷ Танай оронд дүйцүүлэх албыг хуульчилсан эсэх, шаардлагатай бол энэ асуудлыг хуульчлах, эсвэл хуучин хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах.
- ▷ Энэ асуудлаар бусад улс орны туршлага, хууль эрх зүйн болон бодит зохицуулалтын талаар шинэ мэдээлэл олж авах.

Наймдугаар хэсэг

Материаллаг нөөц:

Зэвсэг техникийн нийлүүлэлт, худалдан авалтад үр
дүнтэй хяналт тавих

Зэвсэг техник худалдан авах ажиллагаа

Худалдан авах ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, батлан хамгаалах стратеги зэрэг “дээд түвшний” төлөвлөгөө, бодлогод суурилсан байх ёстой. Шинэ зэвсэг, цэргийн тоног төхөөрөмж худалдан авах хэрэгцээг бүхэлд нь үндэсний аюулгүй байдлын бодлоготой хэрхэн уялдаж, ямар нөлөө үзүүлж байгаагаар үнэлэх нь зүйтэй.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь батлан хамгаалахын менежментэд тогтвортой байдал бий болгох, урт хугацааны батлан хамгаалах бодлогыг таамаглах боломжийг нэмэгдүүлнэ. Үндэсний батлан хамгаалах бодлогын зорилтуудыг батлан хамгаалах салбарт хуваарилсан төсөв хөрөнгөтэй уялдуулж, улмаар батлан хамгаалах салбар болон нийгмийн хэрэгцээний тэнцвэрийг хадгалах нь нэн чухал.

Зэвсэг техникийн худалдан авах ажиллагааны ил тод байдал

Аливаа төлөвшсөн ардчилалд төсөв боловсруулах ажиллагаа, үүний дотор зэвсэг техник худалдан авах ажиллагаа нь олон нийтэд ил тод, хариуцлагатай байх ёстой. Олон нийтийн өмнө хариуцлага хүлээх үүднээс авч үзвэл бодлого, төлөвлөгөө, төсвийн болон зэвсэг техникийн худалдан авалтын хооронд зохистой уялдаа байх ёстой. Харамсалтай нь ихэнх оронд зэвсэг техник худалдан авах ажиллагаан дахь парламентын оролцоо хязгаарлагдмал, зарим тохиолдолд байхгүйтэй адил байдаг.

Зэвсэг техник худалдан авах ажиллагаанд зориулж төсөв хуваарилах эсвэл ийм ажиллагааг батлахдаа парламент уг ажиллагаа хуульд нийцэж буй эсэх, нэн ялангуяа зарим тодорхой төрлийн зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалтад тавигдсан хоригийг анхаарах ёстой. Тухайлбал, Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ (1968), Явган цэрэг эсэргүүцэх мина хэрэглэх, нөөцлөх, үйлдвэрлэх, шилжүүлэхийг хориглох, түүнийг устгах тухай Оттавагийн конвенц (1997), НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн холбогдох тогтоолууд зэрэг олон улсын зохицуулалад нийцэж буй эсэхэд анхаарал хандуулах нь чухал.

Түүнчлэн гол төрлийн зэвсэг техникийн үнэ өртгийг олон жилээр тооцоолох төвөгтэй асуудалтай парламент тулгардаг. Үүний улмаас, нэн ялангуяа хямралын дараах буюу хөгжиж буй орнууд гадаад, дотоодын зэвсгийн наймаачдын аманд унах нь их. Зэвсэг нийлүүлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг хамгийн өндөр үнээр зарж борлуулахыг эрмэлздэг бөгөөд тэдэнд ардчилсан хяналтын шаардлага огт хамаагүй гэдэг нь ойлгомжтой.

Эдгээр шалтгааны улмаас улс орны парламентууд зэвсэг техникийн худалдан авалтын асуудлыг хариуцсан хороо буюу дэд хороог тусгайлан байгуулах сонирхолтой байдаг. Ингэснээр зэвсэг техникийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг сайжруулахын зэрэгцээ гүйцэтгэх засаг олон нийтийн өмнө хариуцлага хүлээхэд дэмтэй.

Парламентад тулгардаг нэг бэрхшээл бол засгийн газар өөрийн эзэмшилд буй болон худалдан авах шаардлагатай гол нэрийн ердийн зэвсэглэл (нисэх онгоц, хуягт техник, артиллерийн зэвсэг, чиглүүлэгч болон радарын систем, пуужин, байлдааны хөлөг онгоц)-ийн талаар мэдээлэл өгөхдөө хойрго ханддаг бөгөөд тэр тусмаа жижиг, хөнгөн зэвсэглэл гэж нэрлэгддэг бага оврын зэвсгийн (100 мм буюу түүнээс бага калибрын) талаарх мэдээллийг олон нийтэд ил болгохоос бүр ч илүү цааргалдаг явдал.

Уг нь хамгийн боломжит хувилбар бол зэвсэг техникийн худалдан авах ажиллагаа эхлэхэд засгийн газар парламенттай хамтран ажиллаж, хэт ихэд санаархсан худалдан авалт алс хэтдээ улс орныг санхүүгийн дарамтад оруулах явдлаас зайлсхийх явдал юм. Зэвсэг техник худалдан авах ажиллагааг олон нийтийн бусад ашиг сонирхолтой ямагт харьцуулж ойлгох нь зүйтэй. Тиймээс шийдвэр гаргах ажиллагаанд зөвхөн цэргийн бус, харин бусад салбарын тэргүүлэх чиглэлүүд ч чухал. Парламент нь зэвсэг техник худалдан авалтын нийгэмд үзүүлэх нөлөө, санхүүгийн дарамтыг үнэлж үзэх ёстой.

Тодруулга №72

Парламентын гишүүд яагаад зэвсэг техник худалдан авах ажиллагааг анхаарах ёстой вэ?

- ▷ Төрийн өмч хөрөнгөөр худалдан авдаг;
- ▷ Зэвсгийн системийн талаар шийдвэр гаргах нь зөвхөн техникийн мэргэжлийн болон аюулгүй байдлын асуудал төдий бус, харин мөнгийг “буу эсвэл талхны” алинд зарцуулах, хэрэв ‘буу’ гэвэл ямар зэвсэг, хэдий хэмжээний мөнгө, яагаад зарцуулах вэ гэдэгтэй холбоотой.
- ▷ Зэвсэг техник худалдан авах ажиллагаа нь улс оронд урт болон богино хугацаанд санхүүгийн дарамт учруулах ёсгүй (нийт ашиглалтын хугацааны зардлыг мөн оруулна);

- ▷ Парламентын хяналт нь зэвсгийн зардлыг нийгмийн бусад салбарын хэрэгцээ шаардлагатай тэнцвэржүүлэх ёстой.
- ▷ Парламентын хяналтын дор явагдах зэвсэг техник худалдан авах ил тод ажиллагаа нь авлига, үр ашиггүй зардал, төрийн өмч хөрөнгийг шамшигдуулахаас зайлсхийх боломж олгоно.
- ▷ Парламентын болон олон нийтийн хяналт байх нь бүс нутгийн зэвсгийн наймааг сааруулахад тус дөхөм үзүүлж болно.

Онцгой нөхцөл байдал нууцлалыг зөвтгөх үндэслэл болж чадах уу?

Төрийн бодлого боловсруулах бүх ажиллагаа, нэн ялангуяа зэвсэг борлуулах хийгээд худалдан авах ажиллагаа нь ил тод байдлыг оролцуулан сайн засаглалын зарчимд захирагдах ёстой. Тиймээс, ямар онцгой нөхцөл байдал батлан хамгаалахын шийдвэр гаргах ажиллагааг тусгаарлаж, нууцлахыг зөвтгөх үндэслэл болж чадах талаар судлаж үзэх хэрэгтэй.

Зэвсэг техник борлуулах, худалдан авах ажиллагаа нь ил тод байдал, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх зарчим дээр тулгуурлах ёстой. Хүлээн авагч эсвэл борлуулагч орноос шаардаж буй нууцлалын үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарласан байх шаардлагатай. Хэрэв нууцлалын улмаас тухайн ажиллагааг гүйцэтгэх явцад авлигын хэрэг үүсэх магадлалтай бол талууд энэ эрсдлийг хамтран тодорхойлж, түүнээс зайлсхийх арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой.

Тодруулга №73

Зэвсэг техник худалдан авах бодлого хэт сул, тодорхойгүй, эсвэл эсрэгээр хэт хаалттай байхын үр дагавар ...

- ▷ Зэвсгийн систем худалдан авах ажиллагааны үндэслэл шаардлагыг хангалтгүй судлах;
- ▷ Засгийн газрын шийдвэр алдаа дутагдалтай байснаас үндэсний болон бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх;
- ▷ Хөрш орнуудад хардлага төрүүлэх;
- ▷ Зэвсэг техникийн худалдан авалт болон цэргийн салбартай холбоотой бүх төрлийн худалдан авах ажиллагааны шийдвэр авлигад автах;
- ▷ Зэвсэгт хүчинд үзүүлэх олон нийтийн итгэл ноцтойгоор алдагдаж зэвсэгт хүчний нэр хүнд буурч, үл ойлголцол үүсэх.

Худалдан авах ажиллагааны цогц шийдвэр

Томоохон зэвсгийн систем худалдан авах тохиолдолд шийдэр гаргах ажиллагаанд дараах асуудал, холбогдох аргачлалыг тусгах нь зүйтэй:

- ✓ Аюул заналын үнэлгээ;
- ✓ Батлан хамгаалах чадавх бэхжүүлэх урт хугацааны үзэл баримтлал;
- ✓ Шинэ зэвсгийн бодит хэрэгцээ шаардлага;
- ✓ Зэвсэг техник худалдан авах төсвийн хуваарилалт;
- ✓ Техникийн чанарын баталгаа болон худалдан авалтын дараах ажиллагааны аудит;
- ✓ Засвар үйлчилгээ, шинэчлэл зэргийг оруулаад ашиглалтын нийт хугацааны зардал;
- ✓ Үнийн санал, төлбөр тооцооны үнэлгээ.

Эдгээр бүх үе шатанд парламентын хяналт тогтоосноор гүйцэтгэх засгийн шийдвэр гаргах ажиллагаанд үргүй зардал, луйвар, эрх мэдлээ урвуулан ашиглах явдал гарах эрсдлийг бууруулна. Хяналтын чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд парламент зэвсэг техник худалдан авах ажиллагааны бүхий л үе шатанд мэдээллээр хангах шаардлагыг засгийн газарт тавих нь зүйтэй. Цаашилбал, зэвсэг техник худалдан авах гэрээг шийдэх эрх парламентад байх ёстой. Зэвсэг техник худалдан авах ажиллагааны бүх үе шатанд хууль тогтоогчийн зүгээс тавих хяналтын нэг жишээ нь Нидерландын парламент юм (Тодруулга N°74-ийг үз).

Тодруулга N°74

Нидерланд: батлан хамгаалах салбарын худалдан авалтын бодлого ба парламентын хяналт

Нидерланд улс зэвсэг техник худалдан авах ажиллагаанд парламентын зүгээс хатуу чанд хяналт тавих он удаан жилийн туршлагатай. Ерөнхийдөө, 25 сая евро (ойролцоогоор 25 сая ам.доллар)-оос дээш үнийн дүн бүхий худалдан авалтын бүх шийдвэр парламентаар дамжиж гардаг. Үүнийг худалдан авах журам гэгч аргаар гүйцэтгэдэг. Засгийн газар (буюу төсвийн багцад нь батлан хамгаалах өмч хөрөнгө багтдаг Батлан хамгаалахын төрийн нарийн бичгийн дарга) худалдан авалтын үе шатаас хамааран дөрвөн төрлийн (А, В, С болон D) аль нэгийг сонгосон албан бичиг явуулна. Товчоор хэлбэл, эдгээр үе шат нь шинэ зэвсгийн системийн (эсвэл өнөөгийн системийн дараагийн хувилбар) хэрэгцээ шаардлагаас эхлээд үйлдвэрлэгч Y-ээс зэвсгийн X системийг худалдан авах тодорхой санал хүртэл үргэлжилнэ.

Парламент дээрх худалдан авах үе шат бүрийн шийдвэрт нөлөөлөх эрхтэй. Тухайлбал, засгийн газар шинэ худалдан авалт хийх, эсвэл хуучныгаа шинэчлэх байр суурь илэрхийлэхэд (эсвэл худалдан авах системийн тоог

санал болгоход) парламент татгалзах буюу өөрчлөлт оруулах боломжтой. Худалдан авалтын эцсийн шийдвэрийг мөн эсэргүүцэх буюу өөрчлөх боломжтой хэдий ч амьдрал дээр энэ нь тэр болгон тохиолддоггүй. Ихэнхдээ худалдан авах ажиллагааны явцад засгийн газрын төлөвлөгөөнд өмнө дурдсан 4 үсэг (А, В, С болон D) нөлөөлдөг ба тухай бүрийг нь парламент хэлэлцэн шийдвэрлэнэ.

Үүний дүн нь 100 сая евро давсан томоохон төслүүдийн хувьд тусгай журам (Том төслүүд) нэвтрүүлсэн бөгөөд илүү дэлгэрэнгүй, илүү өндөр давтамжтайгаар парламентад тайлагнадаг байна. Үүний нэг жишээ бол F-16 загварын сөнөөгч онгоцны халаа америкийн Joint Strike байлдааны нисэх онгоц боловсруулах ажилд оролцох тухай Нидерландын засгийн газрын санал юм. Air Mobile Brigade зэрэг том төслүүдийг мөн дурдаж болно.

Ерөнхийдөө Нидерланд дахь өнөөгийн нөхцөл байдал шаардлага хангахуйц түвшинд байна хэмээн дүгнэж болно. Нарийн ширийн, техникийн шинжтэй энэ ажиллагааг парламент ийнхүү нарийвчлан хянаж шалгахын учир утга, санхүүгийн босгын талаар яриа хэлцэл байнга явагдаж байдаг ажээ. Энэ хүрээнд, засгийн газрын мэдээллийн чанар хийгээд хараат бүс байдал, батлан хамгаалах судалгааны хараат бүс хүрээлэнгээс гаргах “сөрөг нотолгооны” хэрэгцээ шаардлага зэрэг асуудал босдог байна. Эцэст нь, батлан хамгаалах аж үйлдвэрийн салбар, лоббичдийн үүрэг роль болон тэд парламентын батлан хамгаалах хорооны гишүүдтэй шууд харилцах эсэх талаар багагүй яригддаг. Гэхдээ одоогийн байдлаар үүнтэй холбоотой ноцтой хэрэг, дуулиан шуугиан гарч байсан удаагүй.

Эх сурвалж: Ян Хойкэма, Парламентын гишүүн асан, Нидерланд, 2002

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Зэвсэг техник худалдан авах ажиллагааг хянах нь

- ▷ Зэвсэг техник худалдан авах ажиллагаанд тавих хяналтыг хуульчлах шаардлагатай.
- ▷ Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналт нь цогц бөгөөд худалдан авах ажиллагааг бүх талаар хамарч чадаж байгаа эсэхэд санаа тавих, ингэхдээ дараах асуудлуудад анхаарах:
 - Аюулгүй байдлын хэрэгцээ шаардлага;
 - Бүс нутаг дахь улс төрийн үр дагавар буюу сөрөг хариу үйлдэл дагуулж, бүс нутагт зэвсэглэлийн өрсөлдөөн бий болох;
 - Төсвийн дарамт (богино болон урт хугацааны);
 - Дотоодын төрийн болон хувийн хэвшлийн аж үйлдвэрт үзүүлэх нөлөө.

Зэвсэг техник худалдан авах ажиллагааны ил тод, хариулагатай байдал

- ▷ Зэвсэг, цэргийн техник худалдан авах ажиллагаанд парламентын оролцоог хангах.
- ▷ Парламент буюу асуудал хариуцсан парламентын хороо нь зэвсэглэлд буй гол төрлийн зэвсэг техник (нисэх онгоц, хуягт техник, артиллерийн зэвсэг, чиглүүлэгч болон радарын систем, пуужин, байлдааны хөлөг онгоц) болон жижиг зэвсэглэл (100 мм буюу түүнээс бага калибрын), тэдгээрийн техникийн чанар байдал болон шинээр худалдан авах хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээлэл авдаг байх шаардлага тавих.
- ▷ Парламент батлан хамгаалах чадавх бэхжүүлэх урт хугацааны үзэл баримтлалтай танилцаж байх.
- ▷ Зэвсэг техникийн худалдан авах ажиллагааны гэрээний нууцлалтай холбоотой асуудлыг парламент эсвэл эрх мэдэл бүхий парламентын хороо хуулийн дагуу шийдвэрлэж байх. Чингэхдээ хариулагатай байдал болон цэргийн нууцын аль алийг нь хангахад анхаарах.

Худалдан авалтын нөлөөллийн шинжилгээ

- ▷ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө аюулгүй байдлын бодлоготой нийцэж буй эсэхийг судлах.
- ▷ Улс орны хөгжил, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор парламент нь зэвсэг техникийн худалдан авалтаас үүдэх санхүүгийн дарамтыг олон нийтийн бусад эрх ашиг, нийгмийн тэргүүлэх чиглэлтэй харьцуулан судлаж үздэг байх.
- ▷ Хэт ихийг санаархсан зэвсэг техникийн худалдан авалтыг парламентаас зогсоож байх. Мөн алс хэтдээ улс оронд цэргийн дарамт үүсгэхгүй байхаар төлөвлөгөөний зохист байдлыг хангах ёстой.

Худалдан авах ажиллагааны аудит

- ▷ Батлан хамгаалах бодлого болон төлөвлөгөө, батлан хамгаалах төсөв болон зэвсэг, цэргийн техникийн бодит зардлын хоорондын уялдаа холбоог хянах.
- ▷ Гэрээ хэрэгжсэний дараа зэвсгийн системийн ажиллагаанд худалдан авалтын дараах аудит хийх (зэвсгийн ашиглалтын нийт хугацаанд дор хаяж гурван үзүүлэлт/үе шаттайгаар)

Худалдан авах ажиллагаанд тавих парламентын хяналт

- ▷ Зэвсэг техник худалдан авах ажиллагаа хариуцсан хороо буюу дэд хороо байхгүй тохиолдолд тийм хороо байгуулах санаачилга гаргаж, бодлогын төлөвлөлт, санхүүгийн төлөвлөлт болон аудит, батлан хамгаалах аж үйлдвэр ба судалгаа боловсруулалтын ажлын уялдаа холбооны ач холбогдлыг нэмэгдүүлэх.
- ▷ Үүнтэй холбогдуулан, бусад орны парламентын үйл ажиллагаа, үр дүнгийн талаар судлах, мэдээлэл цуглуулах.
- ▷ Танай улсын парламент мэргэжлийн зөвлөгөө авах, түүнийгээ ашиглах чадвартай эсэхэд анхаарах.

Зэвсгийн наймаа болон нийлүүлэлт

Зэвсгийн наймаа болон нийлүүлэлтэд тавих хяналтад парламент нэн чухал үүрэгтэй. Зэвсэг техникийн худалдан авах ажиллагааны зохицуулалт нь худалдан авах ажиллагаа, төсөв санхүү, гэрээ, маргаан шийдвэрлэхтэй холбоотой дотоодын хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Зэвсгийн худалдаа, нийлүүлэлтийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалт нь ил тод, хариуцлагатай байдлын зарчмуудад тулгуурлах ёстой.

Тодруулга №75

Зэвсэг нийлүүлэх: тодорхойлолт

Зэвсэг нийлүүлэх гэдэгт зэвсэг авах буюу зарах чиглэлээр улсын болон хувийн хэвшлийн тоглогчдын явуулж буй бүх ажиллагааг хамруулан ойлгоно. Үүнд, зэвсэг борлуулах, арилжих, худалдан авах болон хандивлах зэрэг бүх ажиллагаа багтана.

Зэвсгийн худалдаа, нийлүүлэлтийн талаарх үндэсний бодлого

Засгийн газар зэвсгийн худалдааны бодлого, хууль тогтоомжийг боловсруулан, парламентад өргөн барьж батлуулах ёстой. Уг бодлогод ердийн зэвсгийн худалдааны суурь зарчмуудыг тусгахын зэрэгцээ дараах асуудлыг анхаарах нь чухал:

- ✓ Ердийн зэвсгийн импорт, экспорт нь парламентын холбогдох хорооны хяналт дор явагдах ёстой;
- ✓ Зэвсгийн худалдааны зохицуулалтууд нь НҮБ-ын дүрэм, олон улсын хууль тогтоомж, НҮБ-ын зэвсгийн хоригтой нийцэж байх ёстой бөгөөд зэвсэг худалдан авагч орны эдийн засаг, улс төр, ёс зүй, аюулгүй байдлын асуудлуудыг харгалзсан байх ёстой;
- ✓ Шалгалт хийх нөхцөл бололцоо, мэргэжлийн хариуцлагатай байдлыг хангахын тулд шийдвэр гаргах ажиллагаанд ил тод байдлын зарчмыг баримтлах.

- ✓ Ёс зүйгүй худалдааны ажиллагаанаас урьдчилан сэргийлэх тогтолцоог НҮБ-ын зөвлөмж, бусад улс орны тэргүүн туршлагад тулгуурлан хуульчлах; нийлүүлэгч болон хүлээн авагч шударга байдлын дүрмийг хамтран боловсруулж, баримтлах.
- ✓ Парламент нь худалдаалж буй зэвсгийн мөн чанар, төрөл нь хүлээн авагч орны парламентаас баталсан батлан хамгаалахын жинхэнэ хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих боломжтой байх ёстой.
- ✓ Зэвсэг нийлүүлэгч орны парламент нь хүлээн авагч орон хүний эрх, үндсэн эрх чөлөөг дээдэлдэг бөгөөд зэвсэг техникийн худалдан авах ажиллагаандаа үр дүнтэй хариуцлагын тогтолцоо нэвтрүүлсэн эсэхийг баталгаажуулах боломжтой байх ёстой.

Зэвсгийн худалдаа нь бүс нутгийн энх тайванд сөргөөр нөлөөлж, хямрал, зэвсэгт мөргөлдөөнийг даамжруулах, бүс нутагт зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг дэгдээх, тогтвортой байдал алдагдуулах зэвсгийн систем нэвтрүүлэх эсвэл жижиг, хөнгөн зэвсэглэлийн тоонд ноцтой өөрчлөлт гарснаар бүс нутагт тогтворгүй байдал үүсгэх зэрэг үр дагавар авчрахгүй гэдгийг парламент баталгаажуулах чадвартай байх ёстой бөгөөд хэрэв парламентын батлан хамгаалах асуудал хариуцсан хороо бүс нутгийн тогтвортой байдалд учирч буй эрсдлийн асуудлаар бүс нутгийн яриа хэлцэл эхлүүлбэл авлига, хээл хахууль дагуулсан хэт их хэмжээний худалдан авалт, түүнийг тойрсон нууцлалын асуудал бүс нутгийн хэмжээнд нээлттэй болно.

- ✓ Тухайн улсад худалдсан зэвсгийг цааш дахин экспортлох эсвэл импортын гэрчилгээнд заасан зориулалтыг өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох.

Парламент нь хуулиар олгосон эрх бүхий бие даасан аудитын бүтэц бий болгох замаар үндэсний зэвсгийн худалдааны ажиллагаанд хараат бус хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх ёстой бөгөөд энэ ажиллагаа нь парламентаас тогтоосон зарчим, дүрэм журмын дагуу явагдана. Тодруулга N°76-д улс орны зэвсгийн худалдааны талаарх бодлоготой холбоо бүхий олон улсын гэрээ хэлэлцээр, ёс зүйн дүрмийн жишээг харуулсан болно.

Тодруулга N°76

Зэвсэг техник нийлүүлэх талаарх бүс нутгийн гэрээ хэлцлүүд

▷ Европын ёс зүйн дүрэм

Европын холбооны зөвлөлөөс Европын ёс зүйн дүрэм батлах тухай тогтоолыг 1998 оны 6 дугаар сарын 8-ны өдөр гаргасан. Европын холбооны гишүүн орнууд хүний эрхийн ноцтой зөрчил гарч байх магадлалтай, тогтворгүй бүс нутгуудад зэвсэг наймаалахаас урьдчилан сэргийлэхэд энэ тогтоолын

зорилго оршиж байв. Зэвсгийн худалдаанд хариуцлагатай хандах бодлого баримтлахыг хэд хэдэн төрийн бүс байгууллага 8 жилийн турш шахалт үзүүлсний дүнд Европын холбооны гишүүн орнууд энэ шийдвэрийг гаргажээ. Энэхүү дүрэмд эргэлзээтэй улс орнуудын жагсаалт, ашиглалтын эцсийн зориулалтыг хянан шалгах тогтолцоо болон зэвсгийн экспортын тусгай зөвшөөрөл олгох эсвэл татгалзах асуудлаар харилцан мэдээлэл солилцох ба зөвлөлдөх тогтолцоог тодорхойлсон байна.

Европын ёс зүйн дүрмийг гишүүн орнууд заавал дагаж мөрдөх эрх зүйн үүрэггүй бөгөөд дагаж мөрдөөгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоо байхгүй. Тиймээс хүний эрх зөрчигчдөд зэвсгийн экспорт хийхийг хязгаарласан экспортын илүү хатуу чанд хууль тогтоомжтой байх, хоёр талын уулзалт зөвлөлдөөнөөр дамжуулан шахалт үзүүлэх эсэх нь гишүүн орнуудын үзэмжийн асуудал юм.

Уг дүрэмд зэвсгийн экспортын үед гишүүн орнуудын харгалзаж үзэх ёстой найман шалгуур үзүүлэлт бий. Үүнд:

- 1) “Европын холбооны гишүүн орнуудын олон улсын үүрэг амлалт, тэр дундаа НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тогтоосон хоригийг хүндэтгэх (...)
- 2) Хүлээн авагч улс хүний эрхийг хүндэтгэдэг байх (...)
- 3) Хүлээн авагч улсын дотоод нөхцөл байдал, тухайлбал хурцадмал байдал үүссэн эсвэл зэвсэгт мөргөлдөөн болж байгаа эсэх (...)
- 4) Хүлээн авагч орон тухайн экспортыг бусад улс орны эсрэг хүч түрэмгийлэх болон газар нутаг хүчээр эзлэх зорилгоор ашиглах бодит эрсдэл байгаа тохиолдолд гишүүн орнууд экспортын зөвшөөрөл олгохгүй (...);
- 5) Гишүүн орнууд болон гадаад харилцааг нь гишүүн орнууд хариуцдаг газар нутаг, түүнчлэн найрсаг харилцаатай болон эвслийн орнуудын үндэсний аюулгүй байдал (...)
- 6) Худалдан авагч орон олон улсын хамтын нийгэмлэгийн эрх ашигт хэрхэн ханддаг, тухайлбал терроризмд хандах хандлага, эвслийнх нь мөн чанар болон олон улсын хууль тогтоомжийг хүндэтгэх (...)
- 7) Зэвсэг техникийг худалдан авагч орон зоиулалтыг нь өөрчлөн ашиглах эсвэл зохисгүй нөхцөл байдалд шилжүүлэн экспортлох эрсдэл бий эсэх (...)
- 8) Зэвсгийн экспорт нь хүлээн авагч орны техник, эдийн засгийн нөөц бололцоонд тохирч буй эсэх (...)

Эх сурвалж: <http://europa.eu.int>

► Америкийн орнуудын байгууллага ба зэвсэг нийлүүлэлт

Америкийн орнуудын байгууллагын гишүүн 19 улс ердийн зэвсэг нийлүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурснаар Америк тив дэх бүс нутгийн зэвсгийн

худалдааны ил тод байдал сайжирсан гэхэд болно. Гватемала хотод зохион байгуулагдсан Ерөнхий ассамблейн хуралдаанаас баталсан Ердийн зэвсгийн худалдан авалтын ил тод байдлын тухай Америкийн орнуудын конвенцын дагуу оролцогч талууд зэвсгийн томоохон экспорт, импортын талаарх тайлангаа жил тутам гаргах үүрэг хүлээдэг.

Тус конвенцын III зүйлийн дагуу, “Гишүүн орнууд өмнөх хуанлийн жилд хийгдсэн ердийн зэвсгийн импорттой холбогдуулан экспортлогч орон, импортлосон зэвсгийн төрөл, хэмжээ зэрэг мэдээлэл, экспорттой холбогдуулан импортлогч орон, экспортлосон зэвсгийн төрөл, хэмжээ зэргийг итгэмжлэгдсэн этгээдэд жил тутам тайлагнана. Түүнчлэн гишүүн орнууд өөрийн тайланд тухайн ердийн зэвсгийн зориулалт, загвар зэрэг шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг оруулж болно (...)”. Үүний дээр гишүүн орнууд ердийн зэвсэг импортоор худалдаж авсан, үйлдвэрлэсэн эсвэл худалдан авалт хийгдээгүй талаар бие биендээ харилцан мэдээлнэ (IV зүйл).

Эх сурвалж: <http://www.oas.org>, 2002

Олон улсын зэвсгийн хоригийг сахин биелүүлэх

Хориг гэдэг нь аливаа улс орон олон улсын хууль тогтоомж эсвэл энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байгааг олон улсын хамтын нийгэмлэг үл зөвшөөрч буйг илэрхийлсэн дохио юм. Үүний хууль эрх зүйн үндэслэл нь НҮБ-ын дүрмийн 41 дүгээр зүйл бөгөөд түүний дагуу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сэргээн тогтоохын тулд зэвсгийн бус арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад уриалдаг байна. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл 1945-1990 оны хооронд хоёр оронд л хориг тавьж байсан бол 1990 оноос хойш нийт 12 удаа ийм арга хэмжээ авсан байна.

Энэ хүрээнд тухайн зэвсгийг аль оронд ашиглахыг заасан “хэрэглэгчийн гэрчилгээ” шаардах нь зэвсэг нийлүүлэхэд тусгай зөвшөөрөл олгох парламентын ажиллагааны нэг чухал арга байж болох юм. Гэсэн хэдий ч энэ гэрчилгээг хуурамчаар үйлдэх явдал их гардаг байна.

НҮБ-ын ердийн зэвсгийн бүртгэл

Ерөнхий ассамблей 1991 оны 12 дугаар сарын 6-ны өдөр “Зэвсэглэлийн ил тод байдлын тухай” 46/36 L тоот тогтоолыг баталсан. Энэ тогтоолын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга нь Нью-Йорк дахь НҮБ-ын төв байранд бүх нийтийн, үл ялгаварлах Ердийн зэвсгийн бүртгэл бий болгож хөтлөх бөгөөд тус бүртгэлд нь олон улсын зэвсгийн арилжаа болон улс орнууд дотоод үйлдвэрлэл болон

холбогдох бодлогын хүрээнд бүрдүүлсэн цэргийн эд материалын нөөц, худалдан авалтын талаар гишүүн орнуудаас ирүүлсэн мэдээллийг бүртгэх үүрэгтэй.

Бүртгэл нь ердийн зэвсгийн нийтээр зөвшөөрсөн долоон төрөл болох байлдааны танк, хуягт тээвэрлэгч, том калибрын артиллерийн систем, байлдааны нисэх онгоц, дайралтын нисдэг тэрэг, байлдааны хөлөг онгоц, пуужин/пуужингийн харвах суурь зэргийг хамаардаг. Энэ товчоо нь 1992 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү бүртгэлд хамаарах ердийн зэвсгийн импорт, экспортын талаар 110 улсын засгийн газраас ирүүлсэн мэдээлэл, тоо баримтыг Ерөнхий Ассамблейд тогтмол тайлагнана. Улс орнууд үндэсний үйлдвэрлэл болон цэргийн зэвсэг-техник борлуулагч компаниудаас худалдаж авсан цэргийн эд материалын талаарх засгийн газрын мэдээллийг ч уг тайланд мөн багтаадаг байна. Дэлгэрэнгүйг <http://disarmament.un.org/cab/register.html> хаягаас үз.

“Ухаалаг хориг”-ийн хэрэгцээ шаардлага

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга эдийн засгийн цогц хориг арга хэмжээг “мохоо хэрэгсэл” хэмээн нэрлэсэн байдаг. Тэдгээр арга хэмжээ тэр болгон олигтой үр дүн өгдөггүйгээс гадна хөрш зэргэлдээ орнууд болон хориг тавигдсан орны энгийн иргэдэд хохирол учруулах нь их. Тиймээс, илүү ухаалаг хийгээд нарийвчилсан цар хүрээ бүхий хориг арга хэмжээ шаардлагатай гэж зарим нь үздэг. Зэвсгийн хориг нь санхүүгийн болон аяллын хоригуудтай зэрэгцэх ухаалаг хоригийн нэг төрөл мөн. Ухаалаг хориг нь тухайн орны дэглэм хийгээд эрх баригч давхаргад чиглэсэн байдаг бөгөөд энгийн иргэд болон сөрөг хүчнийг ялган зааглаж чаддаг. Гэсэн хэдий ч ухаалаг хоригуудыг хэрэгжүүлэхэд нэн хэцүү, бүрэн хэмжээнд амжилттай байх нь ховор бөгөөд сайжруулж, шинэчлэх хэрэгцээ шаардлага бий. (Тодруулга N°77-г үз).

Тодруулга N°77

Зэвсэглэлийн хоригийг боловсронгуй болгох нь: Парламент юу хийж чадах вэ?

- ▷ Зэвсэг экспортлогч орны парламент дараах шаардлага хэрэгжиж байгаа эсэхэд анхаарч ажиллах ёстой. Үүнд:
- ▷ НҮБ-ын зэвсгийн хоригийг зөрчсөн үйлдлийг гэмт хэрэг хэмээн хуульчилсан хууль тогтоомж болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм журам;
- ▷ Засгийн газрын дотоод зохицуулалтаар зэвсгийн хоригийн хэрэгжилтийг хариуцаж ажиллах толгой байгууллага бий болгох;

- ▷ Сэжигтэй ачаа тээвэрлэлт, чиглэл, дамжин өнгөрөх чиглэл эсвэл зуучлагчдыг олж илрүүлэх зорилгоор засгийн газрын байгууллага хооронд болон засгийн газар хооронд мэдээлэл, тагнуулын мэдээ солилцох;
- ▷ Хоригт хамрагдсан бараа бүтээгдэхүүний хяналтын жагсаалт;
- ▷ Хориг зөрчсөн гэж үзэх илэрхий үндэслэл бүхий ачааг гарал үүслийн хаягаар буцаах бус харин хурааж авах эрх;
- ▷ Хууль бус зэвсгийн хүргэлт буюу түүнээс олсон орлогыг царцаах, хурааж авах заалтууд;
- ▷ Замаас нь өөр зориулалтаар ашиглах эрсдэл бүхий зэвсгийн ачааг мөрдөх болон шалгах.

Эх сурвалж: Бонны олон улсын шилжилтийн төвийн цахим хуудасд суурилав www.bicc.de, 2002

Хүйтэн дайны өв залгамж: Илүүдэл зэвсэг ба бусдад шилжүүлэх

Хүйтэн дайн төгссөнөөр дэлхийн улс орнууд армийн тоо хэмжээгээ багасгасан. Ингэснээр саяар тоологдох зэвсэг шаардлагагүй болж, илүүдэл хэмээн тооцогдох болсон байна. Олон улсад илүүдэл зэвсгийн оновчтой зохицуулалт байхгүйн улмаас олон сая зэвсэг улс хооронд болон төрийн бус бүлэглэлүүд рүү олон нийтийн хяналтаас гадуур арга замаар шилжүүлэх явдал газар авсан. Эдгээр зэвсгийн олонх нь хулгайн зэвсгийн наймааны замаар орсон эсвэл хамгаалалт муутай агуулахуудаас шууд хулгайлагдсан нь ойлгомжтой.

1990-ээд онд ердийн гол зэвсгийн худалдааны тавны хоёр орчим нь илүүдэл зэвсэг байв. Тухайн үед илүүдэл зэвсэг ийнхүү газар авсан гол шалтгаан нь хуучин Зөвлөлтийн эвслийн зэвсэглэлд байсан ихээхэн хэмжээний зэвсэг төвлөрсөн хяналтаас гэнэт гарсан явдал байв. Тухайн үед эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэний дээр илүүдэл зэвсгийн томоохон нөөц байсан бөгөөд илүүдэл зэвсэг нь санхүүгийн тулгамдсан хэрэгцээг хангахад шаардлагатай байсан хатуу валютын эх үүсвэр болж байв. Нөгөө талаас, зэвсгийн олон тооны наймааг улс төрийн эрх баригчидтай холбоотой эсвэл холбоогүй гэмт хэргийн сүлжээнүүд гардан зохион байгуулж байв. Гэхдээ хуучин Зөвлөлтийн эвсэл бол илүүдэл зэвсгийн худалдаа эрхэлж байсан цорын ганц эх сурвалж биш бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй зарим орон мөн тийм үйл ажиллагаа явуулж байжээ.

Тодруулга № 78

Илүүдэл зэвсгийн худалдаа: Зэвсэглэл хураах санаачилгын нэгэн сөрөг үр дагавар

“Шинэ зэвсгийн худалдаа буурсан хэдий ч илүүдэл, хуучин зэвсгийн худалдаа урьд өмнө байгаагүй өндөр хэмжээнд хүрсэн гэдгийг тоон үзүүлэлтүүд харуулж байна. Илүүдэл зэвсгийн энэхүү нийлүүлэлтэд татах, түлхэх хүчин зүйлс хослон нөлөөлж байна. Зэвсэглэл хураах гэрээ, гал зогсоох гэрээ, цэргийн анги салбарын тоо буурснаас дэлхийн хэмжээнд нийт 165,000 нэгж томоохон зэвсэг илүүц болсноос 18,000 гаруйг нь 1990-1995 оны хооронд экспортлох буюу бэлэглэжээ. Түүхэнд анх удаа, 1994 онд илүүдэл зэвсгийн худалдааны хэмжээ шинэ зэвсгийнхээс давж гарсан байна. Олдоц сайтай илүүдэл зэвсгийг харьцангуй хямд үнээр арилжиж эсвэл тусламжийн хөтөлбөрийн хүрээнд үнэ төлбөргүй тараасан. Зэвсэглэл хураах ажиллагааны нэг сөрөг үр дагавар болох ийм худалдаа нь хямралт бүс нутгуудад хүрч, бүс нутгуудад зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг даамжруулсан байна.”

Эх сурвалж: Херберт Вулф, 1998, Бонны олон улсын шилжилтийн төв www.bicc.de

Илүүдэл зэвсгийн хүлээн авагчид нь парламентын хяналтын бүтэц харьцангуй султай, хөгжлийн түвшин доогуур орнууд байсан нь ойлгомжтой. 1990-ээд оны үед дор хаяж 90 орон илүүдэл үндсэн зэвсэг импортлосон байна. Жижиг зэвсэгт тусгай хяналт тогтоож, алдаж үрэгдүүлсэн болон хулгайд алдсан жижиг зэвсэг, сумны тоог засгийн газар болон цэргийнхэн парламентад жил тутам мэдээлж байх үүргийг хуульчлах нь нэн чухал. Жижиг зэвсгийн үйлдвэрийг цэргийн бус үйлдвэр болгож шинэчлэх арга хэмжээг авах ёстой.

Дэлхийн зэвсгийн арилжааны таван жилийн хөдөлгөөнт дундаж 1997–2001 онд буурсан. 1998 оноос хойш зэвсгийн нийлүүлэлтээ 65%-иар бууруулсан хэдий ч зэвсгийн хамгийн том нийлүүлэгч хэвээр байсан АНУ 1997-2001 онд зэвсгийн арилжаагаа бууруулсан нь үүний гол шалтгаан байлаа. Энэ үед зэвсгийн хоёр дахь том нийлүүлэгч нь Орос улс байв. ОХУ 2000-2001 онд зэвсэг нийлүүлэлтээ 24%-иар нэмэгдүүлснээр 2001 онд зэвсгийн хамгийн том нийлүүлэгч болсон байна (Эх сурвалж: SIPRI Жилийн тайлан 2002).

Хятад Улс 2000 онд зэвсгийн худалдан авалтаа 44%-иар өсгөснөөр 2001 онд хамгийн том импортлогч болжээ. Мөн үед Энэтхэг зэвсгийн импортоо 50%-иар нэмэгдүүлснээр 2001 онд зэвсгийн гурав дахь том худалдан авагч болсон. Мөн 1997–2001 онд зэвсэг импортлогч гол орнуудын тоонд Саудын Араб, Тайвань, Турк зэрэг орнууд оржээ (Эх сурвалж: SIPRI Жилийн тайлан 2002).

Тодруулга №79

Жижиг зэвсгийн наймааны тоон үзүүлэлтүүд

“Жижиг зэвсгийн үйлдвэрлэл Хүйтэн дайны сүүлийн жилүүдтэй харьцуулахад буурсан хэдий ч жил бүр олон сая ийм төрлийн зэвсэг үйлдвэрлэгдсэн хэвээр байна (...). Тооцооноос үзэхэд (...), галт хэрэгслийг оролцуулан дэлхийн зэвсгийн үйлдвэрлэлийн үнэ өртөг 2000 онд ойролцоогоор 4 тэрбум ам.доллар байв. Хэмжээний хувьд, мөн онд ойролцоогоор 4.3 сая жижиг зэвсэг шинээр үйлдвэрлэгдсэн нь (...) Хүйтэн дайны үеийн жилийн дундажтай харьцуулахад 30%-иар буурсан үзүүлэлт юм”.

“Жижиг зэвсгийн эрэлт буурч байгаа хэдий ч (...) зах зээлдээрх нийлүүлэлтийн хэмжээ өссөөр байна” (...). Үйлдвэрлэгчдийн тоо 1980-аад онд 196 байсан бол 20 гаруй жилийн дотор 3 дахин нэмэгдэж, өдгөө 600-д хүрчээ”.

(...) Хэнтэй ч, хаана ч, ямар ч үнээр хамаагүй худалдаа хийхэд бэлэн жижиг зэвсэг шинээр үйлдвэрлэгч компани болон улс орны тоо өсөн нэмэгдэж байгаа нь дарангуйлагч засгийн газар, улс бус тоглогчид, террористууд, гэмт хэрэгтнүүдэд шинэ, илүү боловсронгуй, үхлийн илүү аюултай зэвсэг олж авахад хэзээ хэзээнээс хялбар болсон гэсэн үг. Засгийн газраас жижиг зэвсгийн үйлдвэрлэлд хяналт тавих шаардлага олон улсын аюулгүй байдлын тулгамдсан асуудал болон хувирчээ.”

Эх сурвалж: Жижиг зэвсгийн судалгаа 2001, Оксфордын их сургуулийн хэвлэлийн газар

Тодруулга №80

Жижиг зэвсэг болон хөнгөн зэвсэглэлийн хууль бус наймааны эсрэг НҮБ-ын үйл ажиллагааны хөтөлбөр: Парламентын гишүүдийн анхаарах гол асуудлууд

Жижиг зэвсэг, хөнгөн зэвсэглэл (ЖЗХЗ)-ийн хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоохын тулд Жижиг зэвсэг, хөнгөн зэвсэглэлийн хууль бус худалдааны бүх асуудлууд сэдэвт НҮБ-ын бага хурлын гишүүн орнууд [2001 оны 7 дугаар сар, Нью Йорк] үндэсний, бүс нутгийн, дэлхийн хэмжээнд авах улс төрийн өргөн хүрээтэй арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

Үндэсний хэмжээнд

- ▷ ЖЗХЗ-ийн үйлдвэрлэл болон тэдгээрийн экспорт, импорт, дамжин өнгөрүүлэх, шилжүүлэх ажиллагааг хянах хууль тогтоомж, зохицуулалт, дүрэм журмыг боловсруулж батлах,
- ▷ ЖЗХЗ хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, нөөцлөх, шилжүүлэх, эзэмших болон тийм ажиллагааг санхүүжүүлсэн хувь хүн, бүлэглэлийг олж тогтоох, дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих шийтгэл ноогдуулах;
- ▷ Зөвшөөрөл бүхий үйлдвэрлэгчид нь ЖЗХЗ нэг бүрт зохих, найдвартай тэмдэглэгээ тавих явдлыг үйлдвэрлэлийн зайлшгүй шат дамжлагын нэг болгох;

- ▷ ЖЗХЗ-ийн үйлдвэрлэл болон түүний эзэмшил, арилжааны талаарх иж бүрэн, үнэн зөв бүртгэлийг аль болох удаан хугацаанд хадгалах;
- ▷ Эзэмшиж буй болон олгосон бүх ЖЗХЗ-ийг төр хариуцаж, тэдгээр зэвсгийн байршлыг тогтоох үр дүнтэй арга хэмжээ авах;
- ▷ Эцсийн хэрэглэгчийн баталгаат гэрчилгээ зэргийг ашиглан ЖЗХЗ-ийг экспортлох, дамжин өнгөрүүлэх ажиллагаанд тавих үр дүнтэй хяналтыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журмыг боловсруулж, нэвтрүүлэх;
- ▷ импортоор авсан ЖЗХЗ-ээ дахин экспортлох улс орны эрхэнд халдалгүйгээр, хоёр талын хэлэлцээрийн дагуу анхны экспортлогч оронд тухайн зэвсгийн дахин шилжүүлгийн талаар мэдээлэх;
- ▷ ЖЗХЗ-ийн зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан үндэсний хууль тогтоомж, дүрэм журам боловсруулж, батлах;
- ▷ НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тавьсан зэвсгийн хоригийг зөрчсөн аливаа үйл ажиллагааны эсрэг зохих арга хэмжээг авах;
- ▷ Хураалгасан, олзолсон, цуглуулсан ЖЗХЗ-ийг устгах;
- ▷ ЖЗХЗ эзэмших эрх бүхий зэвсэгт хүчин, цагдаа болон бусад байгууллагууд зэвсгийн нөөцийн удирдлага, аюулгүй байдалд чиглэсэн зохистой, нарийвчилсан хэм хэмжээ, дүрэм журам боловсруулж хэрэгжүүлэх;
- ▷ Боломжтой тохиолдолд зэвсэг хураах, цэргийн тоог багасгах, эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
- ▷ Зэвсэгт мөргөлдөөний улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн асуудлыг тусгайлан авч үзэх (...)"

Эх сурвалж: НҮБ-ын Зэвсэглэл хураах газар,
Цахим хуудас <http://www.un.org/Depts/dcta>, 2002

Өмнө дурдсан Хүйтэн дайны дараах үйл явдлаас улбаалан зэвсгийн экспортын хяналтын ажиллагааны ил тод, хариуцлагатай байдал, түүнтэй холбогдуулан парламент юу хийж болох ба юу хийх ёстой нь олон улс оронд ихээхэн маргаан дагуулж байна.

Тодруулга N°81-д Европын холбооны гишүүн орнуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний жишээг харуулав. Ил тод, хариуцлагатай байдлын ач холбогдлыг өргөнөөр ухамсарлах болсноор эдгээр орны зэвсгийн экспортод тавих парламентын хяналтад ахиц дэвшил гарсан. Хэдий тийм ч олон орны хувьд энэ асуудал бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

Тодруулга N°81

Зэвсгийн экспортын хяналтад парламентын гүйцэтгэх үүрэг: Европын холбооны орнууд дахь ил тод, хариуцлагатай байдал

Австри: Тус улсад парламентын гишүүдийг мэдээллээр хангахтай холбоотой хууль тогтоомж байхгүй.

Бельги: Засгийн газар зэвсгийн шилжүүлгийн талаар парламентад жил тутам мэдээлэх үүргийг баталгаажуулсан хууль 1991 онд батлагдсан. Чухам ямар этгээд, хэнд зэвсэг экспортлох зөвшөөрөл авсныг тодруулах тухай заалт тус хуулинд байдаггүй. Гэтэл энэ нь чухал шаардлага мөн. Учир нь тухайн экспорт Европын холбооны ёс зүйн дүрэмтэй зөрчилдөх ёсгүй.

Дани: Зэвсгийн экспортын асуудлыг парламентаар хэлэлцүүлэх, уг асуудалд ардчилсан хяналт тавих зохистой арга хэрэгслийн талаар хуулийн зохицуулалт байхгүй. Гэсэн хэдий ч уг асуудлаарх олон нийтийн шаардлага шахалт нэмэгдэж байгаа тул хууль зүйн сайдаас зэвсгийн экспортын талаарх анхны тайланг гаргахаар зэхэж буй бөгөөд үүнд экспортын хяналт, үнийн дүн, худалдан авагч улсын талаарх мэдээллийг тусгах аж.

Финлянд: Одоогийн байдлаар батлан хамгаалах яам Европын холбооны ёс зүйн дүрмийн дагуу батлан хамгаалах эд материалын экспортын тайланг хоёр удаа гаргаад байна. Эдгээр тайлан нь хангалттай дэлгэрэнгүй бөгөөд ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Гэсэн хэдий ч зэвсгийн шилжүүлгийг парламентаар тогтмол хэлэлцүүлэх асуудал учир дутагдалтай хэвээр байна.

Франц: Францын парламентаас засгийн газарт хандан жил тутмын тайландаа жижиг зэвсэг, цагдаагийн болон хамгаалалтын тоноглол, давхар хэрэглээ бүхий тоног төхөөрөмж болон цэргийн бүх төрлийн хамтын ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл оруулах шаардлагыг тавьсаар байгаа. Түүнчлэн, парламент дээр дурьдсан тайланг сайтар хэлэлцэх ёстой.

Герман: Зэвсгийн экспортын талаарх анхны тайлан 2000 онд хэвлэгдсэн. Парламентын дор дурьдсан хороод дараа дараагийн тайланг хэлэлцэх ажээ. Үүнд: Батлан хамгаалах, Гадаад хэрэг, Худалдааны хороод болон мөн Хүний эрхийн хороо үүн дээр нэмэгдэх бололтой. Ингэхдээ парламентын оролцоо нь засгийн газрын экспортын уламжлалт хяналтаар хязгаарлагдах ажээ.

Грек: Зэвсгийн экспортын зөвшөөрөлтэй холбогдуулан парламент болон олон нийтийг мэдээллээр хангах тогтолцоо байхгүй. Албан ёсны мэдээллийн цорын ганц эх сурвалж бол НҮБ-ын Ердийн зэвсгийн бүртгэл юм.

Ирланд: Ирландын хуулиар зэвсгийн экспортын тухай мэдээллийг засгийн газар нийтлэх үүрэг хүлээдэггүй. Гэхдээ, Европын холбооны ёс зүйн дүрмийн дагуу 2002 оныг хүртэл Гадаад хэргийн яамнаас 2 удаа жилийн тайлан гаргасан байна. Парламентын гишүүдээс сайд нарт хандан зэвсгийн экспортын зөвшөөрлийн талаар асуулт тавих жишиг тогтож байгаа.

Итали: Засгийн газар нь цэргийн тоног төхөөрөмжийн импорт, экспорт, дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл, гүйцэтгэлийн талаар парламентад тайлагнах үүрэгтэй. Энэ үүргийг 1990 онд батлагдсан хуулиар зохицуулсан бөгөөд дэлгэрэнгүй загварыг уг хуулинд өгсөн байдаг. Гэхдээ зэвсгийн экспортын хяналтад парламент албан ёсны үүрэг гүйцэтгэдэггүй.

Люксембург: Зэвсгийн том үйлдвэрлэл, хяналтын тогтолцоо аль аль нь байхгүй.

Нидерланд: Зэвсгийн экспортын талаарх иж бүрэн тайлан анх 1998 оны 10 дугаар сард гарсан. Тус улсын зэвсгийн экспортод парламентаас урьдчилсан хяналт хэрэгжүүлэх албан бус тогтолцоо буюу засгийн газраас парламентын батлан хамгаалах хороонд илүүдэл зэвсгийн худалдааны талаарх бүх мэдээллийг нууц зарчмаар тайлагнах тогтолцоо байдаг.

Португаль: Анхны тайлан 1998 гарахаас өмнө зэвсгийн наймааны экспортын лицензэд тавих парламентын хяналтын талаар ямар нэг зохицуулалт байгаагүй. Түүнчлэн, өнөөг хүртэл уг асуудлыг парламентаар хэлэлцүүлэх зохицуулалт байхгүй байна. Парламентын гишүүд мэдээлэл авах журмаар зэвсгийн экспортын зөвшөөрөлтэй холбоотой асуулт тавих боломжтой.

Испани: Анхны тайлан 1998 онд хэвлэгдсэнээс хойш дахиж тайлан гараагүй. Зэвсгийн экспортод тавих урьдчилсан хяналт байхгүй. Зөвхөн парламентын Албаны нууцын хороо оролцдог. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлээрх парламентын хэлэлцүүлэг өргөжиж буй.

Швед: 1984 онд анхны тайлан гарсны дээр Европын бусад орнуудад жишиг болох Цэргийн тоног төхөөрөмжийн асуудлаар зөвлөлдөх хороог тус улсын парламентаас байгуулсан. Парламент тус тайланг жил тутам хэлэлцдэг.

Их Британи: Британийн тайлагнах тогтолцоо хамгийн ил тод. Анхны тайлан 1999 онд хэвлэгдсэнээс хойш батлан хамгаалах, гадаад хэрэг, олон улсын хөгжил болон худалдаа, аж үйлдвэрийн яамдын хамтарсан хороо байгуулагдсан. Тус хороо нь Нийтийн танхимд тайлагнах бөгөөд экспортод хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Эх сурвалж: www.saferworld.co.uk, 2002

Парламентын мэргэжлийн чадавх

Өмнө дурдсанчлан, зэвсгийн худалдаа, нийлүүлэлтэд зохистой хяналт тавих гол үндэс нь парламентын мэргэжлийн чадавх. Мэргэжлийн ур чадвар дутмаг байх нь шийдвэр гаргах ажиллагааг нууцлах гол шалтгааны нэг. Тиймээс, парламентын гишүүдийг, нэн ялангуяа, парламентын холбогдох хороодын гишүүдийг сургах нь нэн чухал. Үүний нэгэн адил, зэвсгийн худалдаа, худалдан авалтын баланс, операцын түвшний судалгаа, эд материалын менежмент, тоног төхөөрөмжийн зардлын тооцоо, нөөцийн хяналт зэрэг асуудлаар мэргэшүүлэх сургалтад парламентын ажилтнуудыг хамруулснаар парламентын батлан хамгаалах хорооны асуултуудад хариулт өгөх чадавх бүхий шинжээчдийн нөөц бүрдүүлэхэд тустай байдаг. Үүнээс гадна, аюулгүй байдлын салбарт гаргасан шийдвэрийн талаар төрөл бүрийн мэдээллийн сан байгуулах нь гүйцэтгэх засаг болон цэргийнхний гаргасан шийдвэрийг парламентын батлан хамгаалах хорооны зүгээс хянан үзэх зорилгоор мэдээлэл шаардах боломжийг бүрдүүлнэ.

Парламентын гишүүний хувьд таны хийж чадах зүйлс

Зэвсгийн худалдааг хянах нь

- ▷ Олон улсын зэвсгийн худалдааны асуудал нь парламентын хэлэлцэх чухал асуудлын нэг байхад анхаарах.
- ▷ “Жижиг зэвсэг, хөнгөн зэвсэглэлийн бус наймааны эсрэг НҮБ-ын үйл ажиллагааны хөтөлбөр: Парламентын гишүүдийн анхаарах гол асуудлууд” сэдэвт Тодруулга N°80-д тусгасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарах.
- ▷ Өөрийн улсыг дараах зохицуулалтыг тогтмол дагаж мөрдөхөд анхаарах. Үүнд:
 - НҮБ-ын Ердийн зэвсгийн бүртгэлд мэдээлэл хүргүүлэх үүрэг;
 - Цэргийн зардал тайлагнах НҮБ-ын стандартчлагдсан арга хэрэгслүүд;
 - Ердийн зэвсэгтэй холбоотой бүс нутгийн гэрээ хэлцлүүд.

Зэвсгийн худалдааны үндэсний бодлого

- ▷ Зэвсгийн худалдааны талаарх үндэсний зохистой бодлого бий эсэх болон тус бодлогыг парламентаар баталсан эсэхэд анхаарах.
- ▷ Засгийн газраас зэвсгийн худалдааны асуудлаар парламентад тайлагнах тогтолцоо бий эсэхэд анхаарах.

Зэвсгийн хориг

- ▷ Зэвсгийн хоригтой холбогдуулан уг хоригийн зохист байдал, хэлбэр, үр дагаврыг парламентаар хэлэлцэж байх.
- ▷ Тодруулга N°77-д багтсан асуудлуудын хүрээнд “ухаалаг хориг”-ийн талаар парламентад хэлэлцүүлэг өрнүүлэх.
- ▷ Зэвсгийн хоригийг даган биелүүлэх талаар засгийн газарт шаардлага тавих, хоригийг зөрчсөн тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авахад анхаарч ажиллах.

Илүүдэл зэвсэг

- ▷ Парламент болон парламентын холбогдох хороо(д), түүний дотор гаалийн асуудал хариуцсан хорооноос илүүдэл зэвсгийн асуудалд онцгой анхаарал хандуулах, дараах асуудалд хяналт тавих чиглэлээр арга хэмжээ авах. Үүнд:

- Танай орноос эсвэл танай орноор дамжин өнгөрч буй илүүдэл зэвсгийн аливаа шилжүүлэг;
- Илүүдэл зэвсэг худалдан авах аливаа ажиллагаа.
- ▷ Төрөөс илүүдэл зэвсгийн бүртгэл болон тэдний устгалд хувь нэмэр оруулах шаардлага тавих.
- ▷ Төрөөс илүүдэл зэвсэг арилжих үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг олж тогтоох, хяналт тавихыг шаардах.

Жижиг зэвсэг

- ▷ Парламент болон парламентын холбогдох хороо нь жил бүр жижиг зэвсгийн үйлдвэрлэл хийгээд худалдааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авдаг байхад анхаарах. Уг тайланд энэ үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулах шаардлага тавих.
- ▷ Дотоодын жижиг зэвсгийн үйлдвэрлэл энэ бүлэгт дурдсан шаардлагыг хангаж байхад анхаарч ажиллах.

ОУПХ гэж юу вэ?

Олон улсын парламентын холбоо 1889 байгуулагдсан бөгөөд тусгаар улсуудын парламентын олон улсын байгууллага юм. Тус байгууллага саяхан НҮБ-ын ажиглагчийн статусыг авсан нь олон улсын түвшин дэх парламентын оролцоог нэмэгдүүлж, ард түмнээс сонгосон төлөөлөгчдийн дуу хоолойг олон улсын яриа хэлцлийн ажиллагаанд хүргэх зорилгодоо хүрэх нэгэн шинэ алхам болсон.

2003 оны 1 дүгээр сарын байдлаар, 144 орны парламент ОУПХ-нд гишүүнээр элссэн байв. Парламентын яриа хэлцэл, үйл ажиллагааны нэгдсэн төв болохын хувьд тус байгууллага нь дараах боломжийг гишүүддээ олгодог. Үүнд:

- ▷ Олон улсын хэмжээнд сонирхол татсан буюу сэтгэл зовоосон асуудлыг судалж үзэх,
- ▷ Парламентын гишүүдийн хүний эрхийг хамгаалах, дэмжихэд хувь нэмэр оруулах,
- ▷ Дэлхий даяар төлөөллийн байгууллыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх.

ОУПХ-ны үйл ажиллагаанд энх тайван, аюулгүй байдлын асуудал ямагт чухал байр суурь эзэлсээр ирсэн. ОУПХ-ны гишүүд зэвсэглэл хураах, олон улсын хориг, Олон улсын гэмт хэргийн шүүх, терроризм зэрэг аюулгүй байдлын асуудлаар үйл ажиллагаа явуулсан олон тохиолдол бий. Тус байгууллага 1994 онд олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг дээдлэх үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий тусгай Хороо байгуулсан. Тус хороо нь Олон улсын улаан загалмайн хороотой хамтран 1999 онд олон улсын хүмүүнлэгийн хуулийн талаар парламентын гишүүдэд зориулсан гарын авлага гаргасан билээ.

ОУПХ-ноос хурцадмал байдлыг улс төрийн яриа хэлцлийн аргаар шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлсээр ирсэн юм. Тус холбооны уулзалтууд нь хурцадмал байдлыг намжааж, харилцан итгэлцлийг бэхжүүлэх талбар болсоор ирсэн. Түүнчлэн ОУПХ-нд Ойрхи Дорнодын асуудлыг үр дүнтэйгээр шийдэхэд тус дөхөм үзүүлэх парламентын хороо, Киприйн хоёр талын улс төрийн намуудын төлөөлөл хоорондын яриа хэлэлцээрийг дэмжих зорилго бүхий Зуучлагчдын бүлэг байдаг. Үүний зэрэгцээ, тус холбооноос Газар дундын тэнгис орчмын бүс нутагт аюулгүй байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх тусгай механизм ажиллуулдаг болно.

ОУПХ-ны төв

Inter-Parliamentary Union
Chemin du Pommier 5
Case Postale 330
CH-1218 Grand Saconnex, Geneva
Switzerland
Tel: 41 22 919 41 50
Fax: 41 22 919 41 60
e-mail: postbox@mail.ipu.org
Website: www.ipu.org

ОУПХ-ноос НҮБ-д суугаа байнгын

ажиглагчийн газар
Inter-Parliamentary Union
220 East 42nd Street
Suite 3102
New York, N.Y. 10017
USA
Tel. (212) 557 58 80
Fax (212) 557 39 54
e-mail: ny-office@mail.ipu.org

Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв (ЗХАХТЖТ-ДСАФ)

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд шилжилт болон цэрэг иргэний ардчилсан харилцааны шинэчлэл, менежментэд тодорхой ахиц гарсан хэдий ч олон оронд, нэн ялангуяа ардчилалд шинэ тутам шилжиж буй, дайнд нэрвэгдсэн болон хямралын дараах орнуудын хувьд бэрхшээлтэй асуудал хэвээр байна. Олон орны хувьд зэвсэгт хүчин, цагдаа, хилийн цэрэг, цэрэгжсэн бусад байгууллага зэрэг аюулгүй байдалд хамааралтай бүтцүүд гол тоглогчид хэвээр байна. Ихэнх тохиолдолд тэд “улсын доторх улс” болж хувирсан байдаг бөгөөд улс орны хомс төсөв хөрөнгөд дарамт учруулахын зэрэгцээ ардчиллын явцад саад болж, дотоодын болон олон улсын хямрал үүсэх эрсдлийг нэмэгдүүлдэг. Иймд эдгээр байгууллагуудад ардчилсан, иргэний хяналт тавих нь мөргөлдөөнөөс сэргийлэх, энх тайван, ардчиллыг бэхжүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нэн чухал механизм болохыг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг.

Хүчний бүтцэд тавих ардчилсан, иргэний хяналтыг бэхжүүлэх нь олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд бодлогын чухал асуудал болоод байна. Энэхүү нийтлэг, эерэг чиг хандлагад бодит хувь нэмэр оруулах үүднээс Швейцарийн Засгийн газар 2000 оны 11 дүгээр сард Холбооны Батлан хамгаалах, спорт, иргэний хамгаалалтын яам болон Гадаад хэргийн яамны хамтарсан санаачилгаар Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв /ЗХАХТТ/-ийг үүсгэн байгуулсан юм.

Зорилго

Тус төв нь төрийн болон төрийн бус байгууллагуудаас зэвсэгт хүчин, аюулгүй байдлын салбарт тавих иргэний ардчилсан хяналтыг дэмжих, Евро-Атлантын бүс нутагт энэ чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.

Эл зорилгыг хэрэгжүүлэхийн тулд тус төв дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Зэвсэгт хүчинд тавих ардчилсан хяналт, иргэн-цэргийн харилцааны тулгамдсан асуудлыг тодорхойлох, өнгөрсөн сургамжийг тогтоох, тэргүүний туршлага хуримтлуулах үүднээс **мэдээлэл цуглуулж, судалгаа хийхийн зэрэгцээ, олон улсын сүлжээ үүсгэх;**
- Сонирхсон бүх талууд буюу засгийн газар, парламент, цэргийн удирдлага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдад **мэргэжлийн зөвлөгөө, тусалцаа үзүүлэх.**

ЗХАХТЖТ нь улс орны засгийн газар, олон улсын болон төрийн бус байгууллагууд, судалгааны хүрээлэн, хувь хүмүүс, шинжээчидтэй нягт хамтран ажилладаг. Тус төв өөрийн үйл ажиллагаа, дүн шинжилгээний ажлаа Үүсгэн байгуулах зөвлөлийн гишүүн 42 орны засгийн газар, олон улсын нэр хүнд бүхий 50 орчим мэргэжилтнээс бүрдсэн Олон улсын зөвлөх зөвлөл, өөрийн Тинк Танк болон ажлын хэсгүүдэд тулгуурлан явуулдаг. Түүнчлэн ЗХАХТЖТ хэд хэдэн судалгааны хүрээлэн, олон улсын байгууллага, парламент хоорондын чуулгантай хамтын ажиллагаа тогтоосон буюу хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Үйл ажиллагааны хөтөлбөр

Зэвсэгт хүчинд тавих ардчилсан хяналттай холбоотой тодорхой сэдвүүдийг бүрэн хамрахын тулд ЗХАХТЖТ дараах асуудлыг хариуцах 12 ажлын хэсгийг байгуулсан буюу байгуулах шатандаа ажиллаж байна. Үүнд: аюулгүй байдлын салбарын шинэчлэл, зэвсэгт хүчинд тавих парламентын хяналт, зэвсэгт хүчинд тавих ардчилсан хяналтын хууль эрх зүйн хэм хэмжээ, батлан хамгаалахын төсвийн ажиллагаа, зэвсэг техникийн худалдан авалтад ил тод байдлыг бий болгох, үндэсний аюулгүй байдлын бодлогын иргэний мэргэжилтнүүд, цагдаа болон цэргийн бус аюулгүй байдлын албадад тавих ардчилсан хяналт, бие бүрэлдэхүүнийг өөрчлөн зохион байгуулах болон цомхотгох үеийн иргэн-цэргийн харилцаа, цэрэг ба нийгэм, иргэний нийгмийг байгуулах, зэвсэгт мөргөлдөөний дараах үеийн иргэн-цэргийн харилцаа, зэвсэгт хүчинд тавих ардчилсан хяналт амжилттай болох буюу бүтэлгүйтэх шалгуур үзүүлэлтүүд, Африкийн нөхцөл дэх иргэн-цэргийн харилцаа. Ажлын хэсгүүдийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалт, уялдаа холбоог тус төвийн Тинк-танк байгууллага хариуцдаг байна.

ЗХАХТЖТ хоёр талын болон олон талт түвшинд мэргэжлийн туслалцаа үзүүлдэг бөгөөд олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудыг мөн авч үздэг. Зүүн өмнөд болон Зүүн Европын орнуудад зэвсэгт хүчинд тавих парламентын хяналт, аюулгүй байдлын салбарын шинэчлэлийн асуудлаарх хоёр талын хэд хэдэн төслийг хэрэгжүүлж байна. Олон талт хамтын ажиллагааны хүрээнд ЗХАХТЖТ нь Зүүн өмнөд Европын тогтвортой байдлын гэрээ болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд хэд хэдэн төслийг хэрэгжүүлж байгаа болно. Түүнчлэн тус төвөөс төрөл бүрийн гарын авлага, материалыг хэвлэл гаргахын зэрэгцээ семинар, сургалт зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуудаг. Мэдээллийн технологи болон өөрийн цахим хуудсаар (<http://www.dcaf.ch>) дамжуулан сонирхсон этгээд, улмаар олон нийтэд мэдээлэл, судалгаагаа хүргэдэг байна.

Зохион байгуулалт болон төсөв

ЗХАХТЖТ нь Швейцарийн хуулиар зохицуулагддаг олон улсын сан юм. Уг төвийн Үүсгэн байгуулах зөвлөлд 42 орны засгийн газар багтдаг¹. Олон улсын зөвлөх зөвлөлд батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч шинжээчид багтдаг бөгөөд тус зөвлөл нь үйл ажиллагааны ерөнхий стратегийн асуудлаар тус төвийн захиралд зөвлөдөг байна. ЗХАХТЖТ-д 23 орны 40 орчим мэргэжилтэн Тинк-танк, Олон улсын хөтөлбөр, Мэдээллийн сан, Захиргаа гэсэн 4 нэгжид хуваагдан ажилладаг.

ЗХАХТЖТ-ийг Швейцарийн Холбооны батлан хамгаалах яам, иргэний хамгаалалт болон спортын яам санхүүжүүлдэг бөгөөд 2002 оны төсөв нь 8 сая швейцарь франк байжээ. Санхүүгийн дэмжлэг үзүүлэгч бас нэгэн гол байгууллага бол Швейцарийн Гадаад хэргийн яам мөн. Тус төвийн үүсгэн байгуулагч зарим гишүүн орнууд мэргэжилтэн илгээх эсвэл зарим тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлэх зэргээр ЗХАХТТ-ийн үйл ажиллагааг дэмждэг байна.

Харилцах хаяг

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Geneva Centre for the Democratic Control of Armed Forces (DCAF)

Rue de Chantepoulet 11, P.O.Box 1360, CH-1211 Geneva 1, Switzerland

Tel: 41(22) 741-7700; Fax: 41 (22) 741-7705; E-mail: info@dcaf.ch; Website: www.dcaf.ch

¹ Албани, Армени, Австри, Азербайжан, Белорус, Босни Герцеговени, Болгар, Зааны ясан эрэг, Хорват, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Ирланд, Итали, Латви, Литви, Молдав, Голланд, Нигер, Норвеги, Польш, Португал, Румын, ОХУ, Серб ба Монтенегро, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцарь, Македоны хуучин Югослав улс, Украин, Англи, АНУ, Женевийн Кантон

Сэдэвчилсэн индекс

А

Авлига 35, 72, 81, 132, 193, 197, 200, 213, 218, 234

Авран туслах 26, 74, 234

Ажиллагааны дүрэм журам 155, 157, 236

Ажилтнууд 52, 57, 101, 155, 189, 227, 235

Аудит хийх 16, 43, 179, 182, 216, 234

Аудитын газар 177, 178, 179, 180, 182, 234

Арга хэмжээ 14, 20, 26, 27, 41, 55, 57, 58, 62, 75, 76, 80, 81, 88, 89, 105, 108, 110, 127, 128, 129, 131, 132, 135, 136, 137, 138, 139, 140, 143, 144, 145, 147, 149, 151, 152, 156, 159, 168, 176, 182, 186, 193, 194, 197, 206, 208, 213, 220, 223, 224, 225, 228, 232, 236

Ардчилал 4, 7, 12, 19, 20, 25, 29, 48, 50, 54, 62, 72, 91, 130, 133, 140, 174, 185, 189, 193, 201, 211, 231, 234

Ардчилах (цэргийг) 234

Ардчилсан хяналт: хяналт-ыг үз 2, 4, 5, 7, 10, 12, 13, 18, 19, 20, 32, 35, 54, 56, 75, 82, 85, 88, 89, 90, 91, 127, 152, 181, 185, 186, 194, 226, 231, 232, 234

Ардчилсан засаглал 14, 21, 136, 144, 162, 169, 235

Ардчилсан үнэт зүйлс 16, 18, 185, 189, 191, 234

Асуулт 19, 20, 39, 41, 42, 44, 65, 91, 98, 104, 105, 106, 107, 109, 140, 149, 154, 159, 226, 227, 235

Аюулгүй байдлын улс төр-цэргийн асуудлууд (ЕАБХАБ) 21, 35, 46, 193, 194, 234

Аюулгүй байдлын хороо 235

Аюулгүй байдал бүх хуудсанд

Аюулгүйн зөвлөл 61, 62, 136, 137, 146, 150, 151, 155, 211, 219, 220, 225, 236

Аюулгүй байдлын бодлого 11, 13, 14, 17, 19, 20, 30, 32, 33, 39, 40, 41, 44, 51, 56, 59, 60, 106, 113, 116, 150, 170, 211, 216, 236

Аюулгүй байдлын салбарын шинэчлэл 199, 232, 236

Аюулгүй байдлын хувийн хэвшлийн байгууллагууд

Африкийн нэгдлийн байгууллага (Африкийн холбоо-г үз) 46, 235

Африкийн холбоо 46, 234, 235

Б

Баруун Европын холбоо 46, 235

Батлан хамгаалал 27, 74, 234

Батлан хамгаалах хороо 120, 215, 227, 235

Батлан хамгаалах төсөв 21, 56, 167, 168, 169, 170, 171, 172, 173, 175, 216, 234

Батлан хамгаалахын шинэчлэл 19, 72, 75, 234

Бодлого 14, 17, 22, 26, 29, 30, 33, 35, 39, 40, 41, 42, 43, 45, 48, 51, 52, 54, 56, 59, 61, 64, 75, 94, 97, 99, 101, 103, 106, 108, 113, 114, 116, 141, 147, 149, 150, 164, 166, 170, 171, 175, 190, 191, 198, 199, 211, 213, 214, 216, 217, 228, 236

Г

Гадаадын иргэн 234

Гамшиг/Хямрал 26, 73, 100, 105, 128, 141, 234

Гүйцэтгэх засаг: засгийн газар-ыг үз

Гэрээ: гэрээ хэлцэл-ийг үз 34, 46, 47, 48, 49, 102, 112, 234

Гэрээ хэлэлцээр (олон улсын) 61, 143, 218, 234

Д

Дайн 12, 19, 26, 27, 29, 30, 33, 35, 53, 60, 61, 62, 63, 71, 72, 77, 127, 128, 151, 152, 153, 164, 188, 191, 193, 194, 203, 224, 225, 231, 235

Дарамт үзүүлэх (хугацаат цэргийн албан хаагчдад) 28, 234, 235

Дотоод хариуцлага 234

Дотоод аюулгүй байдал 15, 131, 132, 133, 134, 135, 141, 145, 235

Дүйцүүлэх алба: итгэл үнэмшлийн дагуу татгалзагчид хэсгийг үз 22, 201, 202, 204, 206, 207, 208, 234

Дэлхий нийтийн сүлжээ, Интернет-ийг үз

Дэлхийн банк 35, 236

Е

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага

Европын зөвлөл 21, 59, 147, 148, 187, 188, 234

Европын холбоо 22, 46, 218, 219, 225, 226, 234

Есдүгээр сарын 11 - 15, 20, 136, 137, 138, 236

Ё

Ёс зүйн дүрэм 16, 21, 35, 157, 191, 192, 193, 194, 218, 226, 234

Ж

Жендэр: эмэгтэйчүүд-ийг үз

Жижиг зэвсэг 22, 216, 223, 224, 226, 228, 229, 236

З

Зардал (цэргийн) 114, 162, 163, 164, 165, 167, 168, 169, 172, 173, 177, 181, 213, 214, 228, 234

Зарцуулалтын ашигт байдал 166, 178, 236

Зарчмууд 14, 21, 26, 33, 35, 39, 45, 84, 85, 93, 128, 130, 138, 144, 150, 166, 171, 176, 182, 185, 191, 192, 205, 217, 234, 236

Засаглал 4, 14, 19, 20, 21, 25, 26, 32, 35, 41, 51, 53, 54, 56, 80, 81, 89, 91, 127, 129, 133, 136, 140, 144, 150, 152, 162, 163, 169, 171, 173, 178, 186, 191, 196, 198, 204, 213, 234

Засгийн газар 14, 29, 30, 32, 33, 34, 40, 41, 43, 46, 47, 48, 49, 52, 53, 54, 56, 57, 67, 75, 82, 84, 91, 92, 94, 97, 100, 101, 102, 105, 109, 117, 144, 149, 152, 153, 154, 163, 167, 168, 171, 172, 173, 175, 180, 186, 190, 206, 212, 214, 217, 222, 223, 224, 226, 228, 2131, 232, 233, 234

Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо 234

Зэвсэг нийлүүлэх (ЕХ) 22, 217, 219, 220, 234

Зэвсэглэл 22, 30, 46, 47, 156, 212, 215, 216, 218, 219, 221, 222, 223, 224, 225, 228, 230, 234

Зэвсэгт хүчин: цэрэг-ийг үз 51, 52, 63, 64, 71, 72, 74, 78, 87, 92, 110, 111, 119, 132, 145, 150, 153, 157, 185, 191, 192, 194, 198, 200, 201, 202, 203, 204, 206, 213, 225, 231, 232, 234

Зэвсгийн хориг: хориг арга хэмжээ

хэсгийг үз 217, 220, 221, 225, 234

Зэвсгийн худалдаа/шилжүүлэг 16, 22, 217, 218, 219, 222, 223, 227, 228, 234

Зэвсэглэл хураах 223, 225, 230, 234

И

Ил тод байдал 35, 80, 94, 100, 163, 165, 167, 168, 169, 170, 172, 211, 220, 236

Интернэт 54, 58, 84, 141, 142, 146, 167, 175, 235

Иргэний боловсрол 21, 191, 234

Иргэн-цэргийн харилцаа 10, 12, 111, 171, 231, 232, 234

Иргэний эрх 136, 143, 144, 186, 191, 194, 218, 226, 234

Иргэний нийгэм 14, 17, 19, 50, 51, 52, 53, 82, 106, 166, 169, 234

Итгэл үнэмшлийн дагуу татгалзагчид/ татгалзах 204, 234

К

Кибер гэмт хэрэг 15, 146, 149, 234

М

Мөргөлдөөн 12, 25, 30, 46, 54, 60, 61, 62, 63, 66, 73, 82, 91, 92, 93, 127, 128, 151, 153, 156, 201, 218, 219, 225, 231, 234

Мэргэжлийн чадавх 11, 90, 100, 101, 149, 174, 181, 227, 235

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 57, 88, 89, 169, 172, 173, 235

Мэдээллийн дайн: Кибер гэмт хэрэг-ийг үз

Мэтгэлцээн 41, 42, 51, 55, 56, 58, 104, 105, 106, 107, 109, 140, 149, 154, 159, 226, 227, 235

Н

Нийгэм: иргэний нийгэм-ийг үз 14, 17, 19, 50, 51, 52, 53, 82, 106, 166, 169, 234

Нууцлал (тагнуулын албад-ыг үз) 16, 21, 55, 84, 87, 88, 89, 102, 103, 106, 107, 119, 148, 162, 168, 170, 172, 193, 213, 216, 218, 234

Нөөц чадавх 178, 235

нөхцөл: онцгой нөхцөл байдал-ыг үз 18, 73, 122, 127, 128, 143, 213, 234, 236

Нэгдсэн Үндэстний Байгууллага 27, 28, 236

О

Олон улсын байгууллагууд 58, 146, 147, 235

(байгууллага тус бүрийн нэрийн дор үз)

Олон улсын парламентын холбоо

Олон нийтийн санаачилгууд 235

Олон нийтийн цагдаа 234

Олон улсын зохицуулалт 235

Олон улсын хууль тогтоомж 35, 129, 131, 137, 153, 194, 217, 219, 220, 235

Олон улсжих (цэрэг) 235

Олон улсын энхийн ажиллагаа: энхийн ажиллагаа-г үз 18, 99, 102, 112, 150, 152, 154, 156, 157, 158, 159, 167, 199, 202, 203, 235

Омбудсмэн 15, 18, 20, 32, 33, 57, 82, 87, 114, 117, 118, 119, 120, 121, 144, 188, 208, 235

Онцгой нөхцөл: онцгой нөхцөл байдал-ыг үз

Онцгой нөхцөл байдал 18, 73, 73, 122, 125, 127, 128, 143, 213, 234

Онц байдал/урт хугацааны хүнд бэрх

15, 20, 43, 71, 74, 79, 100, 128, 129,
130, 131, 143, 236

П

Парламентын хяналт - бүх хуудсанд

Парламентын ассамблей 59, 102, 187,
188, 235

Парламентын бүх хуудсанд

Парламентын хороод 15, 18, 20, 59,
86, 88, 101, 108, 112, 113, 179, 235

С

Саатуулан хорих төв 234, 236

Сайн засаглал 4, 19, 35, 54, 56, 80, 91,
150, 152, 163, 171, 173, 178, 186, 191,
213, 235

Сонсгол 15, 41, 57, 98, 109, 113, 135,
159, 235

Сөрөг хүчин 105, 140, 235

Т

Тагнаж чагнах 144, 234

Тагнуулын албад (нууцлал-ыг үз) 17,
19, 66, 82, 84, 85, 86, 87, 88, 89, 102,
144, 165, 198, 235

Тагнуулын хороо 235

Терроризм (дотоод аюулгүй байдал-ыг
үз) 15, 18, 20, 26, 27, 39, 40, 55, 72, 84,
89, 136, 137, 138, 139, 140, 141, 143,
144, 145, 146, 219, 230, 236

Тусгаар орнуудын хамтын нийгэмлэг
234

Тушаал үл биелүүлэх 234

Төсвийн систем (ТХТБТ) 234

Төсөв 11, 16, 18, 19, 21, 29, 33, 34, 43,
51, 52, 56, 57, 85, 89, 91, 98, 99, 100,
102, 112, 114, 116, 121, 123, 141, 154,
159, 162, 163, 164, 165, 166, 167, 168,
169, 170, 171, 172, 173, 174, 175, 176,

177, 179, 181, 198, 211, 216, 217, 231,
233, 234

Төрийн бус байгууллага 51, 219, 231,
235

Төрийн бусад цэрэгжсэн байгууллага
15, 17, 77, 235

Төлөөллийн байгууллагууд 235, 236

Тэтгэвэр 16, 172, 174, 198, 199, 200,
236

Тэргүүний туршлага 231, 234

У

Уламжлалын хууль 234

Улс үндэстэн 75, 235

Улс төрийн хариуцлага 33, 234

Умард Атлантын гэрээний байгууллага
(НАТО) 234

Ү

Үндсэн хууль/үндсэн хуулийн
зохицуулалт 33, 34, 39, 62, 97, 98, 104,
128, 130, 153, 166, 182, 185, 186, 189,
190, 191, 192, 196, 207, 234

Үр дүнтэй засаглал 25, 235

Х

Хамтын ажиллагаа 11, 27, 28, 34, 45,
46, 47, 52, 73, 84, 89, 89, 136, 137, 139,
141, 143, 147, 153, 190, 226, 230, 231,
232, 235

Хамтын аюулгүй байдал 27, 234

Хариуцлагатай байдал (хяналт-ыг мөн
үз) 22, 54, 89, 163, 170, 172, 173, 216,
225, 234

Хилийн хяналт 79, 141, 142, 234

Хилийн чанадад цэрэг байрлуулах 234

Хориг арга хэмжээ 131, 221, 239, 236

Хороо 15, 18, 20, 21, 33, 41, 42, 49, 52,

57, 58, 59, 62, 63, 67, 75, 85, 86, 87, 88, 89, 101, 102, 103, 106, 108, 109, 110, 112, 113, 114, 115, 116, 117, 120, 123, 124, 127, 135, 163, 175, 179, 226, 227, 235

Хугацаат цэргийн алба 21, 75, 187, 197, 201, 202, 203, 204, 207, 208, 234

Худалдан авах ажиллагаа 18, 211, 212, 213, 214, 215, 216, 217, 218, 236

Хууль ёсны шинж 152, 153, 235

Хууль сахиулах 4, 19, 21, 71, 74, 76, 81, 82, 83, 93, 141, 142, 144, 192, 193, 234, 235

Хууль сахиулах байгууллагын албан хаагчид (НҮБ) 21, 192, 193

Хууль тогтоомж 12, 30, 33, 34, 35, 40, 41, 49, 52, 53, 55, 57, 61, 64, 65, 66, 67, 75, 76, 77, 82, 88, 89, 92, 94, 104, 105, 106, 113, 114, 116, 124, 128, 129, 130, 131, 132, 133, 134, 135, 137, 138, 139, 140, 14, 143, 144, 145, 146, 147, 149, 156, 166, 169, 172, 173, 175, 178, 182, 186, 188, 189, 190, 193, 194, 196, 204, 206, 208, 217, 219, 220, 221, 224, 225, 235, 236

Хүмүүнлэгийн ажиллагаа 62, 152, 158, 235

Хүмүүнлэгийн хууль тогтоомж 41, 140, 156, 189, 193, 194, 196, 197, 230, 235

Хүний аюулгүй байдал 73, 133, 235

Хүний эрх 2, 4, 5, 15, 21, 26, 40, 41, 46, 51, 55, 59, 62, 66, 73, 76, 77, 80, 81, 82, 83, 84, 87, 89, 92, 118, 122, 127, 129, 130, 131, 132, 135, 136, 137, 138, 143, 144, 146, 149, 151, 158, 159, 185, 187, 189, 189, 190, 193, 197, 205, 206, 218, 219, 226, 230, 235

Хэвлэл мэдээлэл 19, 51, 53, 55, 58, 106, 171, 174, 235

Хяналт бүх хуудсанд

Хянан шалгах ажиллагаа 154, 159, 196, 197, 208, 235

Хянах/мониторинг хийх 20, 29, 30, 34, 35, 43, 50, 51, 52, 53, 64, 79, 84, 85, 88, 89, 102, 103, 104, 105, 106, 112, 113, 114, 119, 122, 132, 136, 141, 142, 151, 162, 171, 182, 198, 215, 216, 224, 228, 235

Ц

Цагдаа 4, 15, 17, 19, 40, 51, 52, 62, 65, 66, 74, 77, 78, 80, 81, 82, 83, 87, 113, 118, 132, 134, 136, 140, 141, 142, 144, 151, 155, 165, 188, 189, 194, 198, 225, 226, 231, 232, 234, 236

Цагдаагийн шинэчлэл 52, 236

Цалин хөлс (албан хаагчдын) 169, 188, 198, 198, 200, 236

Цэрэг 4, 15, 16, 17, 19, 40, 41, 43, 51, 53, 57, 63, 65, 66, 71, 73, 77, 78, 79, 81, 90, 91, 92, 94, 99, 101, 107, 110, 113, 127, 132, 134, 141, 143, 150, 152, 153, 154, 155, 158, 165, 188, 190, 194, 196, 201, 211, 231, 232, 234, 235

Цэргийн албан хаагч (эрэгтэй болон эмэгтэй) 21, 63, 92, 101, 114, 120, 186, 187, 188, 189, 190, 191, 194, 195, 196, 197, 202, 203, 204, 208, 235, 236

Цэргийн холбоод: төлөөллийн байгууллагууд-ыг үз

Цэргүүд: цэрэг-ийг үз 4, 15, 16, 17, 19, 40, 41, 43, 51, 53, 57, 63, 65, 71, 73, 77, 78, 79, 81, 90, 91, 92, 94, 99, 101, 107, 110, 113, 127, 132, 133, 134, 141, 143, 150, 152, 154, 158, 165, 188, 190, 194, 196, 201, 211, 231, 232, 234

Цэрэгжсэн бүтэц: төрийн бусад цэрэгжсэн байгууллага-ыг үз

Ч

Чөлөөнд гарах: тэтгэвэр-ийг үз 236

Ш

Шийдвэр гаргах ажиллагаа 158, 212, 213, 214, 217, 227, 234

Шинэчлэл 5, 7, 19, 52, 53, 64, 72, 75, 168, 170, 199, 214, 234, 236

Шорон: саатуулан хорих төв-ийг үз 122, 236

Шүүх 4, 14, 32, 33, 35, 62, 76, 80, 81, 85, 87, 89, 108, 110, 118, 123, 124, 131, 132, 133, 137, 141, 142, 144, 145, 177, 178, 190, 193, 195, 196, 234

Шүүх засаг 14, 235

Э

Эмэгтэйчүүд 15, 19, 60, 61, 62, 63, 64, 64, 65, 66, 67, 199, 202, 235

Энхийг байгуулах 21, 60, 61, 150, 152, 235

Энхийг тогтоох 19, 21, 60, 61, 62, 71, 150, 151, 152, 235

Энхийг сахиулах: энхийн ажиллагаа-г үз 236

Энхийг бүрдүүлэх 21, 150, 151, 236

Энхийн ажиллагаа 18, 99, 102, 112, 150, 152, 154, 156, 157, 158, 159, 167, 199, 202, 203, 235

Эрүүдэн шүүх 123, 124, 131, 132, 193, 236

Эрх мэдэл 3, 27, 29, 33, 34, 75, 85, 97, 98, 109, 113, 117, 118, 120, 132, 134, 144, 154, 158, 166, 170, 178, 186, 190, 199, 216, 235

Innere Führung (манлайлал) 235

Зэвсэгт хүчинд ардчилсан
хяналт тавих Женевийн төв



Олон улсын парламентын холбоо